



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Доржзовдын ЭНХТУЯА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-27-70, Факс: 32-70-16
E-mail: enkhtuya@parliament.mn
<http://www.parliament.mn>

2026.06.22 № чир-03/7418
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн
мэдүүлэх тухай

Монгол Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтуяа, А.Ганбаатар нар Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Асрах үйлчилгээний тухай хуулийн төслийг санаачлан боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

Хавсралт ²⁶ хуудастай.

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



Д.ЭНХТУЯА

А.ГАНБААТАР

Ж.АЛДАРЖАВХЛАН

О.АЛТАНГЭРЭЛ

Н.АЛТАНХУЯГ

Н.АЛТАНШАГАЙ

Д.АМАРБАЯСГАЛАН

20260057

С.АМАРСАЙХАН

О.АМГАЛАНБААТАР

Ч.АНАР

А.АРИУНЗАЯА

Т.АУБАКИР

Х.БААСАНЖАРГАЛ

Ц.БААТАРХҮҮ

М.БАДАМСҮРЭН

Э.БАТ-АМГАЛАН

Б.БАТБААТАР

Д.БАТБАЯР

Р.БАТБОЛД

Ж.БАТЖАРГАЛ

Д.БАТЛУТ

О.БАТНАЙРАМДАЛ

Ж.БАТСУУРЬ

Н.БАТСҮМБЭРЭЛ

Х.БАТТУЛГА

Б.БАТЦЭЦЭГ

П.БАТЧИМЭГ

Э.БАТШУГАР

Б.БАТ-ЭРДЭНЭ

Ж.БАТ-ЭРДЭНЭ

20260057

Б.БАЯРБААТАР

Ж.БАЯРМАА

Ж.БАЯСГАЛАН

Б.БЕЙСЕН

Э.БОЛОРМАА

Х.БОЛОРМАА

Х.БУЛГАНТУЯА

Д.БУМ-ОЧИР

Ш.БЯМБАСҮРЭН

С.БЯМБАЦОГТ

Ж.ГАЛБАДРАХ

А.ГАНБААТАР

Г.ГАНБААТАР

Ж.ГАНБААТАР

С.ГАНБААТАР

Д.ГАНБАТ

П.ГАНЗОРИГ

Д.ГАНМАА

Л.ГАНТӨМӨР

Х.ГАНХУЯГ

М.ГАНХҮЛЭГ

Ц.ДАВААСҮРЭН

Г.ДАМДИННЯМ

20260057



Т.ДОРЖХАНД

Б.ДЭЛГЭРСАЙХАН

Б.ЖАВХЯН



Х.ЖАНГАБЫЛ



Б.ЖАРГАЛАН

Д.ЖАРГАЛСАЙХАН

С.ЗАМИРА

Б.ЗАЯАБАЛ



Ж.ЗОЛЖАРГАЛ

С.ЗУЛПХАР



Ц.ИДЭРБАТ

Ч.ЛОДОЙСАМБУУ

Г.ЛУВСАНЖАМЦ

С.ЛҮНДЭГ


М.МАНДХАЙ



Л.МӨНХБААТАР

Ц.МӨНХБАТ

Л.МӨНХБАЯСГАЛАН



Т.МӨНХСАЙХАН



Б.МӨНХСОЁЛ

П.МӨНХТУЛГА



Ц.МӨНХТУЯА

З.МЭНДСАЙХАН

Б.НАЙДАЛАА

Н.НАРАНБААТАР

П.НАРАНБАЯР

М.НАРАНТУЯА-НАРА

Ч.НОМИН

О.НОМИНЧИМЭГ

Н.НОМТОЙБАЯР

Э.ОДБАЯР

С.ОДОНТУЯА

У.ОТГОНБАЯР

Г.ОЧИРБАТ

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Б.ПУНСАЛМАА

Д.ПҮРЭВДАВАА

Б.ПҮРЭВДОРЖ

Д.РЭГДЭЛ

П.САЙНЗОРИГ

Ц.САНДАГ-ОЧИР

О.САРАНЧУЛУУН

М.САРНАЙ

Л.СОРОНЗОНБОЛД

Р.СЭДДОРЖ

Ц.ТУВААН

20260057

Б.ТУЛГА

Б.ТҮВШИН

Х.ТЭМҮҮЖИН

Г.ТЭМҮҮЛЭН

А.УНДРАА

Ч.УНДРАМ

Н.УЧРАЛ

Б.УЯНГА

Г.УЯНГАХИШИГ

Д.ҮҮРИЙНТУЯА

Г.ХОСБАЯР

Б.ХЭРЛЭН

ДАВ.ЦОГТБААТАР

ДАМ.ЦОГТБААТАР

О.ЦОГТГЭРЭЛ

С.ЦЭНГҮҮН

Ж.ЧИНБҮРЭН

Б.ЧОЙЖИЛСҮРЭН

Ө.ШИЖИР


Л.ЭНХ-АМГАЛАН

Б.ЭНХБАЯР

Ж.ЭНХБАЯР

Л.ЭНХНАСАН

20260057



Д.ЭНХТҮВШИН



М.ЭНХЦЭЦЭГ



С.ЭРДЭНЭБАТ

С.ЭРДЭНЭБОЛД

Р.ЭРДЭНЭБҮРЭН





МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Доржзовдын ЭНХТУЯА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-27-70, Факс: 32-70-16
E-mail: enkhtuya@parliament.mn
<http://www.parliament.mn>

УЛСЫН ИХ ХУРЛЫН ЕРӨНХИЙ
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Л.ӨЛЗИЙСАЙХАН ТАНАА

2026.06.09 № УИХ-03/6647
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
тов тогтоолгох тухай

Монгол Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтуяа, А.Ганбаатар нар Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Асрах үйлчилгээний тухай хуулийн төслийг санаачлан боловсрууллаа.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэгт зааснаар Засгийн газраас санал, дүгнэлт авч төсөлд тусгасан болно.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасны дагуу хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх тов тогтоож өгнө үү.

Хуулийн төсөл, үзэл баримтлал, товч бөгөөд дэлгэрэнгүй танилцуулга, холбогдох тайланг хавсаргав.

Хавсралт 225 хуудастай.

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



Д.ЭНХТУЯА

20260060



УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Д.ЭНХТУЯА ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д Сүхбаатарын галбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08
Цахим шуудан: info@cabinet.gov.mn
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2026-03-23 № ХХТ/933
танай _____-ны № _____-т

Хуралдааны тэмдэглэл
хүргүүлэх тухай

Таны санаачлан боловсруулсан Асрах үйлчилгээний тухай хуулийн төслийг
Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэн тэмдэглэлийг хүргүүлж байна.

Хүлээн авч, танилцана уу.

Хүндэтгэсэн,

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

С.БЯМБАЦОГТ

000065003722

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 10 дугаар хуралдааны тэмдэглэлд:

"3.ХЭЛЭЛЦСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтуяагаас санаачлан боловсруулсан Асрах үйлчилгээний тухай хуулийн төсөлд Засгийн газраас өгөх санал, дүгнэлт

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтуяагаас санаачлан боловсруулсан Асрах үйлчилгээний тухай хуулийн төслийг хэлэлцээд хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан асаргаа сувилгаа шаардлагатай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүнд өвчтэй хүнд нийцүүлсэн олон хувилбарт үйлчилгээг стандарт, мэргэжлийн хүний нөөцөд тулгуурлан үзүүлэх, хувийн хэвшлийн оролцоог дэмжих, гэр бүлийн ачааллыг бууруулах, ажлын байр нэмэгдүүлэх бодлогыг зарчмын хувьд дэмжиж, дараах санал, дүгнэлтийг хууль санаачлагчид уламжлахаар тогтов:

1.Хууль тогтоомжийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт хууль тогтоомжийн төслийг үзэл баримтлалд нь нийцүүлэн боловсруулахаар заасан.

Хуулийн төслийн үзэл баримтлалд асрах үйлчилгээг нийгмийн халамжийн хавсарга, туслах хэлбэрээс ангид, бие даасан, мэргэжлийн, хүний эрхэд суурилсан үйлчилгээ болгож хөгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх гэж, төслийн 36 дугаар зүйлийн 36.2 дахь хэсэгт "Асрах үйлчилгээний санхүүжилт нь нийгмийн халамжийн тэтгэмжтэй адилтгахгүй бөгөөд үйлчилгээний бодит өртөг, чанарт суурилна" гэж тус тус тусгасан боловч хуулийн төслийг дагалдан боловсруулсан Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлд асрах үйлчилгээг нийгмийн халамжийн төрөлд хамааруулахаар, мөн халамжийн үйлчилгээний зардлыг халамжийн сангийн хөрөнгөөс санхүүжүүлэхээр тус тус заасан нь хуулийн төслийн үзэл баримтлалд нийцэхгүй байгааг анхаарах;

2.Хуулийн төслийн 8, 10 дугаар бүлэгт тусгасан асрах үйлчилгээнд төрөөс үзүүлэх дэмжлэг, санхүүжилт, төлбөрийн тогтолцооны талаарх зохицуулалт, тухайлбал, төслийн 27 дугаар зүйлийн 27.1.1, 27.1.2 дахь заалтад заасан татварын хөнгөлөлт, нийгмийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлт, мөн төслийн 38 дугаар зүйлд тусгасан төр асрах үйлчилгээ худалдан авах талаарх зохицуулалтад хамаарах асуудлыг бүрэн тусгаагүй, тунхаглалын шинжтэй, хэт ерөнхий агуулгатай буюу төрөөс үзүүлэх дэмжлэгийн төрөл, тэдгээрийн хамрах хүрээ, олгох нөхцөл, шалгуур зэрэг нь тодорхойгүй байна.

Иймд Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Татварын ерөнхий хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжтой уялдуулан хуулийн төслийн дээрх зохицуулалтуудыг хэрэгжүүлэх журмыг нарийвчлан тусгах нь зүйтэй;

3.Татварын ерөнхий хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтад татвар бий болгох, тогтоох, ногдуулах, тайлагнах, төлөх, хяналт шалгалт хийх, хураах, хөнгөлөх, чөлөөлөх үйл ажиллагаанд шударга байх зарчмыг баримтлахаар заасан. Хуулийн төсөлд тусгасан мэргэжил, орлогын эх үүсвэрээс хамааран татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх зохицуулалт нь дээрх хуулийн шударга байх зарчимд нийцэхгүй байх тул хуулийн төслийн 27 дугаар зүйлийн 27.1.1 дэх заалтад тусгасан “татварын хөнгөлөлт, чөлөөлөлт” гэснийг хасаж, мөн зүйлийн 27.1.3 дахь заалтад тусгасан “ус, дулаан, цахилгаан, хог хаягдлын төлбөрийн хөнгөлөлт” гэснийг “дулаан, цахилгааны төлбөрийн хөнгөлөлт” гэж өөрчлөх;

4.Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.4 дэх хэсэгт Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, нутгийн өөрөө удирдах байгууллага, Засгийн газар, Засаг даргын аливаа шийдвэр нь төсөвт үзүүлэх нөлөөллийн талаарх дүгнэлтэд үндэслэсэн байхаар хуульчилсан.

Хуулийн төслийг дагалдан боловсруулсан Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд асрах үйлчилгээний зардлыг нийгмийн халамжийн сангаас санхүүжүүлэхээр тусгасан нь Нийгмийн халамжийн сангийн төсөвт хэт их ачаалал үүсгэх эрсдэлтэй байна. Түүнчлэн, тус зохицуулалт нь тооцоо судалгаанд үндэслээгүй, ирээдүйд ахмадын тоо өсөхөд төсөвт үзүүлэх нөлөөллийг тооцоолоогүй, хэрэгжүүлэхэд хүндрэл үүсгэхээр байна.

Иймд хуулийн төслийн 36 дугаар зүйлийн 36.2 дахь хэсэгт “Асрах үйлчилгээний санхүүжилт нь нийгмийн халамжийн тэтгэмжтэй адилтгахгүй бөгөөд үйлчилгээний бодит өртөг, чанарт суурилна” гэж тусгасан зохицуулалтад төрөөс асрах үйлчилгээний зардлыг гаргахаас гадна гэр бүлийн гишүүд, хамаатан садан, хүмүүнлэгийн болон буяны байгууллагаас гаргах боломжийг олгох зохицуулалт нэмж тусгах;

5.Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 191 дүгээр захирамжаар Монгол Улсын Засгийн газар, төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагад хуулиар тусгайлан эрх олгогдсон зохицуулалтад дүн шинжилгээ хийж, холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулахыг чиглэл болгосон.

Энэ хүрээнд Үндсэн хуулиар олгогдсон хууль батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах онцгой бүрэн эрхийг гагцхүү Улсын Их Хуралд хадгалж, одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа болон цаашид батлан гаргах хуульд холбогдох харилцааг журмаар биш, хуулиар зохицуулахаар тусгах, хуулийн төслийн үзэл баримтлалд тусгагдаагүй асуудлаар эрх шилжүүлсэн буюу хуульчилсан дэд акт батлах зохицуулалтыг хязгаарлах чиглэлийг баримтлан ажиллаж байна.

Иймд хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, 7 дугаар зүйлийн 7.8 дахь хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.1.5 дахь заалт, 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсэг, 46 дугаар зүйлийн 46.2 дахь хэсэгт тус тус дүрэм, журам батлах эрх олгосон зохицуулалтыг хуулийн төсөлд тусгах.

Түүнчлэн, стандартыг батлах чиг үүргийг Стандарт, хэмжил зүйн газар хэрэгжүүлдэг тул хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэгт “Үйлчилгээний орчин, хөдөлгөөнт үйлчилгээний стандарт шаардлагыг Засгийн газар батална” гэснийг хасах;

6.Хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн 9.3.1 дэх заалтад асрах үйлчилгээ эрхлэхэд “үйл ажиллагааны эхний хугацаанд түр зөвшөөрөлтэй байж болох” гэж, 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсэгт “хувилбарт болон шинээр байгуулагдаж буй төвд 24 сарын хугацаатай түр зөвшөөрөл” олгохоор тусгасан нь Зөвшөөрлийн тухай хуульд заасан зөвшөөрлийн ангилал болон зөвшөөрлийн хугацаанд тавигдах шаардлагад нийцэхгүй байна.

Мөн хуулийн төслийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэгт “Хувилбарт асрах үйлчилгээний төвийн үйлчилгээ эрхлэхэд шаардлагатай зөвшөөрлүүд, түүний баримт бичгийн бүрдүүлэлтийн шаардлагыг нийгмийн халамж болон холбогдох асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална” гэж заасан нь Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 17-д “Зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон захиргааны хэм хэмжээ тогтоосон акт гаргахыг хориглоно” гэж заасантай нийцэхгүй байгааг анхаарах;

7.Хуулийн төслийн зарим зохицуулалтууд нь хүчин төгөлдөр мөрдөж байгаа Нийгмийн халамжийн тухай болон Ахмад настны тухай хуулийн зарим зохицуулалт, тухайлбал, Нийгмийн халамжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт заасан төрөлжсөн асрамжийн үйлчилгээний талаар болон Засгийн газраас боловсруулж буй Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, түүний үзэл баримтлалд тусгасан ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний асаргаа, үйлчилгээнд холбогдох зохицуулалтуудтай давхардаж байгааг анхаарах;

8.Хууль тогтоомжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт заасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх, хуулийн төсөл боловсруулахад тавигдах нийтлэг шаардлагад нийцүүлэн төслийн хэл зүй, найруулгыг сайжруулах, хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн зохицуулалттай нийцүүлэх.

Хэл зүй, найруулга, томъёоллын шинжтэй саналууд:

1/хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэгт тусгасан “асрах үйлчилгээнд хамрагдах хүн” гэсэн нь 4 дүгээр зүйлийн 4.1.4 дэх заалтад заасан “асруулагч хүн” гэсэн тодорхойлолттой, мөн зүйлийн 4.1.7, 4.1.13 дахь заалт болон 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасан хувилбарт асрах үйлчилгээ гэсэн ойлголт нь хоорондоо, 4 дүгээр зүйлийн 4.1.9 дэх заалтад тусгасан нөхөн сэргээх асрах үйлчилгээний тодорхойлолт нь 6 зүйлийн 6.3 дахь хэсэгт тусгасан нөхөн сэргээх асрах үйлчилгээ нь асруулагч хүний бие, амьдралын чанар, хөдөлгөөн, танин мэдэхүйн чадвар, сэтгэл зүй, өвчний удирдлагыг сайжруулах зорилгоор сэргээн засах, сувилах, эмийн хяналттай үйлчилгээ зэргээр үйлчлэхэд чиглэнэ гэж тусгасантай, 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт хувилбарт асрах үйлчилгээ нь 3 төрөлтэй байхаар тусгасан нь төслийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсэгт асруулах хүнийг үйлчилгээний төрлөөр 2 ангилан тусгасантай тус тус зөрчилдөж байгааг анхаарч, холбогдох заалтуудыг өөрчлөн найруулах;

2/хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 3.2.1 дэх заалтын “даамжирсан өвчлөлөөс” гэснийг “өвчний хүндрэлээс” гэж, 4 дүгээр зүйлийн 4.1.9 дэх заалтын “Нөхөн сэргээх” гэснийг “Сэргээн засах” гэж, “эм, эмнэлгийн” гэснийг “эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ” гэж, 4.1.11 дэх заалтын “амсхийх хугацаа олгох” гэснийг “түр амрах хугацаа олгох” гэж, 4.1.12 дахь заалтын “оройн унтлагад байршуулахгүй үйлчилгээг” гэснийг “өдрийн үйлчилгээг” гэж, 9 дүгээр зүйлийн 9.3.3 дахь заалтын “хүнд болон яаралтай эрсдэлийн тохиолдолд” гэснийг “яаралтай тусламж

шаардлагатай тохиолдолд энэ хуулийн 5.1.11-д заасны дагуу” гэж, 32 дугаар зүйлийн 32.3 дахь хэсгийн “Сургалт нь дараах чиглэлийг заавал хамарна” гэснийг “Сургалтын хөтөлбөрт дараах агуулгыг заавал тусгаж, хэрэгжүүлнэ” гэж, 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсгийн “их, дээд сургууль, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв” гэснийг “дээд боловсролын сургалтын байгууллага, мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллага” гэж тус тус өөрчлөх;

3/хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэгт “бүх төрлийн байгалийн гамшиг гэнэтийн ослоос шалтгаалан байнгын асаргаа, сувилгаа, шаардлагатай хүн” гэж, 3.2.4 дэх заалтын “жирэмсний” гэсний дараа “тээлтийн” гэж, “нярай” гэсний дараа “, ганц бие эцэг” гэж, 4 дүгээр зүйлийн 4.1.6 дахь заалтад “сувилах мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх лицензтэй хүн” гэж, 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэгт “Галын аюулгүй байдлын дүгнэлт гаргах журмын дагуу харьяа газрынхаа Онцгой байдлын газраас галын аюулгүй байдлын дүгнэлт гаргуулсан байх” гэж тус тус нэмж, 17 дугаар зүйлд “Асрах үйлчилгээ үзүүлэх байгууллага, хувийн хэвшлийн байгууллагатай байгуулах гэрээний үлгэрчилсэн загвар батлах” гэж, 32 дугаар зүйлд “32.3.6.хувь хүний хөгжил, ёс зүйн боловсрол;” гэж, “32.3.7.дохионы хэлний анхан шатны мэдлэг.” гэсэн агуулгатай заалт тус тус нэмэх;

4/хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.1.11 дэх заалтыг “эрүүл мэндийн байгууллагад үнэлгээ хийлгэн шаардлагатай тохиолдолд эрүүл мэндийн байгууллагад шилжүүлэх” гэж, 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалтыг “гамшгийн осол аюулаас урьдчилан сэргийлж, эрсдэлийн үнэлгээ хийлгэсэн байх” гэж, 9 дүгээр зүйлийн 9.2.1 дэх заалтыг “галын аюулгүй байдлын тухай хуулийн 19 дүгээр зүйл, Галын аюулгүй байдлын үндсэн дүрмийн 2 дугаар зүйлийн шаардлагыг хангасан байх” гэж тус тус өөрчлөн найруулах;

5/хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.7 дахь заалтад заасан түр болон өдрөөр асрах үйлчилгээ, 4.1.11 дэх заалтад тусгасан түр асаргаа, 4.1.12 дахь заалтад тусгасан өдөр өнжүүлэх асаргаа гэх ойлголтууд нь хоорондоо ямар ялгаатай болохыг тодруулах.

Мөн төслийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэгт “Энэ хуулийн 7.1.1-д заасан үйлчилгээг үйлчлүүлэгчийн гэрт нь, хөдөлгөөнт явуулын хэлбэрээр болон байршуулан үзүүлж болно” гэж заасан боловч мөн зүйлийн 7.1.2-7.1.4 дэх заалтуудад тусгасан үйлчилгээг ямар хэлбэрээр үзүүлэх, 11 дүгээр зүйлийн 11.1.5 дахь заалтад “асруулагч, түүний төлөөлөгч нь худал, дутуу, ташаа мэдээлэл өгсөн, эмийн хэрэглээг нуун дарагдуулсан, эсхүл заавал мэдээлэх ёстой эрсдэлийг мэдээлээгүйгээс болж учирсан эрсдэлийг зохицуулах асуудлыг нийгмийн халамж хариуцсан Засгийн газрын гишүүн батална” гэсэн нь, 44 дүгээр зүйлийн 44.2 дахь хэсэгт заасан дэмжлэгийг хэн үзүүлэх зэрэг нь тус тус тодорхой бус, ойлгомжгүй байгааг анхаарч томъёоллыг нягталж, сайжруулах;

6/хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн 9.3.1 дэх заалт, 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсгийн “түр зөвшөөрөл” гэснийг, 15.2 дахь хэсгийн “II-IV түвшний үйлчилгээ авах иргэд” гэснийг тус тус хэрхэн ойлгох нь тодорхойгүй, 10 дугаар зүйлийн 10.2.1, 10.2.6 дахь заалтууд нь хоорондоо утга, агуулгын хувьд давхардсан, 11, 12 дугаар зүйлд тусгагдсан асрах үйлчилгээ үзүүлэгчийн эрх, үүрэг холилдсон, 13 дугаар зүйлийн 13.5 дахь хэсэгт Аймаг, нийслэлийн Засаг дарга хувилбарт асрах төвийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийг олгохоор тусгасан боловч хуулийн төслийг дагалдан боловсруулсан Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлд уг зөвшөөрлийг Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар

олгохоор тусгасан байгааг тус тус анхаарч хууль тогтоомжийн төсөл боловсруулах нийтлэг шаардлагад нийцүүлэх нь зүйтэй.” гэжээ.




ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

БАТЛАВ.
Д.ЭНХТУЯА

2026 оны 06 дугаар сарын 08-ны өдөр



АСРАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд зааснаар Монгол Улсын иргэн нь нийгмийн хамгаалал, асрамж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах суурь эрхтэй бөгөөд эдгээр эрх нь хүний нэр төр, амьдралын чанарыг хангах үндсэн баталгаа болдог. Иймд эдгээр эрхийг бодитой хэрэгжүүлэх нийгэм, эдийн засаг, эрх зүйн орчныг бүрдүүлэх нь төрийн зайлшгүй үүрэг мөн. Гэвч эдгээр эрхийн хэрэгжилт бодит амьдралд хангалтгүй байгаа нь төрөөс тусгайлан зохицуулалт хийх шаардлагыг үүсгэж байна.

Монгол Улсын төрийн бодлогын баримт бичгүүдэд ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон асрах үйлчилгээ шаардлагатай иргэдэд чиглэсэн нийгмийн хамгааллын тогтолцоог хөгжүүлэх, асрамжийн үйлчилгээний хүртээмж, чанарыг нэмэгдүүлэх зорилтыг дэвшүүлсэн бөгөөд эдгээр зорилтыг хэрэгжүүлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох шаардлагатай юм.

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050” баримт бичигт Монгол Улс 2050 онд нийгмийн хөгжил, эдийн засгийн өсөлт, иргэдийн амьдралын чанараар Азид тэргүүлэгч орнуудын нэг болно, амар тайван, хүмүүнлэг нийгмийг цогцлоож, эрүүл чийрэг, эрдэм боловсролтой, эх оронч, хөрвөх чадвартай, оюунлаг, бүтээл иргэнтэй улс болж хөгжинө гэж алсын хараа, эрхэм зорилгыг тодорхойлсон байдаг.

Уг бодлогын баримт бичгийн Гурав.Амьдралын чанар ба дундаж давхарга бүлгийн Нийгмийн хамгаалал ба даатгалын тогтолцооны шинэчлэл, зорилт 3.1-д Амьдралын баталгааг хангах нийгмийн хамгааллын үйлчилгээг хөгжүүлж, амьдралын чанарыг дээшлүүлэхүйц нийгмийн даатгалын тогтолцоог бэхжүүлнэ, 1 үе шат (2021-2030): нийгмийн хамгааллын тогтолцоог шинэчлэх үе: 3. Хүн амын бүлгүүдийн ялгаатай хэрэгцээ, нийгмийн хөгжлийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн нийгмийн хамгаалал, халамжийн үйлчилгээг үзүүлнэ. 4. Нийгмийн

халамжийн үйлчилгээнд хүн амын эмзэг бүлгүүдийг бүрэн хамруулна.. 5. Зорилтот, эмзэг бүлгийн өрх, иргэний амьжиргаанд хүрэлцэхүйц хэмжээний нийгмийн халамжийн тусламж, дэмжлэгийг үзүүлдэг болно гэж заасан.

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 3.1.10-д Нийгмийн халамжийн тусламж, дэмжлэг, үйлчилгээг зорилтот, эмзэг бүлгийн хэрэгцээнд нийцүүлж, амьжиргааг нь дээшлүүлэхэд чиглүүлнэ, 3.1.13-д Ахмад настанд урт хугацааны тусламж үйлчилгээ үзүүлэх хөгжлийн төвүүдийг байгуулна гэж заажээ.

Гэвч нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээ шаардлагатай иргэдэд үзүүлэх үйлчилгээний хүртээмж, чанар хангалтгүй байгаа нь асрах үйлчилгээ шаардлагатай иргэд, ахмад настан болон эмзэг бүлгийн хүмүүсийн эрх, амьдралын чанарт сөргөөр нөлөөлж, нийгмийн бухимдлыг нэмэгдүүлж байна. Өнгөрсөн хугацаанд холбогдох хууль тогтоомж, стандарт тодорхой хэмжээнд бүрдсэн боловч асрах үйлчилгээний харилцаа нь салангид, цогц бус зохицуулалттай байгаа тул уг харилцааг бие даасан хуулиар нарийвчлан зохицуулах шаардлага үүссэн байна. Иймд асрах, асрамжийн үйлчилгээний харилцааг бие даасан, иж бүрэн хуулиар зохицуулж, үйлчилгээний хүртээмж, чанар, үр нөлөөг дээшлүүлэх шаардлага үүссэн.

Асрах үйлчилгээ нь нийгмийн хамгааллын тогтолцооны суурь хэсэг бөгөөд улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд шууд нөлөө үзүүлдэг. Иймд асрахуйн эдийн засгийг бие даасан бодлогын чиглэл болгон хөгжүүлэх, эрх зүйн орчныг нь тодорхой болгох шаардлагатай байна.

Монгол Улсад ахмад настны эзлэх хувь нэмэгдэж, гэр бүлийн асаргааны ачаалал өсөж байгаа хэдий ч мэргэжлийн асрах үйлчилгээний тогтолцоо бүрэн бүрдээгүй, үйлчилгээний хүртээмж хангалтгүй хэвээр байгаа болно.

Эмэгтэйчүүд дийлэнх цагаа асрахуйн хөлсгүй хөдөлмөрт зарцуулж байгаад асрахуйн үйлчилгээний хүртээмжгүй байдалд нөлөөлж байна. Тодруулбал, асаргаа шаардлагатай гэр бүлийн гишүүдийг асрах цалин хөлсгүй хөдөлмөрт эмэгтэйчүүдийн зарцуулдаг цаг эрэгтэйчүүдийнхээс 2.1 дахин их, хүүхэд өвдсөн тохиолдолд даруй 10 дахин нэмэгдэж байна. Өрх гэр болон ажлын байран дахь жендерийн тэгш бус байдлыг арилгаснаар Монгол Улс эмэгтэйчүүдийн ажиллах хүчин дэх оролцооны түвшинг 63.2 хувь хүртэл өсгөх, улмаар нэг хүнд ногдох эдийн засгийн жилийн өсөлтийн түвшинг 0.5 хувиар нэмэгдүүлж, 2025 он гэхэд Монгол Улсын ДНБ-ийг 16 хувиар өсгөх боломжтой гэж АХБ тооцоолсон байна.¹

¹ Азийн сан, Асрахуйн эдийн засаг: Бодлогын зөвлөмж

УИХ-ын даргын 2024 оны 9 дүгээр сарын 5-ны өдрийн 100 дугаар захирамжаар Асрах үйлчилгээний эрх зүй орчныг бүрдүүлэх чиглэлээр судлаж, санал дүгнэлт гаргах, шаардлагатай бол холбогдох хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж ажилласан.

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн Хоёр. Хүний хөгжлийн бодлого, 2.1.1.18-д Ахмад настанд Гэр бүлийн хөгжлийн цогц төвөөр дамжуулан тэдний эрэлт, хэрэгцээнд нийцсэн хөгжлийн болон нийгмийн үйлчилгээ үзүүлж, идэвхтэй насжилтыг дэмжинэ, 2.1.1.21-д Ахмад настны асаргааны хувилбарт үйлчилгээг хөгжүүлж, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын оролцоог дэмжинэ, 2.1.3.9-д Төрөөс үзүүлж байгаа нийгмийн халамж, тусламж, үйлчилгээг зөвхөн зорилтот бүлэгт чиглүүлнэ гэж тус тус заасан байна. Засгийн газрын хөтөлбөрт төрөөс үзүүлэх нийгмийн халамж, тусламж, үйлчилгээг зөвхөн зорилтот бүлэгт чиглүүлэх бодлого баримтлах талаар тусгасан байна, энэ үүссэн асуудлыг бүрэн шийдвэрлэх арга хэмжээ биш юм, иймд асрах үйлчилгээг хөгжүүлэхэд хувийн хэвшил болон төрийн бус байгууллагын оролцоог дэмжих чухал байна.

Монгол Улс 2012 онд Нийгмийн халамжийн тухай хуулийг баталж, нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, үйлчилгээний төрөл, хамрах хүрээ, халамжийн сангийн зарцуулалт, үйлчилгээ үзүүлэх тогтолцоо, байгууллагын чиг үүргийг тодорхойлсон. Уг хуулиар нийгмийн халамжийн үйл ажиллагааг халамжийн тэтгэвэр, тэтгэмж, халамжийн үйлчилгээ, нийгмийн хөгжлийн үйлчилгээ гэсэн үндсэн төрөлд хувааж, халамжийн үйлчилгээний хүрээнд олон нийтийн оролцоонд түшиглэсэн үйлчилгээ болон төрөлжсөн асрамжийн үйлчилгээг тус тус зохицуулсан. Түүнчлэн төрөлжсөн асрамжийн үйлчилгээг ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд зэрэг зорилтот бүлгээр ангилан тодорхойлсон нь эрх зүйн зохицуулалтын хувьд тодорхой ахиц болсон. Гэвч дээрх зохицуулалт нь асрах, асрамжийн үйлчилгээний харилцааг иж бүрэн, системтэй зохицуулж чадахгүй байгаа бөгөөд үйлчилгээний хүртээмж, чанар хангалтгүй хэвээр байна. Үүний улмаас ахмад настан болон асрах үйлчилгээ шаардлагатай иргэдийн хэрэгцээ бүрэн хангагдахгүй, бодит хүндрэл үүсч, нийгмийн сөрөг нөлөөлөл нэмэгдэж байна.

Бие махбодын, нийгмийн, сэтгэл зүйн төрөл бүрийн асаргаа, дэмжлэг, туслалцаа үзүүлэх цалин хөлстэй болон хөлсгүй хөдөлмөр, үйлчилгээний бүх хэлбэрийг хамарсан нийгэм, эдийн засгийн харилцааг асрахуйн эдийн засаг гэдэг. Үүнд хүүхэд, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх шууд болон шууд бус халамж, эрүүл мэнд, боловсрол, түүнчлэн хувь хүний сайн сайхан байдлыг дэмжих, сайжруулахад чиглэсэн санхүүгийн болон бусад үйлчилгээ багтана. Хэдийгээр ДНБ зэрэг үндэсний дансны системд үл үзэгдэх, бараг л тооцогддоггүй ч асрахуйн ажил нь хувь хүний чадавх, сайн сайхан

байдлыг хадгалах, нийгэм, эдийн засгийн үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай гэдгийг улам бүр хүлээн зөвшөөрч байна.²

Манай улсад бодлогын баримт бичиг, хууль тогтоомжийн хүрээнд ахмад настны асуудлыг тодорхой хүрээнд зохицуулдаг боловч бодит байдал дээр үр дүн хангалттай биш байгаа болно. Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 181 дүгээр тогтоолоор Монгол Улсын Хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийг баталсан, уг баримт бичгийн 95 дахь хэсэгт Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг боловсруулах талаар тусгасан байна. Хэдийгээр Нийгмийн халамжийн тухай хуулийг шинэчлэн батлах нь чухал хэдий ч нийгмийн харилцааг нь илүү нарийвчилсан, тодорхой үйлчилгээ, бие даасан харилцааг зохицуулсан, нийгмийн эрэлт хэрэгцээг хангасан хуулийн хэрэгцээ шаардлага өндөр байна.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний комисс ахмад настны асуудлаар судалгаа хийж олон нийтэд дүнгээ танилцуулсан байдаг. Уг судалгааны үр дүнгээс харвал ахмад настны эрхийн асуудал сэтгэл зовоосон асуудал хэвээр байгааг харуулж байна.

Монгол Улсад 388300 ахмад настан байна. Тодруулбал, 10.1 хувийг эзэлж байна. 2050 он гэхэд таван хүн тутмын нэг нь ахмад настан болно гэсэн тооцоолол бий. Үргэлжлүүлэн ахмадуудын хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлтийг харвал 20.7 хувь нь ажил, хөдөлмөр эрхэлж байна. Ахмадын холбооны судалгаагаар, нийт ахмадуудын 16.7 хувь буюу 28.2 мянган ахмад настан амьжиргааны баталгаажих түвшнөөс доогуур орлоготой өрхөд, 3963 ахмад настан ганц бие, харж хандах үр хүүхэдгүй, 7815 ахмад хөгжлийн бэрхшээлтэй хэвтрийн 184 мянган ахмад настан бусдын байнгын асрамжид байна. Монгол Улс ахмад настны хуультай цөөн орны нэг. ХЭҮК-оос 2023 онд судалгаа хийж, Засгийн газарт илтгэл хүргүүлсэн. Нэгдүгээрт Нийгмийн даатгалын багц хуулийг сайжруулсан ч ахмад настуудын тэтгэврийн зөрүүний асуудал хэвээр байна. Ахмад настанд нийгмийн амьдралд оролцох эрх нь тулгамдсан асуудал болоод байна. Ахмадад ээлтэй орчин Монголд бүрдээгүй байгааг ХЭҮК-ын судалгаанд оролцсон 70 хувь нь хэлсэн байдаг. Мөн ахмадууд чөлөөт цагаа өнгөрүүлэх газар хомс байна. Нийгмээс тусгаарлагдах, ганцаардах асуудал түгээмэл байгаа. Хөдөлмөр эрхлэлтийн байдлыг төрөөс дэмжиж байгаа ч бодит байдал дээр ахиц дэвшил харагдахгүй байна. ХЭҮК-ын судалгаанд оролцогсдын таван ахмад тутмын нэг нь ялгаварлан гадуурхалтад өртөж байгаа нь батлагдсан. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас зөрчлийн гэмт хэрэгт хохирсон ахмад настны тоо 2022 онд 968 буюу 34.8 хувиар нэмэгдсэн байна. Үүнд 64 хувь сэтгэл санааны хүчирхийлэл, 36 хувь нь эдийн засгийн хүчирхийлэл, 0.1 хувь нь бэлгийн хүчирхийлэл, бие махбодын хүчирхийлэл 47 хувь, үл хайхрах хүчирхийлэл 21

² Азийн сан, Асрахуйн эдийн засагтай холбоотой өгөгдлийн өнөөгийн байдал, хэрэгцээ, бодлогын зөвлөмж, 2024 он

хувь байна. Ахмадууд эрүүл мэндийн үнэтэй чанартай үйлчилгээг төдийлөн авч чадахгүй байна.³

Хүн амын дундаж наслалт нэмэгдэж байгаа хэдий ч ахмад настанд үзүүлэх тусламж, үйлчилгээний хүртээмж, чанар хангалтгүй хэвээр байна. Ахмад настанд чиглэсэн төрийн бодлого, шийдвэрийн хэрэгжилт бодит байдалд үр дүн сул байгаа нь нийгмийн хамгааллын тогтолцооны үр ашигт сөргөөр нөлөөлж байна. Асрах, асрамжийн үйлчилгээ шаардлагатай нийгмийн бүлэгт ахмад настан, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон өрхийн түвшинд асаргаа шаардлагатай иргэд хамаарна. Эдгээр иргэд нь амьдралын тодорхой үе шатанд нийгэмд хувь нэмрээ оруулж ирсэн боловч өндөр нас, эрүүл мэндийн байдал, нийгмийн нөхцөл байдлын улмаас тусламж, дэмжлэг шаардлагатай болж байна.

Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд шаардлагатай нийгмийн дэд бүтэц, орчин, үйлчилгээ хангалтгүй байгаа нь тэдний амьдралын чанарт сөргөөр нөлөөлж, эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх нөхцөлийг бүрдүүлж байна. Асрамжийн үйлчилгээ нь ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувьд зайлшгүй шаардлагатай хэдий ч манай улсад энэ чиглэлийн бүрэн, цогц, үр нөлөөтэй үйлчилгээний тогтолцоо, дэд бүтэц хангалтгүй хэвээр байна. Үүний улмаас эдгээр иргэдийн эрх зөрчигдөх суурь нөхцөл бүрдэж байна.

Хэдийгээр ахмад настанд тэтгэвэр олгож байгаа боловч түүний хэмжээ нь амьжиргааны хэрэгцээг бүрэн хангахгүй, ядууралд өртөх эрсдэлийг бууруулахад хангалтгүй байна. Түүнчлэн ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээг зөвхөн тэтгэвэр, тэтгэмжээр шийдвэрлэх боломжгүй бөгөөд тэдэнд шаардлагатай нийгмийн дэд бүтэц, орчин, үйлчилгээний хүртээмжийг бүрдүүлэх асуудалтай шууд хамааралтай байна.

Иймд нийгмийн баталгаа, халамжийг зөвхөн мөнгөн тэтгэмжид тулгуурлан ойлгох нь хангалтгүй бөгөөд асрах, асрамжийн үйлчилгээ, дэд бүтэц, орчны цогц зохицуулалтыг хамтад нь авч үзэх шаардлагатай байна. Манай улсад олгож буй тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ хязгаарлагдмал, мөн ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн нийгмийн дэд бүтэц, үйлчилгээ хангалтгүй байгаа нь энэ чиглэлд эрх зүйн болон бодлогын цогц шийдэл шаардлагатай байгааг харуулж байна.

Ахмад настны эрхийг хамгаалах төрийн бодлого, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, ахмад настанд холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангахын тулд асрамжийн үйлчилгээний тогтолцоог боловсронгуй болгох, олон улсын шилдэг туршлагыг нэвтрүүлэх шаардлагатай байна.

³ <https://itoim.mn/a/2024/09/26/event>

Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон асрах, халамжийн үйлчилгээ дутагдалтай байгаа нийгмийн тодорхой бүлгийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэснээр нийгмийн баталгаа сайжирч, хүмүүнлэг, иргэний нийгэм байгуулах Үндсэн хуулийн зорилгыг хэрэгжүүлэх нөхцөл бүрдэнэ. Иймд хэрэгжүүлэх бодлого, арга хэмжээ нь тодорхой, хэмжих боломжтой, хүрэхүйц, бодитой байх шаардлагатай.

Иймд асрах үйлчилгээ шаардлагатай иргэдэд үзүүлэх халамж, асрамжийн үйлчилгээг хүртээмжтэй, чанартай болгох, уг харилцааг дэмжих эдийн засаг, нийгэм, эрх зүйн цогц зохицуулалтыг бий болгох нь энэхүү хуулийн төслийн үндсэн зорилго болно.

Асрамжийн харилцааг тусгайлан зохицуулсан хуультай болох тохиолдолд асрамжийн үйлчилгээний нэр төрөл, арга хэлбэр, стандарт, үйлчилгээнд тавигдах шаардлага, хяналт, асрамжийн үйлчилгээг төрөөс дэмжих эдийн засаг, нийгэм, эрх зүйн баталгааг бүрдүүлж өгснөөр асрамжийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх боломжтой болно. Асрах үйлчилгээ нь хөдөлмөр их шаарддаг, нийгмийн суурь үйлчилгээ бөгөөд асрах үйлчилгээг хувь хүний болон аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөхөөр төсөлд тусгана, учир нь татвар, НӨАТ ногдуулах нь үйлчилгээний үнийг 10 хувиар нэмэгдүүлэх, хэрэглээг бууруулах эрсдэлтэй гэж үзсэн.

Үндэсний баялагийн сангийн тухай хуулийн 10 дугаар зүйлд Төрөлжсөн сангийн талаар заасан бөгөөд хуулийн 10.1.2 дахь заалтад Хуримтлалын сан нь газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг одоо үеийн Монгол Улсын иргэн бүрд тэгш, шударга хүртээх зорилгоор иргэний эрүүл мэнд, боловсрол, орон сууцны зориулалтаар дэмжлэг үзүүлэхээр заасан. Уг заалтад асрах үйлчилгээг нэмж оруулахаар тусгана. Учир иргэн нь эрүүл мэндээ уг сангаас дэмжлэг авахаар тусгасан бөгөөд асрах үйлчилгээ нь нийгмийн эрүүл мэндтэй салшгүй холбоотой юм.

Асрах үйлчилгээний хүний нөөцийг бүрдүүлэх зорилгоор гадаадаас мэргэжлийн асрах үйлчилгээний ажилтан тодорхой түвшинд оруулж ирэх нь асрах үйлчилгээний хөдөлмөрийн нөөц, мэргэжлийн чадавхид ач холбогдолтой тул гадаад ажилтын ажлын байрны төлбөрөөс чөлөөлөхөөр тусгана.

Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулиар боловсрол, эрүүл мэнд, соёл, спортын байгууллагад гэрээгээр ажиллах эмч, эрдэм шинжилгээний ажилтан, мэргэжлийн багш, дасгалжуулагч авч ажиллуулах ажил олгогчийг ажлын байрны төлбөрөөс чөлөөлдөг.

Асрамжийн үйлчилгээний харилцааг бие даасан хуулиар зохицуулснаар нийгмийн халамжийн үйлчилгээний хүртээмж, чанар дээшилж, хувийн хэвшлийн

оролцоо нэмэгдэхийн зэрэгцээ төрийн нийгмийн зардлын ачааллыг оновчтой бууруулах боломж бүрдэнэ. Мөн иргэдийн үйлчилгээ авах боломж нэмэгдэж, асрах үйлчилгээний салбар хөгжиж, ажлын байр нэмэгдэх боломж бүрдэнэ.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Энэхүү хуулийн зорилго нь асрах үйлчилгээний төрөл, ангилал, хэлбэр, чанар, хүртээмж, стандартыг тодорхойлж, асруулагч болон үйлчилгээ үзүүлэгчийн эрх, үүрэг, хариуцлага, хувийн хэвшлийн оролцоог дэмжихэд оршино. Хууль нь өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн, архаг өвчтэй хүн, жирэмсэн болон төрсний дараах асаргаа шаардлагатай эх, нярай, ганц бие эцэг зэрэг асаргаа шаардлагатай бүх хүнд үйлчлэх асрах үйлчилгээг хамаарна.

Хуулийн төсөлд асрах үйлчилгээний нэр томъёо, ойлголтыг тодорхойлох, асрах үйлчилгээнд хамрагдах иргэн, үзүүлэхэд тавигдах шаардлага, үйлчилгээний чанар, хүртээмжийн асуудлыг тодорхойлж, асрах үйлчилгээ үзүүлэх иргэн, хуулийн этгээдэд тавигдах шаардлага, төрөөс асрах үйлчилгээ үзүүлж байгаа иргэн, хуулийн этгээдэд үзүүлэх дэмжлэгтэй холбоотой харилцааг зохицуулна.

Асрах үйлчилгээг нэвтрүүлэхтэй холбогдуулан уг үйлчилгээг татварын дарамтаас чөлөөлж, асрах үйлчилгээ шаардлагатай байгаа иргэд мэргэжлийн асрах үйлчилгээ авах хүртээмжийг нэмэгдүүлнэ.

Гурав.Хууль тогтоомж батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Хууль тогтоомж батлагдан хэрэгжсэнээр ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдралын чанар дээшилж, асрах үйлчилгээний хүртээмж, чанар сайжран, үйлчилгээний сэтгэл ханамж нэмэгдэх нөхцөл бүрдэнэ. Мөн асрах үйлчилгээг хөгжүүлэх хүрээнд хувийн хэвшлийн оролцоог бодлогоор дэмжих, татварын зохицуулалтыг хэрэгжүүлснээр үйлчилгээний хүртээмж нэмэгдэж, гэр бүлийн асаргааны ачаалал буурч, зорилтот бүлгийн амьдралын чанар сайжрах боломж бүрдэнэ.

Дөрөв.Хууль тогтоомжийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, шинэчлэн найруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсон тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал:

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон Олон улсын гэрээтэй нийцэж байгаа бөгөөд ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, асрах үйлчилгээ шаардлагатай байгаа иргэдийн нийгмийн хэрэгцээ шаардлагыг хангахад чиглэнэ. Хуулийн төсөлтэй холбоотойгоор Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт оруулах тухай, Асрах үйлчилгээний тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг боловсруулна.

--oOo--

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Асрах үйлчилгээний тухай хуулийн төсөл

Энэхүү дэлгэрэнгүй танилцуулгыг Хууль тогтоомжийн тухай хуулийн 33 дугаар зүйлд заасны дагуу боловсруулав. Танилцуулгад хуулийн төслийн зүйл, хэсэг, заалт бүрийн агуулга, түүнийг боловсруулсан үндэслэл, шаардлага, зохицуулж буй харилцааны мөн чанар, шаардлагатай тохиолдолд гадаад улсын эрх зүйн зохицуулалттай харьцуулсан тайлбар, нэр томъёоны хэрэглээ болон эх сурвалжийг тус тус тайлбарласан болно.

Хуулийн төслийг боловсруулахдаа Хууль тогтоомжийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгаа, мөн хуулийн 17 дугаар зүйлд заасан хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээг тус тус хийж гүйцэтгэсэн. Судалгааны хүрээнд Монгол Улсын эрх зүйн зохицуулалт, хэрэгжилтийн өнөөгийн байдал, тулгамдсан асуудал, олон улсын туршлага, зохицуулалтын боломжит хувилбаруудыг судалж, дүн шинжилгээ хийсэн болно.

Асрах үйлчилгээний тухай хуулийн төслийг боловсруулах болсон хэрэгцээ, шаардлага нь хүн амын насжилт, асрах үйлчилгээний өсөн нэмэгдэж буй хэрэгцээ, үйлчилгээний хүртээмж, чанартай холбоотой тулгамдсан асуудлаар тодорхойлогдож байна.

Гэвч асрах үйлчилгээний хүртээмж, чанар хангалтгүй, үйлчилгээний төрөл, хэлбэр хязгаарлагдмал, хүний нөөц, санхүүжилтийн тогтолцоо сул байгаагаас шалтгаалан асаргаа шаардлагатай иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол бүрэн хангагдахгүй, амьдралын чанарт сөргөөр нөлөөлөх нөхцөл байсаар байна.

Одоогийн байдлаар асрах үйлчилгээтэй холбоотой харилцааг Нийгмийн халамжийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийн хүрээнд хэсэгчлэн зохицуулж байгаа боловч энэхүү зохицуулалт нь асрах үйлчилгээний төрөл, хэлбэр, стандарт, хүний нөөц, санхүүжилт, төр, хувийн хэвшил болон төрийн бус байгууллагын оролцоог цогцоор нь зохицуулахад хүрэлцээгүй байна. Иймээс асрах үйлчилгээний харилцааг бие даасан хуулиар иж бүрэн зохицуулах шаардлага үүссэн болно.

Асрах үйлчилгээний тухай хуулийн төсөл нь нийт 10 бүлэг, 30 зүйлээс бүрдэх бөгөөд асрах үйлчилгээний төрөл, ангилал, хэлбэр, үйлчилгээ үзүүлэхэд тавигдах шаардлага, асруулагч болон үйлчилгээ үзүүлэгчийн эрх, үүрэг, үйлчилгээний байгууллагын удирдлага, зохион байгуулалт, төрөөс баримтлах бодлого, дэмжлэг, санхүүжилт, төлбөрийн тогтолцоо, хяналт, хариуцлага болон маргаан шийдвэрлэхтэй холбоотой харилцааг зохицуулна.

Энэхүү дэлгэрэнгүй танилцуулгыг боловсруулахдаа хуулийн төслийн бүлэг, түүний зүйл, хэсэг, заалт бүрийн агуулга, зохицуулалтын зорилго, үндэслэл, шаардлагыг тайлбарлах аргачлалыг баримталсан болно. Мөн шаардлагатай тохиолдолд олон улсын болон гадаад улсын эрх зүйн зохицуулалттай харьцуулсан тайлбар, нэр томъёоны хэрэглээ, эх сурвалжийн мэдээллийг холбогдох зүйл, хэсэгт тусгасан болно.

Хуулийн төслийн нэгдүгээр бүлгээр Асрах үйлчилгээний тухай хуулийн зорилт, хууль тогтоомжийн тогтолцоо, үйлчлэх хүрээ, нэр томъёоны тодорхойлолт болон асрах үйлчилгээнд баримтлах үндсэн зарчмыг тогтоосон болно.

Хуулийн төслийн нэгдүгээр зүйлд хуулийн зорилтыг тодорхойлсон бөгөөд асрах үйлчилгээний төрөл, хэлбэр, стандарт, үйлчилгээ үзүүлэгч болон үйлчилгээ авагчийн эрх, үүрэг, талуудын хамтын ажиллагаа, санхүүжилт, төрөөс үзүүлэх дэмжлэг, зохицуулалт, хяналттай холбогдсон харилцааг зохицуулахад чиглэж байна. Хуулийн зорилтыг тодорхойлохдоо асрах үйлчилгээний харилцааны үндсэн бүрэлдэхүүн болох үйлчилгээний агуулга, оролцогч талуудын эрх зүйн байдал, санхүүжилтийн тогтолцоо болон төрийн оролцоог бүхэлд нь хамруулсан бөгөөд энэ нь хуулийн нийт бүтэц, дараагийн бүлгүүдийн зохицуулалтын хамрах хүрээг тодорхойлох суурь болж байна. Хоёрдугаар зүйлээр асрах үйлчилгээний харилцааг зохицуулах хууль тогтоомжийн бүрэлдэхүүнийг тодорхойлсон. Асрах үйлчилгээ нь нийгмийн хамгааллын тогтолцооны нэг хэсэг тул уг харилцааг Монгол Улсын Үндсэн хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актаар зохицуулахаар тусгасан. Түүнчлэн Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээний зохицуулалт энэ хууль болон бусад хууль тогтоомжийн зохицуулалтаас өөрөөр тогтоосон тохиолдолд олон улсын гэрээг дагаж мөрдөхөөр зохицуулсан нь Үндсэн хуульд заасан зарчимтай нийцэж байна. Гуравдугаар зүйлээр хуулийн үйлчлэх хүрээг тодорхойлсон. Хуулийн төсөлд асрах үйлчилгээг зөвхөн ахмад настанд зориулсан үйлчилгээ гэж үзэхгүйгээр өдөр тутмын амьдралын үйл ажиллагааг бие даан гүйцэтгэх боломж нь хязгаарлагдсан, бусдын тусламж, дэмжлэг шаардлагатай бүх хүнд хамаарахаар тогтоосон. Ингэхдээ хамрагдах хүрээг нас, өвчин, хөгжлийн бэрхшээлийн төрөл зэргээр бус тухайн хүний бодит хэрэгцээ, бие даан амьдрах чадварын түвшинд тулгуурлан тодорхойлсон нь үйлчилгээний хүртээмжийг өргөжүүлэх ач холбогдолтой юм. Дөрөвдүгээр зүйлээр хуулийн хэрэгжилтийг нэг мөр ойлгож хэрэглэх зорилгоор асрах үйлчилгээтэй холбоотой үндсэн нэр томъёог тодорхойлсон. Асрах үйлчилгээний харилцааг бие даасан хуулиар анх удаа зохицуулж байгаа тул “асрах үйлчилгээ”, “асруулагч”, “үйлчилгээ үзүүлэгч этгээд”, “өдөр тутмын ахуйн асаргаа”, “сэргээн засах асрах үйлчилгээ”, “хувилбарт асрах үйлчилгээ”, “эрсдэлийн үнэлгээ” зэрэг суурь ойлголтыг тодорхойлон хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангахыг зорьсон. Нэр томъёог боловсруулахдаа Ахмад настны тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд хэрэглэж байгаа нэр томъёотой уялдуулж, хууль хоорондын давхардал, зөрүүтэй ойлголт үүсэхээс сэргийлсэн болно. Харин “асрах үйлчилгээ”, “хувилбарт асрах үйлчилгээ”, “эрсдэлийн үнэлгээ” зэрэг ойлголтыг олон улсын урт хугацааны асаргаа, дэмжлэгийн үйлчилгээний нийтлэг ойлголт, зарчимд тулгуурлан үндэсний эрх зүйн тогтолцоонд нийцүүлэн боловсруулсан. Тавдугаар зүйлээр асрах үйлчилгээнд

баримтлах үндсэн зарчмуудыг тогтоосон. Асрах үйлчилгээ нь хүний эрхэд суурилсан үйлчилгээ байх ёстой тул асруулагчийн амь нас, аюулгүй байдал, нэр төр, эрх чөлөөг хүндэтгэх, ялгаварлан гадуурхахгүй байх, хувийн мэдээллийн нууцлалыг хамгаалах, хүсэл зориг, сонголтыг нь хүндэтгэх зарчмыг тусгасан. Үүний зэрэгцээ үйлчилгээний чанар, аюулгүй байдал, хүртээмж, тасралтгүй байдлыг хангах, ил тод, хариуцлагатай ажиллах, алслагдсан бүс нутагт хүртээмжтэй хүргэх, хувийн хэвшлийн оролцоог дэмжих, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх зэрэг зарчмыг хуульчилсан. Эдгээр зарчим нь хуулийн бусад зүйл, заалтыг тайлбарлах, хэрэгжүүлэх суурь чиг баримжаа болохын зэрэгцээ асрах үйлчилгээний салбарыг хүний эрх, чанар, хариуцлагад тулгуурлан хөгжүүлэх эрх зүйн үндэс болж байна.

Хуулийн төслийн хоёрдугаар бүлэгт асрах үйлчилгээний төрөл, ангилал, хэлбэрийг тодорхойлж, асруулагчийн хэрэгцээ, бие даан амьдрах чадварын түвшин, эрсдэлийн үнэлгээнд үндэслэн үйлчилгээ үзүүлэх эрх зүйн үндсийг тогтоосон болно. Хуулийн төслийн зургаадугаар зүйлд асрах үйлчилгээг өдөр тутмын ахуйн асаргаа, сэргээн засах асрах үйлчилгээ, хүний эрх болон нийгмийн оролцооны дэмжлэг гэсэн үндсэн гурван төрөлтэй байхаар ангилсан. Өдөр тутмын ахуйн асаргаа нь хооллолт, хувийн ариун цэвэр, хөдөлгөөн, ахуйн хэрэгцээг хангах зэрэг өдөр тутмын амьдралын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд чиглэж байгаа бол сэргээн засах асрах үйлчилгээ нь бие даан амьдрах чадварыг хадгалах, сэргээх, сайжруулах зорилготой байна. Харин хүний эрх, нийгмийн оролцооны дэмжлэг нь асруулагчийг нийгмийн амьдралд идэвхтэй оролцох, эрхээ хэрэгжүүлэх, ялгаварлан гадуурхалт, тусгаарлалтаас хамгаалахад чиглэсэн үйлчилгээ юм. Асрах үйлчилгээг ийнхүү зөвхөн ахуйн тусламж үйлчилгээ гэж ойлгох уламжлалт хандлагаас татгалзаж, бие махбодын, сэтгэл зүйн, нийгмийн хэрэгцээг хамарсан цогц үйлчилгээ болгон тодорхойлсон нь хуулийн төслийн үзэл баримтлалын гол шинэчлэлийн нэг болно. Түүнчлэн хувилбарт асрах үйлчилгээг бие даасан болон хосолмол хэлбэрээр хэрэгжүүлэх боломжийг нээлттэй үлдээсэн нь үйлчилгээний уян хатан байдлыг хангах ач холбогдолтой юм. Долоодугаар зүйлд асрах үйлчилгээг хугацаа болон үйлчилгээ үзүүлэх хэлбэрээр ангилан зохицуулсан. Хугацааны хувьд цагийн болон өдрийн үйлчилгээ, түр хугацааны үйлчилгээ, богино хугацааны үйлчилгээ, урт хугацааны үйлчилгээ гэж ангилсан бол үйлчилгээ үзүүлэх хэлбэрийн хувьд гэрээр үзүүлэх үйлчилгээ, байгууллагад байршуулан үзүүлэх үйлчилгээ, явуулын буюу хөдөлгөөнт үйлчилгээ, өдрийн үйлчилгээ гэсэн төрөлтэй байхаар тогтоосон.

Энэхүү ангилал нь асруулагчийн хэрэгцээ, эрүүл мэндийн байдал, бие даан амьдрах чадвар, гэр бүлийн нөхцөл байдал, эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан хамгийн тохиромжтой үйлчилгээний хэлбэрийг сонгох боломжийг бүрдүүлж байна. Мөн үйлчилгээний хугацааг тодорхой ангилснаар санхүүжилт, төлбөр тооцоо, үйлчилгээний чанарын үнэлгээ, тайлагналын тогтолцоог жигд хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн.

Хуулийн төсөлд гэрээр үзүүлэх үйлчилгээ, өдрийн үйлчилгээ, байгууллагад байршуулан үзүүлэх үйлчилгээ, хөдөлгөөнт үйлчилгээний хэлбэрийг тусгайлан зохицуулсан нь олон улсын урт хугацааны асаргааны үйлчилгээний нийтлэг чиг хандлагатай нийцэж байна.

Мөн энэ зүйлээр асрах үйлчилгээний зардал, төлбөр, хөнгөлөлт болон даатгалын сангаас санхүүжүүлэхтэй холбоотой журмыг Засгийн газар, үйлчилгээний нөхцөл, шаардлагыг нийгмийн халамж болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батлахаар зохицуулсан нь хуулийн хэрэгжилтийг хангах дэд зохицуулалтын эрх зүйн үндсийг бүрдүүлж байна.

Хуулийн төслийн гуравдугаар бүлэгт асрах үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангах зорилгоор бүх төрлийн үйлчилгээ үзүүлэгчид мөрдөх нийтлэг болон тусгай шаардлагыг тогтоосон болно.

Наймдугаар зүйлд асрах үйлчилгээний бүх төрөл, хэлбэрт нийтлэг мөрдөх үндсэн шаардлагуудыг тодорхойлсон. Үүнд асруулагчийн хүний эрх, нэр төрийг хүндэтгэх, хувийн мэдээллийн нууцлалыг хамгаалах, эрүүл мэнд, халдвар хамгаалал, эмийн хэрэглээнд тавих хяналтыг хэрэгжүүлэх, аюулгүй хүнс, зохистой хоол тэжээлээр хангах, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, сэргээн засах үйлчилгээ болон орчны тохируулгыг хэрэгжүүлэх, эрсдэлийн үнэлгээ хийх, бүртгэл, мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх, хүний нөөцийн мэргэжлийн чадавхыг хангах, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, шаардлагатай тохиолдолд эрүүл мэндийн байгууллагад шилжүүлэх зохицуулалтыг хэрэгжүүлэх зэрэг шаардлагыг тусгасан.

Эдгээр шаардлага нь асрах үйлчилгээний чанар, аюулгүй байдлын доод стандартыг тогтоож байгаа бөгөөд үйлчилгээ үзүүлэгчийн хэлбэр, өмчлөлийн төрөлөөс үл хамааран ижил түвшний чанарын баталгааг бий болгох зорилготой. Мөн энэхүү зохицуулалт нь хуулийн 5 дугаар зүйлд заасан хүний эрх, чанар, хүртээмж, аюулгүй байдлын зарчмыг бодит үйл ажиллагааны түвшинд хэрэгжүүлэх эрх зүйн үндэс болж байна.

Түүнчлэн асруулагчийг үнэлэх, үйлчилгээ сонгох, үйлчилгээний хооронд шилжүүлэхтэй холбоотой журмыг нийгмийн халамж болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батлахаар тусгасан нь үйлчилгээний хэрэгцээний үнэлгээ, үйлчилгээний чанарын удирдлагыг нэгдсэн аргачлалаар хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж байна.

Есдүгээр зүйлд асрах үйлчилгээний хэлбэр тус бүрд тавигдах тусгай шаардлагыг тогтоосон. Асрах үйлчилгээ нь гэрээр үзүүлэх, байгууллагад байршуулан үзүүлэх, явуулын буюу хөдөлгөөнт хэлбэрээр үзүүлэх, өдрийн үйлчилгээ хэлбэрээр зохион байгуулагдах боломжтой бөгөөд үйлчилгээний орчин, эрсдэл, хүний нөөц, тоног төхөөрөмж, аюулгүй байдлын шаардлага нь харилцан адилгүй байдаг. Иймээс гэрээр үзүүлэх үйлчилгээний хувьд үйлчилгээ авагчийн амьдрах орчинд үзүүлэх үйлчилгээний онцлогийг, байгууллагад байршуулан үзүүлэх үйлчилгээний хувьд байр, орчин, аюулгүй байдал, хүний нөөцийн шаардлагыг, явуулын үйлчилгээний хувьд алслагдсан болон хүрч үйлчлэхэд хүндрэлтэй бүс нутгийн иргэдэд үйлчилгээ хүргэх нөхцөлийг, өдрийн үйлчилгээний хувьд өдөр тутмын асаргаа, нийгмийн оролцоог дэмжих үйл ажиллагааны онцлогийг харгалзан тусгай шаардлага тогтоосон болно.

Ялангуяа явуулын үйлчилгээтэй холбоотой зохицуулалт нь хөдөө орон нутаг, алслагдсан бүс нутагт амьдарч байгаа иргэдийн үйлчилгээний хүртээмжийг

нэмэгдүүлэхэд чиглэж байгаа бөгөөд хуулийн төслийн хүртээмжийг хангах зарчимтай уялдаж байна.

Хуулийн төслийн дөрөвдүгээр болон тавдугаар бүлэгт асрах үйлчилгээний харилцаанд оролцогч үндсэн субъект болох асруулагч, түүний хууль ёсны төлөөлөгч, асрах үйлчилгээ үзүүлэгч байгууллага болон асаргааны мэргэжилтний эрх, үүрэг, хууль зүйн баталгааг тогтоосон болно.

Аравдугаар зүйлд асруулагч болон түүний хууль ёсны төлөөлөгчийн эдлэх эрх, хүлээх үүргийг тодорхойлсон. Асруулагч нь үйлчилгээ авах эсэхээ шийдвэрлэх, үйлчилгээ үзүүлэгчийг сонгох, өөрчлөх, өөрийн нөхцөл байдалтай холбоотой үнэн зөв мэдээлэл авах, асаргааны төлөвлөгөө боловсруулахад оролцох, хүний эрх, нэр төрөө хамгаалуулах, хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтаас ангид байх, хувийн мэдээллийн нууцлалаа хамгаалуулах, санал хүсэлт, гомдол гаргах зэрэг үндсэн эрхтэй байхаар тусгасан. Энэ нь асруулагчийг үйлчилгээний идэвхгүй объект бус, өөрийн эрх, ашиг сонирхлоо хэрэгжүүлэх боломжтой эрх бүхий оролцогч гэж үзсэн хүний эрхэд суурилсан хандлагыг илэрхийлж байна.

Үүний зэрэгцээ асруулагч болон түүний хууль ёсны төлөөлөгчид эрүүл мэндийн болон бусад шаардлагатай мэдээллийг үнэн зөв өгөх, үйлчилгээ үзүүлэгчтэй хамтран ажиллах, тогтоосон дэг журам, аюулгүй ажиллагааны шаардлагыг мөрдөх, бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, эрсдэл болон хүчирхийллийн талаарх мэдээллийг шуурхай мэдэгдэх, төлбөртэй үйлчилгээний төлбөрийг хууль, гэрээнд заасны дагуу төлөх зэрэг үүргийг хүлээлгэсэн. Ийнхүү эрх, үүргийг хамтад нь зохицуулснаар үйлчилгээний харилцаанд талуудын хамтын хариуцлагыг бий болгох зорилготой.

Арваннэгдүгээр зүйлд асрах үйлчилгээ үзүүлэгч байгууллага болон асаргааны мэргэжилтний эрх, үүргийг тодорхойлсон. Үйлчилгээ үзүүлэгч нь хууль тогтоомж, стандартын хүрээнд дотоод журам тогтоох, шаардлагатай мэдээлэл авах, үйлчилгээний төлбөр авах, ажилтан болон үйлчилгээ үзүүлэгчийн аюулгүй байдлыг хамгаалуулах, хууль болон гэрээнд заасан үндэслэлээр үйлчилгээ үзүүлэхээс татгалзах, гэрээг цуцлах зэрэг эрхтэй байхаар тусгасан.

Нөгөө талаас үйлчилгээ үзүүлэгчид асруулагчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдал, нэр төр, эрхийг хамгаалах, үйлчилгээний чанар, стандартыг хангах, хувийн мэдээллийн нууцлалыг хамгаалах, эрүүл мэндийн хяналт тавих, үйлчилгээний бүртгэл, баримтжуулалтыг хөтлөх, хүчирхийлэл болон эрсдэлийн талаарх мэдээллийг холбогдох байгууллагад хүргүүлэх, ажилтнуудын мэргэжлийн ур чадварыг тасралтгүй дээшлүүлэх зэрэг үүргийг хүлээлгэсэн. Мөн үйлчилгээний үнийг шударга ёс, хүмүүнлэг зарчим, зах зээлийн бодит нөхцөлд үндэслэн тогтоох үүргийг тусгасан нь үйлчилгээний хүртээмжийг хангах, үйлчилгээ авагчийн эрх ашгийг хамгаалах ач холбогдолтой юм.

Арванхоёрдугаар зүйлд үйлчилгээ үзүүлэгчийн хууль зүйн баталгааг тогтоосон. Асруулагч эсхүл түүний хууль ёсны төлөөлөгч эрүүл мэндийн байдал, өвчний түүх, эмчилгээний талаарх мэдээллийг санаатайгаар худал мэдүүлэх, нуун дарагдуулах, дутуу өгөх зэргээс үүдэн гарсан хор уршгийн төлөө үйлчилгээ үзүүлэгч

хариуцлага хүлээхгүй байхаар зохицуулсан. Энэхүү зохицуулалт нь үйлчилгээ үзүүлэгчийн хариуцлагын хязгаарыг тодорхой болгож, асруулагчийн үнэн зөв мэдээлэл өгөх үүрэгтэй уялдан талуудын хоорондын хариуцлагын шударга тэнцвэрийг хангах зорилготой.

Энэ бүлгийн зохицуулалтын үр дүнд асруулагчийн эрхийг хамгаалах, үйлчилгээ үзүүлэгчийн хууль ёсны ашиг сонирхлыг хангах, талуудын харилцан хариуцлага, хамтын ажиллагаанд тулгуурласан үйлчилгээний эрх зүйн үндэс бүрдэж байгаа бөгөөд асрах үйлчилгээний харилцааг тогтвортой, үр ашигтай хэрэгжүүлэх нөхцөл бүрдэх юм.

Хуулийн төслийн зургаа, долоо, наймдугаар бүлэгт асрах үйлчилгээний байгууллагын тогтолцоо, үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааны эрх зүйн үндэс, төрөөс баримтлах бодлого, дэмжлэг, санхүүжилтийн эх үүсвэр болон төлбөрийн тогтолцоог цогцоор нь зохицуулсан болно.

Арвангуравдугаар зүйлд асрах үйлчилгээний төв байгуулах эрхийг тодорхойлж, иргэн болон хуулийн этгээд хуульд заасан нөхцөл, шаардлагыг хангасан тохиолдолд асрах үйлчилгээ эрхлэхээр зохицуулсан. Асрах үйлчилгээ нь хүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалтай шууд холбоотой тул тусгай шаардлага зохицуулалтад хамруулах хэрэгтэй гэж үзсэн. Харин зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох нөхцлийг нийгмийн халамжийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батлахаар тусгав.

Арвандөрөвдүгээр зүйлд асрах үйлчилгээний төвийн барилга байгууламж, орчинд тавигдах үндсэн шаардлагыг тогтоосон. Асруулагчдын аюулгүй байдал, эрүүл ахуй, халдвар хамгаалал, хөгжлийн бэрхшээлтэй хүний хүртээмжийг хангах нь үйлчилгээний чанарын суурь нөхцөл тул барилга, галын аюулгүй байдал, эрүүл ахуй, хүртээмжийн стандартыг мөрдүүлэхээр зохицуулсан. Энэ нь асрах үйлчилгээний байгууллагыг энгийн үйлчилгээний байгууллагаас ялгаж, хүний эрхэд суурилсан тусгай орчин бүрдүүлэх зорилготой юм.

Арвантавдугаар зүйлд асрах үйлчилгээний байгууллагын удирдлага, зохион байгуулалтын үндсийг тодорхойлсон. Үйл ажиллагаа нь хүний эрхийг дээдэлсэн, ил тод, хариуцлагатай, чанар, хүртээмжийг хангахад чиглэсэн байх бөгөөд төр, төрийн бус байгууллага, хувийн хэвшил дангаар болон хамтран үйлчилгээ үзүүлэх боломжийг нээлттэй байхаар тусгасан. Мөн мэргэжлийн холбоо байгуулах, үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангаа нийтэд мэдээлэх үүргийг хуульчилсан нь салбарын ил тод байдал, олон нийтийн хяналтыг нэмэгдүүлэх ач холбогдолтой.

Арванзургаа, арвандолоодугаар зүйлд хүний нөөц болон сургалтын тогтолцоог зохицуулсан. Асрах үйлчилгээний чанар нь хүний нөөцийн ур чадвар, мэргэжлийн түвшнээс шууд хамаардаг тул үйлчилгээний төрөл, эрсдэлийн түвшин, асруулагчийн хэрэгцээнд тохирсон мэргэжлийн хүний нөөцтэй байх шаардлагыг тогтоосон. Мөн асаргааны мэргэжилтэн, ажилтны сургалтын агуулга, хугацаа, үнэлгээ, гэрчилгээжүүлэлтийн тогтолцоог бүрдүүлэхээр тусгасан нь Монгол Улсад асрах үйлчилгээний мэргэжлийн хүний нөөцийн тогтолцоог төлөвшүүлэх эрх зүйн үндэс болж байна.

Арваннаймдугаар зүйлд төрөөс асрах үйлчилгээний талаар баримтлах бодлого, чиг үүргийг тодорхойлсон. Төр нь асрах үйлчилгээг нийгмийн хамгааллын тогтолцооны чухал бүрэлдэхүүн хэсэг гэж үзэж, үйлчилгээний хүртээмж, чанар, тогтвортой байдлыг хангах бодлого хэрэгжүүлэхээр тусгасан. Үүний зэрэгцээ төрийн үүргийг бодлого боловсруулагч, зохицуулагч, санхүүжүүлэгч, үйлчилгээ худалдан авагч, хяналт хэрэгжүүлэгч байдлаар тодорхойлж, харин үйлчилгээ үзүүлэгчдийн бие даасан үйл ажиллагаанд хуульд зааснаас бусад тохиолдолд оролцохгүй байх зарчмыг тогтоосон нь төрийн зохицуулалт болон хувийн хэвшлийн санаачилгын тэнцвэрийг хангах ач холбогдолтой юм.

Арван ес, хорь, хорин нэг, хорин хоёрдугаар зүйлд төрөөс үзүүлэх дэмжлэгийн хэлбэрүүдийг зохицуулсан. Үүнд газар, барилга, дэд бүтэц, тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлэх, төрөөс үйлчилгээ худалдан авах, санхүүгийн дэмжлэг олгох, татвар болон төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх, алслагдсан бүс нутаг болон онцгой нөхцөлд нэмэлт дэмжлэг үзүүлэх зэрэг арга хэмжээг тусгасан. Энэхүү зохицуулалтын зорилго нь асрах үйлчилгээний салбарт төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих, үйлчилгээний хүртээмжийг өргөжүүлэхэд оршино.

Хуулийн төсөл нь санхүүжилтийг зөвхөн улсын төсөвт тулгуурлах бус, олон эх үүсвэрт суурилсан тогтолцоог бий болгохоор тусгасан. Үүнд үйлчилгээ үзүүлэгчийн өөрийн хөрөнгө, улсын болон орон нутгийн төсөв, төрөөс үйлчилгээ худалдан авах санхүүжилт, үйлчилгээ авагчийн төлбөр, даатгалын санхүүжилт, олон улсын байгууллага болон хандивын эх үүсвэр зэрэг боломжит бүх эх үүсвэрийг хуульчилсан. Энэ нь төсөвт үзүүлэх ачааллыг бууруулахын зэрэгцээ салбарын урт хугацааны тогтвортой байдлыг хангах зорилготой юм.

Хорин тавдугаар зүйлд үйлчилгээний төлбөрийн тогтолцоог зохицуулсан бөгөөд төлбөрийг үйлчилгээний төрөл, хугацаа, эрчим болон үйлчилгээ авагчийн төлбөрийн чадварт үндэслэн тогтоохоор заасан. Түүнчлэн төлбөрийн чадваргүй иргэдэд төрөөс үйлчилгээ худалдан авах хэлбэрээр санхүүгийн дэмжлэг үзүүлэх боломжийг тусгасан нь нийгмийн хамгааллын зорилготой нийцэж байна. Мөн Үндэсний баялгийн сангийн хуримтлалын санд иргэний нэр дээр бүртгэгдсэн хөрөнгийг асрах үйлчилгээний төлбөрт ашиглах боломжийг нээсэн нь иргэдэд урт хугацааны асаргааны хэрэгцээгээ өөрийн хуримтлалд тулгуурлан шийдвэрлэх шинэ эрх зүйн боломжийг бүрдүүлж байна.

Хорин зургаадугаар зүйлд асрах үйлчилгээний даатгалын тогтолцоог шинээр нэвтрүүлэхээр тусгасан. Даатгал нь асрах үйлчилгээ шаардлагатай болсон үед үйлчилгээний зардлыг санхүүжүүлэх зорилготой бөгөөд эхний үе шатанд сайн дурын үндсэн дээр хэрэгжихээр зохицуулагдсан. Мөн үйлчилгээ үзүүлэгчийг мэргэжлийн хариуцлагын даатгалд хамруулах шаардлагыг тусгаснаар үйлчилгээ авагч болон үйлчилгээ үзүүлэгч талуудын эрх ашгийг хамгаалах нөхцөлийг бүрдүүлсэн. Урт хугацааны асаргааны даатгалын тогтолцоо нь Герман, Япон, Бүгд Найрамдах Солонгос Улс зэрэг орны туршлагаар үр нөлөөгөө нотолсон бөгөөд энэхүү хуулийн төсөл нь Монгол Улсад уг тогтолцоог үе шаттайгаар нэвтрүүлэх эрх зүйн суурийг бүрдүүлж байна.

Энэ бүлгүүдийн зохицуулалтын үр дүнд асрах үйлчилгээний байгууллагын тогтолцоо, хүний нөөцийн бэлтгэл, төрөөс үзүүлэх бодлого, дэмжлэг, санхүүжилтийн олон эх үүсвэрт тогтолцоо бүрдэж, төр, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын хамтын оролцоонд тулгуурласан тогтвортой хөгжлийн үндэс бий болох юм.

Хуулийн төслийн есдүгээр бүлэгт асрах үйлчилгээний үйл ажиллагаанд төрөөс тавих хяналт, хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлага болон маргаан шийдвэрлэхтэй холбоотой харилцааг зохицуулсан.

Асрах үйлчилгээ нь хүний амь нас, эрүүл мэнд, нэр төр, хувийн мэдээлэл, эд хөрөнгө зэрэг үндсэн эрх, ашиг сонирхолтой шууд холбоотой үйлчилгээ тул үйлчилгээний чанар, аюулгүй байдал, хууль тогтоомжийн хэрэгжилтэд төрөөс тогтмол хяналт тавих эрх зүйн үндсийг бүрдүүлсэн. Энэ хүрээнд төрийн хяналтыг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, улсын байцаагч болон хуульд заасан бусад эрх бүхий байгууллага хэрэгжүүлэхээр тусгасан.

Мөн асрах үйлчилгээний чанар, аюулгүй байдлын шаардлагыг ноцтой зөрчих, асруулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчих, хүчирхийлэл, үл хайхрах үйлдэл гаргах, санхүүжилтийг зориулалтын бусаар ашиглах, нууц мэдээлэлд халдах, зөвшөөрөлгүй үйлчилгээ эрхлэх, хяналт шалгалтад саад учруулах, бүртгэл тайланг хуурамчаар үйлдэх зэрэг хүний эрх болон үйлчилгээний аюулгүй байдалд ноцтой эрсдэл учруулах үйлдлийг ноцтой зөрчилд тооцож, зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох хүртэл арга хэмжээ авах боломжтой байхаар зохицуулсан.

Түүнчлэн санаатай үйлдэл, мэргэжлийн алдаа, эсхүл үл хайхрах, хайхрамжгүй хандлагын улмаас учруулсан хохирол, хор уршгийн төлөө хуульд заасан хариуцлага хүлээлгэх, гэмт хэргийн шинжтэй үйлдэлд эрүүгийн, бусад тохиолдолд зөрчлийн хариуцлага ногдуулах, учруулсан эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирлыг нөхөн төлүүлэх эрх зүйн үндсийг тогтоосон.

Маргаан үүссэн тохиолдолд талууд эхний ээлжид эвлэрүүлэн зуучлах болон үйлчилгээ үзүүлэгчийн дотоод гомдол шийдвэрлэх журмаар асуудлыг шийдвэрлэх боломжтой бөгөөд эвлэрэн шийдвэрлэж чадаагүй тохиолдолд шүүхэд хандах, хуульд зөвшөөрсөн болон арбитрын хэлэлцээр байгуулсан нөхцөлд арбитрын журмаар шийдвэрлүүлэх боломжийг нээж өгсөн.

Энэхүү бүлгийн зохицуулалт нь асруулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангах, хариуцлагын тогтолцоог тодорхой болгох, маргааныг шуурхай, үр нөлөөтэй шийдвэрлэх эрх зүйн орчныг бүрдүүлэхэд чиглэж байна.

Асрах үйлчилгээний тухай хуулийн төслийг үр нөлөөтэй хэрэгжүүлэх, холбогдох хууль тогтоомжийн уялдаа холбоог хангах зорилгоор Нийгмийн халамжийн тухай хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, Үндэсний баялгийн сангийн тухай

хууль, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль болон Асрах үйлчилгээний тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг хамт боловсруулсан.

Нийгмийн халамжийн тухай хуульд оруулах нэмэлтээр асрах үйлчилгээг нийгмийн хамгааллын тогтолцооны нэг бүрэлдэхүүн хэсэг болгон тусгаж, төлбөрийн чадваргүй иргэнийг төрөөс асрах үйлчилгээнд хамруулах эрх зүйн үндсийг бий болгож байгаа бөгөөд асрах үйлчилгээтэй холбоотой харилцааг бие даасан Асрах үйлчилгээний тухай хуулиар зохицуулахаар тусгасан.

Татварын хууль тогтоомжид оруулах нэмэлтүүдээр асрах үйлчилгээний салбарт төрөөс үзүүлэх бодлогын дэмжлэгийг хэрэгжүүлэх, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, хувийн хэвшлийн оролцоо, хөрөнгө оруулалтыг дэмжих эрх зүйн орчныг бүрдүүлэхээр тусгасан. Тухайлбал, асрах үйлчилгээний үйл ажиллагааны орлогыг татварын хөнгөлөлтөд хамруулах, асрах үйлчилгээний төв байгуулахад чиглэсэн хөрөнгө оруулалтыг дэмжих, асрах үйлчилгээг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх зохицуулалтыг тусгасан.

Үндэсний баялгийн сангийн тухай хуульд оруулах нэмэлтээр иргэний нэрийн дансанд хуримтлагдсан хөрөнгийг асрах үйлчилгээ авахтай холбоотой төлбөр, зардлыг санхүүжүүлэхэд ашиглах эрх зүйн боломжийг бүрдүүлж байгаа бөгөөд энэ нь иргэдийн урт хугацааны асаргаа, дэмжлэгийн хэрэгцээг санхүүгийн хувьд хангах шинэ эх үүсвэрийг бий болгох ач холбогдолтой.

Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд оруулах нэмэлтээр дотоодын хүний нөөц хүрэлцэхгүй тохиолдолд асрах үйлчилгээний ажилтны хэрэгцээг хөдөлмөр эрхлэлтийн бодлоготой уялдуулан шийдвэрлэх эрх зүйн үндсийг бүрдүүлэхээр тусгасан.

Мөн Асрах үйлчилгээний тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслөөр одоо үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээдүүдийг шинэ хуульд нийцүүлэх шилжилтийн хугацааг тогтоож, хуулийг хэрэгжүүлэхэд шаардлагатай дүрэм, журам, стандартыг батлах хугацааг тодорхойлсон.

Эдгээр дагалдах хуулийн төслүүд нь Асрах үйлчилгээний тухай хуулийг хэрэгжүүлэхэд шаардлагатай институцийн тогтолцоо, санхүүжилт, татварын дэмжлэг, хүний нөөц, шилжилтийн зохицуулалтыг бүрдүүлж, хуулийн хэрэгжилтийг бодитой хангах эрх зүйн цогц орчныг бий болгоход чиглэж байгаа болно.

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Асрах үйлчилгээний тухай хуулийн төсөл

Асрах үйлчилгээтэй холбоотой харилцаа нь Нийгмийн халамжийн тухай хууль болон бусад хууль тогтоомжид хэсэгчлэн тусгагдсан боловч үйлчилгээний төрөл, хэлбэр, чанар, хүний нөөц, санхүүжилт, төрийн болон хувийн хэвшлийн оролцоо, үйлчилгээ үзүүлэгч болон үйлчилгээ авагчийн эрх, үүргийг цогцоор нь зохицуулсан бие даасан эрх зүйн орчин бүрдээгүй байна.

Үүний улмаас асрах үйлчилгээний хүртээмж хангалтгүй, үйлчилгээний чанар харилцан адилгүй, хувийн хэвшил болон төрийн бус байгууллагын оролцоо сул, хүний нөөцийн тогтолцоо төлөвшөөгүй, санхүүжилтийн эх үүсвэр хязгаарлагдмал хэвээр байна. Мөн асрах үйлчилгээ шаардлагатай олон иргэн хэрэгцээндээ нийцсэн үйлчилгээ авч чадахгүй байгаа нь тэдний амьдралын чанар, эрүүл мэнд, нийгмийн оролцоонд сөргөөр нөлөөлж байна.

Дэлхийн олон улс орон хүн амын насжилт, урт хугацааны асаргааны хэрэгцээ нэмэгдэж буй нөхцөлд асрах үйлчилгээг нийгмийн хамгааллын бие даасан тогтолцоо болгон хөгжүүлж, төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн хамтын оролцоонд тулгуурласан эрх зүйн зохицуулалтыг бий болгож байна.

Иймд асрах үйлчилгээний төрөл, хэлбэр, шаардлага, үйлчилгээ үзүүлэгч болон үйлчилгээ авагчийн эрх, үүрэг, санхүүжилтийн тогтолцоо, төрөөс үзүүлэх дэмжлэг, хяналт, хариуцлагын эрх зүйн үндсийг бүрдүүлэх зорилгоор Асрах үйлчилгээний тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Асрах үйлчилгээний тухай хуулийн төсөл нь асрах үйлчилгээний эрх зүйн үндсийг тогтоож, асрах үйлчилгээний төрөл, ангилал, хэлбэр, үйлчилгээ үзүүлэхэд тавигдах шаардлага, үйлчилгээ үзүүлэгч болон үйлчилгээ авагчийн эрх, үүрэг, талуудын хамтын ажиллагаа, хүний нөөц, сургалт, санхүүжилт, төрөөс үзүүлэх дэмжлэг, хяналт, хариуцлагатай холбогдсон харилцааг цогцоор нь зохицуулахад чиглэсэн болно.

Төсөл нь нийт 10 бүлэг, 30 зүйлээс бүрдэх бөгөөд асрах үйлчилгээний нийтлэг үндэслэл, үйлчилгээний төрөл, хэлбэр, үйлчилгээ үзүүлэгч болон үйлчилгээ авагчийн эрх, үүрэг, хүний нөөц, санхүүжилт, даатгал, төрийн дэмжлэг, хяналт, хариуцлага болон бусад холбогдох харилцааг зохицуулна.

Хуулийн төсөл нь хүн амын насжилт, хөгжлийн бэрхшээл, урт хугацааны асаргаа шаардлагатай иргэдийн өсөн нэмэгдэж буй хэрэгцээнд нийцсэн асрах үйлчилгээний эрх зүйн орчныг бүрдүүлэх, асрах үйлчилгээг бие даасан нийгмийн үйлчилгээ болгон хөгжүүлэх, төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн хамтын оролцоонд тулгуурласан үндэсний тогтолцоог бий болгоход чиглэсэн болно.

Хуулийн төсөлд асрах үйлчилгээтэй холбоотой харилцааг бие даасан хуулиар цогцоор зохицуулахаар тусгасан. Асрах үйлчилгээний хамрах хүрээг зөвхөн ахмад настангаар хязгаарлахгүйгээр өдөр тутмын амьдралын үйл ажиллагааг бие даан гүйцэтгэх боломж нь хязгаарлагдсан, бусдын тусламж, дэмжлэг шаардлагатай бүх хүнд хэрэгцээнд нь тулгуурлан үйлчилгээ үзүүлэхээр тогтоосон. Түүнчлэн асрах үйлчилгээг өдөр тутмын ахуйн асаргаа, сэргээн засах асрах үйлчилгээ, хүний эрх болон нийгмийн оролцоог дэмжих үйлчилгээ гэсэн төрөлтэй байхаар, мөн гэрээр, байгууллагад, явуулын болон өдрийн үйлчилгээний хэлбэрээр зохион байгуулахаар зохицуулсан.

Хуулийн төсөлд асрах үйлчилгээг тусгай нөхцөл, шаардлагыг хангасан этгээд эрхлэхээр тогтоож, төр, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн оролцоог дэмжих эрх зүйн орчныг бүрдүүлсэн. Мөн төрөөс үйлчилгээ худалдан авах, татварын болон төлбөрийн дэмжлэг үзүүлэх, сайн дурын даатгалын тогтолцоог хөгжүүлэх зэрэг олон эх үүсвэрт санхүүжилтийн механизмыг тусгасан.

Түүнчлэн хүний эрхийг дээдлэх, асруулагчийн хүсэл, сонголтыг хүндэтгэх, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангах, ил тод, хариуцлагатай байх, ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллах зэрэг асрах үйлчилгээний суурь зарчмуудыг тусгасан болно.

Асрах үйлчилгээтэй холбоотой харилцааг Монгол Улсад өнөөг хүртэл бие даасан, тусгайлсан хуулиар зохицуулаагүй байна. Одоогийн байдлаар энэхүү харилцааг Нийгмийн халамжийн тухай хууль болон бусад салбарын хууль тогтоомжийн хүрээнд хэсэгчлэн зохицуулж байгаа бөгөөд асрах үйлчилгээ нь нийгмийн халамжийн үйлчилгээний нэг бүрэлдэхүүн хэсэг байдлаар тусгагдсан байдаг.

Монгол Улс 2012 онд Нийгмийн халамжийн тухай хуулийг баталж, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ болон төрөлжсөн асрамжийн үйлчилгээг эрх зүйн хүрээнд зохицуулсан нь тухайн үеийн нөхцөлд чухал ахиц болсон. Уг хуулиар ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд зэрэг зорилтот бүлэгт үзүүлэх асрамжийн үйлчилгээний үндсийг тодорхойлсон.

Улсын Их Хурлын даргын 2024 оны 9 дүгээр сарын 5-ны өдрийн 100 дугаар захирамжаар асрах үйлчилгээний эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр судалж, санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан ажилласан.

Хуулийн төслийг боловсруулахдаа Хууль тогтоомжийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгаа, мөн хуулийн 17 дугаар зүйлд заасан хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээг тус тус хийж гүйцэтгэсэн. Судалгааны хүрээнд асрах үйлчилгээний өнөөгийн эрх зүйн зохицуулалт, хэрэгжилт, тулгамдсан асуудал, олон улсын туршлага болон зохицуулалтын боломжит хувилбаруудыг судлан шинжилсэн болно.

Түүнчлэн хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулж, уг төсөлтэй хамт Нийгмийн халамжийн тухай хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, Үндэсний баялгийн сангийн тухай хууль, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт оруулах болон Асрах үйлчилгээний тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг тус тус боловсруулсан.

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу олон нийтийн хэлэлцүүлэгт оруулж, төрийн байгууллага, мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллага, эрдэмтэн, судлаачид болон иргэдээс санал авч хэлэлцүүлсэн. Ирүүлсэн санал, зөвлөмжийг ажлын хэсэг нэг бүрчлэн судалж, үндэслэл бүхий саналуудыг хуулийн төсөлд тусган боловсруулсан болно.

Улсын Их Хурлын Тамгын газрын дэргэдэх Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэн 2024 онд гадаад улсын асрах, асрамжийн үйлчилгээний эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа хийсэн бөгөөд уг судалгаагаар Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс, Их Британи, Япон Улсын төрөлжсөн асрамжийн үйлчилгээний зохицуулалтыг судалсан.

Судалгааны үр дүнгээс үзэхэд хүн амын насжилт нэмэгдэж буй улс орнууд урт хугацааны асаргааны үйлчилгээг нийгмийн хамгааллын тогтолцооны бие даасан, чухал бүрэлдэхүүн хэсэг болгон хөгжүүлж байна. Ялангуяа Герман, Япон, Бүгд Найрамдах Солонгос Улс зэрэг орнууд урт хугацааны асаргааны үйлчилгээний эрх зүйн орчныг тусгай хуулиар зохицуулж, даатгал, санхүүжилт, үйлчилгээний чанар, хүний нөөц, хяналтын тогтолцоог цогцоор нь бүрдүүлсэн байна.

Хуулийн төслийг боловсруулахдаа УИХ-ын Тамгын газрын дэргэдэх Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн хийсэн харьцуулсан судалгаа, Азийн сангийн 2024 оны “Асрахуйн эдийн засаг” судалгаа, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний комиссын ахмад настны эрхийн талаарх судалгаа болон бусад холбогдох эх сурвалжийг ашигласан.

Судалгаануудын дүнгээс харахад Монгол Улсад асрах үйлчилгээний хэрэгцээ өсөн нэмэгдэж байгаа боловч эрх зүйн зохицуулалт, санхүүжилт, үйлчилгээний хүртээмж, хүний нөөцийн тогтолцоо хангалттай хөгжөөгүй байна. Мөн асрахуйн хөдөлмөрийн ачаалал өрх гэр, ялангуяа эмэгтэйчүүдэд төвлөрч байгаа нь хөдөлмөр эрхлэлт, эдийн засгийн оролцоонд сөргөөр нөлөөлж байна.

Азийн хөгжлийн банкны тооцооллоор өрх гэр болон хөдөлмөрийн зах зээл дэх жендэрийн тэгш бус байдлыг бууруулж, асрахуйн эдийн засгийг хөгжүүлснээр эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоог нэмэгдүүлж, Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг дэмжих боломжтой гэж үзсэн байна. Иймээс асрах үйлчилгээг бие даасан эрх зүйн зохицуулалттай болгон хөгжүүлэх нь зөвхөн нийгмийн хамгааллын төдийгүй хүний хөгжил, хөдөлмөр эрхлэлт, эдийн засгийн өсөлтийн бодлоготой шууд холбоотой ач холбогдолтой гэж үзэж байна.

Хуулийн төсөл батлагдсанаар асрах үйлчилгээний эрх зүйн орчин анх удаа бие даасан хуулиар бүрдэж, үйлчилгээний төрөл, хэлбэр, шаардлага, хүний нөөц, санхүүжилт, хяналт, хариуцлагын нэгдсэн тогтолцоо бий болно.

Мөн асрах үйлчилгээний хүртээмж, чанар сайжирч, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхэд болон бусдын тусламж, дэмжлэг шаардлагатай иргэд хэрэгцээндээ нийцсэн үйлчилгээ авах боломж өргөжих юм. Түүнчлэн төр, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын хамтын ажиллагаа хөгжиж, асрах үйлчилгээний салбарт хөрөнгө оруулалт, шинэ үйлчилгээ, мэргэшсэн хүний нөөц бий болох эрх зүйн үндэс бүрдэнэ.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

АСРАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь асрах үйлчилгээний эрх зүйн үндсийг тогтоож, үйлчилгээний төрөл, хэлбэр, шаардлага, үйлчилгээ үзүүлэгч болон асруулагчийн эрх, үүрэг, санхүүжилт, төрийн дэмжлэг, зохицуулалт, хяналттай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Асрах үйлчилгээний хууль тогтоомж

2.1.Асрах үйлчилгээний тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хуулийн үйлчлэл нь бие даан амьдрах, нийгмийн харилцаанд оролцоход хүндрэлтэй, бусдын туслалцаа, дэмжлэг шаардлагатай хүнд үзүүлэх асрах үйлчилгээтэй холбогдсон харилцаанд хамаарна.

3.2.Асрах үйлчилгээнд дараах хүн хамрагдана:

3.2.1.өндөр насжилт, архаг өвчин болон өвчний хүндрэлээс шалтгаалан өдөр тутмын амьдралын үйл ажиллагааг бие даан гүйцэтгэх боломжгүй болсон хүн;

3.2.2.хөгжлийн бэрхшээлээс шалтгаалан ахуйн болон нөхөн сэргээх асаргаа, байнгын асаргаа, дэмжлэг шаардлагатай хүн;

3.2.3.тодорхой хугацаанд асаргаа, нөхөн сэргээх дэмжлэг, хүний эрхийн хамгаалал, нийгмийн оролцоог хангах зэрэг хосолсон үйлчилгээ шаардлагатай хүн;

3.2.4.жирэмсний болон төрсний дараах үед ахуйн асаргаа, сэргээн засах асаргаа шаардлагатай эх, нярай;

3.2.5.дэмжлэг, асрамж, хамгаалал шаардлагатай насанд хүрээгүй хүн.

4 дүгээр зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“асрах үйлчилгээ” гэж асаргаа шаардлагатай хүнд орон байр, хоол хүнс, хувцас, ахуй, сувилахуйн болон бие бялдар, нийгэм, сэтгэл зүйн хэрэгцээг хангах, тэдний амьдралын хэвийн нөхцөлийг бүрдүүлэх зорилготой дэмжлэг, үйлчилгээг;

4.1.2.“асрах үйлчилгээний ажилтан” гэж асрах үйлчилгээ үзүүлэх чиглэлээр зохих сургалт, мэргэшил эзэмшсэн хүнийг;

4.1.3.“асруулагч” гэж өндөр насжилт, хөгжлийн бэрхшээл, архаг өвчин, танин мэдэхүйн хомсдол болон бусад шалтгааны улмаас өдөр тутмын амьдралын үйл ажиллагааг урт хугацаанд бие даан гүйцэтгэх боломжгүй, асрах үйлчилгээ шаардлагатай хүнийг;

4.1.4.“ахмад настан” гэж Ахмад настны тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан хүнийг;

4.1.5.“өдөр тутмын ахуйн асаргаа” гэж өндөр насжилт, архаг өвчин, хөгжлийн бэрхшээл болон бусад шалтгааны улмаас өдөр тутмын амьдралын үйл ажиллагааг бие даан гүйцэтгэх боломжгүй хүнд ахуйн хэрэгцээ, бие бялдар, сэтгэл зүй, орон байр, хоол тэжээл, хөдөлгөөн болон орчны дэмжлэгийг цогцоор нь үзүүлэх үйлчилгээг;

4.1.6.“сэргээн засах асрах үйлчилгээ” гэж өндөр насжилт, өвчин, гэмтэл, хөгжлийн бэрхшээлийн улмаас алдагдсан бие бялдар, хөдөлгөөн, танин мэдэхүй, сэтгэл зүйн чадварыг сэргээх, хадгалах, сайжруулах зорилгоор асаргаа, сувилахуйн болон сэргээн засах дэмжлэгийг цогцоор нь үзүүлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй уялдсан асрах үйлчилгээг;

4.1.7.“түр асаргаа” гэж асруулагчид тодорхой хугацаанд мэргэжлийн орчинд асаргаа үзүүлэх замаар асран хамгаалагч, гэр бүлийн гишүүдэд амралт олгох зорилготой асрах үйлчилгээг ойлгоно;

4.1.8.“үйлчилгээ үзүүлэгч этгээд” гэж тусгай зөвшөөрлийн үндсэн дээр асрах үйлчилгээний төрөл, ангилалд нийцсэн стандарт, хүний нөөц, тоног төхөөрөмжийн шаардлагыг хангасан, асрах үйлчилгээ үзүүлж байгаа иргэн, хуулийн этгээдийг;

4.1.9.“хөгжлийн бэрхшээлтэй хүн” гэж Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 4.1.1-д заасан хүнийг;

4.1.10.“хувилбарт асрах үйлчилгээ” гэж асруулагчийн хэрэгцээ, эрсдэлийн үнэлгээ, бие даах чадварын түвшинд үндэслэн гэрээр, байгууллагад байршуулан, өдрийн үйлчилгээний төвөөр, эсхүл хөдөлгөөнт хэлбэрээр үзүүлэх асрах үйлчилгээний хэлбэрийг;

4.1.11.“хувилбарт асрах үйлчилгээний төв” гэж энэ хуулийн 4.1.1-д заасан асрах үйлчилгээг үзүүлэх зорилгоор байгуулагдсан, хуульд заасан нөхцөл, шаардлагыг хангасан, уг үйлчилгээг тасралтгүй, түр, өдрөөр, цагаар болон хөдөлгөөнт хэлбэрээр зохион байгуулан хэрэгжүүлэх байгууллагыг;

4.1.12.“хүний эрх, нийгмийн оролцооны дэмжлэг” гэж асруулагчийн нэр төр, эрх, өмч, санхүүгийн аюулгүй байдлыг хамгаалах, нийгмийн харилцаа, соёл, мэдээллийн хүртээмжийг хангах, оролцоог дэмжих, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн эрхийг сэргээх, хохирлыг арилгах зорилготой үйлчилгээний цогц арга хэмжээг;

4.1.13.“эрсдэлийн үнэлгээ” гэж асруулагчийн бие бялдар, сэтгэл зүй, санхүү, эрхийн эрсдэлийг тодорхойлж, шаардлагатай анхаарал, тусламжийн түвшинг тогтоох зорилготой үнэлгээг.

5 дугаар зүйл.Асрах үйлчилгээнд баримтлах зарчим

5.1.Асрах үйлчилгээнд дараах зарчмыг баримтална:

5.1.1.асруулагчийн амь нас, аюулгүй байдлыг хангах, нэр, нэр төр, эрх, эрх чөлөөг хүндэтгэх;

5.1.2.асруулагчийн хувийн мэдээлэл, нууцлалыг хамгаалах, ялгаварлан гадуурхахгүй, тэгш хүртээмжтэй байх;

5.1.3.асруулагчийн хүсэл, сонголт, оролцоог хүндэтгэх;

5.1.4.асрах үйлчилгээний хүртээмжийг хангах;

5.1.5.асрах үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангах;

5.1.6.асрах үйлчилгээний ил тод, хариуцлагатай байдлыг хангах;

5.1.7.Асрах үйлчилгээний салбарт хувийн хэвшлийн оролцоог дэмжих;

5.1.8.Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлж, түүнээс ангид байх.

ХОЁРДУГААР БҮЛЭГ АСРАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨРӨЛ, АНГИЛАЛ, ХЭЛБЭР

6 дугаар зүйл.Асрах үйлчилгээний төрөл

6.1.Асрах үйлчилгээ нь дараах төрлөөс бүрдэнэ:

6.1.1.өдөр тутмын ахуйн асаргаа;

6.1.2.сэргээн засах асрах үйлчилгээ;

6.1.3.хүний эрх ба нийгмийн оролцооны дэмжлэг;

6.2.Өдөр тутмын ахуйн асаргаа нь асруулагчийн хооллолт, хөдөлгөөн, хувийн ариун цэвэр, харилцаа, орчны хүртээмж, өдөр тутмын амьдралын зохион байгуулалт зэрэг үйл ажиллагааг бие даан гүйцэтгэх боломжийг нэмэгдүүлэхэд чиглэнэ.

6.3.Сэргээн засах асрах үйлчилгээ нь асруулагчийн бие бялдар, хөдөлгөөн, танин мэдэхүйн чадвар, сэтгэл зүйн байдлыг сайжруулах, хадгалах, амьдралын чанарыг дээшлүүлэх зорилгоор сэргээн засах дэмжлэг, сувилахуйн асаргаа, эмийн хэрэглээнд дэмжлэг үзүүлэхэд чиглэнэ.

6.4. Хүний эрх, нийгмийн оролцооны дэмжлэг нь асруулагчийн нэр төр, эрх, өмч, санхүүгийн аюулгүй байдлыг хамгаалах, нийгмийн харилцаа, соёл, мэдээллийн

хүртээмжийг хангах, оролцоог дэмжих, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирлыг арилгах үйлчилгээний цогц арга хэмжээг хамарна.

6.5.Хувилбарт асрах үйлчилгээ нь тусад нь болон хосолмол хэлбэрээр хэрэгжиж болно.

7 дугаар зүйл. Асрах үйлчилгээний ангилал

7.1.Асрах үйлчилгээ нь асруулагч хүний хэрэгцээ, бие даах чадварын түвшин, эрсдэлийн үнэлгээнд үндэслэн дараах хугацааны ангилалтай байна.

- 7.1.1.цагийн болон өдрийн үйлчилгээ;
- 7.1.2.түр асрах үйлчилгээ /30 хүртэл хоног/;
- 7.1.3.богино хугацааны үйлчилгээ /1–6 сар/;
- 7.1.4.урт хугацааны үйлчилгээ /6 сараас дээш/.

7.2.Асруулагчийн хэрэгцээ, шаардлага, сонголтоос хамаарч асрах үйлчилгээ нь дараах хэлбэртэй байна:

- 7.2.1.гэрээр үзүүлэх үйлчилгээ;
- 7.2.2.байгууллагад байршуулан үзүүлэх үйлчилгээ;
- 7.2.3.явуулын буюу хөдөлгөөнт үйлчилгээ;
- 7.2.4.өдрийн үйлчилгээ.

7.3.Энэ хуулийн 7.1-д заасан асрах үйлчилгээг асруулагчийн гэрт, явуулын буюу хөдөлгөөнт хэлбэрээр, эсхүл байгууллагад байршуулан үзүүлж болно.

7.4.Гэрийн үйлчилгээг асаргааны мэргэжилтэн болон дэмжлэг үзүүлэх баг асруулагчийн оршин суугаа газарт очиж үзүүлнэ.

7.5.Байгууллагад байршуулан үзүүлэх үйлчилгээг хувилбарт асрах үйлчилгээний төв, асрах үйлчилгээний төв, сэргээн засах асрах төв болон хуульд заасан шаардлага хангасан байгууллагад тогтоосон стандартын дагуу үзүүлнэ.

7.6.Явуулын буюу хөдөлгөөнт үйлчилгээг алслагдсан болон хүртээмжгүй бүсэд асаргааны хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор тухайн засаг захиргааны нэгжийн оролцоотойгоор хөдөлгөөнт баг, асаргааны мэргэжилтнээр дамжуулан асруулагчийн гэрт, эсхүл шаардлага хангасан түр төв, түр байранд үзүүлнэ.

7.7.Өдрийн үйлчилгээг асруулагчийг хонуулахгүйгээр тухайн өдөрт багтаан үйлчилгээ үзүүлнэ.

7.8.Төрөөс үзүүлэх хувилбарт асрах үйлчилгээ, хувийн хэвшлээс худалдан авах үйлчилгээний зардлыг тооцох, хөнгөлөлт, дэмжлэг олгох, даатгалын сангаас санхүүжүүлэх журмыг Засгийн газар батална.

7.9.Хувилбарт асрах үйлчилгээ нь энэ хуулийн заасан үндсэн шаардлагыг хангасан байх бөгөөд үйлчилгээний нөхцөл, шаардлагыг Нийгмийн халамж болон Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

ГУРАВДУГААР БҮЛЭГ АСРАХ ҮЙЛЧИЛГЭЭНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

8 дугаар зүйл.Асрах үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлага

8.1.Асрах үйлчилгээ нь дараах нийтлэг шаардлагыг хангасан байна:

8.1.1.хүний эрх, нэр төр, хувийн нууц, мэдээллийн нууцлалыг хамгаалсан байх;

8.1.2.эрүүл мэндийн дэмжлэг, халдвар хамгаалал, эмийн хяналтын шаардлагыг ханган ажиллах;

8.1.3.аюулгүй хүнс, зохистой хоол тэжээлээр хангах нөхцөлийг бүрдүүлсэн байх;

8.1.4.сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, ялгаварлан гадуурхахгүй байх;

8.1.5.хөдөлгөөн засал, хөдөлмөр засал, сэргээн засах үйлчилгээ болон орчны тохируулгатай байх;

8.1.6.гамшиг, осол, аюулаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийн үнэлгээ хийсэн байх;

8.1.7.үйлчилгээний баримтжуулалт, үйл ажиллагааны бүртгэл, хөтлөлтийг тогтмол хийдэг байх;

8.1.8.хүний нөөцийн чадавх бэхжүүлэх хөтөлбөр, дотоод хяналтын тогтолцоо, ажилтнуудтай ёс зүйн хариуцлагын гэрээ байгуулсан байх;

8.1.9.хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, мэдээлэх тогтолцоотой байх;

8.1.10.асруулагчийг шаардлагатай тохиолдолд эрүүл мэндийн байгууллагад шуурхай шилжүүлэх зохицуулалттай байх;

8.1.11.асруулагчийн эрх ашиг, хэрэгцээ шаардлагад нийцсэн байх;

8.1.12.хувилбарт асрах үйлчилгээ нь асаргааны мэргэжилтэн, асрах үйлчилгээ үзүүлэгч байгууллага, асруулагч болон түүний хууль ёсны төлөөлөгчийн хоорондын зөвшилцөл, хамтын хариуцлагад тулгуурласан, нээлттэй, уян хатан байх.

8.2.Асрах үйлчилгээнд хамруулах хүнийг үнэлэх, үйлчилгээний төрлийг сонгох, өөрчлөх, шилжүүлэх журмыг нийгмийн халамж болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

9 дүгээр зүйл.Асрах үйлчилгээнд тавигдах тусгай шаардлага

9.1.Гэрийн үйлчилгээ нь дараах тусгай шаардлагыг хангасан байна:

9.1.1.үйлчилгээ үзүүлэгч болон асруулагч, эсхүл түүний хууль ёсны төлөөлөгчийн хооронд гэрээ байгуулж, эрсдэлийн үнэлгээ, эрсдлээс сэргийлэх хариу арга хэмжээний баримт бичгийг үйлдсэн байх;

9.1.2.асруулагчийн хууль ёсны төлөөлөгч болон гэр бүлийн гишүүдийн оролцоо, үүргийг тодорхойлсон байх;

9.1.3.үйлчилгээ үзүүлэх хугацаанд асаргааны мэргэжилтний үйлчилгээ үзүүлэх оролцоог хангасан байх;

9.1.4.эрүүл мэндийн болон мэргэжлийн байгууллагатай тогтмол хамтын ажиллагаа, холбоо харилцаатай байх;

9.1.5.үйлчилгээний баримтжуулалт, эрсдэлийн тэмдэглэл зэргийг нэгдсэн мэдээллийн системд бүртгэсэн байх.

9.2.Байгууллагад байршуулан үзүүлэх үйлчилгээ нь дараахь тусгай шаардлагыг хангасан байна:

9.2.1.галын аюулгүй байдлын тухай хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан, холбогдох эрх бүхий байгууллагын дүгнэлттэй байх;

9.2.2.асруулагчийн хувийн орон зай, нууцлалыг хангах дотоод зохион байгуулалттай байх;

9.2.3.сэргээн засах, хоол тэжээл, эрсдэлийн үнэлгээг хариуцах мэргэжлийн баг, мэргэжилтэнтэй байх;

9.2.4.төлбөр, хандив, үйлчилгээний санхүүжилтийн ил тод байдлыг хангасан байх;

9.2.5.ахмад настны эрүүл мэндийг хамгаалах, дэмжих хөтөлбөртэй байх;

9.2.6.хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн оролцоог дэмжих хөтөлбөртэй байх.

9.3.Явуулын буюу хөдөлгөөнт үйлчилгээ нь дараахь тусгай шаардлагыг хангасан байна:

9.3.1.үйлчилгээний орчинд халдвар хамгаалал, галын болон цахилгааны аюулгүй байдлыг шуурхай үнэлэх аргачлалтай байх;

9.3.2.яаралтай тусламж шаардлагатай тохиолдолд асруулагчийг холбогдох байгууллагад нэн даруй шилжүүлэх зохицуулалттай байх;

9.3.3.алслагдсан, хүн амын нягтрал багатай бүсэд чиглэсэн хүртээмжийг хангах зорилгоор тухайн засаг захиргааны байгууллагатай хамтран ажиллах;

9.3.4.мэргэжлийн хүний нөөцийн тогтмол хангалт, давтан сургалтын төлөвлөгөөтэй байх;

9.3.5.түр байр, хөдөлгөөнт нэгжийн орчныг тогтмол үнэлж, аливаа ослоос сэргийлэх, халдвар хамгааллын шаардлагыг хангасан аюулгүй ажиллагаа, эрсдэлийн хяналттай байх.

9.4.Өдөр өнжүүлэх үзүүлэх үйлчилгээ нь дараах тусгай шаардлагыг хангасан байна:

9.4.1.өдрийн үйлчилгээг асруулагчийн санал, хүсэлтэд нийцүүлэн уян хатан зохион байгуулах;

9.4.2.асруулагчийг хонуулахгүйгээр үйлчилгээ үзүүлэх;

9.4.3.хоол хүнс, эрүүл мэндийн дэмжлэг, сэтгэл зүй, нийгмийн оролцооны хөтөлбөрийг өдрийн багц үйлчилгээ хэлбэрээр хэрэгжүүлдэг байх;

9.4.4.ахмад настны идэвхтэй насжилтыг дэмжих хөтөлбөртэй байх;

9.4.5.хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн оролцоог дэмжих хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлдэг байх.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ АСРУУЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

10 дугаар зүйл.Асруулагчийн эрх, үүрэг

10.1.Асруулагч, түүний хууль ёсны төлөөлөгч нь асрах үйлчилгээ авахдаа дараах эрх эдэлнэ:

10.1.1.үйлчилгээний төрөл, ангилал, хэлбэр, үйлчилгээ үзүүлэгчийг чөлөөтэй сонгох;

10.1.2.амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлаа хамгаалуулах;

10.1.3.хүчирхийлэл, үл хайхрал, ялгаварлан гадуурхалтаас ангид байх, хамгаалалтад хамрагдах;

10.1.4.асрах үйлчилгээний талаар үнэн зөв, бүрэн мэдээлэл авах;

10.1.5.өөрт тохирсон асаргааны төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэхэд оролцох;

10.1.6.хувийн мэдээлэл, нууцлалаа хамгаалуулах;

10.1.7.нэр төр, эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хүндэтгүүлэх;

10.1.8.үйлчилгээний чанар, аюулгүй байдлын шаардлага хангасан үйлчилгээ авах;

10.1.9.шаардлагатай тохиолдолд үйлчилгээ үзүүлэгчийг солих, үйлчилгээ авахаас татгалзах;

10.1.10.эрх бүхий байгууллагад гомдол гаргаж, шийдвэрлүүлэх.

10.2.Асруулагч, түүний хууль ёсны төлөөлөгч нь асрах үйлчилгээ авахдаа дараах үүрэг хүлээнэ:

10.2.1.эрүүл мэндийн байдал, эмийн хэрэглээ, харшил, өвчний түүх, халдварт шинж тэмдэг, эмчилгээний зааврын талаарх мэдээллийг үнэн зөв, бүрэн мэдүүлэх;

10.2.2.асрах үйлчилгээ үзүүлэгч болон асаргааны мэргэжилтэнтэй хамтран ажиллах, шаардлагатай мэдээлэл, дэмжлэг үзүүлэх;

10.2.3.үйлчилгээний аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэмийг мөрдөх;

10.2.4.үйлчилгээний явц, эмийн хэрэглээ, хоол тэжээлийн талаар мэргэжлийн ажилтны өгсөн зааварыг дагаж мөрдөх;

10.2.5.бусдын нэр төр, тайван амьдрах орчин, сэтгэл зүйн амгалан тайван байдлыг алдагдуулах, саад, хохирол учруулахгүй байх;

10.2.6.байгууллагын өмч, үйлчилгээний тоног төхөөрөмжийг эвдэх, зориудаар гэмтээх, буруу хэрэглэхээс зайлсхийх;

10.2.7.хүчирхийлэл, үл хайхрал, ялгаварлал, эрсдэлийн нөхцөл илэрсэн тохиолдолд нэн даруй мэдээлэх;

10.2.8.халдварт өвчний шинж тэмдэг илэрсэн, эмчилгээ хэвийн бус болсон нөхцөлд шуурхай мэдээлэх;

10.2.9.төлбөртэй үйлчилгээний төлбөрийг гэрээний дагуу төлөх.

ТАВДУГААР БҮЛЭГ

АСРАХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

11 дүгээр зүйл.Асрах үйлчилгээ үзүүлэгчийн эрх, үүрэг

11.1.Асрах үйлчилгээ үзүүлэгч байгууллага, асаргааны мэргэжилтэн нь дараах эрх эдэлнэ:

11.1.1.үйлчилгээ үзүүлэх нөхцөл, стандарт, дотоод журам, дэглэмийг тогтоож мөрдүүлэх;

11.1.2.гэрээний нөхцөл, үйлчилгээний журам, аюулгүй ажиллагааны шаардлагыг удаа дараа ноцтой зөрчсөн тохиолдолд үйлчилгээ үзүүлэх гэрээг цуцлах;

11.1.3.асруулагч болон түүний хууль ёсны төлөөлөгчөөс асаргаанд шаардлагатай мэдээллийг хуульд заасан хүрээнд шаардах;

11.1.4.үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангах зорилгоор асруулагч, түүний хууль ёсны төлөөлөгчөөс хамтын ажиллагаа, дэмжлэг шаардах;

11.1.5.үзүүлсэн үйлчилгээний төлбөрийг гэрээний дагуу авах;

11.1.6.асаргааны үйл ажиллагааг хэвийн явуулахад саад учруулсан, аюултай нөхцөл үүссэн тохиолдолд холбогдох байгууллагад хандах, хамгаалалт авах.

11.2.Асрах үйлчилгээ үзүүлэгч нь дараах үүрэг хүлээнэ:

11.2.1.асруулагчийн амь нас, аюулгүй байдал, нэр төр, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэн хамгаалах;

11.2.2.асрах үйлчилгээг хууль тогтоомж, стандарт, журмын дагуу чанартай, тасралтгүй, хүртээмжтэй үзүүлэх;

11.2.3.асруулагчийн хувийн мэдээлэл, нууцлалыг хамгаалах;
11.2.4.асруулагчийн эрүүл мэндийн байдалд тогтмол хяналт тавьж, шаардлагатай тохиолдолд холбогдох байгууллагад шилжүүлэх;

11.2.5.үйлчилгээний явц, асаргааны төлөвлөгөө, эрсдэлийн үнэлгээ, баримтжуулалтыг тогтмол, үнэн зөв хөтлөх;

11.2.6.асруулагч, түүний хууль ёсны төлөөлөгчид үйлчилгээний талаар үнэн зөв, бүрэн мэдээлэл өгөх;

11.2.7.хүчирхийлэл, үл хайхрал, ялгаварлал илэрсэн тохиолдолд холбогдох байгууллагад мэдээлэх;

11.2.8.ажилтнуудын мэргэжлийн ур чадварыг тасралтгүй дээшлүүлэх, ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлэх;

11.2.9.халдвар хамгаалал, аюулгүй ажиллагааны дэглэмийг чанд мөрдөх;

11.2.10.үйлчилгээ үзүүлэх явцад учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, хариу арга хэмжээ авах тогтолцоог бүрдүүлж ажиллах;

11.2.11.үйлчилгээ үзүүлэгч нь үйлчилгээний үнийн бодлогыг шударга ёс, хүмүүнлэг зарчимд нийцүүлэн үйлчилгээний өртөг, чанар, хүртээмж болон үйлчилгээ авагчийн эрх ашгийг харгалзан тогтоох;

11.2.12.асрах үйлчилгээ үзүүлэгч нь асруулагчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд шууд эрсдэл учирсан нөхцөл байдлыг мэдсэн даруйд шаардлагатай арга хэмжээ авч, холбогдох байгууллага болон хууль ёсны төлөөлөгчид мэдэгдэх үүрэгтэй.

12 дугаар зүйл.Үйлчилгээ үзүүлэгчийн хууль зүйн баталгаа

12.1.Асруулагч, эсхүл түүний хууль ёсны төлөөлөгчөөс асрах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай мэдээллийг санаатайгаар худал, ташаа, дутуу өгсөн, эсхүл өвчний болон эмчилгээний түүхийг нуун дарагдуулснаас үүдэн бий болсон хор уршгийн төлөө асаргаа үзүүлэгч хариуцлага хүлээхгүй.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ АСРАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ БАЙГУУЛАХ НӨХЦӨЛ, ШААРДЛАГА, УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

13 дугаар зүйл.Асрах үйлчилгээний төв байгуулах эрх

13.1.Иргэн, хуулийн этгээд нь хуульд заасан нөхцөл, шаардлагыг хангасан тохиолдолд асрах үйлчилгээний төв байгуулж, тусгай зөвшөөрлийн үндсэн дээр асрах үйлчилгээ эрхэлнэ.

13.2.Асрах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нөхцөл, шаардлагыг Нийгмийн халамж болон Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

13.3.Асрах үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох харилцааг Зөвшөөрлийн тухай хуулиар зохицуулна.

14 дүгээр зүйл.Асрах үйлчилгээний төвийн барилга, орчны шаардлага

14.1.Асрах үйлчилгээний төвийн барилга байгууламж, орчин нь барилга, галын аюулгүй байдал, эрүүл ахуй, халдвар хамгаалал, хөгжлийн бэрхшээлтэй хүний хүртээмжийн талаар хууль тогтоомж болон холбогдох стандартад нийцсэн байна.

14.2.Асрах үйлчилгээний төвийн барилга, орчинд тавигдах нарийвчилсан нөхцөл, шаардлага, стандартыг Нийгмийн халамж болон Барилга, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

15 дугаар зүйл.Удирдлага, зохион байгуулалт

15.1.Асрах үйлчилгээний төвийн удирдлага, зохион байгуулалт нь хүний эрхийг дээдэлсэн, аюулгүй байдал, үйлчилгээний чанар, хүртээмж, тасралтгүй ажиллагааг хангахад чиглэсэн байна.

15.2.Асрах үйлчилгээний төв нь нээлттэй, ил тод, хариуцлагатай удирдлагын тогтолцоотой байна.

15.3.Асрах үйлчилгээг төр, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн оролцоотойгоор дангаар болон хамтран хэрэгжүүлж болно.

15.4.Асрах үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээд нь хууль тогтоомжид заасны дагуу холбоо, мэргэжлийн нэгдсэн холбоо байгуулж болно.

15.5.Асрах үйлчилгээний төв нь жил бүр үйлчилгээний чанар, хүний эрхийн хэрэгжилт, санхүүжилтийн товч тайланг олон нийтэд нээлттэйгээр мэдээлнэ.

16 дугаар зүйл.Хүний нөөц

16.1.Асрах үйлчилгээний хүний нөөц нь үйлчилгээний төрөл, эрсдэлийн түвшин, асруулагчийн хэрэгцээнд нийцсэн мэргэжлийн мэдлэг, ур чадвар, чадавхтай байна.

16.2.Асрах үйлчилгээний хүний нөөц нь өдөр тутмын ахуйн асрах үйлчилгээ болон сэргээн засах асрах үйлчилгээний онцлогт нийцсэн мэргэжлийн чиглэл, ур чадвар, шаардлагын дагуу бүрдсэн байна.

17 дугаар зүйл.Асрах үйлчилгээний сургалт

17.1.Асаргааны мэргэжилтэн, асрах үйлчилгээний ажилтны сургалтын агуулга, үргэлжлэх хугацаа, үнэлгээний шалгуур, гэрчилгээ олгох журмыг Боловсрол, эрүүл мэнд болон Нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

17.2.Асрах үйлчилгээний ажилтан нь батлагдсан хөтөлбөрийн дагуу сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсны үндсэн дээр асрах үйлчилгээ үзүүлнэ.

ДОЛООДУГААР БҮЛЭГ АСРАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТЛАХ БОДЛОГО, ДЭМЖЛЭГ

18 дугаар зүйл.Төрөөс баримтлах бодлого, чиг үүрэг

18.1.Төр нь асрах үйлчилгээг нийгмийн зайлшгүй шаардлагатай мэргэжлийн үйлчилгээ гэж үзэж, түүний хүртээмж, чанар, тогтвортой байдлыг хангахад чиглэсэн бодлого хэрэгжүүлнэ.

18.2.Төрөөс асрах үйлчилгээг дэмжихдээ үйлчилгээ худалдан авах, санхүүжилт, хөрөнгө оруулалт, дэд бүтэц, үйл ажиллагааны болон бусад дэмжлэг үзүүлж болно.

18.3.Асрах үйлчилгээг хөгжүүлэх арга хэмжээг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгаж, шаардлагатай хөрөнгийг улсын төсөвт тусган хэрэгжүүлнэ.

18.4.Төр нь асрах үйлчилгээг хөгжүүлэх зорилгоор хөрөнгө оруулалт, хөгжлийн зээл, санхүүгийн үйлчилгээ, зээлийн хөнгөлөлт болон бусад дэмжлэгийн арга хэмжээг хэрэгжүүлж болно.

18.5.Төр нь асрах үйлчилгээний талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

18.5.1.асрах үйлчилгээний бодлого, стандарт, нөхцөл, шаардлагыг тогтоох;

18.5.2.үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл, магадлан итгэмжлэлтэй холбоотой үйл ажиллагааг зохион байгуулах;

18.5.3.асрах үйлчилгээнд хамруулах, хэрэгцээ, нөхцөл байдлыг үнэлэх нэгдсэн журмыг батлах;

18.5.4.үйлчилгээний чанар, хүний эрх, аюулгүй байдалд хяналт тавих;

18.5.5.төрийн худалдан авалт, санхүүгийн дэмжлэгийн бодлогыг хэрэгжүүлэх.

18.6.Төр нь асрах үйлчилгээ үзүүлэгчийн бие даасан үйл ажиллагаанд хуульд зааснаас бусад үндэслэлээр хөндлөнгөөс оролцохгүй.

19 дүгээр зүйл.Дэд бүтэц, хөрөнгө оруулалтын дэмжлэг

19.1.Асрах үйлчилгээний төвийн зориулалтаар хуульд заасан үндэслэл, журмын дагуу газар олгож, газрын төлбөрт хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлж болно.

19.2.Төр нь асрах үйлчилгээний төвийн барилга байгууламж, дэд бүтэц, тоног төхөөрөмжийн бүтээн байгуулалтад Нийгмийн халамжийн тухай хуульд заасан дэмжлэг үзүүлэхээс гадна дангаар болон хамтран санхүүжүүлж, байгуулж, ажиллуулж болно.

19.3.Төрийн өмчийн ашиглалтгүй барилга байгууламж, газар, дэд бүтцийг асрах үйлчилгээний төвийн зориулалтаар тодорхой хугацаагаар ашиглуулж болно.

19.4.Төрөөс дэмжлэг үзүүлэхдээ орон нутгийн хэрэгцээ, үйлчилгээний хүртээмж, эрсдэлийн үнэлгээг харгалзан үзнэ.

20 дугаар зүйл.Үйлчилгээ худалдан авах, санхүүгийн дэмжлэг

20.1.Төр нь асрах үйлчилгээний төвөөс асрах үйлчилгээ болон сэргээн засах асрах үйлчилгээ худалдан авч болно.

20.2.Үйлчилгээ худалдан авах гэрээ нь гүйцэтгэлд суурилсан, хугацаатай байна.

21 дүгээр зүйл.Татвар, төлбөр, зардлын хөнгөлөлт

21.1.Төр нь асрах үйлчилгээ эрхлэгчдэд дараах дэмжлэг үзүүлж болно:

21.1.1.татварын хөнгөлөлт, чөлөөлөлт;

21.1.2.дулаан, цахилгааны төлбөрийн хөнгөлөлт;

21.1.3.түрээсийн төлбөрийн хөнгөлөлт;

21.2.Энэ хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, энэ зүйлийн 21.1.2, 21.1.3-д заасан хөнгөлөлт, дэмжлэг үзүүлэх нөхцөл, журам, хэмжээг Засгийн газар батална.

22 дугаар зүйл.Эрсдэлийн болон онцгой нөхцөлийн үеийн дэмжлэг

22.1.Алслагдсан, хүн амын нягтрал багатай бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа асрах үйлчилгээний төвд төрөөс нэмэлт дэмжлэг үзүүлж болно.

22.2.Гамшиг, халдварт өвчин болон онцгой нөхцөлийн үед төр нь асрах үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах зорилгоор санхүүгийн болон хүнийн нөөц, зохион байгуулалтын дэмжлэг үзүүлнэ.

НАЙМДУГААР БҮЛЭГ САНХҮҮЖИЛТ, ТӨЛБӨРИЙН ТОГТОЛЦОО

23 дугаар зүйл.Санхүүжилт

23.1.Асрах үйлчилгээний санхүүжилт нь хүртээмж, чанар, тогтвортой байдлыг хангах, үйлчилгээ авагчийн эрх ашгийг хамгаалах зарчимд үндэслэнэ.

23.2.Асрах үйлчилгээний санхүүжилтэд төр, төрийн бус байгууллага, хувийн хэвшил болон бусад хуульд заасан этгээд бүрэн буюу хэсэгчлэн оролцож болно.

24 дүгээр зүйл.Санхүүжилтийн эх үүсвэр

24.1.Асрах үйлчилгээний санхүүжилт дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

24.1.1.асрах үйлчилгээ үзүүлэгчийн өөрийн хөрөнгө;

24.1.2.улсын болон орон нутгийн төсөв, төсвөөс хуульд заасны дагуу олгох санхүүгийн дэмжлэг;

24.1.3.төрөөс үйлчилгээ худалдан авах санхүүжилт;

24.1.4.үйлчилгээ авагчийн төлсөн төлбөр;

24.1.5.асрах үйлчилгээний даатгалын санхүүжилт;

24.1.6.олон улсын байгууллага, төсөл, хөтөлбөр, хандивын санхүүжилт;

24.1.7.хуульд хориглоогүй бусад эх үүсвэр.

25 дугаар зүйл.Үйлчилгээний төлбөр

25.1.Асрах үйлчилгээ авагч нь үйлчилгээний төрөл, хэмжээ, өртөгт тохирсон төлбөр төлнө.

25.2.Үйлчилгээний төлбөрийг дараах хүчин зүйлийг харгалзан тогтооно:

25.2.1.үйлчилгээний төрөл, хэлбэр;

25.2.2.үйлчилгээний хугацаа, эрчим;

25.2.3.асруулагчийн төлбөрийн чадвар.

25.3.Төлбөрийн чадваргүй иргэнд төрөөс үйлчилгээ худалдан авах хэлбэрээр санхүүгийн дэмжлэг үзүүлж болно.

25.4.Үндэсний баялгийн сангийн хуримтлалын санд хуримтлагдаж, иргэний нэрийн дансанд бүртгэгдсэн хөрөнгийг тухайн иргэн асрах үйлчилгээ авахтай холбоотой төлбөр, зардлыг санхүүжүүлэхэд хуульд заасан үндэслэл, журмын дагуу ашиглаж болно.

26 дугаар зүйл.Асрах үйлчилгээний даатгал

26.1.Асрах үйлчилгээний даатгал нь асрах үйлчилгээ шаардлагатай болсон тохиолдолд үйлчилгээний зардлыг санхүүжүүлэх зорилго бүхий сайн дурын даатгалын тогтолцоо байна.

26.2.Иргэн асрах үйлчилгээний даатгалд сайн дурын үндсэн дээр хамрагдаж болно.

26.3.Асрах үйлчилгээ үзүүлэгч нь үйлчилгээ үзүүлэх явцад бусдад учруулж болзошгүй хохирол, хариуцлагын эрсдэлийг хамгаалах зорилгоор хариуцлагын даатгалд даатгуулсан байна.

26.4.Асрах үйлчилгээний даатгалын нөхцөл, хамрах хүрээ, даатгалын тохиолдол, нөхөн төлбөр олгох журмыг даатгалын тухай хууль тогтоомжид нийцүүлэн тогтооно.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА, МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

27 дугаар зүйл.Төрийн хяналт

27.1.Асрах үйлчилгээний үйл ажиллагаанд төрөөс хууль тогтоомж, үйлчилгээний стандарт, чанар, аюулгүй байдлын шаардлагын хэрэгжилтэд хяналт тавина.

27.2.Асрах үйлчилгээний үйл ажиллагаанд тавих төрийн хяналтыг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, улсын байцаагч болон хуульд заасан бусад эрх бүхий байгууллага хэрэгжүүлнэ.

28 дугаар зүйл.Хариуцлага

28.1.Энэ хуулийг зөрчсөн этгээдэд үйлдлийн шинж, учруулсан хохирол, үр дагаврыг харгалзан Зөрчлийн тухай хууль болон бусад хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

28.2.Энэ хуулийн 28.3.1-28.3.11-д заасан ноцтой зөрчил гаргасан тохиолдолд эрх бүхий байгууллага зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох санал гаргах, эсхүл хуульд заасан бусад арга хэмжээ авч болно.

28.3.Дараах үйлдлийг ноцтой зөрчилд тооцно:

28.3.1.асрах үйлчилгээний чанар, аюулгүй байдлын шаардлага, стандарт, журмыг ноцтой зөрчих;

28.3.2.асруулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчих;

28.3.3.төрөөс олгосон санхүүжилт болон асрах үйлчилгээний зориулалттай хөрөнгийг зориулалтын бусаар ашиглах;

28.3.4.асруулагчид бие махбодын, сэтгэл санааны, бэлгийн болон эдийн засгийн дарамт, хүчирхийлэл, үл хайхрах үйлдэл гаргах;

28.3.5.асруулагчийн хувийн мэдээлэл, эрүүл мэндийн мэдээлэл болон хуульд хамгаалагдсан бусад нууц мэдээлэлд халдах;

28.3.6.асруулагчийн амь нас, эрүүл мэндэд ноцтой эрсдэл учруулсан, эсхүл учруулах үйлдэл, эс үйлдэхүй гаргах;

28.3.7.асрах үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах зөвшөөрөл, эрх, мэргэжлийн шаардлага хангахгүйгээр үйлчилгээ үзүүлэх;

28.3.8.асруулагчийн баримт бичиг, эд хөрөнгө, мөнгөн хөрөнгө, өмчийг хууль бусаар ашиглах, захиран зарцуулах;

28.3.9.хяналт шалгалтад саад учруулах, хуурамч мэдээлэл гаргах, шаардлагатай мэдээлэл, баримт бичгийг санаатайгаар нуун дарагдуулах;

28.3.10.асруулагчийг ялгаварлан гадуурхах, нэр төр, алдар хүндэд нь халдах;

28.3.11.асрах үйлчилгээний бүртгэл, тайлан, санхүүгийн болон эрүүл мэндийн мэдээллийг хуурамчаар үйлдэх, өөрчлөх, устгах.

28.4.Асрах үйлчилгээ үзүүлэгч нь санаатай үйлдэл, хууль бус үйл ажиллагаа, мэргэжлийн алдаа, эсхүл үл хайхрах, хайхрамжгүй хандсаны улмаас учруулсан хохирол, хор уршгийн төлөө хуульд заасан хариуцлага хүлээнэ.

28.5.Энэ хуулийг зөрчсөн үйлдэл нь гэмт хэргийн шинжтэй бол эрүүгийн хариуцлага, гэмт хэргийн шинжгүй бол Зөрчлийн тухай хууль болон бусад хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

28.6.Энэ хуулийг зөрчсөний улмаас бусдад учруулсан эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирлыг Иргэний хуульд заасны дагуу нөхөн төлүүлнэ.

29 дүгээр зүйл.Маргаан шийдвэрлэх

29.1.Асрах үйлчилгээтэй холбоотой маргааныг талууд эвлэрүүлэн зуучлах болон үйлчилгээ үзүүлэгчийн дотоод гомдол шийдвэрлэх журмаар шийдвэрлэж болно.

29.2.Талууд маргааныг эвлэрүүлэн шийдвэрлэж чадаагүй тохиолдолд шүүхэд хандана. Хуульд зөвшөөрсөн болон арбитрын хэлэлцээр байгуулсан тохиолдолд арбитрын журмаар шийдвэрлүүлж болно.

АРАВДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

30 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

30.1.Энэ хуулийг 2026 оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 21 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 21.1.17 дахь заалт нэмсүгэй:

“21.1.17.асрах үйлчилгээний үйл ажиллагааны орлого.”

2 дугаар зүйл. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.9.2 дахь заалтын “хүүхдийн тоглоомын талбай,” гэсний дараа “асрах үйлчилгээний төв,” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Асрах үйлчилгээний тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙ ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухайн хуулийн 32 дугаар зүйлийн 32.3 дахь хэсгийн “эрүүл мэнд” гэсний дараа “асрах үйлчилгээ” гэж, “гэрээгээр ажиллах эмч” гэсний дараа “асрах үйлчилгээний ажилтан” гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Асрах үйлчилгээний тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нийгмийн халамжийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах заалт нэмсүгэй:

1/5 дугаар зүйлийн 5.1.5 дахь заалт:

“5.1.5.асрах үйлчилгээ.”

2/8 дугаар зүйлийн 8.2.11 дэх заалт:

“8.2.11.асрах үйлчилгээ.”

3/17 дугаар зүйлийн 17.1.3 дахь заалт:

“17.1.3.асрах үйлчилгээ.”

2 дугаар зүйл. Нийгмийн халамжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 19² дугаар зүйл нэмсүгэй:

“19² дугаар зүйл. Асрах үйлчилгээ

19².1. Асрах үйлчилгээ шаардлагатай иргэнд үзүүлэх асрах үйлчилгээтэй холбоотой харилцааг Асрах үйлчилгээний тухай хуулиар зохицуулна.

19².2. Төрөөс төлбөрийн чадваргүй иргэнийг асрах үйлчилгээнд хамруулж болно.”

3 дугаар зүйл. Энэ хуулийг Асрах үйлчилгээний тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

Төсөл

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 13.5.21 дэх заалт нэмсүгэй:

“13.5.21.асрах үйлчилгээ.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Асрах үйлчилгээний тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

Төсөл

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь заалтын “иргэний эрүүл мэнд” гэсний дараа “асрах үйлчилгээ” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Асрах үйлчилгээний тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

Төсөл

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

АСРАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

1 дүгээр зүйл. Асрах үйлчилгээний тухай хууль хүчин төгөлдөр үйлчлэхээс өмнө асрах үйлчилгээ эрхэлж байсан иргэн, хуулийн этгээд нь Асрах үйлчилгээний тухай хуульд заасан шаардлагыг хангаж, хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш нэг жилийн дотор тусгай зөвшөөрөл авна.

2 дугаар зүйл. Засгийн газар, холбогдох асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Асрах үйлчилгээний тухай хуулийн 7.8, 7.9, 8.2, 13.2, 14.2, 17.1, 21.2-т заасан захиргааны хэм хэмжээний актыг хууль батлагдсан өдрөөс хойш 6 сарын дотор батална.

Гарын үсэг



**ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЦЭЭ,
ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН
СУДАЛСАН СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

Улаанбаатар хот
2026 он

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

НЭГ.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

- 1.1.Судалгааны зорилго
- 1.2.Судалгааны арга зүй
- 1.3.Судалгааны баг

ХОЁР.АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ

- 2.1.Асуудлын мөн чанар, цар хүрээг тодорхойлсон байдал
- 2.2.Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх этгээдийг тодорхойлсон байдал
- 2.3.Асуудлыг үүсгэж байгаа шалтгаан нөхцөл

ГУРАВ.АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ

ДӨРӨВ.ЗОХИЦУУЛАЛТЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ

- 4.1.Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө
- 4.2.Эдийн засагт үзүүлэх үр нөлөө
- 4.3.Нийгэмд үзүүлэх үр нөлөө
- 4.4.Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө
- 4.5.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх

ТАВ.ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

ЗУРГАА. ЗӨВЛӨМЖ

ДОЛОО.АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

УИХ	Улсын их хурал
ХЭҮК	Хүний эрхийн үндэсний комисс
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
АХБ	Азийн хөгжлийн банк
ХНХ	Хөдөлмөр нийгмийн хамгаалал

НЭГ.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1.1.Судалгааны зорилго

Энэхүү судалгааны зорилго нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу Асрах үйлчилгээний тухай хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалж, тухайн харилцааг зохицуулах эрх зүйн оновчтой хувилбарыг тодорхойлон хууль санаачлагчид санал, зөвлөмж боловсруулахад оршино.

Урьдчилан тандан судалгааны хүрээнд шийдвэрлэх шаардлагатай асуудал, түүний шалтгаан, үр дагаврыг тодорхойлж, боломжит зохицуулалтын хувилбаруудын давуу болон сул тал, нийгэм, эдийн засаг, эрх зүйн үр нөлөөг харьцуулан үнэлж, хэрэгжих боломжтой, үр ашигтай зохицуулалтын хувилбарыг санал болгохыг зорив.

Энэ хүрээнд Монгол Улсад асрах үйлчилгээтэй холбоотой эрх зүйн зохицуулалт, түүний хэрэгжилт, бодит нөхцөл байдал, тулгамдсан асуудал, олон улсын туршлагад дүн шинжилгээ хийж, асрах үйлчилгээний харилцааг бие даасан хуулиар зохицуулах хэрэгцээ, шаардлага байгаа эсэхийг судлан, цаашид баримтлах эрх зүйн зохицуулалтын чиг хандлага, оновчтой хувилбарыг тодорхойлов.

1.2.Судалгааны арга зүй

Энэхүү судалгааг чанарын болон тоон судалгааны аргад тулгуурлан гүйцэтгэсэн бөгөөд баримт бичгийн шинжилгээ, статистик мэдээллийн дүн шинжилгээ, ярилцлага, хэлэлцүүлэг, кейс судалгаа болон харьцуулалтын аргыг ашиглав.

Мэдээлэл цуглуулахдаа баримт бичиг судлах, ажиглалт хийх, чөлөөт болон албан хэлбэрийн ярилцлага авах, ганцаарчилсан болон бүлгийн (фокус) ярилцлага зохион байгуулах, холбогдох кейсийг судлах, дотоод болон гадаадын эрх зүйн зохицуулалтыг харьцуулан шинжлэх аргыг хэрэглэсэн болно.

Судалгааг Хууль тогтоомжийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэгт заасан шаардлага болон хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалд нийцүүлэн гүйцэтгэв. Судалгааны явцад асуудал, шалтгаан, үр дагавар, зохицуулалтын хувилбар, тэдгээрийн нөлөөлөл хоорондын уялдаа холбоог харгалзан үе шаттайгаар шинжилгээ хийсэн болно.

Түүнчлэн тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх боломжит хувилбарууд Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээ, хүний эрхийн нийтлэг зарчим, холбогдох хууль тогтоомж болон төрөөс баримталж буй бодлого, хөгжлийн зорилттой нийцэж байгаа эсэхийг судалж үнэлэв. Мөн гадаад улсын эрх зүйн

зохицуулалт, олон улсын туршлагыг харьцуулан судалж, тухайн асуудлыг хууль тогтоомжоор зохицуулах шаардлага байгаа эсэх, зохицуулалтын оновчтой хувилбарыг тодорхойлох шинжилгээ хийсэн.

Судалгааны хүрээнд асрах үйлчилгээний чиглэлээр хийгдсэн эрдэм шинжилгээний бүтээл, судалгааны тайлан, бодлогын баримт бичиг, статистик мэдээлэлтэй танилцаж, төрийн байгууллага, мэргэжлийн холбоо, салбарын мэргэжилтэн, судлаачидтай уулзалт, ярилцлага, хэлэлцүүлэг зохион байгуулан санал, дүгнэлтийг нэгтгэн судалгаанд тусгав. Түүнчлэн асрах үйлчилгээний хэрэгцээ бүхий иргэд болон тэдгээрийн гэр бүлийн гишүүдийн байр суурь, хэрэгцээ шаардлагыг тандан судалж, судалгааны үр дүнг зохицуулалтын хувилбар боловсруулахад ашигласан болно.

1.3.Судалгааны баг

Энэхүү судалгааны ажлыг хараат бус, бие даасан судлаач, хуульчдын бүрэлдэхүүнтэй Хууль зүйн мэдээлэл, судалгааны хамтын ажиллагааны нийгэмлэг (Legal Information and Research Society – LIRS)-ийн судалгааны баг гүйцэтгэв.

Судалгааны баг нь хууль тогтоомжийн төсөл боловсруулах, эрх зүйн судалгаа, бодлогын шинжилгээ, хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагын урьдчилан тандан судалгаа хийх чиглэлээр ажиллаж буй судлаач, хуульчдаас бүрдсэн болно

ХОЁР.АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ

2.1.Шийдвэрлэх асуудлын мөн чанар, цар хүрээг тодорхойлсон байдал

Нийгмийн харилцаанд тулгамдаж буй асуудлын мөн чанар, цар хүрээг тодорхойлох зорилгоор холбогдох хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, статистик мэдээлэл, судалгааны тайлан, эрдэм шинжилгээний бүтээлд дүн шинжилгээ хийж, салбарын мэргэжилтэн, судлаачид болон асрах үйлчилгээний хэрэгцээ бүхий иргэд, тэдгээрийн гэр бүлийн гишүүдтэй уулзалт, ярилцлага зохион байгуулан нөхцөл байдлыг судлав.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд иргэний амьд явах эрх, эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх, эрүүл мэндээ хамгаалуулах эрх, өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд нийгмийн хамгаалал, дэмжлэг авах эрхийг баталгаажуулсан байдаг. Иймд төрөөс иргэний үндсэн эрхийг хангах хүрээнд нийгмийн хамгаалал, халамж, асрамжийн үйлчилгээг зохион байгуулах эрх зүйн болон институцийн тогтолцоог бүрдүүлэх үүрэгтэй.

Тухайн салбарын хүрээнд авч үзвэл УИХ-аас Нийгмийн халамжийн тухай хууль, Ахмад настны тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай зэрэг олон хуулийг батлан гаргасан байна.

Мөн Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолоор Хөгжлийн бэрхшээлтэй хүнд тусламж, хөнгөлөлт үзүүлэх журам, 2024 оны 245 дугаар тогтоолоор Ахмад настны асрамжийн үйлчилгээ шинээр үзүүлэх, барилга байгууламж барих аж ахуй нэгж, байгууллагад төрөөс нэг удаагийн дэмжлэг үзүүлэх журам, 2025 оны 241 дугаар тогтоолоор Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг шинэчлэн тогтоож, Сангийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан 2018 оны А/03/А/03 тоот тушаалаар Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалттай асрамжийн газарт санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам, ХНСХ-ын сайдын 2023 оны А/180 тушаалаар Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ болон ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүнд зарим төрлийн үйлчилгээ үзүүлэх иргэн, ААН, ТББ-ыг магадлан итгэмжлэх журам, ХНХС-ын сайдын 2023 оны А/190 тушаалаар “Төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа ахмад настан, 18 нас ба түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй иргэнд тэтгэвэр олгох журам, ХНХС-ын сайдын 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдөр А/189 тушаалаар “Төрөлжсөн асрамжийн газрын төсвийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам, ХНХС-ын 2023 оны А/191 дүгээр тушаалаар “Төрөлжсөн асрамжийн газрыг магадлан итгэмжлэх журам” зэрэг олон эрх зүйн баримт бичгийг батлан мөрдөж иржээ.

Нийгмийн халамжийн тухай хуулиар нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, үйлчилгээний төрөл, хамрах хүрээ, санхүүжилт, байгууллагын тогтолцоо, чиг үүргийг зохицуулж байгаа бөгөөд халамжийн үйлчилгээг олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ болон төрөлжсөн асрамжийн үйлчилгээ гэж ангилсан байна. Мөн төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд болон бусад зорилтот бүлэгт үзүүлэх асрамжийн үйлчилгээг хамруулан зохицуулжээ.

Гэвч өнөөгийн эрх зүйн зохицуулалт нь асрах үйлчилгээтэй холбоотой харилцааг бие даасан байдлаар иж бүрэн зохицуулаагүй байна. Тухайлбал, асрах үйлчилгээний төрөл, хэлбэр, үйлчилгээ үзүүлэгчид тавигдах шаардлага, үйлчилгээ авагчийн эрх, үйлчилгээний чанар, санхүүжилт, даатгал, төрийн болон хувийн хэвшлийн оролцооны харилцаа тусгайлсан зохицуулалтгүй байна. Үүний улмаас асрах үйлчилгээний хүртээмж, чанар, санхүүжилтийн тогтолцоо жигд бус, үйлчилгээ үзүүлэгч болон үйлчилгээ авагчийн эрх, үүрэг тодорхойгүй байх нөхцөл үүсчээ.

Монгол Улсад хүн амын насжилт нэмэгдэж, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, байнгын асаргаа шаардлагатай иргэдийн тоо өсөж байгаа нөхцөлд асрах

үйлчилгээний хэрэгцээ тасралтгүй нэмэгдэж байна. Гэсэн хэдий ч үйлчилгээний эрх зүйн орчин, стандарт, санхүүжилт, хүний нөөцийн тогтолцоо хангалттай хөгжөөгүй байгаа нь иргэдэд шаардлагатай үйлчилгээг чанартай, хүртээмжтэй хүргэхэд хүндрэл учруулж байна.

Иймд асрах үйлчилгээний бүх хэлбэрийг хүлээн зөвшөөрч, үйлчилгээ үзүүлэгч болон үйлчилгээ авагчийн эрх, үүрэг, үйлчилгээний стандарт, санхүүжилт, төрийн дэмжлэг, хяналтын тогтолцоог цогцоор нь зохицуулсан бие даасан хууль батлах хэрэгцээ, шаардлага үүссэн гэж үзэж байна.

Үндсэн хуульд заасан иргэний үндсэн эрхийг хангах хүрээнд Нийгмийн халамжийн тухай хуулиар нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, үйлчилгээний төрөл, хамрах хүрээ, халамжийн сангийн хөрөнгийг зарцуулах журам, нийгмийн халамжийн байгууллагын тогтолцоо, чиг үүргийг зохицуулсан байдаг.

Тус хуулиар “нийгмийн халамж”-ийг эрүүл мэндийн доройтолтой, гэр бүлийн халамж, асрамж дутагдалтай, бие даан эсхүл бусдын тусламжгүйгээр хэвийн амьдрах боломжгүй, өвөрмөц хэрэгцээ бүхий иргэн болон нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэний наад захын хэрэгцээг хангах зорилгоор улсаас тэтгэвэр, тэтгэмж олгох, тусгайлсан үйлчилгээ үзүүлэх ажиллагаа гэж тодорхойлсон байна.

Мөн нийгмийн халамжийн үйл ажиллагааг халамжийн тэтгэвэр, тэтгэмж, халамжийн үйлчилгээ, нийгмийн хөгжлийн үйлчилгээ гэж ангилсан бөгөөд халамжийн үйлчилгээг олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ болон төрөлжсөн асрамжийн үйлчилгээ гэсэн хоёр төрөлтэй байхаар зохицуулжээ. Түүнчлэн хуулийн 19 дүгээр зүйлд төрөлжсөн асрамжийн үйлчилгээг ахмад настны асрамжийн үйлчилгээ, хөгжлийн бэрхшээлтэй иргэний асрамжийн үйлчилгээ, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн асрамжийн үйлчилгээ болон гурав ба түүнээс дээш ихэр хүүхдийн асрамжийн үйлчилгээ гэж ангилан зохицуулсан байна.

Гэвч дээрх зохицуулалт нь төрөлжсөн асрамжийн үйлчилгээний хүрээнд хязгаарлагдаж байгаа бөгөөд асрах үйлчилгээний төрөл, хэлбэр, үйлчилгээ үзүүлэгчид тавигдах шаардлага, үйлчилгээ авагчийн эрх, үйлчилгээний чанар, санхүүжилт, даатгал, төрийн болон хувийн хэвшлийн оролцоо зэрэг харилцааг бие даасан байдлаар цогцоор нь зохицуулаагүй байна. Иймээс асрах үйлчилгээтэй холбоотой харилцааг тусгайлсан хуулиар зохицуулах хэрэгцээ, шаардлага үүссэн гэж үзэж байна.

Гэвч нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээ шаардлагатай иргэдэд хүрч байгаа үйлчилгээний хүртээмж, чанар хангалтгүй хэвээр байна. Ялангуяа ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, байнгын асаргаа шаардлагатай хүн болон тэдгээрийн гэр бүлийн гишүүд өдөр тутмын асаргаа, дэмжлэг авахад хүндрэлтэй байгаа нь судалгаа, бодит нөхцөл байдлаас харагдаж байна.

Монгол Улс өнгөрсөн хугацаанд нийгмийн халамж, асрамж, асрах үйлчилгээтэй холбоотой хууль тогтоомж, бодлогын баримт бичгийг баталж, тодорхой хэмжээний эрх зүйн зохицуулалт, стандарт, хэм хэмжээг бүрдүүлсэн байна. Гэсэн хэдий ч асрах үйлчилгээтэй холбоотой харилцааг бие даасан, цогц байдлаар зохицуулсан эрх зүйн орчин бүрэн төлөвшөөгүй хэвээр байна.

Тухайлбал, асрах үйлчилгээний төрөл, хэлбэр, үйлчилгээ үзүүлэгчид тавигдах шаардлага, үйлчилгээ авагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол, үйлчилгээний чанар, санхүүжилт, даатгал, төрийн болон хувийн хэвшлийн оролцооны зохицуулалт хангалттай тодорхой бус байна. Мөн гэр бүлийн хүрээнд болон олон нийтэд суурилсан асрахуйн ажлын бүх хэлбэрийг хүлээн зөвшөөрөх, дэмжих, эрх зүйн баталгаагаар хангах хэрэгцээ нэмэгдэж байна.

Иймд асрах үйлчилгээ үзүүлэгч болон үйлчилгээ авагчийн эрх, үүрэг, үйлчилгээний стандарт, санхүүжилт, төрийн дэмжлэг, хяналтын тогтолцоог цогцоор нь зохицуулсан бие даасан эрх зүйн зохицуулалт бий болгох шаардлага үүссэн гэж дүгнэж болно.

Эмэгтэйчүүд дийлэнх цагаа асрахуйн хөлсгүй хөдөлмөрт зарцуулж байгаад асрахуйн үйлчилгээний хүртээмжгүй байдалд нөлөөлж байна. Тодруулбал, асаргаа шаардлагатай гэр бүлийн гишүүдийг асрах цалин хөлсгүй хөдөлмөрт эмэгтэйчүүдийн зарцуулдаг цаг эрэгтэйчүүдийнхээс 2.1 дахин их, хүүхэд өвдсөн тохиолдолд даруй 10 дахин нэмэгдэж байна. Өрх гэр болон ажлын байран дахь жендерийн тэгш бус байдлыг арилгаснаар Монгол Улс эмэгтэйчүүдийн ажиллах хүчин дэх оролцооны түвшинг 63.2 хувь хүртэл өсгөх, улмаар нэг хүнд ногдох эдийн засгийн жилийн өсөлтийн түвшинг 0.5 хувиар нэмэгдүүлж, 2025 он гэхэд Монгол Улсын ДНБ-ийг 16 хувиар өсгөх боломжтой гэж АХБ тооцоолсон байна.¹

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050” баримт бичигт Монгол Улс 2050 онд нийгмийн хөгжил, эдийн засгийн өсөлт, иргэдийн амьдралын чанараар Азид тэргүүлэгч орнуудын нэг болно, амар тайван, хүмүүнлэг нийгмийг цогцлоож, эрүүл чийрэг, эрдэм боловсролтой, эх оронч, хөрвөх чадвартай, оюунлаг, бүтээл иргэнтэй улс болж хөгжинө гэж алсын хараа, эрхэм зорилгыг тодорхойлсон.

Уг бодлогын баримт бичгийн Гурав.Амьдралын чанар ба дундаж давхарга бүлгийн Нийгмийн хамгаалал ба даатгалын тогтолцооны шинэчлэл, зорилт 3.1-д Амьдралын баталгааг хангах нийгмийн хамгааллын үйлчилгээг хөгжүүлж, амьдралын чанарыг дээшлүүлэхүйц нийгмийн даатгалын тогтолцоог бэхжүүлнэ, 1 үе шат (2021-2030): нийгмийн хамгааллын тогтолцоог шинэчлэх үе: 3. Хүн амын бүлгүүдийн ялгаатай хэрэгцээ, нийгмийн хөгжлийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн нийгмийн хамгаалал, халамжийн үйлчилгээг үзүүлнэ, 4. Нийгмийн

¹ Азийн сан, Асрахуйн эдийн засаг: Бодлогын зөвлөмж

халамжийн үйлчилгээнд хүн амын эмзэг бүлгүүдийг бүрэн хамруулна, 5. Зорилтот, эмзэг бүлгийн өрх, иргэний амьжиргаанд хүрэлцэхүйц хэмжээний нийгмийн халамжийн тусламж, дэмжлэгийг үзүүлдэг болно гэж заасан.

Асрах үйлчилгээ нь зөвхөн нийгмийн хамгааллын үйлчилгээ төдийгүй улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд чухал нөлөө үзүүлдэг салбар юм. Иймээс олон улс оронд асрах үйлчилгээтэй холбоотой хөдөлмөр, үйлчилгээ, санхүүжилт, хүний нөөц, нийгмийн хамгааллын асуудлыг “асрахуйн эдийн засаг” (care economy) хэмээх бие даасан бодлогын чиглэл болгон авч үзэх болсон байна.

Асрахуйн эдийн засаг нь хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон бусдын байнгын тусламж, дэмжлэг шаардлагатай хүмүүст үзүүлэх асрах үйлчилгээтэй холбоотой хөдөлмөр, үйлчилгээ, хөрөнгө оруулалт, санхүүжилт болон нийгмийн үр өгөөжийг хамарсан өргөн хүрээтэй ойлголт юм. Асрах үйлчилгээний тогтолцоо сайн хөгжсөнээр иргэдийн амьдралын чанар сайжрах, хөдөлмөр эрхлэлт нэмэгдэх, гэр бүлийн асрах ачаалал буурах, эмэгтэйчүүдийн эдийн засгийн оролцоо өсөх, урт хугацаанд нийгмийн хамгааллын тогтолцооны үр ашиг дээшлэх ач холбогдолтой байдаг.

Иймд асрах үйлчилгээний асуудлыг зөвхөн нийгмийн халамжийн үйлчилгээний хүрээнд бус, хүний эрх, нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлт, эдийн засгийн хөгжлийн бодлоготой уялдсан цогц асуудал гэж үзэх шаардлагатай байна.

Бие махбодын, нийгмийн, сэтгэл зүйн төрөл бүрийн асаргаа, дэмжлэг, тусалцаа үзүүлэх цалин хөлстэй болон хөлсгүй хөдөлмөр, үйлчилгээний бүх хэлбэрийг хамарсан нийгэм, эдийн засгийн харилцааг асрахуйн эдийн засаг гэдэг. Үүнд хүүхэд, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх шууд болон шууд бус халамж, эрүүл мэнд, боловсрол, түүнчлэн хувь хүний сайн сайхан байдлыг дэмжих, сайжруулахад чиглэсэн санхүүгийн болон бусад үйлчилгээ багтана. Хэдийгээр ДНБ зэрэг үндэсний дансны системд үл үзэгдэх, бараг л тооцогддоггүй ч асрахуйн ажил нь хувь хүний чадавх, сайн сайхан байдлыг хадгалах, нийгэм, эдийн засгийн үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай гэдгийг улам бүр хүлээн зөвшөөрч байна.²

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 3.1.10-д Нийгмийн халамжийн тусламж, дэмжлэг, үйлчилгээг зорилтот, эмзэг бүлгийн хэрэгцээнд нийцүүлж, амьжиргааг нь дээшлүүлэхэд чиглүүлнэ, 3.1.13-д Ахмад настанд урт хугацааны тусламж үйлчилгээ үзүүлэх хөгжлийн төвүүдийг байгуулна гэж заасан.

² Азийн сан, Асрахуйн эдийн засагтай холбоотой өгөгдлийн өнөөгийн байдал, хэрэгцээ, бодлогын зөвлөмж, 2024 он

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн Хоёр. Хүний хөгжлийн бодлого, 2.1.1.18-д Ахмад настанд Гэр бүлийн хөгжлийн цогц төвөөр дамжуулан тэдний эрэлт, хэрэгцээнд нийцсэн хөгжлийн болон нийгмийн үйлчилгээ үзүүлж, идэвхтэй насжилтыг дэмжнэ, 2.1.1.21-д Ахмад настны асаргааны хувилбарт үйлчилгээг хөгжүүлж, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын оролцоог дэмжинэ гэж тус тус заасан байна.

Монгол Улсын хувьд 60 ба түүнээс дээш насны хүн амын нийт хүн амд эзлэх хувь 2015 онд 6.4 хувь байсан бол 2030 онд 11.9 хувь, 2050 он гэхэд 21.1 хувь болох хэтийн тооцоог ҮСХ-оос хийсэн байна.³

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссоос ахмад настны эрхийн хэрэгжилт, нийгмийн хамгаалал, халамж, асрамжийн үйлчилгээний хүртээмжтэй холбоотой судалгаа хийж, үр дүнг олон нийтэд танилцуулсан байна. Тус судалгааны үр дүнгээс үзэхэд халамж, асрамжийн үйлчилгээ шаардлагатай ахмад настуудын эрхийн хэрэгжилт, үйлчилгээний хүртээмж, чанартай холбоотой асуудал тулгамдсан хэвээр байгааг харуулжээ.

Тухайлбал, ахмад настанд шаардлагатай асрамж, халамжийн үйлчилгээ хангалттай хүрч чадахгүй байх, гэр бүлд ногдох асаргааны ачаалал өндөр байх, урт хугацааны асаргаа, дэмжлэг шаардлагатай ахмад настуудад үзүүлэх үйлчилгээний төрөл, хэлбэр хязгаарлагдмал байх, үйлчилгээний хүртээмж орон нутаг болон хүн амын бүлгээр ялгаатай байх зэрэг асуудал түгээмэл байгааг тэмдэглэсэн байна.

Эдгээр нөхцөл байдал нь ахмад настны нийгмийн хамгаалал, бие даан амьдрах боломж, эрүүл мэнд, амьдралын чанарт сөргөөр нөлөөлөхөөс гадна гэр бүл, асран хамгаалагчдад эдийн засаг, нийгмийн нэмэлт ачаалал үүсгэж байгааг харуулж байна. Тухайлбал,

Монгол Улсад 388300 ахмад настан байна. Тодруулбал, 10.1 хувийг эзэлж байна. 2050 он гэхэд таван хүн тутмын нэг нь ахмад настан болно гэсэн тооцоолол бий. Үргэлжлүүлэн ахмадуудын хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлтийг харвал 20.7 хувь нь ажил, хөдөлмөр эрхэлж байна. Ахмадын холбооны судалгаагаар, нийт ахмадуудын 16.7 хувь буюу 28.2 мянган ахмад настан амьжиргааны баталгаажих түвшнөөс доогуур орлоготой өрхөд, 3963 ахмад настан ганц бие, харж хандах үр хүүхэдгүй, 7815 ахмад хөгжлийн бэрхшээлтэй, хэвтрийн 184 мянган ахмад настан бусдын байнгын асрамжид байна. Монгол Улс ахмад настны хуультай цөөн орны нэг. ХЭҮК-оос 2023 онд судалгаа хийж, Засгийн газарт илтгэл хүргүүлсэн. Нэгдүгээрт Нийгмийн даатгалын багц хуулийг сайжруулсан ч ахмад настуудын тэтгэврийн зөрүүний асуудал хэвээр байна.

³ Я.Отгонбаяр, Г.Түмэннаст нар, Ахмад настны асрамжийн үйлчилгээний харьцуулсан судалгаа: БНСУ, Монгол Улсын жишээгээр, Монголын хүн амын сэтгүүл, №34, 2024 он, 110 дахь тал

Ахмад настанд нийгмийн амьдралд оролцох эрх нь тулгамдсан асуудал болоод байна. Ахмадад ээлтэй орчин Монголд бүрдээгүй байгааг ХЭҮК-ын судалгаанд оролцсон 70 хувь нь хэлсэн байдаг. Мөн ахмадууд чөлөөт цагаа өнгөрүүлэх газар хомс байна. Нийгмээс тусгаарлагдах, ганцаардах асуудал түгээмэл байгаа. Хөдөлмөр эрхлэлтийн байдлыг төрөөс дэмжиж байгаа ч бодит байдал дээр ахиц дэвшил харагдахгүй байна. ХЭҮК-ын судалгаанд оролцогсдын таван ахмад тутмын нэг нь ялгаварлан гадуурхалтад өртөж байгаа нь батлагдсан. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас зөрчлийн гэмт хэрэгт хохирсон ахмад настны тоо 2022 онд 968 буюу 34.8 хувиар нэмэгдсэн байна. Үүнд 64 хувь сэтгэл санааны хүчирхийлэл, 36 хувь нь эдийн засгийн хүчирхийлэл, 0.1 хувь нь бэлгийн хүчирхийлэл, бие махбодын хүчирхийлэл 47 хувь, үл хайхрах хүчирхийлэл 21 хувь байна. Ахмадууд эрүүл мэндийн үнэтэй чанартай үйлчилгээг төдийлөн авч чадахгүй байна.⁴

Хүн амын дундаж наслалт нэмэгдэж байгаа ч ахмад настанд үзүүлэх тусламж үйлчилгээ хангалттай биш, ахмад настанд чиглэсэн төрийн бодлого, шийдвэрийн хэрэгжилт бодит байдал дээр үр дүн тааруу байгаа юм.

Өнөөдрийн байдлаар Монгол Улсын ахмад настанд чиглэгдсэн үйлчилгээ нь ахмадад зориулсан мөнгөн тусламж, рашаан сувилал, амралтын эрх зэрэг цөөн тооны үйлчилгээгээр хязгаарлагдаж байна. Цаашид хүн амын өсөлт удааширч, нийт хүн амд ахмад настануудын эзлэх хувь өсөх хандлагатай байгаа Монгол Улсын хувьд ахмад настны нийгмийн хамгааллын бодлого нь зөвхөн нийгмийн ядуу, эмзэг, зорилтот бүлэгт чиглэсэн үйлчилгээгээр хязгаарлагдахгүйгээр нийт ахмад настанд зориулагдсан дэмжих, хөгжүүлэх, урьдчилан сэргийлэх тусламж үйлчилгээний цогц тогтолцоо бий болгох хэрэгцээ, шаардлага гарч байна.⁵

Шийдвэрлэх шаардлагатай асуудалд хийсэн шинжилгээнээс үзэхэд асрах үйлчилгээний хэрэгцээ бүхий ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон байнгын тусламж, дэмжлэг шаардлагатай иргэдийн нийгмийн хамгаалал, үйлчилгээний хүртээмжтэй холбоотой асуудал тулгамдсан хэвээр байна.

Одоогийн эрх зүйн зохицуулалт болон үйлчилгээний тогтолцоо нь асрах үйлчилгээний өсөн нэмэгдэж буй хэрэгцээг бүрэн хангах хэмжээнд хүрээгүй бөгөөд үйлчилгээний хүртээмж, чанар, төрөл, хэлбэрийн хувьд тодорхой хязгаарлалттай байна. Үүний улмаас асрах үйлчилгээ шаардлагатай иргэдийн амьдралын чанар, бие даан амьдрах боломж, нийгмийн харилцаанд оролцох нөхцөлд сөргөөр нөлөөлөх эрсдэл үүсэж байна.

⁴ <https://itoim.mn/a/2024/09/26/event>

⁵ Я.Отгонбаяр, Г.Түмэннаст нар, Ахмад настны асрамжийн үйлчилгээний харьцуулсан судалгаа: БНСУ, Монгол Улсын жишээгээр, Монголын хүн амын сэтгүүл, №34, 2024 он, 110 дахь тал

Ялангуяа ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувьд шаардлагатай асаргаа, дэмжлэгийг цаг тухайд нь авч чадахгүй байх нь ганцаардал, нийгмийн тусгаарлалт, эдийн засгийн эмзэг байдалд өртөх эрсдэлийг нэмэгдүүлж байна. Түүнчлэн асрах үүргийг гэр бүлийн гишүүд дангаар хариуцах нөхцөл түгээмэл байгаа нь өрхийн орлого, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн оролцоонд сөрөг нөлөө үзүүлж, гэр бүлийн түвшинд нэмэлт ачаалал бий болгож байна.

Нөгөө талаас хүн амын насжилт эрчимжиж, урт хугацааны асаргаа, дэмжлэг шаардлагатай иргэдийн тоо өсөн нэмэгдэж байгаа өнөөгийн нөхцөлд асрах үйлчилгээний эрэлт цаашид улам нэмэгдэх төлөвтэй байна. Гэтэл үйлчилгээний эрх зүйн орчин, санхүүжилтийн тогтолцоо, хүний нөөцийн чадавх, үйлчилгээ үзүүлэгчдийн оролцоо хангалттай хөгжөөгүй байгаа нь ирээдүйд энэхүү хэрэгцээг үр дүнтэй хангахад хүндрэл учруулж болзошгүй юм.

Иймээс асрах үйлчилгээний төрөл, хэлбэр, үйлчилгээ үзүүлэгч болон үйлчилгээ авагчийн эрх, үүрэг, үйлчилгээний чанар, санхүүжилт, төрийн болон хувийн хэвшлийн оролцоог цогцоор нь зохицуулсан эрх зүйн орчныг бүрдүүлэх хэрэгцээ, шаардлага бодитойгоор үүссэн гэж үзэж байна.

2.2.Тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээдийг тодорхойлох;

Асрах үйлчилгээтэй холбоотой харилцаанд дараах нийгмийн бүлэг, иргэн, байгууллагын эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөж байна. Үүнд:

- асрах үйлчилгээ шаардлагатай ахмад настан;
- хөгжлийн бэрхшээлтэй иргэн;
- байнгын болон урт хугацааны асаргаа, дэмжлэг шаардлагатай иргэн;
- асрах үйлчилгээ шаардлагатай хүүхэд;
- асаргаа үзүүлж байгаа гэр бүлийн гишүүн, асран хамгаалагч;
- асрах үйлчилгээ үзүүлэгч иргэн, байгууллага;
- төрийн болон орон нутгийн байгууллага;
- төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн үйлчилгээ үзүүлэгчид.

Асрах үйлчилгээ шаардлагатай иргэдийн хувьд шаардлагатай үйлчилгээ, дэмжлэгийг цаг тухайд нь авах боломж хязгаарлагдмал, үйлчилгээний хүртээмж, төрөл, хэлбэр хангалтгүй байгаа нь тэдний бие даан амьдрах боломж, нийгмийн оролцоо, амьдралын чанарт сөргөөр нөлөөлж байна.

Түүнчлэн ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээнд нийцсэн орчин, дэд бүтэц, асаргаа, дэмжлэгийн үйлчилгээ хангалтгүй байгаа нь

тэдний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг бүрэн хэрэгжүүлэхэд хүндрэл учруулж байна.

Нөгөө талаас асрах үүргийг гэр бүлийн гишүүд дангаар хариуцах нөхцөл түгээмэл байгаа нь өрхийн эдийн засаг, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн оролцоонд нөлөөлж, гэр бүлийн түвшинд нэмэлт ачаалал үүсгэж байна.

Мөн асрах үйлчилгээ үзүүлэгч иргэн, байгууллагын үйл ажиллагаа, эрх, үүрэг, хариуцлага, үйлчилгээний стандарт, санхүүжилттэй холбоотой эрх зүйн зохицуулалт хангалттай тодорхой бус байгаа нь үйлчилгээний чанар, хүртээмжийг тогтвортой хөгжүүлэхэд хүндрэл учруулж байна.

Иймээс асрах үйлчилгээтэй холбоотой харилцаанд оролцогч бүх талын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, үйлчилгээний хүртээмж, чанарыг нэмэгдүүлэх зорилгоор эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлага үүссэн байна.

2.3.Тухайн асуудал үүссэн шалтгаан, нөхцөлийг тодорхойлох

Асрах үйлчилгээний хүртээмж, чанар хангалтгүй байгаа өнөөгийн нөхцөл байдал нь эрх зүйн зохицуулалт, институцийн тогтолцоо, санхүүжилт, хүний нөөц болон нийгмийн хөгжлийн хүчин зүйлүүдтэй холбоотой байна.

Нэгдүгээрт, асрах үйлчилгээтэй холбоотой харилцааг бие даасан байдлаар зохицуулсан эрх зүйн орчин бүрдээгүй байна. Одоогийн байдлаар асрамж, халамжийн үйлчилгээтэй холбоотой зарим зохицуулалт Нийгмийн халамжийн тухай хууль болон бусад хууль тогтоомжид тусгагдсан боловч асрах үйлчилгээний төрөл, хэлбэр, үйлчилгээ үзүүлэгчид тавигдах шаардлага, үйлчилгээ авагчийн эрх, үйлчилгээний чанар, санхүүжилт, төрийн болон хувийн хэвшлийн оролцоог цогцоор нь зохицуулсан эрх зүйн тогтолцоо бүрэн төлөвшөөгүй байна.

Хоёрдугаарт, асрах үйлчилгээний институцийн тогтолцоо, үйлчилгээний дэд бүтэц хангалтгүй байна. Асрах үйлчилгээний хэрэгцээ өсөн нэмэгдэж байгаа хэдий ч гэрээр үзүүлэх үйлчилгээ, олон нийтэд түшиглэсэн үйлчилгээ, өдрийн үйлчилгээ, урт хугацааны асаргаа зэрэг үйлчилгээний төрөл, хэлбэр хязгаарлагдмал хэвээр байгаа нь иргэдэд шаардлагатай үйлчилгээг хүртээмжтэй хүргэх боломжийг хязгаарлаж байна.

Гуравдугаарт, санхүүжилтийн тогтолцоо хангалттай хөгжөөгүй байна. Асрах үйлчилгээ нь урт хугацаанд тогтвортой санхүүжилт шаарддаг онцлогтой боловч үйлчилгээний санхүүжилтийн эх үүсвэр, төрийн дэмжлэг, үйлчилгээ худалдан авах тогтолцоо, даатгалын механизм хангалттай хөгжөөгүй байгаа нь үйлчилгээний хүртээмж, тогтвортой байдалд нөлөөлж байна.

Дөрөвдүгээрт, асрах үйлчилгээний чиглэлээр мэргэшсэн хүний нөөцийн хомсдол ажиглагдаж байна. Асрах үйлчилгээ үзүүлэх ажилтан бэлтгэх, сургах, мэргэшүүлэх тогтолцоо хангалттай хөгжөөгүй байгаа нь үйлчилгээний чанар, аюулгүй байдалд нөлөөлөх эрсдэлийг бий болгож байна.

Түүнчлэн хүн амын насжилт нэмэгдэж, урт хугацааны асаргаа, дэмжлэг шаардлагатай иргэдийн тоо өсөж байгаа нь асрах үйлчилгээний хэрэгцээг улам нэмэгдүүлж байна. Гэвч гэр бүлд төвлөрсөн уламжлалт асаргааны хэлбэр давамгайлж, гэр бүлийн гишүүд асрах үүргийг дангаар хариуцах нөхцөл түгээмэл байгаа нь өрхийн эдийн засаг, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн оролцоонд нэмэлт ачаалал үүсгэж байна.

Иймээс асрах үйлчилгээний хэрэгцээ өсөн нэмэгдэж байгаа нөхцөлд үйлчилгээний эрх зүйн орчин, институцийн тогтолцоо, санхүүжилт, хүний нөөц, төрийн болон хувийн хэвшлийн оролцоог цогцоор нь хөгжүүлэх шаардлага үүссэн гэж үзэж байна.

ГУРАВ.АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ

Асрах үйлчилгээний хэрэгцээтэй ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхэд болон бусдын тусламж, дэмжлэг шаардлагатай иргэдэд үзүүлэх үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулж, тэдгээрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах эрх зүйн орчныг бүрдүүлэх нь энэхүү зохицуулалтын үндсэн зорилго болно.

Энэ хүрээнд асрах үйлчилгээний төрөл, хэлбэр, стандарт, үйлчилгээ үзүүлэгч болон үйлчилгээ авагчийн эрх, үүрэг, санхүүжилт, төрийн болон хувийн хэвшлийн оролцоог тодорхойлсон эрх зүйн цогц зохицуулалтыг бий болгож, үйлчилгээний тогтвортой, хүртээмжтэй тогтолцоог хөгжүүлэхэд чиглэнэ.

Мөн асрах үйлчилгээний салбарт төр, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг дэмжих, үйлчилгээний чанар, хяналт, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох, иргэдэд хэрэгцээнд нь нийцсэн үйлчилгээг сонгох боломжийг нэмэгдүүлэх зорилтыг хэрэгжүүлнэ.

Түүнчлэн Монгол Улсын хүн амын насжилтын асуудлаарх үндэсний стратеги болон ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах төрийн бодлогын зорилттой уялдуулан асрах үйлчилгээний шинэ төрөл, хэлбэрийг хөгжүүлэх, үйлчилгээний санхүүжилтийн эх үүсвэрийг төрөлжүүлэх, урт хугацаанд тогтвортой ажиллах тогтолцоог бүрдүүлэхэд энэхүү зохицуулалт чиглэнэ.

Ингэснээр асрах үйлчилгээ шаардлагатай иргэдийн амьдралын чанар, нийгмийн оролцоо, бие даан амьдрах боломжийг дэмжихийн зэрэгцээ гэр

бүлийн асаргааны ачааллыг бууруулж, нийгмийн хамгааллын тогтолцооны үр нөлөө, хүртээмжийг дээшлүүлэх нөхцөл бүрдэх юм.

ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫГ ТОДОРХОЙЛЖ, ЭЕРЭГ, СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Зохицуулалтын дараахь хувилбарууд байна:

4.1.“Тэг” хувилбар буюу шинээр зохицуулалт хийхээс татгалзах :

Энэ хувилбар нь одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа эрх зүйн зохицуулалтыг хэвээр хадгалж, асрах үйлчилгээтэй холбоотой харилцааг бие даасан хуулиар зохицуулахгүй байх хувилбар юм.

Уг хувилбарын давуу тал нь төрөөс нэмэлт зохицуулалт бий болгох, хууль тогтоомж боловсруулах, хэрэгжүүлэхтэй холбоотой зардал, нөөц шаардахгүй байх явдал юм. Мөн одоо хэрэгжиж байгаа нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээний тогтолцоог хэвээр хадгалах боломжтой.

Гэвч энэхүү хувилбар нь тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх боломжгүй гэж үзэж байна. Учир нь өнөөгийн эрх зүйн зохицуулалт нь асрах үйлчилгээний өсөн нэмэгдэж буй хэрэгцээг бүрэн хангаж чадахгүй байгаа бөгөөд үйлчилгээний төрөл, хэлбэр, чанар, хүртээмж, санхүүжилт, үйлчилгээ үзүүлэгч болон үйлчилгээ авагчийн эрх, үүрэгтэй холбоотой харилцааг цогцоор нь зохицуулаагүй байна.

Түүнчлэн хүн амын насжилт нэмэгдэж, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон байнгын асаргаа, дэмжлэг шаардлагатай иргэдийн тоо өсөж байгаа өнөөгийн нөхцөлд асрах үйлчилгээний хэрэгцээ цаашид улам нэмэгдэх төлөвтэй байна. Гэтэл одоо мөрдөгдөж байгаа зохицуулалтыг хэвээр үлдээх нь үйлчилгээний хүртээмж, чанар, үр нөлөөг сайжруулах боломжийг хязгаарлаж, иргэдийн хэрэгцээг хангахгүй хэвээр үлдэх эрсдэлтэй.

Иймд шинээр зохицуулалт хийхгүй байх буюу “тэг” хувилбар нь тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, зорилгод хүрэх боломжгүй тул тохиромжгүй хувилбар гэж үзэв.

4.2.Хэвлэл мэдээлэл болон бусад хэрэгслийг ашиглан олон нийтэд хандсан ухуулга сурталчилгааны ажил өрнүүлэх:

Тулгамдсан асуудлыг шийдвэрлэхгүйгээр ямар нэгэн сурталчилгаа явуулах боломжгүй. Ухуулга сурталчилгааны хүрээнд шийдвэрлэгдэх асуудал биш юм.

Энэ хувилбар нь асрах үйлчилгээтэй холбоотой мэдээлэл, мэдлэгийг олон нийтэд түгээх, иргэдийн ойлголтыг нэмэгдүүлэх зорилготой боловч тулгамдаж буй асуудлын үндсэн шалтгааныг шийдвэрлэх боломжгүй юм.

Асрах үйлчилгээний өнөөгийн хүндрэл нь зөвхөн мэдээлэл дутмаг байгаатай холбоотой бус, харин эрх зүйн зохицуулалтын хийдэл, үйлчилгээний тогтолцооны сул хөгжил, санхүүжилтийн тогтолцооны хязгаарлалт, үйлчилгээний хүртээмж, хүний нөөцийн асуудал зэрэг олон хүчин зүйлтэй холбоотой байна.

Иймд зөвхөн мэдээлэл түгээх, сурталчлах арга хэмжээг хэрэгжүүлснээр асрах үйлчилгээ шаардлагатай иргэдийн хэрэгцээг хангах, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, үйлчилгээ үзүүлэгч болон үйлчилгээ авагчийн эрх, үүргийг тодорхой болгох зэрэг зорилгод хүрэх боломжгүй юм.

Түүнчлэн энэхүү хувилбар нь асрах үйлчилгээний төрөл, хэлбэр, санхүүжилт, үйлчилгээний стандарт, төрийн болон хувийн хэвшлийн оролцоог зохицуулах эрх зүйн үндсийг бий болгож чадахгүй тул тулгамдсан асуудлыг шийдвэрлэх үр дүнтэй арга хэмжээ гэж үзэх боломжгүй байна.

Иймээс хэвлэл мэдээлэл болон бусад хэрэгслийг ашиглан олон нийтэд мэдээлэл түгээх, сурталчилгаа хийх нь дэмжих шинжтэй арга хэмжээ байж болох боловч асуудлыг бие даан шийдвэрлэх зохицуулалтын хувилбар болж чадахгүй гэж үзэв.

4.3.Зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх:

Энэ хувилбар нь татварын бодлого, санхүүгийн урамшуулал, тусгай зөвшөөрөл, үйлчилгээний төлбөр, төрөөс үйлчилгээ худалдан авах зэрэг зах зээлийн эдийн засгийн арга хэрэгслийг ашиглан асрах үйлчилгээний салбарыг дэмжих, хөгжүүлэхэд чиглэнэ.

Уг хувилбарын давуу тал нь хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, үйлчилгээний нийлүүлэлтийг дэмжих, зах зээлийн өрсөлдөөнийг хөгжүүлэх боломжтойд оршино. Түүнчлэн төрөөс эдийн засгийн хөшүүргээр дамжуулан тодорхой чиглэлээр үйлчилгээний хөгжлийг дэмжих боломжтой.

Гэвч асрах үйлчилгээний өнөөгийн тулгамдсан асуудал нь зөвхөн эдийн засгийн зохицуулалтаар шийдвэрлэх боломжтой асуудал биш юм. Асрах үйлчилгээтэй холбоотой эрх зүйн зохицуулалт, үйлчилгээний стандарт, үйлчилгээ үзүүлэгч болон үйлчилгээ авагчийн эрх, үүрэг, чанарын хяналт, санхүүжилтийн тогтолцоо зэрэг суурь харилцааг тодорхойлох шаардлага хэвээр байна.

Иймд зах зээлийн эдийн засгийн арга хэрэгслийг ашиглах нь асрах үйлчилгээний хөгжлийг дэмжих нэмэлт механизм байж болох боловч тулгамдсан асуудлыг дангаар нь шийдвэрлэх хангалттай зохицуулалтын хувилбар гэж үзэх боломжгүй байна.

Тиймээс энэхүү хувилбарыг бие даасан зохицуулалтын үндсэн шийдэл бус, харин эрх зүйн зохицуулалтыг дэмжих дагалдах арга хэмжээний шинжтэй гэж үзэв.

4.4.Төрөөс санхүүгийн интервенц хийх:

Энэ хувилбар нь төрөөс шууд мөнгөн хэлбэрийн дэмжлэг, тэтгэвэр, тэтгэмж, татаас олгох замаар тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэнэ.

Уг хувилбарын давуу тал нь асрах үйлчилгээ шаардлагатай иргэдийн орлогыг богино хугацаанд дэмжих, эдийн засгийн хүндрэлтэй нөхцөлд байгаа иргэдэд шууд санхүүгийн туслалцаа үзүүлэх боломжтойд оршино.

Гэвч асрах үйлчилгээтэй холбоотой өнөөгийн асуудал нь зөвхөн орлогын хүрэлцээтэй холбоотой бус бөгөөд үйлчилгээний хүртээмж, төрөл, хэлбэр, чанар, хүний нөөц, үйлчилгээний стандарт, дэд бүтэц, эрх зүйн зохицуулалт зэрэг олон хүчин зүйлтэй холбоотой цогц асуудал юм. Иймээс зөвхөн мөнгөн хэлбэрийн дэмжлэг үзүүлснээр асуудлыг бүрэн шийдвэрлэх боломжгүй байна.

Нөгөө талаас нийгмийн даатгал, нийгмийн халамжийн сангийн нөөц боломж, улсын төсвийн ачааллыг харгалзан үзвэл төрөөс байнгын өсөн нэмэгдэх хэмжээний мөнгөн дэмжлэг үзүүлэх нь урт хугацаанд төсвийн тогтвортой байдалд хүндрэл учруулж болзошгүй юм.

Иймд төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх нь асрах үйлчилгээний хэрэгцээтэй иргэдийг дэмжих нэг арга хэрэгсэл байж болох боловч тулгамдсан асуудлыг дангаар нь шийдвэрлэх оновчтой хувилбар гэж үзэх боломжгүй байна. Харин санхүүгийн дэмжлэгийг үйлчилгээний хүртээмж, чанар, төрөөс үйлчилгээ худалдан авах тогтолцоо болон бусад эрх зүйн зохицуулалттай уялдуулан хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэв.

4.5.Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх:

Энэ хувилбар нь асрах үйлчилгээний тодорхой хэсгийг төрийн бус байгууллага болон хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх, төрөөс үйлчилгээ худалдан авах, хамтын ажиллагааны хэлбэрээр үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэнэ.

Уг хувилбарын давуу тал нь төрийн ачааллыг бууруулах, үйлчилгээний төрөл, хэлбэрийг нэмэгдүүлэх, иргэдэд сонголт бий болгох, үйлчилгээний хүртээмжийг өргөжүүлэх боломжтойд оршино. Мөн төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн туршлага, нөөц боломжийг ашиглан үйлчилгээний чанар, үр ашгийг дээшлүүлэх боломжтой.

Гэвч асрах үйлчилгээ нь нийгмийн хамгааллын шинжтэй, урт хугацааны санхүүжилт шаарддаг, үйлчилгээний өртөг өндөртэй салбар учир зах зээлийн зарчмаар бие даан хөгжих боломж хязгаарлагдмал байдаг. Иймээс зөвхөн хувийн хэвшил, төрийн бус байгууллагад тулгуурлан асуудлыг бүрэн шийдвэрлэх боломжгүй юм.

Түүнчлэн асрах үйлчилгээний салбарт хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэхийн тулд эрх зүйн тодорхой зохицуулалт, төрийн дэмжлэг, санхүүжилтийн механизм, үйлчилгээний стандарт, чанарын хяналтын тогтолцоо зэрэг суурь нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай байна. Ийм нөхцөл бүрдээгүй тохиолдолд үйлчилгээний хүртээмж, тогтвортой байдал, чанарыг хангах боломж хязгаарлагдмал хэвээр үлдэнэ.

Иймд төрийн бус байгууллага болон хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг хэрэгжүүлэх нь асрах үйлчилгээний тогтолцооны чухал бүрэлдэхүүн хэсэг байж болох боловч тулгамдсан асуудлыг дангаар нь шийдвэрлэх хангалттай хувилбар гэж үзэх боломжгүй байна. Харин энэхүү хувилбарыг төрийн бодлого, эрх зүйн зохицуулалт, санхүүгийн дэмжлэгтэй уялдуулан хэрэгжүүлэх нь илүү үр дүнтэй гэж үзэв.

4.6.Захиргааны шийдвэр гаргах:

Энэ хувилбар нь төрийн эрх бүхий байгууллагаас дүрэм, журам, заавар, шийдвэр зэрэг захиргааны акт гаргах замаар тулгамдсан асуудлыг зохицуулахад чиглэнэ.

Уг хувилбарын давуу тал нь тодорхой асуудлыг харьцангуй богино хугацаанд зохицуулах, хэрэгжилтийг шуурхай эхлүүлэх боломжтойд оршино. Мөн хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулахгүйгээр зарим харилцааг зохицуулах боломж бүрдэнэ.

Гэвч асрах үйлчилгээтэй холбоотой өнөөгийн тулгамдсан асуудал нь үйлчилгээний төрөл, хэлбэр, үйлчилгээ үзүүлэгч болон үйлчилгээ авагчийн эрх, үүрэг, санхүүжилт, төрийн болон хувийн хэвшлийн оролцоо, үйлчилгээний чанар, хяналт зэрэг олон талт харилцааг хамарч байгаа тул зөвхөн захиргааны акт гаргах замаар бүрэн шийдвэрлэх боломжгүй юм.

Түүнчлэн захиргааны акт нь хуульд заасан эрх зүйн үндэслэлд тулгуурлан гардаг бөгөөд хуульд зохицуулаагүй шинэ харилцаа, эрх, үүрэг,

санхүүжилтийн тогтолцоог бие даан бий болгох боломжгүй байдаг. Иймээс энэхүү хувилбар нь асуудлын үндсэн шалтгааныг арилгах, тогтвортой эрх зүйн орчин бүрдүүлэхэд хангалтгүй гэж үзэв.

Иймд захиргааны шийдвэр гаргах нь тодорхой асуудлыг зохицуулах туслах шинжтэй арга хэмжээ байж болох боловч асрах үйлчилгээтэй холбоотой тулгамдсан асуудлыг цогцоор нь шийдвэрлэх үр дүнтэй хувилбар гэж үзэх боломжгүй байна.

4.7.Хууль тогтоомжийн төсөл боловсруулах:

Дээр дурдсан зохицуулалтын хувилбаруудыг харьцуулан судалж үзэхэд шинээр зохицуулалт хийхгүй байх, олон нийтэд мэдээлэл түгээх, зах зээлийн эдийн засгийн арга хэрэгсэл ашиглах, төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх, төрийн бус байгууллага болон хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг хэрэгжүүлэх, захиргааны шийдвэр гаргах зэрэг хувилбарууд нь асуудлыг дангаар нь бүрэн шийдвэрлэх боломжгүй байна.

Асрах үйлчилгээтэй холбоотой өнөөгийн тулгамдсан асуудал нь үйлчилгээний төрөл, хэлбэр, үйлчилгээ үзүүлэгч болон үйлчилгээ авагчийн эрх, үүрэг, санхүүжилт, төрийн болон хувийн хэвшлийн оролцоо, үйлчилгээний чанар, хяналт, хариуцлага зэрэг олон талт харилцааг хамарч байгаа тул эдгээрийг цогцоор нь зохицуулах эрх зүйн үндэс шаардлагатай байна.

Иймээс асрах үйлчилгээний харилцааг бие даасан байдлаар зохицуулсан хууль тогтоомжийн төсөл боловсруулах нь асуудлыг шийдвэрлэх хамгийн оновчтой бөгөөд үр дүнтэй хувилбар гэж үзэв.

Асрах үйлчилгээний тухай бие даасан хууль батлагдсанаар үйлчилгээний төрөл, хэлбэр, стандарт, санхүүжилтийн тогтолцоо, төрийн болон хувийн хэвшлийн оролцоо, үйлчилгээ үзүүлэгч болон үйлчилгээ авагчийн эрх, үүргийг тодорхой болгож, асрах үйлчилгээний хүртээмж, чанар, үр нөлөөг дээшлүүлэх эрх зүйн орчин бүрдэх боломжтой.

Мөн төрөөс үйлчилгээ худалдан авах, хувийн хэвшил болон төрийн бус байгууллагын оролцоог дэмжих, үйлчилгээний чанар, хяналт, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох, асрах үйлчилгээ шаардлагатай иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах нөхцөл бүрдэх ач холбогдолтой юм.

Иймд тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зохицуулалтын хувилбаруудаас хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбар нь зорилгод хүрэх боломж, хэрэгжилтийн үр нөлөө, тогтвортой байдлын хувьд хамгийн тохиромжтой хувилбар гэж дүгнэв.

Сонгосон зохицуулалтын хувилбарын эерэг болон сөрөг талыг харьцуулан судлах:

Үүнд сонгон авсан Хууль тогтоомжийн төсөл боловсруулах зохицуулалтын хувилбарын эерэг болон сөрөг талыг харьцуулан судлаж үзвэл:

1.Зорилгод хүрэх байдал:

Асрах үйлчилгээний харилцааг бие даасан хуулиар зохицуулах нь тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зорилгод хүрэх хамгийн оновчтой хувилбар гэж үзэж байна.

Асрах үйлчилгээний тухай хууль батлагдсанаар асрах үйлчилгээний төрөл, хэлбэр, стандарт, үйлчилгээ үзүүлэгчид тавигдах шаардлага, үйлчилгээ авагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах эрх зүйн үндэс бүрдэх боломжтой болно. Мөн үйлчилгээний чанар, хүртээмж, аюулгүй байдалд тавих хяналтын тогтолцоог боловсронгуй болгож, үйлчилгээ үзүүлэгчдийн үйл ажиллагаанд тавигдах нэгдсэн шаардлагыг тодорхойлох нөхцөл бүрдэнэ.

Түүнчлэн төр, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн оролцоог дэмжих эрх зүй, эдийн засгийн механизмыг бүрдүүлэх замаар үйлчилгээний төрөл, сонголт, хүртээмжийг нэмэгдүүлэх боломжтой. Ингэснээр асрах үйлчилгээ шаардлагатай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхэд болон бусад зорилтот бүлгийн иргэдийн хэрэгцээнд нийцсэн үйлчилгээг илүү үр дүнтэй хүргэх нөхцөл бүрдэх юм.

Иймээс энэхүү зохицуулалтын хувилбар нь асрах үйлчилгээний тогтолцоог хөгжүүлэх, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, үйлчилгээ авагчийн эрхийг хамгаалах, төрийн болон хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлэх зэрэг зорилгод хүрэх боломж хамгийн өндөртэй хувилбар гэж үнэлэгдэв.

2.Зардал, үр өгөөжийн харьцаа:

Асрах үйлчилгээний харилцааг бие даасан хуулиар зохицуулснаар үйлчилгээний төрөл, хэлбэр өргөжиж, үйлчилгээ үзүүлэгчдийн эрх зүйн орчин тодорхой болохын зэрэгцээ төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх боломж бүрдэнэ. Мөн асрах үйлчилгээний салбарт олон улсын сайн туршлага, шинэ үйлчилгээний загварыг нэвтрүүлэх эрх зүйн үндэс бий болно.

Хэдийгээр хууль хэрэгжүүлэх эхний үе шатанд зохицуулалт, хяналт, сургалт, үйлчилгээний санхүүжилттэй холбоотой тодорхой хэмжээний нэмэлт зардал шаардагдах боловч урт хугацаанд үйлчилгээний хүртээмж, чанар, үр

нөлөө сайжирснаар нийгмийн хамгааллын тогтолцооны үр ашиг нэмэгдэх боломжтой.

Түүнчлэн төрөөс бүх үйлчилгээг дангаар үзүүлэх бус, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн оролцоог дэмжих замаар үйлчилгээний нөөц боломж өргөжиж, төсвийн хөрөнгийг илүү үр ашигтай зарцуулах нөхцөл бүрдэнэ. Үүний үр дүнд асрах үйлчилгээ шаардлагатай иргэдэд хүрэх үйлчилгээний чанар, хүртээмж нэмэгдэж, нийгмийн хамгааллын тогтолцооны урт хугацааны үр өгөөж дээшлэх боломжтой гэж үзэж байна.

Иймээс энэхүү зохицуулалтын хувилбар нь хэрэгжилтийн эхний үе шатанд тодорхой хэмжээний зардал шаардах боловч нийгэм, эдийн засагт үзүүлэх урт хугацааны үр өгөөж нь гарах зардлаас өндөр байх боломжтой гэж үнэлэгдэв.

ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ

Сонгосон хувилбарын үр нөлөөг тус аргачлалын дагуу ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлтийг нэгтгэн гаргалаа. Үүнд:

Хүснэгт 1

ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар	
1.Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж байгаа эсэх	1.1.Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх				
	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Тийм	Үгүй	Ямар сөрөг байхгүй	нэгэн нөлөө
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй		
	1.1.3.Тодорхой эмзэг бүлгийн нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ бол олон улсын болон үндэсний хууль тогтоомжид заасан хүний эрхийн хэм хэмжээтэй нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй		
	1.2.Оролцоог хангах				
	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	Тийм	Үгүй		
	1.2.2.Зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй		

	1.3.Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал, хариуцлага			
	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм	Үгүй	
	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, хүний эрхийг хамгаалах механизмийн талаар НҮБ-аас өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	
	1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	Тийм	Үгүй	
2.Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1.Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах тохиолдолд энэ нь хууль ёсны ашиг сонирхолд нийцсэн эсэх	Тийм	Үгүй	
	2.2.Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх	Тийм	Үгүй	
3.Эрх агуулагч [8]	3.1.Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	
	3.2.Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	
	3.3.Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	Тийм	Үгүй	
	3.4.Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх (хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй)	Тийм	Үгүй	

4.Үүрэг хүлээгч [9]	4.1.Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	
5.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1.Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Тийм	Үгүй	
	5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Тийм	Үгүй	

Хүснэгт 2

ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	
	1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)	Тийм	Үгүй	
	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	Тийм	Үгүй	
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх	Тийм	Үгүй	
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх	Тийм	Үгүй	

	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх	Тийм	Үгүй	
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх	Тийм	Үгүй	
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх	Тийм	Үгүй	
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх	Тийм	Үгүй	
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсч байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх	Тийм	Үгүй	
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх	Тийм	Үгүй	
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	
6.Инноваци болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Тийм	Үгүй	

	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	Тийм	Үгүй	
7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	Тийм	Үгүй	
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	Тийм	Үгүй	
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	
9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх	Тийм	Үгүй	
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	Тийм	Үгүй	
10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Тийм	Үгүй	

11.Олон улсын харилцаа	10.3.Инфляци нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	
	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	

Хүснэгт 3

НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх	Тийм		
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх	Тийм	Үгүй	
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх	Тийм	Үгүй	
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх	Тийм	Үгүй	

3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт	Тийм	Үгүй	
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	
5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	
	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд,	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	

боловсролын систем	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	

БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Агаар	1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	
2.Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх	Тийм	Үгүй	
	2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	
	2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	
	2.4.Тээврийн агаарын хэрэгслийн бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	
3.Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	Тийм	Үгүй	
	3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	
	3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	
	3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	
4.Усны нөөц	4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	
	4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	
	4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	

5.Хөрсний бохирдол	5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	
	5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	
6.Газрын ашиглалт	6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх	Тийм	Үгүй	
	6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	
	6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	
7.Нөхөн сэргээгдэх/ нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхийг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх	Тийм	Үгүй	
	7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	

4.5.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хууль тогтоомжинд нийцсэн байдал.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 5 дахь хэсэгт Монгол Улсын иргэн өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөний тусламж авах эрхтэй гэж заасан байдаг. Мөн иргэн эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй бөгөөд төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангах нөхцөлийг бүрдүүлэх үүргийг хүлээдэг.

Асрах үйлчилгээний тухай хуулийн төсөл нь асрах үйлчилгээ шаардлагатай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхэд болон бусад зорилтот бүлгийн иргэдийн нийгмийн хамгаалал, үйлчилгээ авах боломжийг өргөжүүлэх, тэдний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахад чиглэж байгаа тул Монгол Улсын Үндсэн хуульд нийцэж байна.

Түүнчлэн Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 22 дугаар зүйлд хүн бүр нийгмийн хамгаалал эдлэх эрхтэй болохыг, 25 дугаар зүйлд өвчлөх, тахир дутуу болох, өндөр наслах болон өөрөөс үл хамаарах шалтгаанаар амьжиргааны эх үүсвэргүй болсон тохиолдолд нийгмийн хамгаалал, тусламж авах эрхтэй болохыг тус тус тунхагласан байдаг.

Мөн Монгол Улсын нэгдэн орсон Нэгдсэн Үндэстний Байгууллага-ын Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц болон ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалахтай холбоотой олон улсын эрх зүйн нийтлэг зарчим, стандартад тусгагдсан нийгмийн хамгаалал, хүний нэр төртэй амьдрах эрхийг хэрэгжүүлэхэд энэхүү хуулийн төсөл чиглэж байна.

Түүнчлэн хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, Ахмад настны тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжтой уялдсан байдлаар боловсруулагдсан болно.

Иймд Асрах үйлчилгээний тухай хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, хүний эрхийн нийтлэг зарчим болон хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн үзэл баримтлалтай нийцэж байна гэж үзэв.

ЗУРГАА. ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

УИХ-ын гишүүн, хууль санаачлагч Д.Энхтуяагийн захиалгаар УИХ-ын Тамгын газрын дэргэдэх Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнгээс 2024 онд “Ахмад настны төрөлжсөн асрамжийн үйлчилгээний төвийн эрх зүйн зохицуулалтын талаархи харьцуулсан судалгаа”-г гүйцэтгэсэн байна.

Уг судалгааны хүрээнд ХБНГУ, БНСУ, Их Британи, Япон улсын ахмад настны төрөлжсөн асрамжийн үйлчилгээний эрх зүйн зохицуулалт, үйлчилгээний тогтолцоо, төрийн оролцоо, санхүүжилтийн механизм болон үйлчилгээний стандартын талаар харьцуулан судалж, холбогдох дүгнэлт, зөвлөмж боловсруулсан байна.

Иймд дээрх судалгаагаар өндөр хөгжилтэй орнуудын эрх зүйн зохицуулалт, бодлогын туршлагыг харьцангуй дэлгэрэнгүй судалсан гэж үзэж байгаа тул энэхүү судалгааны ажлын хүрээнд ижил агуулгатай харьцуулсан судалгааг давтан хийхээс зайлсхийв.

Харин Асрах үйлчилгээний тухай хуулийн төслийн үзэл баримтлал, зорилготой уялдуулан асрах үйлчилгээ, урт хугацааны асаргаа, нийгмийн хамгааллын тогтолцооны чиглэлээр онцлог туршлага хуримтлуулсан Финланд Улс болон Бүгд Найрамдах Солонгос Улсын бодлого, эрх зүйн зохицуулалт, санхүүжилтийн тогтолцоонд нэмэлт шинжилгээ хийж, холбогдох сайн туршлагыг судлан үзэв.

Энэхүү харьцуулсан судалгааны зорилго нь Монгол Улсад асрах үйлчилгээний эрх зүйн орчныг боловсронгуй болгох, үйлчилгээний хүртээмж,

чанар, тогтвортой байдлыг хангах чиглэлээр олон улсын сайн туршлагаас суралцах, хууль тогтоомжийн төсөл боловсруулахад шаардлагатай санал, дүгнэлт гаргахад оршино.

Финланд улс

Дэлхийн олон улс орон хүн амын насжилт, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо өсөж байгаа нөхцөлд асаргаа, халамжийн үйлчилгээний тогтолцоог хөгжүүлэхэд онцгой анхаарч байна. Энэ хүрээнд асрахуйн эдийн засгийг хөгжүүлж, урт хугацааны асаргаа, халамжийн цогц тогтолцоог бүрдүүлсэн орнуудын нэг нь Финланд улс юм. Финланд улс нь халамжийн төрийн загварт тулгуурлан ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон байнгын асаргаа шаардлагатай иргэдэд үзүүлэх үйлчилгээний хүртээмж, чанарыг төрийн бодлогын тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлж ирсэн бөгөөд гэрээр үзүүлэх үйлчилгээ, олон нийтийн суурьтай асаргаа, байгууллагын үйлчилгээ, нөхөн сэргээх болон дэмжих үйлчилгээг уялдуулан хэрэгжүүлдэг онцлогтой.

Финланд улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлд “Амьжиргааны наад захын хэрэгцээгээ хангах боломжгүй иргэн амьжиргааны дэмжлэг болон нийгмийн халамжид хамрагдах эрхтэй. Хүн бүр ажилгүйдэлд өртөх, өвчлөх, хөгжлийн бэрхшээлтэй болох, өндөр наслах, амаржих болон тэжээгчээ алдсан тохиолдолд амьжиргааны наад захын эх үүсвэрээр хангагдах эрхтэй. Төрөөс хуульд заасан, иргэний хэрэгцээ шаардлагад нийцсэн нийгмийн үйлчилгээ, эрүүл мэнд, эмнэлгийн үйлчилгээ болон хүн амын эрүүл мэндийг дэмжих баталгааг бүрдүүлнэ. Төрөөс хүүхдийн сайн сайхан байдал, эрүүл мэнд, хөгжих эрхийг хангахад эцэг эх, асран хамгаалагчдын оролцоог дэмжинэ.”⁶ гэж заажээ.

Төрөөс иргэний хэрэгцээ шаардлагад нийцсэн нийгмийн үйлчилгээ, эрүүл мэндийн болон эмнэлгийн үйлчилгээний хүртээмжийг хангах, хүн амын эрүүл мэндийг дэмжих эрх зүйн баталгааг бүрдүүлэх үүргийг хүлээдэг. Мөн хүүхдийн сайн сайхан байдал, эрүүл мэнд, хөгжих эрхийг хангах зорилгоор эцэг эх, асран хамгаалагчдын оролцоог дэмжих төрийн үүргийг Үндсэн хуулийн түвшинд тодорхойлсон байдаг.

Энэхүү зохицуулалт нь асрах, халамжлах үйлчилгээг зөвхөн нийгмийн халамжийн арга хэмжээ гэж үзэхээс илүүтэйгээр хүний нэр төртэй амьдрах эрх, нийгмийн хамгаалал авах эрхийг хэрэгжүүлэх үндэс гэж үзэж байна. Иймээс асрах үйлчилгээ нь хүний үндсэн хэрэгцээг хангах, бие даан амьдрах чадварыг дэмжих, гэр бүл болон асран хамгаалагчдын ачааллыг бууруулах нийгмийн хамгааллын цогц тогтолцооны нэг хэсэг болж хөгжсөн байна.

⁶ Бүгд найрамдах Финланд улсын Үндсэн хууль, УБ., 2024 он, 10 дахь тал

“Disability Services Act” нэртэй шинэ хууль 2025 оны 1 сараас хүчин төгөлдөр болсон бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүн бүрт тэгш боломжтой амьдрах нийгэмд оролцох нөхцөлтэй байх эрхийг баталгаажуулсан байна.

Ахмад настны тухайд “Social Welfare Act” болон мөн олон нийтийн үйлчилгээний байгууллагуудын гүйцэтгэх үүрэг тогтоосон хууль эрх зүйн орчинтой. Энэ нь зөвхөн тусгай төвлөрсөн “асрах газар” биш, тухайн хүн өөрийн гэр орондоо, байрлах орчиндоо боломжийн нөхцөлд амьдрах боломжийг голлодог байна.

2.БНСУ

Бүгд Найрамдах Солонгос Улс нь дэлхийн хамгийн хурдацтай насжилт явагдаж буй орнуудын нэг бөгөөд ахмад настанд үзүүлэх урт хугацааны асаргаа, халамжийн үйлчилгээний эрх зүйн орчин, удирдлага, санхүүжилтийн тогтолцоог эртнээс хөгжүүлэн хэрэгжүүлж ирсэн туршлагатай улс юм.

Бүгд Найрамдах Солонгос Улсад нийгмийн хамгаалал, халамжийн чиглэлээр ахмад настанд үзүүлж байгаа 14 төрлийн үйлчилгээг таван чиглэлд хуваасан байна. Эхний гурван чиглэл нь бие махбодын дэмжлэг, гэрийн ажилд үзүүлэх дэмжлэг, хөдөлгөөнт дэмжлэг гэсэн асрах үйлчилгээтэй шууд холбоотой үйлчилгээнүүд юм. Үлдсэн хоёр чиглэл нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих буюу хөдөлмөр эрхлэлтийн зөвлөгөө, ажлын байрны сургалт, чөлөөт цагаа өнгөрүүлэх үйлчилгээтэй холбоотой байна. Бүгд Найрамдах Солонгос Улсад ахмад настан урт хугацааны тусламж, үйлчилгээ авах үйл явц харьцангуй шат дамжлага багатай явагддаг ба ахмад настанд асрамжийн үйлчилгээ хүргэлтийг дараах дөрвөн субъект хариуцдаг байна. Үүнд:

- төр дангаараа хариуцсан
- төр хувийн хэвшил хамтарсан
- хувийн хэвшил дангаар
- сүм хийд буяны байгууллага орно.⁷

Бүгд Найрамдах Солонгос Улсад ахмад настны урт хугацааны асаргаа, халамжийн үйлчилгээ авах үйл явц нь харьцангуй энгийн, шат дамжлага багатай зохион байгуулагддаг бөгөөд үйлчилгээний хүргэлтэд төр, хувийн хэвшил болон иргэний нийгмийн байгууллагууд хамтран оролцдог тогтолцоотой байна.

⁷ Я.Отгонбаяр, Г.Түмэннаст нар, Ахмад настны асрамжийн үйлчилгээний харьцуулсан судалгаа: БНСУ, Монгол Улсын жишээгээр, Монголын хүн амын сэтгүүл, №34, 2024 он, 117 дахь тал

Энэхүү олон талт оролцоонд суурилсан тогтолцооны үр дүнд асрамж, асаргааны үйлчилгээний хүртээмж, чанар харьцангуй өндөр түвшинд хүрч, ахмад настны хэрэгцээнд нийцсэн урт хугацааны тусламж, үйлчилгээг үр ашигтай хүргэж байна.

ЗУРГАА.ЗӨВЛӨМЖ

Тулгамдсан асуудлыг шийдвэрлэх боломжит хувилбаруудыг зорилгод хүрэх байдал, хэрэгжилтийн боломж, зардал-үр ашгийн харьцаа, нийгэм, эдийн засагт үзүүлэх үр нөлөө зэрэг шалгуураар харьцуулан судалж үнэлгээ хийсэн.

Үнэлгээний хүрээнд шинээр эрх зүйн зохицуулалт бий болгохгүй байх, мэдээлэл түгээх болон ухуулан сурталчлах арга хэмжээ хэрэгжүүлэх, зах зээлийн эдийн засгийн арга хэрэгслээр зохицуулах, төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх, төрийн бус байгууллага болон хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг хэрэгжүүлэх, захиргааны шийдвэрээр зохицуулах зэрэг хувилбаруудыг авч үзсэн болно.

Судалгааны үр дүнгээс үзэхэд дээрх хувилбарууд нь асрах үйлчилгээний эрх зүйн орчны хийдлийг бүрэн арилгах, үйлчилгээний чанар, хүртээмж, стандарт, санхүүжилт, хяналтын тогтолцоог цогцоор нь бүрдүүлэхэд хангалтгүй гэж үзсэн. Тухайлбал, зөвхөн мэдээлэл сурталчилгаа хийх болон захиргааны арга хэмжээгээр зохицуулах нь үйлчилгээний эрх зүйн үндэс, оролцогчдын эрх, үүргийг тодорхой болгох боломжгүй бөгөөд санхүүжилт, хяналт, төрийн дэмжлэгийн тогтолцоог бүрэн бүрдүүлэхэд хүрэлцэхгүй байна.

Иймд тулгамдсан асуудлыг шийдвэрлэх хамгийн оновчтой хувилбар нь Асрах үйлчилгээний тухай бие даасан хууль баталж, эрх зүйн цогц зохицуулалт бий болгох хувилбар гэж үзсэн. Энэхүү хувилбар нь зорилгод хүрэх боломж, хэрэгжилтийн үр нөлөө, зардал-үр ашгийн харьцааны хувьд бусад хувилбараас илүү үр ашигтай бөгөөд тогтвортой шийдэл болох нь тогтоогдсон.

Асрах үйлчилгээний тухай бие даасан хууль батлагдсанаар асрах үйлчилгээний төрөл, хэлбэр, стандарт, үйлчилгээ үзүүлэгчид тавигдах шаардлага, үйлчилгээ авагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах механизм, төрийн дэмжлэг, санхүүжилт, хяналтын тогтолцоог цогцоор нь бүрдүүлэх боломж бүрдэнэ.

Мөн төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх эрх зүйн болон эдийн засгийн нөхцөл бүрдэхийн зэрэгцээ үйлчилгээний хүртээмж, чанар сайжирч, асрах үйлчилгээ шаардлагатай иргэдийн хэрэгцээг илүү үр дүнтэй хангах нөхцөл бүрдэх юм. Үүний үр дүнд төрөөс дангаар үзүүлж байгаа халамжийн үйлчилгээний ачаалал буурч, үйлчилгээний олон төрөлт, өрсөлдөөн, үр ашиг нэмэгдэн, нийгмийн хамгааллын тогтолцооны чанар, үр өгөөж дээшлэх ач холбогдолтой.

ДОЛОО.АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

1.Хууль

- 1.Монгол Улсын Үндсэн хууль;
- 2.Нийгмийн халамжийн тухай хууль;
- 3.Нийгмийн даатгалын тухай хууль;
- 4.Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль;
- 5.Хөдөлмөрийн тухай хууль;
- 6.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль;
- 7.Хүүхэд харах үйлчилгээний тухай хууль;
- 8.Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль;
- 9.Эх эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хууль;
- 10.Ахмад настны тухай хууль;
- 11.Хүүхэд хамгааллын тухай хууль;
- 12.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль;

2.Тогтоол, дүрэм, журам

1.Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоол, Хөгжлийн бэрхшээлтэй хүнд тусламж, хөнгөлөлт үзүүлэх журам;

2.Засгийн газрын 2024 оны 245 дугаар тогтоол, Ахмад настны асрамжийн үйлчилгээ шинээр үзүүлэх, барилга байгууламж барих аж ахуй нэгж, байгууллагад төрөөс нэг удаагийн дэмжлэг үзүүлэх журам;

3.Засгийн газрын 2025 оны 241 дугаар тогтоол, Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай;

4.Сангийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан 2018 оны А/03/А/03 тоот тушаал, Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалттай асрамжийн газарт санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам;

5.ХНСХ-ын сайдын 2023 оны А/180 тушаал, Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ болон ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүнд зарим төрлийн үйлчилгээ үзүүлэх иргэн, ААН, ТББ-ыг магадлан итгэмжлэх журам;

6.ХНХС-ын сайдын 2023 оны А/190 тушаал, “Төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа ахмад настан, 18 нас ба түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй иргэнд тэтгэвэр олгох журам;

7.ХНХС-ын сайдын 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдөр А/189 тушаал, “Төрөлжсөн асрамжийн газрын төсвийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам;

8.ХНХС-ын 2023 оны А/191 дүгээр тушаал, Төрөлжсөн асрамжийн газрыг магадлан итгэмжлэх журам;

--ooOOoo--



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР
ПАРЛАМЕНТЫН СУДАЛГАА,
ХӨГЖЛИЙН ХҮРЭЭЛЭН

**АХМАД НАСТНЫ ТӨРӨЛЖСӨН АСРАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ТӨВИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААРХ ХАРЬЦУУЛСАН
СУДАЛГАА**

Судалгааны төрөл: **Харьцуулсан судалгаа**
Судалгааны код: **СТ-24/226**
Хугацаа: **2024.12.11**

ЗАХИАЛАГЧ: УИХ-ын гишүүн Д.Энхтуяа

Хянасан: ПСХХ-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга Д.Онолт

Судалгаа удирдсан: ПСХХ-ийн Судалгааны хэлтсийн дарга П.Түмэнцэцэг

Судлаач: Б.Батцэцэг, Э.Дашзэгвэ, Д.Жигваагүнсэл,
О.Нарантуяа, Р.Оргилмаа

Улаанбаатар хот, 2024

АГУУЛГА

Удиртгал	3
Судалгааны хураангуй	4
1.Ахмад настны төрөлжсөн асрамжийн үйлчилгээний төвийн үйл ажиллагааны менежмент.....	6
2.Ахмад настны төрөлжсөн асрамжийн үйлчилгээний төвийн барилга, байгууламж, орчны тохижилт, дэд бүтцийн стандарт.....	13
3.Ахмад настны төрөлжсөн асрамжийн үйлчилгээний төвийн хүний нөөцийг бэлтгэх давтан сургах.....	25
4.Ахмад настны төрөлжсөн асрамжийн үйлчилгээний төвийн үйл ажиллагааны санхүүжилт	30
Ашигласан материал.....	35

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1: ХБНГУ, Их Британи, БНСУ, Япон, Монгол Улсын АНТАУТ-ийн Харьцуулалт.....	5
Хүснэгт 2: Их Британи Улсын асрамжийн газрын төрөл, тэдгээрийн үйлчилгээ	8
Хүснэгт 3: БНСУ-ын ахмадын асрамжийн газрын ажилтнуудын орон тоо	10
Хүснэгт 4: Япон Улсын асрамжийн газрын хүний нөөцийн стандарт (29 хүртэлх үйлчлүүлэгчтэй асрамжийн газарт)	11
Хүснэгт 5: ХБНГУ-ын асрамжийн газрын барилга байгууламжид тавигдах доод стандарт.....	13
Хүснэгт 6: БНСУ-ын ахмадын асрамжийн газарт тавих үндсэн шаардлага	21
Хүснэгт 7: БНСУ-ын асрамжийн газрын орон зайн бүс ба шаардлагатай өрөөнүүдийн тохиргооны систем	22
Хүснэгт 8: БНСУ-ын асрамжийн газрын тусгай стандарт.....	22
Хүснэгт 9: Япон Улсын асрамжийн газрын барилга, байгууламжийн стандарт	24
Хүснэгт 10: Мэргэшсэн сувилахуйн мэргэжилтэн бэлтгэх, давтан сургалтын талаарх мэдээлэл	25
Хүснэгт 11: Асрамжийн газруудын санхүүжилтийн эх үүсвэр.....	30

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АНТАУТ	Ахмад настны төрөлжсөн асрамжийн үйлчилгээний төв
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
НХАУ	Нийгмийн халамжийн асрах үйлчилгээ
НХТХ	Нийгмийн халамжийн тухай хууль
ТЗБ	Төрийн захиргааны байгууллага
ТЗТБ	Төрийн захиргааны төв байгууллага
УИХ	Улсын Их Хурал
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ХХҮЕГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

УДИРТГАЛ

УИХ-ын гишүүн Д.Энхтуяагийн захиалгаар “Ахмад настны төрөлжсөн асрамжийн үйлчилгээний төвийн эрх зүйн зохицуулалтын талаарх харьцуулсан судалгаа”-г Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнд гүйцэтгэв.

Судалгааны зорилго: Улс орнуудын ахмад настны төрөлжсөн (олон хувилбарт) асрамжийн үйлчилгээний төвийн эрх зүйн зохицуулалтын онцлог, ижил төстэй байдлыг харьцуулан судлах.

Судалгааны хамрах хүрээ, бүтэц: Захиалагчаас ирүүлсэн хүсэлтийн дагуу ХБНГУ, БНСУ, Их Британи, Япон болон Монгол Улсын ахмад настны төрөлжсөн асрамжийн үйлчилгээний төв (АНТАҮТ)-ийн үйл ажиллагааны дараах үндсэн асуудлуудыг хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжийн хүрээнд нь харьцуулан судаллаа. Үүнд:

1. АНТАҮТ-ийн үйл ажиллагааны менежмент (Удирдлага, зохион байгуулалтын бүтэц, харьяалал гэх мэт);
2. АНТАҮТ-ийн барилга, байгууламж, орчны тохижилт, дэд бүтцийн стандарт;
3. АНТАҮТ-ийн эмч, асрагч, сувилагч зэрэг мэргэшсэн ажилтнуудыг бэлтгэх, давтан сургах;
4. АНТАҮТ-ийн үйл ажиллагааны санхүүжилт зэрэг асуудлыг зохицуулж буй хууль тогтоомжийн хүрээнд нь харьцуулан судласан.

Судалгааны бүтцийн хувьд асуудал тус бүрийг нэг бүлэгт багтаан дээрх дарааллын дагуу бүлэглэж, тухайн асуудлаарх ХБНГУ, БНСУ, Их Британи, Япон, Монгол улсуудын эрх зүйн зохицуулалтыг харьцуулсан байдлаар оруулсан болно.

Судалгааны арга зүй: Судалгааг тухайн улсын холбогдох хууль тогтоомж болон АХБ зэрэг олон улсын байгууллагын санхүүжилттэй судалгааны төслийн ажлын тайлан, зөвлөмж, болон бусад байгууллага, эрдэмтэн судлаачдын бүтээлд судалгааны захиалга болон удирдамжид заасан чиглэлийн дагуу холбогдох мэдээллийг харьцуулан судлах, нэгтгэн дүгнэх арга зүйг ашиглан гүйцэтгэв.

Түлхүүр үг: *ахмад настан, төрөлжсөн асрамжийн үйлчилгээ ахмад настны төрөлжсөн (хувилбарт) асрамжийн төв*

Keywords: *elderly, specialized care service, specialized care service for elderly*

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Энэхүү судалгаанд харьцуулан судалсан ХБНГУ, Их Британи, БНСУ, Япон зэрэг улсууд Ахмад настны төрөлжсөн асрамжийн үйлчилгээний ерөнхий болон тусгай шаардлага, барилга байгууламжийн стандартыг нарийвчлан тогтоож, мөрдүүлдэг байна.

Нийтлэг байдлаар төр, хувийн хэвшил болон ашгийн бус байгууллагын аль аль нь энэхүү үйлчилгээг үзүүлж болох бөгөөд тухайн үйлчилгээний ерөнхий болон тусгай шаардлага, барилга байгууламжийн стандарт, норм, шалгуурыг хангасан хэн боловч тусгай зөвшөөрлийн үндсэн дээр ахмад настны төрөлжсөн асрамжийн үйлчилгээний төв (АНТАУТ) ажиллуулах боломжтой ажээ. ХБНГУ, Их Британи улсуудын асрамжийн газрын үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт харьцангуй нарийвчилсан, тодорхой байгаа бол Монгол Улсын энэ талаарх зохицуулалт хэт ерөнхийлсөн байна.

ХБНГУ, Их Британи, БНСУ, Япон Улсын АНТАУТ-ийн тусгайлсан стандартад өрөөний талбайн хэмжээ, байрлал, тоног төхөөрөмж, гэрэлтүүлэг, саадгүй нэвтрэх боломж болон бусад нэмэлт тоноглолуудын талаар нарийвчлан тусгадаг байна. Монгол Улсын хувьд АНТАУТ-ийн тусгай стандарт байхгүй боловч үйлчилгээний ерөнхий стандарт, жишиг болгон адилтгаж хэрэглэж болох гадаад орчин, барилга, байгууламжийн 2 стандарт баталсан байдаг ажээ.

ХБНГУ, Их Британи, БНСУ, Япон Улсад АНТАУТ-ийн хүний нөөцийг бэлтгэх үндсэн болон давтан сургалтын хугацаа, хэлбэр, агуулгыг тодорхой тусгасан зохицуулалт байдаг. Тухайлбал, ХБНГУ, Их Британи, Япон Улсад АНТАУТ-ийн ажилтнууд нь тусгай зөвшөөрөл буюу лицензтэй байх ба лицензийг сунгах, кредит оноогоор үнэлэх, мэргэшлийн ур чадварыг тогтмол нэмэгдүүлэх тогтолцоо бүрдэж тогтсон байна. Монгол Улсад гэрээр асаргааны үйлчилгээ үзүүлж буй этгээдийг хамруулах асаргаа, сувилгаа, асрамжлах үйлчилгээний ур чадвар олгох түр сургалт, тус сургалтын агуулга, хамрагдах болзол, нөхцөлийг зохицуулсан журам үйлчилдэг. Гэвч АНТАУТ-ийн хүний нөөцийг бэлтгэх, давтан сургахтай холбоотой тусгайлсан зохицуулалт байхгүй байгаа бөгөөд Эрүүл мэндийн тухай хуульд заасан эмнэлгийн тусламж, үйлчилгээний ерөнхий зохицуулалтын хүрээнд явагдаж байгаа болно.

ХБНГУ, Их Британи, БНСУ, Япон Улсад АНТАУТ-ийн хосолмол санхүүжилтийн хэлбэрийг өргөн ашигладаг. Өөрөөр хэлбэл АНТАУТ нь төр, хувийн хэвшил болон даатгалын санхүүжилтийн эх үүсвэртэй байдаг. Монгол Улсын тухайд, АНТАУТ өмчийн хэлбэрийн хувьд төрийн болон орон нутгийн, хувийн, төрийн бус байгууллагын гэсэн ямар ч хэлбэртэй байсан төрийн санхүүжилт давамгайлсан байдалтай байна. АНТАУТ-д Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын баталсан нэг үйлчлүүлэгчид ногдох зардлын нормативаар тооцон төрөөс санхүүжилт олгодог. Түүнчлэн тухайн АНТАУТ-д асруулагч өндөр настны тэтгэврийн 30 хувийг тухайн асрамжийн байгууллагад олгох зохицуулалттай.

Дээрх улс орнуудын АНТАУТ-ийн үйл ажиллагааны харьцуулалтыг дараах хүснэгтээс харна уу.

Хүснэгт 1: ХБНГУ, Их Британи, БНСУ, Япон, Монгол Улсын АНТАУТ-ийн Харьцуулалт

Улс	Удирдлага, зохион байгуулалтын бүтэц	Барилга байгууламжийн стандарт	Хүний нөөц бэлтгэх, сургах	Санхүүжилт
ХБНГУ	Төвлөрсөн болон салбарласан удирдлагын бүтэцтэй	Асрамжийн газрын доод стандартын тухай журам (Regulation on Minimum Standards for Nursing Homes) ¹	3-6 жил мэргэжлийн сургалтад хамрагддаг, лиценз сунгалттай	Төрийн, хувийн хосолсон санхүүжилт
Их Британи	Бүртгэлтэй менежер, орон нутгийн удирдлага	Асрамжийн газарт баримтлах суурь стандарт (Fundamental standards) ба Ахмад настны асрамжийн газарт баримтлах Үндэсний доод стандарт (National Minimum Standards for Care Homes for Older people) ²	5 түвшний мэргэжлийн хөтөлбөр	Төр, хувийн даатгал, үйлчлүүлэгчийн оролцоо
БНСУ	Улс, хот, хувийн болон дүүргийн асрамж	Ахмадын асрамжийн газарт тавих үндсэн шаардлага болон тусгай стандарт	Давтан сургалт 18-30 цаг, мэргэжлийн хяналт	Төрийн, хувийн хосолсон санхүүжилт
Япон Улс	Мужийн захиргааны хяналтад байдаг.	Асрамжийн барилга байгууламжийн стандарт	3 жилийн сувилахуйн боловсрол	Төрийн (25%), орон нутгийн (45%), хувийн (10-30%) тус тус санхүүжилттэй.
Монгол Улс	Төрийн, хувийн, төрийн бус байгууллагын өмчийн төрөл, хэлбэртэй байж болно.	Ахмад настны асрамжийн үйлчилгээний нийтлэг шаардлага MNS 5823:2016-г мөрддөг. Асрамжийн газрын арилга байгууламжийн нарийвчилсан стандартгүй боловч MNS 6055:2009, MNS 6056:2009 стандартыг мөрдөх боломжтой.	Түр хугацаатай болон асаргаа, сувилгааны ерөнхий мэргэжил, мэргэшил	Төрийн санхүүжилт давамгайлдаг. Нэг үйлчлүүлэгчид ногдох зардлын нормативаар тооцдог. Үйлчлүүлэгчийн тэтгэврийн 30%-ыг асрамжийн газарт олгодог.

¹ Асрамжийн газрын барилгын доод стандартын хууль (HeimMindBauV) <https://n9.cl/gyjt9f>

² https://www.dignityincare.org.uk/_assets/resources/dignity/csipcomment/csci_national_minimum_standards.pdf

1. АХМАД НАСТНЫ ТӨРӨЛЖСӨН АСРАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МЕНЕЖМЕНТ

1.1. Холбооны Бүгд Найрамдах Герман улс

Герман Улсын ахмад настны асрамжийн газрын үйл ажиллагаатай холбоотой үндсэн зохицуулалт нь “Асрамжийн газрын хууль” (Heimgesetz (HeimG))³ юм. Тус хуульд зааснаар **Асрамжийн газар** нь Холбооны гэр бүл, ахмад настан, эмэгтэйчүүд, залуучуудын асуудал эрхэлсэн яам (BMFSFJ), орон нутгийн засаг захиргааны хяналтын дор ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, асаргаа шаардлагатай насанд хүрэгчдэд зөвшөөрөгдсөн мэргэжлийн сувилахуйн болон асрамжийн үйлчилгээг үзүүлэх үүрэгтэй.

Холбооны гэр бүл, ахмад настан, эмэгтэйчүүд, залуучуудын асуудал эрхэлсэн яам нь Холбооны Эдийн засаг, технологийн яам, Холбооны Тээвэр, барилга, хот байгуулалтын яам, Холбооны Эрүүл мэндийн яамдуудтай зөвшилцөн, Бундесратын зөвшөөрлөөр асрамжийн газрын өрөө тасалгаа, зохион байгуулалт, удирдлага, ажилтнуудын асуудал зэрэг хууль тогтоомжид заасан холбогдох, дүрэм, журам, заавруудыг **Асрамжийн газрын доод стандартын тухай журамд** үндэслэн гаргадаг.

Тус улсад ахмад настны асрамжийн газрыг төрийн байгууллага, хувийн компаниуд болон ашгийн бус байгууллагууд Нийгмийн халамжийн хуулийн 5-р хэсэг (SGB V), 11-р хэсэг (SGB XI)-т үндэслэн байгуулж болно. Ингэхдээ хуульд заасан мэргэжлийн ур чадвар, үйлчилгээний чанар, стандартыг хангасны үндсэн дээр тусгай зөвшөөрөл авсан байх шаардлагатай.

Асрамжийн газрын бүтэц, зохион байгуулалтын талаар Асрамжийн газрын хууль, Нийгмийн халамжийн хуулийн (SGB-XI) 11-р хэсэгт зохицуулсан.⁴

Бүтэц, удирдлага, зохион байгуулалт

Герман улсын асрамжийн газрын удирдлагын бүтэц нь тухайн асрамжийн газрын хэмжээ, төрлөөс хамааран өөр өөр байна. Ерөнхийдөө төвлөрсөн болон салбарласан удирдлагын бүтэцтэй байдаг.

1. Төвлөрсөн удирдлага:

Төвлөрсөн удирдлагын бүтэц нь асрамжийн газарт нэг удирдлагаар бүх үйл ажиллагааг зохион байгуулахыг хэлнэ. Энэ нь жижиг, нэг төвтэй асрамжийн газарт тохиромжтой бөгөөд удирдлага нь асрамжийн газрын бүх үйл ажиллагааг хариуцдаг. Бүтэц зохион байгуулалтын хувьд ерөнхий захирал (директор) эсвэл асрамжийн газрын эзэмшигч, ахлах менежер, ажилтнууд (ажилтнууд нь эмч,

³ Heimgesetz (HeimG) <https://www.gesetze-im-internet.de/heimg/BjNR018730974.html>

⁴ Sozialgesetzbuch (SGB) - Elftes Buch (XI) https://www.gesetze-im-internet.de/sgb_11/

сувилагч, асран хамгаалагч-мэргэжлийн ажилтнууд, тогооч, зөвлөх гэх мэт олон төрлийн үйлчилгээ үзүүлэгч)-аас бүрдэнэ.

2. Салбарласан удирдлага:

Том хэмжээтэй асрамжийн газрууд, эсвэл сүлжээ бүхий олон тооны салбар, бүс нутагт байрлах асрамжийн төвүүд нь салбарласан удирдлагатай байдаг. Энэ төрлийн бүтэц нь төвөөс салбар, нэгжүүдийг удирдахад чиглэгддэг бөгөөд удирдлагын тодорхой үүрэг, хариуцлагыг салбаруудын удирдлагад хуваарилдаг. Салбарласан удирдлага бүхий асрамжийн газрын бүтэц, зохион байгуулалт нь төв болон салбар асрамжийн газрууд, туслах нэгжүүд (*салбар бүр өөрийн үйл ажиллагааг зохион байгуулах хэд хэдэн туслах нэгжтэй байж болно. Тухайлбал, эмнэлгийн үйлчилгээ хариуцсан баг, ахмад настнуудын нийгмийн үйлчилгээ хариуцсан баг гэх мэт*)-ээс бүрдэнэ.

Асрамжийн газар (Pflegeheime)-ын ажилтны тоо нь ахмад настны хэрэгцээ, асаргааны түвшин зэргээс хамаардаг. Тухайлбал, Хөнгөн асаргааны хэрэгцээтэй (Pflegegrad 1-2) 2-3 ахмад настанд 1 ажилтан нэг дор асаргааны үйлчилгээ үзүүлэх боломжтой бол хүнд асаргааны хэрэгцээтэй (Pflegegrad 3-5) ахмад настны хувьд 1 үйлчлүүлэгчид 1 ажилтан ногдох байдлаар зохицуулдаг.⁵

Герман Улсын ахмад настны асрамжийн төвийн удирдлагад төлөөлөн удирдах зөвлөл заавал байгуулах хуулийн шаардлага байхгүй ч, асрамжийн газрын үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах, үзэл бодлыг тусгах зорилгоор **Асрамжийн газрын зөвлөлдөх зөвлөл** (Bewohnervertretung)-ийг байгуулж болох тухай Асрамжийн газрын хуулийн 10-р зүйлд заасан байна. Тухайлбал, Асрамжийн газрын үйлчлүүлэгчид нь орон байр, асаргаа, амьдрах нөхцөл, асрамжийн дүрэм, хоол хүнс, чөлөөт цагийн үйл ажиллагаа зэрэг асуудалд Зөвлөлдөх зөвлөлөөр дамжуулан оролцох эрхтэй. Асрамжийн газрын зөвлөлдөх зөвлөл (цаашид Зөвлөлдөх зөвлөл гэх) нь өөрийн эрх, үүргийг хэрэгжүүлэхдээ мэргэжлийн хүмүүсийг оролцуулж болно. Эдгээр хүмүүс нь нууцлалын үүрэгтэй байдаг байна. Зөвлөлдөх зөвлөл нь жилд нэг удаа хуралдах бөгөөд тус хуралд үйлчлүүлэгч бүр өөрийн итгэмжит хүнээ оролцуулах боломжтой.

Хэрэв Зөвлөлдөх зөвлөл байгуулах боломжгүй бол зөвлөлийн үүргийг асрамжийн төлөөлөгч гүйцэтгэнэ. Асрамжийн төлөөлөгчийг асрамжийн газрын удирдлага болон хариуцсан байгууллага хамтран томилох ба тэр бээр сайн дурын үндсэн дээр үйл ажиллагаагаа цалин хөлсгүй гүйцэтгэнэ.

Үйлчлүүлэгч болон тэдний хууль ёсны төлөөлөгчид тухайн төлөөлөгчид нэр дэвшүүлэх, санал гаргах эрхтэй. Гэвч үйлчлүүлэгчдийн оролцоо өөр аргаар хангагдаж байгаа бол хариуцсан байгууллага нь асрамжийн төлөөлөгчийг томилохоос татгалзаж болно.

⁵ Sozialgesetzbuch (SGB) - Elftes Buch (XI) https://www.gesetze-im-internet.de/sgb_11/

1.2. Их Британи

Их Британид Асрамжийн тухай хууль болон Эрүүл мэнд, нийгмийн халамжийн тухай хуулиудаар АНТАУТ-ийн бүтэц, зохион байгуулалтыг зохицуулж байна. Асрамжийн газрын үндсэн 2 төрөл байна. Үүнд:

- Асрамжийн газар (хувийн асрамж үйлчилгээ үзүүлэх, Residential homes);
- Сувилахуйн асрамжийн газар (эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх, Nursing homes).

Их Британи улсад улсын, ашгийн бус буюу сайн дурын, хувийн асрамжийн газрууд олноор үйл ажиллагаа явуулдаг. Бүх асрамжийн газрууд асрах газартаа байрлуулан, хувийн асрамж үйлчилгээ үзүүлдэг бол асаргаа, сувилгаа илүү шаардлагатай үйлчлүүлэгчдэд зориулсан тусгай төрөлжсөн асрамжийн газрууд байдаг. Зарим асрамжийн газрууд хувийн асрамж үйлчилгээ болон эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хамтад нь үзүүлдэг байна.⁶

Хүснэгт 2: Их Британи Улсын асрамжийн газрын төрөл, тэдгээрийн үйлчилгээ

Асрамжийн газрын төрлүүд	Үйлчилгээ
Асрамжийн газар (Care homes)	Хувийн асрамж үйлчилгээ (угаалга, хувцаслах, цагаар эм уулгах, бие засуулах, салхинд гаргах) болон өдрийн аялал, зугаалганд авч явах зэрэг олон нийтийн үйл ажиллагаа зохион байгуулдаг.
Сувилахуйн асрамжийн газар (Care homes with nursing)	Хувийн асрамж үйлчилгээ үзүүлэхийн сацуу мэргэшсэн сувилагч 24 цагийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлдэг.
Сэтгэц, ой санамжаа алдах өвчтэй хүмүүсийг асрах газар (Care homes with dementia care)	Сэтгэц, ой санамжаа алдах өвчтэй хүмүүсийг асрах тусгай сургалтад хамрагдсан сувилагч, асрагч үйлчилгээ үзүүлдэг.
Давхар бүртгэлтэй асрамжийн газрууд (Dual-registered care homes)	Хувийн болон сувилахуйн асрамж үйлчилгээ үзүүлэх хэдий ч эхэндээ зөвхөн хувийн асрамж үйлчилгээ шаардлагатай байсан хүн яваандаа сувилахуйн асаргаа шаардлагатай болдог тул тэдгээр хүмүүсийг өөр асрамжийн газар луу шилжүүлэлгүй үргэлжлүүлэн сувилахуйн үйлчилгээ үзүүлдэг.

Үндэсний хэмжээнд ахмад настны асрамж үйлчилгээг Үндэсний эрүүл мэндийн байгууллага (National Health Service) бүсийн болон орон нутгийн салбар байгууллагуудаараа дамжуулан хүргэж байна. Асрамжийн газруудын үйл ажиллагааны чанар стандартад Асрамж үйлчилгээний чанарын хороо (Care Quality Commission) үндэсний хэмжээний хяналт тавьж ажилладаг. Орон нутгийн түвшинд ахмад настнуудын нийгмийн халамжийн үйлчилгээг асрамжийн газарт болон гэрээр тусламж үйлчилгээ үзүүлэх байдлаар хүргэдэг. Орон нутгийн захиргаа (Local Council)-ны Насанд хүрэгчдийн нийгмийн халамж үйлчилгээний хэлтэс нь тухайн орон нутгийнхаа ахмад настнуудын нийгмийн халамжийн үйлчилгээнд хяналт тавьж ажилладаг байна.

⁶ <https://www.agecuk.org.uk/information-advice/care/arranging-care/care-homes/type-of-care-home/>

Өндөр настны асрамжийн газар нь дараах бүтэц, бүрэлдэхүүнтэй ажиллана.

Үүнд:

- Асрамжийн газрын үйл ажиллагааг эрхлэгч (хувь хүн, хувийн компани, сайн дурын байгууллага, орон нутгийн захиргааны байгууллага);
- Удирдлагуудын зөвлөл (улс даяар хэд хэдэн салбар бүхий асрамжийн газрууд нь удирдлагуудын зөвлөлтэй байна.)
- Бүртгэлтэй менежер (Registered Manager): (Британи улсын асрамж үйлчилгээний бүх байгууллага Асрамж үйлчилгээний чанарын хороонд бүртгэлтэй менежерийг ажиллуулах үүрэгтэй бөгөөд тус менежер нь асрамж үйлчилгээний тусгай мэдлэг, ур чадварыг эзэмшсэн буюу асрах үйлчилгээний мэргэжлийн 5 дугаар түвшинтэй, туршлагатай, асрамжийн газрын үйл ажиллагаа нь стандартын дагуу явж байгаа эсэхэд хяналт тавих чадамжтай байна.)
- Асрамжийн газрын менежер (Care Home Manager): (Асрамжийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах эрх бүхий менежер бөгөөд сүлжээ бүхий томоохон асрамжийн газруудад ихэвчлэн өдөр тутмын үйл ажиллагааг дангаар хариуцан гүйцэтгэдэг бол зарим асрамжийн газар Бүртгэлтэй менежер тус үүргийг давхар гүйцэтгэдэг.) Асрамжийн газрын менежер нь асрамж үйлчилгээ үзүүлэх дараах бүрэлдэхүүнтэй багийг удирдан зохион байгуулна. Үүнд:
 - Асрамж үйлчилгээ үзүүлэх ажилтнууд;
 - Асрамж үйлчилгээний ахлах ажилтнууд;
 - Бусад чиг үүрэг бүхий ажилтнууд.

1.3. Бүгд Найрамдах Солонгос Улс

БНСУ-д Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яамнаас баталгаажуулсан улсын болон хувийн асрамжийн газрууд, мөн хот, муж, дүүргийн асрамжийн газрууд байдаг. Эдгээр улсын болон хувийн асрамжийн газруудад тавигдах стандартыг Ахмад настны халамжийн тухай хуульд заасны дагуу Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яамнаас баталсан “Ахмад настны нийгмийн халамжийн байгууллагын барилгын болон ажилтнуудын стандарт”⁷ -ыг дагаж мөрддөг. Тус стандартад ахмадын асрамжийн газрын ажилтны тоог үйлчлүүлэгчийн тоотой уялдуулан тогтоох бөгөөд асрамжийн газрын үйлчлүүлэгчийн хамгийн доод хэмжээ 10 хүн байхаар тогтоосон байна. Тухайлбал, тус стандартад зааснаар 10-30 хүртлэх үйлчлүүлэгчтэй асрамжийн газарт асрамжийн газрын дарга 1 хүн, нарийн бичгийн дарга болон нийгмийн халамжийн ажилтан 1 хүн, сувилагч 1 хүн, 12.5 хүн тутамд 1 сувилахуйн ажилтан, асрагч 1 хүн нийт 6 ажилтантай байхаар тогтоосон байна.

Харин 30-аас дээш үйлчлүүлэгчтэй асрамжийн газрын хувьд асрамжийн газрын дарга, нарийн бичгийн дарга, нийгмийн халамжийн ажилтан, бичиг хэргийн ажилтан тус бүр 1 хүн, эмч 1-ээс дээш, сувилагч 1 хүн, 12.5 хүн тутамд 1 сувилахуйн

⁷ <https://n9.cl/9r3hgp>

ажилтан, хоол тэжээлийн мэргэжилтэн 1 хүн (50 хүртэл хүнд 1 хүн), тогооч 2 хүн (100 хүн тутамд 1-ээр нэмэгдэнэ), 50 хүн тутамд 1 асрагч нийт 13-аас дээш ажилтантай байхаар заажээ. Үйлчлүүлэгчийн тооноос хамаараад байнгын эсхүл гэрээт эмчтэй байх бөгөөд хэрэв гэрээт эмчтэй бол сар бүр тогтсон нэг өдөр үйлчлүүлэгчдийн эрүүл мэндийн байдлыг шалгаж, шаардлагатай эмчилгээ, үйлчилгээг үзүүлэх ёстой.

Хоол тэжээлийн мэргэжилтэн байхгүй бол тухайн байршил хариуцсан нийгмийн эрүүл мэнд төв болон өөр байгууллагын хоол зүйч мэргэжилтний удирдлага дор хоолны цэсийг бэлтгэж, түүний дагуу хооллох ёстой. Нарийвчилсан мэдээллийг хүснэгт 1-ээс үзнэ үү.

Хүснэгт 3: БНСУ-ын ахмадын асрамжийн газрын ажилтнуудын орон тоо

	Асрамжийн газрын дарга	Нарийн бичгийн дарга	Нийгмийн халамжийн ажилтан	Эмч (уламжлалт эмчилгээний эмч нар багтсан) болон гэрээт эмч	Сувилагч	Сувилахуйн ажилтан	Бичиг хэргийн ажилтан	Хоол тэжээлийн мэргэжилтэн	тогооч	асрагч
30-аас дээш хүнтэй	1 хүн	1 хүн	1 хүн	1-ээс дээш	1 хүн (50 хүртэл хүнд)	12.5 хүн тутамд 1 хүн	1 хүн	1 хүн (50 хүртэл хүнд)	2 хүн (100 хүн тутамд 1-ээр нэмэгдэнэ)	50 хүн тутамд 1 хүн
10-30 хүртлэх хүнтэй	1 хүн	1 хүн			1 хүн	12.5 хүн тутамд 1 хүн	-	-		1 хүн

1.4. Япон Улс

Япон Улсын Ахмад настны нийгмийн халамжийн тухай хуулийн 20.4 дүгээр зүйлд зааснаар Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны тушаалаар хотын захиргаа болон орон нутгийн захиргаа нь Агентлагийн тухай хуулийг үндэслэн ахмад настны асрамжийн газрыг байгуулна. Мөн мужийн захиргааны зөвшөөрлөөр ашгийн бус байгууллага асрамжийн газар байгуулж болно.⁸

Япон Улсад ахмад настанд эрүүл мэнд, эмнэлгийн асаргаа сувилгааны үйлчилгээ, халамжийн үйлчилгээ үзүүлдэг төрөлжсөн 7 төрлийн байгууллага байгаагаас 3 нь ахмад настны асрамжийн газар байна. Үүнд:

- **Асрамжийн газар (Yougo)** – Асаргааны хөнгөн болон дунд түвшний 65 ба түүнээс дээш насныхан хамрагддаг асрамжийн газар. Тус асрамжийн газар нь тухайн үйлчлүүлэгчийн өвчин эмгэгийн байдлаас хамааран бүх төрлийн

⁸ Act on Social Welfare for the Elderly <https://www.japaneselawtranslation.go.jp>

эмнэлгийн тусламж үйлчилгээ мөн цаашид нийгмийн үйл ажиллагаанд бие даан амьдрах чадварт сурган ар гэрт нь буцаах эсхүл нийгэмд бие даан амьдрах бололцоо нөхцөлөөр хангадаг байна.

- **Төлбөртэй асрамжийн газар (Keihi)** - 60 ба түүнээс дээш насны ахмад настанд өдөр тутмын асаргаа үйлчилгээ, амьдрах таатай орчин бүрдүүлдэг бөгөөд бүх үйлчилгээ нь төлбөртэй байдаг.
- **Тусгай асрамжийн газар (Tokuyou)** нь бие махбодын болон сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй, ганцаараа бие даан амьдрах чадваргүй, ар гэрт нь асран хамгаалах хүнгүй, 65 ба түүнээс дээш насны ахмад настан, асаргааны 3 дугаар түвшний гэрчилгээтэй 40-64 насны иргэдэд урт хугацаагаар асаргаа сувилгаа, хөдөлгөөн засал, сэтгэл зүйн эмчилгээ, сургалт, ая тухтай амьдрах орчинд амьдруулах, хөнгөвчлөх эмчилгээ үйлчилгээ (хоспис) зэрэг төрөл бүрийн үйлчилгээг үзүүлдэг асрамжийн газар юм.

Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас урт хугацааны асрамжийн даатгалын тухай хуулийг үндэслэн “Асрамжийн газрын дэд бүтцийн стандарт”-ыг тогтоодог.⁹

Тусгай асрамжийн газар нь ахмад настнуудын эрүүл мэнд, аюулгүй байдал, тусламж үйлчилгээ үзүүлэх нарийн бэлтгэгдсэн мэргэшсэн боловсон хүчний орон тоог мужийн захирагч тогтооно. Асрамжийн газрын удирдлага нь байгууллагын албан хаагчдыг нэгдсэн удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд хяналт тавин, бусад удирдлагыг гүйцэтгэнэ. Мөн үйлчлүүлэгчдэд эрүүл мэндийн яаралтай тусламжийг цаг тухай бүр үзүүлэх зорилгоор харьяалагдах эрүүл мэндийн байгууллага болон халамжийн байгууллагатай нягт хамтран ажилладаг.

Боловсон хүчний стандарт¹⁰

Хүснэгт 4: Япон Улсын асрамжийн газрын хүний нөөцийн стандарт (29 хүртэлх үйлчлүүлэгчтэй асрамжийн газарт)

д/д	Албан хаагч	Ажилтны тоо
1	Асрамжийн газрын удирдлага	1
2	Ерөнхий эмч	Үйлчлүүлэгчид эрүүл мэндийн эмчилгээний зааварчилгаа өгөх шаардлагатай тоо
3	Арга зүйн зөвлөх	1 хүн (100 хүртэлх үйлчлүүлэгчид)
4	Сувилах ажилтан	30 үйлчлүүлэгч тутам 1 хүн түүнээс дээш нэмэгдэх тутам 2 хүн
5	Хоол тэжээлийн мэргэжилтэн	1 ба түүнээс дээш
6	Хөдөлгөөн заслын багш	1 ба түүнээс дээш
7	Үйлчилгээний менежер	1 хүн (100 хүртэлх үйлчлүүлэгчид)
8	Тогооч болон бичиг хэргийн ажилтан, бусад ажилтан	Үйлчлүүлэгчийн тооноос хамаарна

⁹ Standard for the staffing, facilities <https://www.mhlw.go.jp/index.html>

¹⁰ 特別養護老人ホーム <https://kaigo.homes.co.jp/manual/facilities>

1.5. Монгол Улс

Монгол Улсын Нийгмийн халамжийн тухай хууль (НХтХ)-ийн 19 дүгээр зүйлийн 19.1.1 дэх заалтад тусгаснаар “Ахмад настны асрамжийн үйлчилгээ” нь төрөлжсөн асрамжийн үйлчилгээний нэг төрөл юм. Энэ үйлчилгээнд тэжээн тэтгэх хүүхэдгүй, бие даан амьдрах чадваргүй ганц бие, эсхүл тэжээн тэтгэх хүүхэд нь ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэйн улмаас дэмжлэг, туслалцаа үзүүлэх чадваргүй, тэжээн тэтгэх үүрэгтэй этгээд нь тухайн ахмад настны эсрэг хүчирхийлэл үйлдсэн болох нь тогтоогдсон бөгөөд олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамрагдах боломжгүй ахмад настан (НХтХ 19.2.1) хамрагдана.

Монгол Улсын ахмад настны тухай хууль 2017 онд батлагдаж, 2017, 2022, 2023, 2024 онуудад тус тус нэмэлт, өөрчлөлт орсон байна. 2024 оны нэмэлт, өөрчлөлтөөр тус хуульд чанартай насжилтад бэлтгэх, ахмад настанд үзүүлэх урт хугацааны цогц тусламж үйлчилгээний бодлогыг сайжруулах, ахмад настны асаргааны хувилбарт үйлчилгээг бий болгох, төрөлжсөн асрамжийн үйлчилгээг сайжруулах тухай зохицуулалт тусгагдсан.

Иргэн, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагууд нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээг хуульд заасан нөхцөл, болзолын хүрээнд үзүүлж болох (НХтХ 26.2.) бөгөөд ийм үйлчилгээ үзүүлэх иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага бүртгэж, гэрчилгээ олгодог (НХтХ 26.3.). Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын даргын 2012 оны 164 дүгээр тушаалаар батлагдсан “Нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээ үзүүлэх иргэн, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулах журам”-аар энэхүү асуудлыг нарийвчлан зохицуулж байна. Өөрөөр хэлбэл Монгол Улсад дараах төрөл, хэлбэрийн ахмад настны асрамжийн газар байж болно. Үүнд:

- Төрийн болон орон нутгийн өмчийн;
- Хувийн хэвшлийн (иргэн, аж ахуйн нэгж);
- Төрийн бус байгууллагын дэргэдэх.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (ХНХЯ)-ны мэдээлснээр 2022 байдлаар улсын хэмжээнд нийт 12 ахмад настны асрамжийн газар үйл ажиллагаагаа явуулж байна. Тухайлбал, “МС Тереза эх”, “Батгэрэлт ирээдүй”, “Жаргалан-Эдлэн”, “Ачлалт хүүхдүүд” зэрэг ТББ-ын дэргэдэх ахмад настны асрамжийн газрууд болон Төв аймгийн Батсүмбэр суман дахь төрийн өмчийн Ахмад настны үндэсний төв, Баянхонгор, Баян-Өлгий, Увс, Ховд, Дорнод, Дорноговь зэрэг аймгийн ахмад настны асрамжийн газрууд байна. Эдгээр асрамжийн газруудад нийт 400 орчим асруулагч асруулж, энэ салбарт 250 гаруй ажилтан, албан хаагчид ажиллаж байгаа ажээ.

Хоёр. АХМАД НАСТНЫ ТӨРӨЛЖСӨН АСРАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН БАРИЛГА, БАЙГУУЛАМЖ, ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ДЭД БҮТЦИЙН СТАНДАРТ

1.1 Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

Герман улсад ахмад настны асрамжийн төвийн барилга байгууламж, орчны тохижилт, дэд бүтцийн стандартыг холбооны түвшинд **“Асрамжийн газрын тухай хууль”** (Nursing Homes Act)¹¹, **“Асрамжийн газрын доод стандартын тухай журам”** (Regulation on Minimum Standards for Nursing Homes)¹²-аар зохицуулж байна. Холбооны Асрамжийн газрын тухай хууль нь улсын тусгайлсан асрамжийн газрын тухай хууль тогтоомжийн үндэс суурь болдог бөгөөд Холбооны Асрамжийн газрын доод стандартын тухай журам нь муж улсын доод стандартын тусгай журмыг удирдан чиглүүлдэг.

Холбооны 16 мужаас 10 нь Асрамжийн газрын доод стандартын тухай холбооны журамд үндэслэн өөрсдийн муж улсын хууль тогтоомжийг бие даасан байдлаар баталж, хэрэгжүүлдэг бол 6 муж нь холбооны зохицуулалтыг шууд дагаж мөрддөг байна.

Холбооны **Асрамжийн газрын тухай хуулиар** асран халамжлах шаардлагатай эсвэл хөгжлийн бэрхшээлтэй насанд хүрэгчид, ахмад настанд зориулсан асрамжийн газрын шаардлагатай өрөөнүүдийн ерөнхий зохион байгуулалт, тавигдах шаардлага зэргийг зохицуулсан.

Холбооны **Асрамжийн газрын доод стандартын тухай журмаар** асрамжийн газрын орц, гарц, талбай, өрөөний стандарт, тоног төхөөрөмжийн нийтлэг болон тусгай шаардлагыг журамлажээ.

Энд Холбооны Асрамжийн газрын тухай хууль болон Холбооны Асрамжийн газрын доод стандартын тухай журмын зохицуулалтыг авч үзсэн болно. Тухайлбал,

Хүснэгт 5: ХБНГУ-ын асрамжийн газрын барилга байгууламжид тавигдах доод стандарт

Нийтлэг дүрэм журам	Байгууламж	Тавигдах стандарт
	Хамрах хүрээ	Асран халамжлах шаардлагатай, хөгжлийн бэрхшээлтэй насанд хүрэгчид, ахмад настанд зориулсан асрамжийн газрын барилгын доод стандартыг зохицуулсан.
	Асрамжийн газрын өрөө, амьдрах орон зай	Ахмад настнуудад зориулсан асрамжийн газрын өрөөний талбай нь 12-15м ² /хүн байх шаардлагатай. Энэ нь ахмад настнуудын хязгаарлагдмал хөдөлгөөнд зориулсан зайг хангах үүднээс тавигддаг стандарт юм. (2-р зүйл)
	Коридор, шат, лифт, шал, гэрэлтүүлэг	Коридор ба шат: – үйлчлүүлэгчдийн ашигладаг коридор нь давхарт ямар ч шатгүй эсвэл зөвхөн тохиромжтой налуу замтай хамт зохион байгуулагдсан шаттай байж болно. (зүйл. 3–6)

¹¹ Асрамжийн газрын тухай хууль (Heimgesetz) <https://www.gesetze-im-internet.de/heimg/>

¹² Асрамжийн газрын барилгын доод стандартын хууль (HeimMindBauV) <https://n9.cl/gyjt9f>

- Коридор нь асрамжийн газар, сувилахуйн тасагт хэвтэрт байгаа хүмүүсийг зөөвөрлөхөд саадгүй байхаар хэмжээтэй байна.
- Коридор болон шат нь хоёр талдаа тогтмол хашлагатай байна.

Цахилгаан шат: Үйлчлүүлэгчдийн байнгын хэрэглээнд зориулж нэг давхраас дээш байрлах, эсвэл тэргэнцэртэй үйлчлүүлэгчдийн зориулалтын шатгүй байгууламжид дор хаяж нэг цахилгаан шат байх. Лифтийн төрөл, хэмжээ, тоног төхөөрөмж нь үйлчлүүлэгчдийн хэрэгцээнд нийцсэн байх.

Шал: Үйлчлүүлэгчдийн ашигладаг өрөөнүүд, эргэлтийн талбайн шалны хучилт нь халтиргаагүй байх.

Гэрэлтүүлэг:

- Гэрлийн унтраалга нь ажиллахад хялбар байх.
- Шөнийн гэрэлтүүлэг нь харанхуй үед шатны хонгил, коридорт тогтмол ажилладаг байх.
- Зочны өрөө, унтлагын өрөө, нийтийн эзэмшлийн талбайд уншлагын чийдэн ажиллуулах холболтууд байх. Унтлагын өрөөнд эдгээр холболтууд нь ор тус бүрт байх.

Яаралтай дохиоллын төхөөрөмж, утас, гарц

- Үйлчлүүлэгчдийн өрөө нь ор бүрээс ажиллах боломжтой дуудлагын системээр тоноглогдсон байх.
- Байгууламжид үйлчлүүлэгчидтэй холбогдох нэгээс доошгүй телефон утас байх.
- Зочны өрөө, унтлагын өрөө, ариун цэврийн өрөөнүүдэд яаралтай тусламжийн үед гаднаас нэвтрэх боломжтой байх.

Угаалгын өрөө, хэрэглээний өрөөнүүд (тусгай зориулалтаар ашиглах, нэмэлт үйлчилгээ явуулах өрөө)

- Асрамжийн газар, сувилахуйн газруудын хаалганууд нь хэвтрийн үйлчлүүлэгчийг тээвэрлэхэд хангалттай өргөн байх. (Зүйл.7–9)
- Нийтийн байгууламж дахь ванн, шүршүүр нь хэрэглэж буй хүн харагдахгүй байхаар хамгаалалттай байх.
- Ваннд орох, гарахад аюулгүй байх.
- Ванн, шүршүүр, ариун цэврийн өрөөний суултуур нь тус бүр нэмэлт бариулаар тоноглогдсон байх.
- Хөгжлийн бэрхшээлтэй үйлчлүүлэгчид тохирсон ариун цэврийн өрөө хангалттай тоогоор байх.
- Байгууламжид гаднаас ханган нийлүүлэлт хийгддэггүй бол хэрэглээний өрөөнүүд нь шаардлагатай тоо хэмжээгээр байх. (Зүйл.10–11)

Халаалт, барилгын орц, гарц

- Бүх өрөө, шат, коридор, ариун цэврийн байгууламжийн халаалтыг үйлчлүүлэгчдийн хэрэгцээнд тохирсон температураар хангахын тулд тохирох халаалтын системийг ашиглах.
- Байгууламжийн үүдний хэсэг нь нийтийн тээврийн газраас шат дамжлагагүйгээр нэвтрэх боломжтой байх. Мөн гэрэлтүүлэгтэй байх. (Зүйл.12–13)

Тусгай журам	Амьдрах орон зай, функциональ туслах өрөө	1 хүнд зориулсан өрөө нь 12 м² талбайтай дор хаяж нэг ор, зочны өрөөг багтаасан байх. 2 хүний өрөө нь 18 м² амьдрах талбайтай байна. 2-оос дээш хүн байрлуулахыг зөвхөн онцгой тохиолдолд зөвшөөрнө. 4-өөс дээш хүн байрлуулахыг хориглоно. 3, 4 дэх хүний нэмэлт амьдрах орон зай нь тус бүрдээ дор хаяж 6 м² байх.
		2 хүртэлх хүнд зориулсан өрөө нь хүйтэн, халуун усны холболттой 1 гар угаах тосгууртай байх. 2-оос дээш хүний өрөө нь мөн нэмэлт гар угаах тосгууртай байх. - Асрамжийн газрын гаднах цэцэрлэгт хүрээлэн, усан бассейн, түүнтэй адилтгах байгууламж нь бүх талаараа хаалттай байх. (Зүйл.14–15)
	Нийтийн эмчилгээний өрөө	- Байгууламж нь хамгийн багадаа 20 м² ашиглах боломжтой 1 нийтийн өрөөтэй байх. 20-иос дээш үйлчлүүлэгчтэй байгууламжид үйлчлүүлэгч бүрт дор хаяж 1 м² ашиглах талбай ногдох. - Ашиглах талбайг тооцоолохдоо хоолны өрөө, коридор, онцгой тохиолдолд бусад тохиромжтой өрөөг харгалзан үзэж болно. Шат, бусад нийтийн эзэмшлийн талбай, тагт зэргийг тооцохгүй. - Байгууламж бүр хөдөлгөөнт заслын болон биеийн тамирын өрөөтэй байх. Хэрэв үйлчлүүлэгчдийн ойр орчимд тогтмол ашиглах тохиромжтой эмчилгээ болон биеийн тамирын өрөө байхгүй бол энэ зорилгоор нийтийн өрөөг ашиглаж болно. (Зүйл.16–17)
	Ариун цэврийн тоног төхөөрөмж	- Нэг давхарт 8 хүртэлх үйлчлүүлэгчийн дунд 1 нийтийн ариун цэврийн өрөөтэй байх. 1 байранд 20 хүртэл үйлчлүүлэгчид зориулсан хамгийн багадаа 1 нийтийн угаалгын өрөө буюу ванн эсвэл шүршүүртэй байх. - Сувилахуйн тасгийн нийтийн угаалгын өрөөнд ванны урт тал болон нэг үзүүрт нь чөлөөтэй зайтай байхаар суурилуулах. (Зүйл.18)

Герман Улсын ахмад настны асрамжийн газрын барилгын стандартад хөдөлгөөн, аюулгүй байдал, эрүүл мэнд, ариун цэврийн байгууламжид чиглэсэн таван нийтлэг шаардлагыг тусгасан бөгөөд саадгүй орчны DIN18040-2:2011-9 стандартыг мөн баримталдаг байна.

1.2 Их Британи

Их Британид Эрүүл мэнд, нийгмийн халамжийн тухай хуулиар асрамжийн газарт баримтлах **Суурь стандарт** (Fundamental standards)-ыг баталсан байна. Мөн Асрамж үйлчилгээний стандартын тухай хуулиар Үндэсний асрамжийн стандартын хороо (National Care Standards Commission)-г байгуулан, мөн хуулийн 23(1) дэх хэсэгт заасны дагуу Ахмад настны асрамжийн газарт баримтлах **Үндэсний доод**

стандарт (National Minimum Standards for Care Homes for Older people)¹³-ыг Эрүүл мэндийн яамнаас баталсан байна. Үндэсний доод стандартын баримт бичигт ахмад настны асрамжийн газруудын үйл ажиллагаандаа баримтлах шаардлагатай дараах стандартыг багтаажээ. Үүнд:

1. Амьдрах орчин
2. Эрүүл мэнд болон хувийн асаргаа
3. Өдөр тутмын амьдрал, нийгмийн үйл ажиллагаа
4. Үйлчилгээний талаарх гомдол болон хуулиар хамгаалагдсан байдал
5. Орчин тойрны нөхцөл
6. Ажилтнууд
7. Удирдлага, зохион байгуулалт зэрэг болно.

Эдгээрээс Амьдрах орчинд тавигдах стандартад доорх асуудлыг багтаасан байна. Үр дүн: Үйлчлүүлэгчид аюулгүй орчинд амьдрах.

19 дүгээр стандарт

19.1 Асрамжийн газрын байршил, зохион байгуулалт нь аюулгүй, хүртээмжтэй, засвар, үйлчилгээ сайтай, үйлчлүүлэгчийн хувийн болон нийтийн хэрэгцээнд нийцсэн, тохь тухтай, гэр орны халуун дулаан уур амьсгалыг бүрдүүлсэн байх.

19.2 Урсгал засварыг товлосон хугацаанд гүйцэтгэж, байрны тохижилтод шаардлагатай эд, материалыг шинэчлэн, тэмдэглэл хийж байх.

19.3 Байр нь нарны гэрэл орох зохион байгуулалттай, цэвэр, аюулгүй, үйлчлүүлэгчдэд хүртээмжтэй байх.

19.4 Байрны тохижилт, засвар үйлчилгээний хөтөлбөрийг гарган, гүйцэтгэлд хяналт тавьж байх.

19.5 Асрамжийн барилга байшин нь орон нутгийн Гал команд болон Эрүүл ахуйн хяналтын газрын шаардлагыг хангасан байх.

19.6 Аюулгүй байдлыг хангах үүднээс үйлчлүүлэгчийн орон сууц (өрөө)-ны зөвхөн үүд хэсэгт CCTV хяналтын камерыг байрлуулахыг зөвшөөрөх бөгөөд өдөр тутмын үйл ажиллагаанд бичлэг хийхийг хориглоно.

Нийтийн эзэмшлийн тохижилт

Үр дүн: Асрамжийн газрын дотор болон гадна аюулгүй, тохь тухтай нийтийн эзэмшлийн хэсгүүдтэй байх.

20 дугаар стандарт

20.1 Үйлчлүүлэгчдийн орон сууц (өрөө), коридор, асрамжийн байрны үүдний хэсгийг үл тооцон, үйлчлүүлэгч бүрд 4.1м.кв-аас багагүй талбай бүхий суух, амрах, хооллох танхим буюу хэсэгтэй байна.

20.2 Нийтийн эзэмшлийн газрууд нь:

¹³ https://www.dignityincare.org.uk/_assets/resources/dignity/csipcomment/csci_national_minimum_standards.pdf

- үйлчлүүлэгчид эргэлтээр ирсэн зочидтой тусдаа уулзах болон нийгэм, соёл, шашны зэрэг олон төрлийн үйл ажиллагаа явуулах өрөө, тасалгаа, танхимуудтай байх;
- Хоолны танхим нь бүх үйлчлүүлэгчид зэрэг үйлчлэх хүчин чадалтай байх;
- Тамхи татахыг хориглосон өрөө, танхимтай байх.

20.3 Хөдөлгөөний хомсдолтой, тэргэнцэртэй хүмүүс болон биеийн, танин мэдэхүйн бэрхшээлтэй хүмүүс саадгүй гарч салхилах боломж бүхий салхилах хэсэгтэй байх.

20.4 Сэргээн засах эмчилгээ, үйлчилгээ үзүүлдэг бол үйлчилгээнд шаардагдах хэсэгтэй байх.

20.5 Гэрэлтүүлэг нь орон байрныхтай ижил, ном унших болон бусад үйл ажиллагаа явуулахад хангалттай тод байх.

20.6 Нийтийн эзэмшлийн хэсэг дэх тавилгууд нь айл гэрийн халуун дулаан орчныг бүрдүүлсэн, чанартай, үйлчлүүлэгчдийн төрөл бүрийн сонирхол, хэрэгцээнд нийцсэн байх.

Ариун цэврийн болон угаалгын өрөө

Үр дүн: Үйлчлүүлэгчдэд хангалттай, тохиромжтой ариун цэврийн байгууламж (усанд орох онгоц эсхүл шүршүүр)-тай байх.

21 дүгээр стандарт

21.1 Үйлчлүүлэгчдийн хэрэгцээнд нийцсэн ариун цэврийн, угаалгын болон усанд орох өрөөгөөр хангах.

21.2 Таних тодорхой тэмдэг бүхий хооллох болон амрах танхимд ойр, хүртээмжтэй ариун цэврийн өрөөтэй байх.

21.3 Үйлчлүүлэгч нь дотроо ариун цэврийн байгууламжтай орон сууц (өрөө)-өөр үйлчлүүлэх боломжтой, эсхүл 8 үйлчлүүлэгч тутамд асрагчийн тусламжтай усанд орох 1 ариун цэврийн байгууламжтай байх (угаалгын онгоц эсхүл шүршүүр суурилуулсан).

21.4 Дотроо ариун цэврийн байгууламж байхгүй тохиолдолд ойрхон зайд ариун цэврийн байгууламжтай байх.

21.5 Дотроо ариун цэврийн өрөөтэй бол (жорлон болон угаалтуур заавал суурилуулсан байх).

21.6 Дотроо ариун цэврийн байгууламжтай бол орон сууц өрөөний зай талбайгаас хасахгүй байх.

21.7 Тэргэнцэр болон бусад эрүүл мэндийн хэрэгсэл ашигладаг үйлчлүүлэгчдэд шаардлагатай тохиргоог хийсэн байх.

21.8 Шингэн бохир зайлуулах хэсэг нь үйлчлүүлэгчдийн ариун цэврийн болон угаалгын өрөөнөөс тусдаа байх.

Тоног төхөөрөмж

Үр дүн: Үйлчлүүлэгчдийн бие даасан байдлыг нэмэгдүүлэхийн тулд шаардлагатай хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах.

22 дугаар стандарт.

22.1 Асрамжийн газрын барилга байгууламж, хүрээлэн буй орчин нь хөгжлийн бэрхшээлтэй болон бусад хүмүүст зориулсан шаардлагатай тохиргоо бүхий, эрүүл мэндийн болон холбогдох бусад байгууллагаар үнэлгээ хийгдсэн байх шаардлагатай.

22.2 Үйлчлүүлэгчид нь хувийн болон нийтийн эзэмшлийн бүх хэсэгт энгийн болон нэмэлт тохиргоо (налуу зам, зорчигчийн цахилгаан шат, шат/сандаал бүхий цахилгаан шат)-ны тусламжтайгаар хүрч очих боломжтой байх.

22.3 Хонгил, угаалгын болон ариун цэврийн өрөө, нийтийн эзэмшлийн өрөө, танхимууд болон шаардлагатай бол үйлчлүүлэгчийн орон сууц (өрөө)-д хананд бэхэлсэн дэмжих бариул зэрэг тохиргоог хийсэн байх.

22.4 Үйлчлүүлэгчдэд шаардлагатай нэмэлт тохиргоо буюу туслах хэрэгсэл, өргөгч, хүний тусламжтай ашиглах ариун цэврийн болон угаалгын өрөө зэргийг тохижуулан, суурилуулсан байх.

22.5 Нийтийн эзэмшлийн хэсгүүд, үйлчлүүлэгчийн өрөө тасалгаа, ариун цэврийн болон угаалгын өрөө зэрэг нь тэргэнцэртэй хүн чөлөөтэй нэвтрэх, ашиглах зай талбайтай байх. Хаалганы өргөн нь 800mm-ээс доошгүй байх.

22.6 Холбоо барих төхөөрөмж, тэмдэг, тэмдэглэгээ зэргийг үйлчлүүлэгчийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн хийсэн байх. Тухайлбал, сонсголын бэрхшээл, харааны бэрхшээл, ой санамж муудах зэрэг өвчтэй үйлчлүүлэгчдэд нийцүүлэн хийх.

22.7 Үйлчлүүлэгчдэд шаардлагатай тэргэнцэр зэрэг эрүүл мэндийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийг хадгалах хэсэгтэй байх.

22.8 Өрөө бүрд яаралтай тусламжийн дуудлагын төхөөрөмжийг байрлуулах.

Өрөөний зай талбайн хэмжээ

Үр дүн: Үйлчлүүлэгчдийн өрөө, сууц нь тэдний хэрэгцээ, шаардлагад нийцсэн байх.

23 дугаар стандарт

23.1 Асрамжийн газар нь үйлчлүүлэгч тус бүрд дор дурдсан хэмжээнээс багагүй талбай бүхий өрөө, сууцаар хангана.

23.2 Нэг хүний өрөөний зай талбай доод тал нь 12м.кв-аас багагүй байна. (ариун цэврийн байгууламжаас гадна)

23.3 Тэргэнцэртэй үйлчлүүлэгчдийн өрөөний зай талбай доод тал нь 12м.кв-аас багагүй байна. (ариун цэврийн байгууламжаас гадна)

23.4 Өрөөний зохион байгуулалт нь үйлчлүүлэгчийн орны аль ч талд үйлчлүүлэгчид тусламж, үйлчилгээ үзүүлэх ажилтан болон эрүүл мэндийн тусламжийн тоног төхөөрөмжийг чөлөөтэй байршуулах боломжтой байх.

23.5 Өрөөг хамтран эзэмших бол нэг өрөөнд хоёроос илүүгүй үйлчлүүлэгчийг харилцан зөвшилцсөний үндсэн дээр байлгах.

23.6 Хэрэв хамтран эзэмшигч нь гарсан тохиолдолд үлдсэн үйлчлүүлэгч хүсвэл цаашид ганцаар амьдрах боломжийг олгох, ингэхдээ шаардлагатай бол өөр өрөөнд нүүн орох боломжоор хангах.

23.7 Хамтран эзэмшиж буй өрөө нь 16м.кв-аас доошгүй зай талбайтай байна. (ариун цэврийн байгууламжаас гадна)

23.8 2002 оноос хойш шинээр нээгдсэн асрамжийн газруудад 2 унтлагын өрөө, 1 зочны өрөөтэй сууцыг хамтран эзэмшүүлэхээр шийдвэрлэсэн.

Өрөөний тавилга, тохижилт

Үр дүн: Үйлчлүүлэгчид аюулгүй, тохь тухтай, өөрсдийн эд зүйлс бүхий өрөөнд амьдрах.

24 дүгээр стандарт

24.1 Асрамжийн газар нь үйлчлүүлэгч бүрийн хувийн орон зайг бүрдүүлсэн, тохь тухтай тавилга болон үйлчлүүлэгчийн хэрэгцээ шаардлагад нийцсэн тохиргоо бүхий өрөө, сууцаар хангах.

24.2 Үйлчлүүлэгч нь өөрийн тавилга, эд зүйлгүй бол дараах тавилга, эд зүйлсийг заавал байршуулсан байх. Үүнд:

- 900mm-ээс багагүй өргөнтэй, үйлчлүүлэгчийн хэрэгцээнд тааруулсан, аюулгүй байдлыг хангасан өндөртэй, цэвэр, тухтай, ор дэрний хэрэглэл бүхий ор;
- хөшиг;
- толь;
- орны толгойн тушаа болон орны хажууд гэрэл;
- 2 хүний тухтай сандал;
- хувцсаа өлгөх ханын шүүгээ болон шургуулга;
- доод тал нь 2 ширхэг давхар цахилгаан залгуур;
- хажууд нь суух болон орны хажуудах ширээ;
- гар угаах угаалтуур (хэрэв өрөө нь ариун цэврийн байгууламжгүй бол)

24.3 Үйлчлүүлэгч нь сувилахуйн тусламж үйлчилгээнд байдаг бол тохиргоо бүхий ор;

24.4 Шалан дээр хивс, хивсэнцэр;

24.5 Үйлчлүүлэгчийн өрөөний хаалга нийцсэн болон яаралтай тусламжийн ажилтнууд цаг алдалгүй нэвтрэх боломжтой хаалганы цоожтой байх;

24.6 Үйлчлүүлэгчийн тусгай хэрэгцээнд өөрөөр заагаагүй бол өрөөний түлхүүрийг өөрт нь олгох;

24.7 Үйлчлүүлэгч бүр өөрийн эм, мөнгө, үнэ бүхий зүйлсээ хадгалах цоожтой савтай байх бөгөөд түлхүүрийг өөрт нь олгоно. (Эрүүл мэндийн шалтгааны улмаас түлхүүрээ өөрөө хадгалах боломжгүй бол хувийн асаргааны дэвтэрт тэмдэглэнэ.)

24.8 Үйлчлүүлэгчийн хувийн нууцыг хүндэтгэн эмчийн үзлэгийг давхар өрөөнд хийнэ.

Халаалт болон гэрэлтүүлэг

Үр дүн: Үйлчлүүлэгчид аюулгүй, тухтай орчин нөхцөлд амьдрах.

25 дугаар стандарт

25.1 Асрамжийн газрын халаалт, гэрэлтүүлэг, усан хангамж болон агааржуулалт нь холбогдох эрүүл ахуй, аюулгүй байдлын болон үйлчлүүлэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн байх.

25.2 Өрөө тасалгаа нь тус бүрдээ байгалийн агаар салхи орох боломжтой, шаардлагад нийцсэн цонхтой байх.

25.3 Цонхны өндөр нь үйлчлүүлэгч суугаад болон орон дээрээ хэвтэж байхдаа гадна орчныг шууд харах боломжтой байх.

25.4 Асрамжийн газрын халаалтыг төвийн халаалттай холбох, үйлчлүүлэгч нь өрөөндөө халаалтаа тоируулах боломжтой байх.

25.5 Усны хоолой болон радиаторууд нь бага температурт ажиллах баталгаатай байх.

25.6 Өрөөний гэрэлтүүлэг нь айл гэрийн гэрэлтүүлгийн стандартад заасан (люкс 150) гэрэлтэй, мөн ширээний гэрэлтэй байх.

25.7 Ослын үед ашиглах гэрлийг асрамжийн газар даяар суурилуулах.

25.8 Legionella-ийн вирусээс урьдчилан сэргийлэх зорилгоор усыг 60C-аас доошгүй хэмд хадгалан, 50C-аас доошгүй хэмтэй түгээнэ.

Ариутгал, халдваргүйжүүлэлтийн хяналт

Үр дүн: Асрамжийн газар цэвэр, таатай, эрүүл ахуйн шаардлага хангасан байх.

26 дугаар стандарт

26.1 Асрамжийн газар нь цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангасан, таагүй үнэр тархахаас сэргийлсэн байх, холбогдох хууль, мэргэжлийн байгууллагаас гаргасан удирдамжийн дагуу халдвар тархахаас урьдчилан сэргийлсэн байх.

26.2 Угаалгын газрыг хоол хүнс хадгалах, бэлтгэх, хийх, идэх газраас хол зайд байрлуулах.

26.3 Гар угаах байгууламжуудыг бохир, халдвартай материал болон эмнэлгийн хог хаягдлаас хол зайд байрлуулах.

26.4 Угаалгын газрын шал ус нэвтрүүлэхгүй, хана цэвэрлэхэд хялбар байх.

26.5 Халдвараас сэргийлэх үйл явц нь хамгаалалтын хувцсаар хангах, эмнэлгийн хог хаягдалтай болгоомжтой харьцах, устгалд оруулах, гараа угаах, ариутгах.

26.6 Бохирдсон цагаан хэрэглэлийг тодорхой хэм (10 минутаас доошгүй хугацаанд 65C-аас доошгүй хэм)-д угааж ариутгах.

26.7 Угаалгын машин нь ариутгах тусгай горимтой байх.

1.3 Бүгд Найрамдах Солонгос Улс

БНСУ-ын Асрамжийн газрын барилга байгууламжийн стандартад саадгүй орчин (Barrier-Free Environment), аюулгүйн түгжээний төхөөрөмж (Safety Lock Device), гэрэл, дулаан, халаалтын систем (Light, Thermal Heating System), дотоод агааржуулалт (Indoor Ventilation) болон нийтийн хэсэг (Community Interaction) гэсэн 6 шаардлага тавьдаг.

1998 онд шинэчлэгдсэн стандартад заасны дагуу унтлагын өрөөний хамгийн дээд багтаамжийг 4 хүн болгож өөрчилсөн. Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яамнаас баталсан ахмадын асрамжийн газрын барилгын стандартад 1 хүнд ногдох нийт талбай нь 15.9 м² ба түүнээс дээш байна гэж заажээ.

Өнөөгийн байдлаар унтлагын өрөөний цэвэр талбайн доод хэмжээ 6.6 м² байна. Харин дементийн тасгийн унтлагын өрөөний талбайн тухайд 2016 онд дементийн нэгжийг нэвтрүүлснээр унтлагын өрөөний хамгийн бага талбай нь 9.9 м² байна.

Ахмад настны халамжийн тухай хуулийг хэрэгжүүлэх журмын дагуу Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яамнаас ахмадын асрамжийн газарт тавих шаардлага, стандартыг баталсан бөгөөд Хүснэгт 2-оос үзнэ үү.

Хүснэгт 6: БНСУ-ын ахмадын асрамжийн газарт тавих үндсэн шаардлага

Стандарт	Үндсэн шаардлага	Нарийвчилсан тайлбар
A-1	Шат	-налуу шат
A-3	Халтиргаанаас хамгаалах шат	- Зөөлөн, халтиргаагүй шал - Коридор, унтлагын өрөө, бие засах газар, угаалгын өрөө, угаалгын өрөөнд гулсдаггүй шат
A-4	Цахилгаан шат	Зорчигчдод зориулсан цахилгаан шат эсхүл налуу шат
A-5	Тэргэнцэр ашиглах боломжтой байх	- Тэргэнцэр нэвтрэх боломжтой байх (коридор, унтлагын өрөө, угаалгын өрөө, бие засах өрөө) - коридор, унтлагын өрөө, угаалгын өрөөний хооронд босго байхгүй - коридор, унтлагын өрөө, угаалгын өрөөнд хамгаалалтын бариул
A-6	Аюулгүйн бариул	- орон дээр чөлөөтэй хөдөлж, босох боломжтой орны эргэн тойронд хамгаалалтын хэрэгсэл - Туслах саваа ба ванны босоо тулгуур - Хаалга түгжих төхөөрөмж
B-1	Гадна орц	- Гал түймэр зэрэг онцгой байдлын үед автоматаар нээгддэг.
B-2	Шат	- Шатны хаалганы цоож - Гал түймэр зэрэг онцгой байдлын үед автоматаар нээгддэг
B-4	Дементийн нэгж	- Галын аюулгүй байдлын хангах үүднээс яаралтай тусламжийн хаалга суурилуулах
B-5	Гал тогоо	- Галын аюулгүй байдлын хангах үүднээс гал тогооны өрөөнд цоожтой хаалга суурилуулах - Эрүүл мэнд, эрүүл ахуйн хувьд өдрийн гэрлийг анхаарах
C-1	Өдрийн гэрэл	- Унтлагын өрөөнд хамгийн багадаа 1/7 нь цонх байх ёстой. - Унтлагын өрөөнд өдрийн гэрэл тохиромжтой
D-1	Халаалтын систем	- Эрүүл мэнд, эрүүл ахуйн үүднээс халаалтыг анхаарах - Унтлагын өрөөрн тохиромжтой халаалт - Эрүүл мэнд, эрүүл ахуйд нийцсэн агааржуулалттай байх
E-1	Агааржуулалт	- Унтлагын өрөөнд тохиромжтой агааржуулалт
K-1	Нэмэлт соёл, спортын байгууламжууд	- Номын сан, спорт, амралт зугаалгын байгууламж гэх мэт - Нээлттэй боловч оршин суугчдад саад учруулахгүй байх
K-2	Өдөр/шөнийн асрамжийн газар	- Ахмад настнуудад зориулсан өдөр/ шөнийн үйлчилгээ гэх мэт

Асрамжийн газрын барилга байгууламжид шаардлагатай өрөөнүүдийг тохируулах систем нь Хүснэгт 7-д үзүүлснээр орон зайн долоон бүсэд ангилагдах бөгөөд 2002 оноос хойш шаардлагатай өрөөнүүдийн тохиргоо нь барилга байгууламжийн цар хүрээ, үйлчлүүлэгчийн тооноос хамаарч өөр өөр байхаар тогтоосон.

Хүснэгт 7: БНСУ-ын асрамжийн газрын орон зайн бүс ба шаардлагатай өрөөнүүдийн тохиргооны систем

А.Хувь хүний орон зай	Б.Зочны өрөө	В.Эмчилгээний өрөө	Г.Эрүүл ахуйн өрөө	Д.Үйл ажиллагааны туслах өрөө	Е.Байрны менежмент	Ё.Ажилтнуудын өрөө
Унтлагын өрөө	Зочны өрөө	Физик, хөдөлмөр заслын эмчилгээний өрөө				Сувилахуйн пост
Тусгай унтлагын өрөө	Гал тогоо өрөө		Нийтийн бие засах газар		Угаалгын өрөө	Ажилтны алба
	Хоолны өрөө		Зочны угаалгын өрөө		Хатаах өрөө	Ажилчдын өрөө
						Сайн дурынхны өрөө

Барилгын үндсэн болон нэмэлт тохиргоог хүчин чадалд нь тохируулан өөр өөрөөр тоноглоно. Нэмэлт тохиргоотой холбоотойгоор 30 ба түүнээс дээш үйлчлүүлэгчийн багтаамжтай барилга байгууламжид ажилчдын өрөө, асран хамгаалагчийн өрөө, сайн дурын ажилчдын өрөө зэрэг нэмэлт өрөөнүүдийн хамт нийтлэг угаалгын өрөө/ариун цэврийн өрөө (эрүүл ахуйн өрөө), угаалгын/хатаах өрөө (гэр ахуйн) байх ёстой гэж заасан.

Асрамжийн газрын өрөөнүүдийн стандарт:

Унтлагын өрөө нь ганц хүний, олон хүний, хосын хамт амьдрах гэсэн төрөлтэй. Эдгээр өрөөнүүд нь ор дэрний аюулгүй байдал, цонхны хэмжээ, эрүүл мэнд, аюулгүй байдлын тоног төхөөрөмж, халтиргаанаас хамгаалах шал, тэргэнцэр, өдрийн гэрэл зэрэг асуудлуудад анхаарлаа хандуулж, зарим тусгай стандарт шаарддаг. Тухайлбал:

Хүснэгт 8: БНСУ-ын асрамжийн газрын тусгай стандарт

А-1. Унтлагын өрөө	Саад бэрхшээлгүй орчин Аюулгүй байдал	Өрөөний төрөл: Ганц хүний, олон хүний, хосын унтлагын өрөө Орны аюулгүй байдал: Өндрийн тохируулгатай Цонхны хэмжээ: Унтлагын өрөөний талбайн 1/7 буюу түүнээс дээш Эрүүл мэндийн тоног төхөөрөмж: Халаалт, агааржуулалт, гэрэлтүүлэг, чийгийн хамгаалалттай. Аюулгүй байдлын тоног төхөөрөмж: Хамгаалалтын бариул, орон дээр чөлөөтэй хөдөлж, босох боломжтой байх, халтиргаанаас хамгаалах шал Тэргэнцэр нэвтрэх: Босгогүй, өдрийн гэрэл
--------------------	---------------------------------------	---

Нийтлэг зочны өрөөний хувьд тус улсын асрамжийн газруудын дүрэм журмууд нь ахмад настнуудын бие даасан байдлыг дэмжих зорилготой байдаг. Нийтийн эзэмшлийн талбайд дараах нарийвчилсан шаардлага тавьдаг. Үүнд:

В-1.Нийтлэг зочны өрөө	Саад бэрхшээлгүй орчин Аюулгүй байдал	Орох хаалга нь орон зайг тусгаарлах ба яаралтай нэвтрэх боломжтой байх Хөтөлбөрийн өрөө: Соёлын болон үзвэр үйлчилгээний өрөөнүүд нь үнэ төлбөргүй ашиглах боломжтой байх
В-2. тогоо/хоолны өрөө	Гал	Гал тогооны өрөөний шал нь усанд тэсвэртэй. Гал тогооны цэвэрлэгээ ба ус зайлуулах хоолой: Цэвэрлэх, ус зайлуулахад хялбар бүтэцтэй. Гал тогооны өрөөний хаалганы түгжээ: Сэтгэцийн өвчтэй хүмүүст зориулсан хаалганы түгжээ

Нийтлэг бие засах газар, угаалгын өрөөний стандартад хальтиргаанаас хамгаалах шал, тэргэнцэр, шөнийн гэрэл, хамгаалалтын бариул, ванн, халуун усны стандартыг багтаасан байна. Тухайлбал,

D-2.Нийтлэг бие засах газар	Саад бэрхшээлгүй орчин Аюулгүй байдал	- Халтиргаагүй шал - Тэргэнцэртэй хүн ашиглах боломжтой - Шөнийн гэрэл
D-3.Нийтлэг угаалгын өрөө	Саад бэрхшээлгүй орчин Аюулгүй байдал	- Халтиргаагүй шал - Тэргэнцэртэй хүн ашиглах боломжтой - Аюулгүйн бариул - Ванн:Гүехэн, дор хаяж нэг бариултай, гэрэлтэй босоо бариултай. - Халуун ус: Автомат термостаттай, цельсийн 40 хэмээс доош температур. - Шөнийн гэрэл

Асрамжийн газарт физик эмчилгээ, ажилтнуудын ажлын байрны талаар зохицуулалт байдаггүй бөгөөд зөвхөн эмнэлгийн болон сувилахуйн ажилтнуудын өрөөнд эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж суурилуулдаг.

1.4 Япон Улс

Асрамжийн газрын барилга байгууламж нь Барилга, байгууламжийн стандартын дагуу гэрэлтүүлэг, агааржуулалт зэрэг эрүүл ахуйн шаардлага, галын аюулгүй байдал зэрэг гамшиг ослоос урьдчилан сэргийлсэн ахмад настанд зориулсан 1-3 давхар барилга байна.

Байгууллагын стандарт

Хүснэгт 9: Япон Улсын асрамжийн газрын барилга, байгууламжийн стандарт

д/д	Өрөө зохион байгуулалт	Тавигдах шаардлага
1	Нийтийн өрөө	1 хүнд ногдох талбайн хэмжээ хамгийн багадаа 1.65м ² - Ор, тоног төхөөрөмж - Хувийн эд зүйл хадгалах тавилга - Дуут дохио өгөх төхөөрөмж
2	Угаалгын өрөө	- Давхар бүрд - Тусгай тоноглогдсон төхөөрөмжтэй
3	Ариун цэврийн өрөө	- Нийтийн өрөө болгонд байна - Дуут дохио өгөх төхөөрөмж - Үйлчлүүлэгчдэд тохирсон тоног төхөөрөмж, хэрэгсэлтэй - Шөнийн гэрэлтүүлэгтэй
4	Эмнэлгийн өрөө	- Үйлчлүүлэгчдэд эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжтэй - Яаралтай үед хэрэглэх багаж хэрэгсэлтэй
	Амрах өрөө	- Сувилахуйн үйлчилгээ үзүүлэх өрөөтэй ойр байх
5	Хоолны өрөө	- 3м²-аас дээш
6	Коридор	- Өргөн 1.8-2.7 метрээс багагүй - Өндөр 1.5-1.8 метр - Тусгай бариултай - Налуу зөөлөвчтэй шаттай

1.5 Монгол Улс

Монгол Улсад ахмад настны асрамжийн газрын барилга байгууламж, дэд бүтэц, орчны тохижилтын талаар тусгайлсан стандарт байхгүй байгаа хэдий ч “Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин”-ы Үндсэн шаардлага **MNS 6055:2009** стандарт, Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар **MNS 6056:2009**, стандарт зэргийг баримтлан барилга байгууламжийн зураг төсөлд төлөвлөлт хийх бүрэн боломжтой. Гэвч тус улсад үйл ажиллагаа явуулж буй ахмад настны асрамжийн газрууд гол төлөв хуучин өөр зориулалтай байсан барилга байгууламжид байдаг байна.

Харин үйлчилгээний хувьд ахмад настны асрамжийн үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага **MNS 5823:2016** дугаартай хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээний стандартаар зохицуулж байна.

Гурав. АХМАД НАСТНЫ ТӨРӨЛЖСӨН АСРАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ХҮНИЙ НӨӨЦИЙГ БЭЛТГЭХ ДАВТАН СУРГАХ

3.1 Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

Тус улсад асаргааны мэргэжлийн болон давтан сургалтын асуудлыг дараах хуулиудаар зохицуулж байна. Үүнд:

- Сувилахуйн мэргэжлийн тухай хууль (Pflegerberufegesetz (PflegerBG))¹⁴
- Нийгмийн халамжийн тухай хуулийн 11-р хэсэг буюу Ахмад настны асрамжийн даатгалын тухай хууль (SGB XI)

Нийгмийн халамжийн тухай хуулийн (SGB XI) 71-р зүйлд¹⁵ зааснаар ахмад настны асрамжийн газрын мэргэшсэн сувилахуйн мэргэжилтэн наанадаж 460 цагийн тусгай (ахмад настны тусламж үйлчилгээний чиглэлээр) сургалтад хамрагдсан байх шаардлагатай.

Хүснэгт 10. Мэргэшсэн сувилахуйн мэргэжилтэн бэлтгэх, давтан сургалтын талаарх мэдээлэл

Мэргэжилтэн	Үндсэн сургалт	Давтан сургалт	Давтан сургалтын зохион байгуулалт
Эмч (Ärztin / Arzt)	- Эмчийн мэргэжил эзэмших сургалт (6-7 жил): Мэргэжлийн их, дээд сургуулийн сургалт, эмнэлгийн дадлага. Ахмад настны тусламжийн салбарт ажиллахын тулд нэмэлт мэргэшлийн сургалтад хамрагдсан байх.	- Шаардлагатай бол давтан сургалтад хамрагдана. Давтан сургалтын кредит цаг нь 20-40 байна. Гэвч мэргэжлийн болон муж улсын зохицуулалтаас шалтгаалан өөрчлөгдөж болно.	- Мэргэжлийн холбоод болон эмнэлгийн байгууллагууд сургалтыг зохион байгуулна. - Ахмад настны тусламж, эмчилгээний шинэ арга барил, эрүүл мэндийн шинэ стандартууд, эмчилгээний менежментийн чиглэлээр сургалтад хамрагдана. - Мэргэшлийн сертификат олгох, лиценз шинэчлэх.
Сувилагч (Pflegefachkraft)	- Мэргэжлийн сургалт (3 жил): Эрүүл мэндийн үндсэн мэдлэг, асаргааны ур чадвар, сэтгэл зүйн боловсрол эзэмшсэн байх. 2,100 цагийн онолын сургалт, 2,500 цагийн практик дадлага.	- Тогтмол давтан сургалт (6 сар тутам): Давтан сургалт нь 1 жилд 24 кредит цаг байна. 1 кредит цаг = 45 минутын сургалт (тогтмол давтан сургалтын хөтөлбөрт багтдаг)	- Улсын сувилахуйн мэргэжлийн зөвлөл болон эрүүл мэндийн байгууллагууд сургалтыг зохион байгуулна. - Лиценз шинэчилдэггүй, кредит тооцож эрх сунгана. (Шинэ стандарт болон сургалтын шалгалттай)
Асрагч (Pflegehelfer / Betreuer)	- Мэргэжлийн сургалт (1-2 жил): Асаргааны үндсэн техник, эрүүл мэндийн тусламж,	- Тогтмол давтан сургалт: (1 жил тутамд)	-Мэргэжлийн холбоод, эрүүл мэндийн байгууллагууд сургалтыг зохион байгуулна. - Давтан сургалтаар лиценз

¹⁴ <https://www.pflegeausbildung.net/umschulung/voraussetzungen-und-ablauf.html>

¹⁵ Sozialgesetzbuch (SGB) - Elftes Buch (XI) https://www.gesetze-im-internet.de/sgb_11/

ахмад настны сэтгэл зүйн боловсрол эзэмшсэн байх. 1,000 цагийн онолын сургалт болон практик дадлага.	Давтан сургалт нь 1 жилд 18-30 кредит цаг байна. Сургалтын хөтөлбөрийн дагуу асаргааны шинэ арга барил, тусламжийн аргачлалын талаар мэдлэг олгох.	шинэчлэх шаардлагагүй боловч мэргэшлийн шаардлагыг хангах үүднээс кредит тооцдог.
--	--	---

3.2 Их Британи

АНТАУТ нь үйл ажиллагааны хүрээ, чиглэлээрээ харилцан адилгүй тул асрамжийн газар бүр өөрийн үйлчлүүлэгчдийн хэрэгцээ, шаардлагын үнэлгээнд нийцүүлэн шаардлагатай ажилтнуудын тоо, ур чадварын түвшинг тодорхойлон Үндэсний асрамжийн стандартын хорооноос зөвшөөрөл авдаг. Нийгмийн халамжийн үндэсний сургалтын газар (National Training Organisation for social care) нь асрамжийн ажилтнуудад зориулсан үндэсний мэргэжлийн стандартыг боловсруулж, эрүүл мэнд, нийгмийн халамжийн 8 гол чиглэлээр 5 түвшин бүхий ур чадвар олгох хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг байна.¹⁶ Үүнд:

- Эрүүл мэнд, аюулгүй байдал;
- Харилцаа, хандлага;
- Хувийн асрамж үйлчилгээ;
- Өвчтөнд зориулсан хувийн асрамж үйлчилгээний төлөвлөгөө;
- Эмчилгээний үйл явц, хяналт;
- Өвчтөнийг хамгаалах;
- Сэтгэц, ой санамжаа алдах өвчинтэй хүнийг асрах;
- Хөнгөвчлөх эмчилгээ, үйлчилгээ.

Эрүүл мэндийн яамнаас баталсан Ахмад настны асрамжийн газарт баримтлах Үндэсний доод стандартад заасны дагуу асрах үйлчилгээ үзүүлэх ажилтнуудын хувьд дараах шалгуурыг хангаж ажиллахыг асрамжийн газруудаас шаарддаг. Үүнд:

- Асрамжийн газрын асрах үйлчилгээ үзүүлж буй нийт ажилтнуудын 50-аас багагүй хувь нь Үндэсний мэргэжлийн ур чадварын үнэлгээ (National Vocational Qualification)-ний 2 дугаар түвшинтэй байх;
- Үйлчлүүлэгчдэд хувийн асаргаа, үйлчилгээ үзүүлж буй ажилтан 18 нас хүрсэн байх, асрамжийн газрыг хариуцан ажиллуулж буй ажилтан 21 болон түүнээс дээш настай байх;
- Дадлагажигчид (18-аас доош насны бүх ажилтнуудыг оролцуулан) Нийгмийн халамжийн үндэсний сургалтын газрын хөтөлбөрт бүртгүүлсэн байх;

¹⁶ <https://www.nvqcourse.co.uk/health-social-care.html>

- Цагдаагийн байгууллага, Хүүхэд, эмзэг бүлгийн насанд хүрэгчдийн хамгаалалт (Protection of Children and Vulnerable Adults) болон Сувилахуй, эх баригчдын зөвлөл (Nursing and Midwifery Council)-ийн бүртгэлээс тус тус тодорхойлолт авсны үндсэн дээр ажилд томилно.

Ажилтны сургалт:

30 дугаар стандарт

30.1 Ажилд орохоор бүртгүүлсэн хүн Үндэсний сургалтын газрын ажиллах хүчин бэлтгэх сургалтын зорилтод нийцсэн ажилтныг сургах, хөгжүүлэх хөтөлбөрт хамрагдах, тухайн асрамжийн газрын зорилго болон үйлчлүүлэгчдийн өөрчлөгдөж буй хэрэгцээ шаардлагыг хангаж ажиллах ойлголттой байх.

30.2 Үндэсний сургалтын газраас үүрэг болгосны дагуу бүх ажилтнууд ажилд орсноос хойш 6 долоо хоногийн дотор ажлын байр, ажлын чиг үүрэгтэйгээ Танилцах сургалтанд хамрагдсан байх. Үүнд: асрамж үйлчилгээнд баримтлах зарчим, аюулгүй ажиллагаа, байгууллага болон ажилтны үүрэг, үйлчлүүлэгчдийн онцгой хэрэгцээ шаардлага, үйлчилгээний тусгай нөхцөл зэрэг орно.

30.3 Танилцах сургалтаар бүх ажилтнууд үйлчлүүлэгч бүрийн хувийн асрамж үйлчилгээний төлөвлөгөөнд тодорхойлсон, тэдний үнэлэгдсэн хэрэгцээ шаардлага (assessed needs)-тай танилцах.

30.4 Нийт ажилтнууд жил бүр доод тал нь ажлын 3 өдрийн цалинтай сургалтад хамрагдах, (үүнд ажлын байран дээрх сургалтыг мөн оруулна), түүнчлэн бие даасан сургалтад хамрагдан, ур чадварын түвшингээ нэмэгдүүлэх.

3.3 Бүгд Найрамдах Солонгос Улс

Ахмад настны халамжийн тухай хуулийн 39-2, 39-3 дугаар зүйлд ахмадын халамжийн байгууллагад ажиллах сувилахуйн ажилтантай холбоотой харилцааг зохицуулсан.

Ахмад настны нийгмийн халамжийн байгууламж нь ахмад настны дасгал хөдөлгөөн болон өдөр тутмын хөдөлгөөнийг дэмжих чиглэлээр мэргэшсэн сувилахуйн ажилтантай байна. Сувилахуйн ажилтан нь сувилахуйн ажилтан бэлтгэх сургалтад хамрагдаж, эрх олгох мэргэшлийн шалгалт өгч тэнцсэн тохиолдолд хот/аймгийн засаг даргаас сувилахуйн гэрчилгээ авсан байх ёстой.

Сувилахуйн ажилтан бэлтгэх сургалтыг Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яамнаас тогтоосон стандартыг хангасан сургалтын байгууллага зохион байгуулах бөгөөд зөвшөөрлийг орон нутгийн засаг захиргааны нэгжийн Засаг дарга олгодог.

Ахмадын асрамжийн газарт ажиллаж буй ажилтнуудыг давтан сургах нь үйлчлүүлэгчдийн аюулгүй байдлыг хангах, асрамжийн газрын үйлчилгээний чанарыг сайжруулахад чухал хүчин зүйл болдог. Тиймээс сургалтын хөтөлбөрүүд нь ахмад настны бие бялдар, сэтгэл санаа болон нийгмийн хэрэгцээ, шаардлагад

нийцсэн үйлчилгээ үзүүлэхэд ажилтнуудад туслах зорилготой байх ёстой бөгөөд дараах агуулгын хүрээнд сургалтуудыг зохион байгуулдаг. Үүнд:

- Ахмад настны асаргаа, сувилгааны анхан шатны боловсрол: Үүнд нас ахих тусам хүний бие махбодийн болон сэтгэцийн өөрчлөлт, ахмад настны өдөр тутмын амьдралд дэмжлэг үзүүлэх, аюулгүй байдал, эрүүл ахуйг хангах талаар;

- Анхны тусламж үзүүлэх, сэхээн амьдруулах боловсрол: Өдөр тутмын амьдралд тохиолдож болох уналт, халуурах, амьсгалахад хүндрэлтэй байх зэрэг гэмтэл бэлтлийн үед авах арга хэмжээ, сэхээн амьдруулах (CPR) тусламж, хариу арга хэмжээ, түүнчлэн эмийг хэрхэн зөв хэрэглэх, гаж нөлөөнөөс зайлхийх талаар;

- Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ: Ахмад настнуудын сэтгэл гутрал, айдас, ой санамж муудах зэрэг сэтгэл зүйн асуудлыг шийдвэрлэх, сэтгэцийн эсхүл танин мэдэхүйн өөрчлөлттэй хүмүүстэй харилцах болон стрессийг хэрхэн зохицуулах, сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх талаар;

- Хөгжлийн бэрхшээлийн менежментийн талаарх боловсрол: Альцгеймерийн өвчин, Паркинсоны өвчин зэрэг ахмад настны өвчний талаар, сэтгэцийн хомсдолтой, бие махбодын бэрхшээлтэй өндөр настанд зориулсан тусгай тусламж үйлчилгээ үзүүлэх талаар;

- Нөхөн сэргээх дасгал хөдөлгөөний боловсрол: Ахмад настны бие махбодын ур чадварыг хадгалах, сайжруулах, физик эмчилгээ болон дасгал хөдөлгөөн хийлгэх талаар;

- Хоол тэжээлийн менежмент: Хоолны дэглэмийг хязгаарлах менежмент: Чихрийн шижин, цусны даралт ихсэх зэрэг өвөрмөц өвчинд тохирсон хоолны дэглэм, Хооллохдоо анхаарах зүйлс: Залгихад хүндрэлтэй байгаа ахмад настанд зориулсан хоол бэлтгэх, аюулгүй хооллох арга техникийн талаар;

- Соёлын мэдрэмж, олон талт байдлын боловсрол: Соёлын ялгааг хүндэтгэх: Соёлын янз бүрийн гарал үүсэлтэй ахмад хүмүүсийг ойлгож, хүндэтгэх, олон янз байдлыг хүлээн зөвшөөрөх: шашин шүтлэг, арьсны өнгө, хүйс зэрэг олон янз байдлыг хүндэтгэх талаар;

- Эрүүл, аюулгүй байдлын сургалт: Гсрамжийн газарт галын хариу арга хэмжээ, яаралтай тусламжийн гарын авлага, уналтаас урьдчилан сэргийлэх, Эрүүл ахуйн менежмент: халдвараас урьдчилан сэргийлэх, нянгийн хяналт, эрүүл ахуйн дүрмийн боловсрол олгох зэрэг сургалтуудад хамруулдаг.

3.4 Япон Улс

Сувилахуйн байгууллагад ажиллахаасаа өмнө албан ёсны 3 жилийн сувилахуйн боловсрол эзэмшиж, Үндэсний лицензийн шалгалт өгөн сувилахуйн лиценз авснаар сувилахуйн чиглэлээр ажиллах эрх нь нээгддэг байна. Ахмад настны тусгай асрамжийн газарт ажиллах сувилахуйн мэргэжилтэн нь:

- Танилцуулах сургалт – Байгууллагын дотоод журам, стандарт, аюулгүй байдал
- Ментор сургалт – Зөвлөх сувилахуйн мэргэжилтэнд дагалдуулан сургах

- Ур чадварыг хөгжүүлэх – ахмад настантай ажиллах мөн тэдний өвөрмөц хэрэгцээ (альцгеймер, хөнгөвчлөх эмчилгээ)-ний сургалт
- Деминтийн тусламж үйлчилгээний сургалт
- Аюулгүй байдал – Хууль эрх зүй болон ёс зүйн сургалтууд
- Харилцааны ур чадвар – өвчтөнд төвлөрсөн хараа, сонсгол, танин мэдэхүйн сургалт
- Олон талт – физик эмчилгээ, хоол зүйч, хөдөлгөөн засалч зэрэг бусад мэргэжлийн багтай хамтран ажиллах арга зүйн сургалт
- Технологи инновац – цахим эрүүл мэндийн систем, дэвшилтэт технологийн сургалт
- Мэргэжил дээшлүүлэх – дотоод гадаадын сургалтад хамрагдаж нэмэлт мэргэжлийн гэрчилгээ авах сургалт гэх мэт сургалтад шат дараалалтай суралцана.

Үүнээс гадна асрамжийн газар нь сувилахуйн ажилтны ажлыг 3 сар тутам үнэлэн, нарийн мэргэшүүлэх шаардлагатай сургалт болон хүний эрхийг хамгаалах, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх тогтолцоог бүрдүүлж, албан хаагчдад тогтмол сургалт явуулах үүрэгтэй.

3.5 Монгол Улс

Монгол Улсын Нийгмийн халамжийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.9 дэх хэсэгт заасны дагуу асаргааны тэтгэмж авч байгаа иргэд асаргаа, сувилгааны болон асрамжлах үйлчилгээний ур чадвар эзэмшүүлэх сургалтад хамрагдах ёстой. ХХҮЕГ-ын даргын 2012 оны 165 дугаар тушаалаар батлагдсан “Асаргаа сувилгааны болон асрамжлах үйлчилгээний ур чадвар эзэмшүүлэх сургалт зохион байгуулах журам”-аар дээрх харилцааг зохицуулж байна.

Төрөлжсөн асрамжийн газрын хүний нөөцийг бэлтгэх, давтан сургах тухайд, тус газарт ажиллаж буй эмч, мэргэжилтэн, асарагч, сувилагч нарыг Эрүүл мэндийн тухай хуульд заасан зохицуулалтын хүрээнд бэлтгэж, давтан сургаж байна. Жишээлбэл, Ахмад настны үндэсний төвд гэхэд 120 орчим ажилтан ажиллаж байгаа бөгөөд тэдгээр нь эмч, сувилагч, асрагч зэрэг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний үндсэн болон төрөлжсөн мэргэшилтэй байна.

Улсын хэмжээнд 250 гаруй ажилтан, албан хаагчид ахмад настны асрамжийн газруудад ажиллаж байна.

Дөрөв. АХМАД НАСТНЫ ТӨРӨЛЖСӨН АСРАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САНХҮҮЖИЛТ

4.1 Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

Герман улсын ахмад настны асрамжийн газрын санхүүжилтийн асуудлыг Нийгмийн халамжийн тухай хуулийн (SGB XI) 11-р хэсэг буюу Ахмад настны урт хугацааны асрамжийн даатгалын тухай хуулийн 82-р зүйлд зохицуулсан.¹⁷

Хуульд зааснаар ахмад настны асрамжийн газрын санхүүжилт нь төрийн, хувийн болон хосолмол санхүүжилтийн хэлбэртэй байж болно. Төрийн санхүүжилттэй асрамжийн газар нь нийгмийн халамжийн даатгал, улсын төсвөөс санхүүждэг, харин хувийн санхүүжилттэй асрамжийн газар нь хувийн хөрөнгө оруулалт, төлбөрийн орлого дээр тулгуурлан үйл ажиллагаагаа явуулдаг. Хосолмол санхүүжилттэй асрамжийн газар нь төрийн болон хувийн түншлэлийн санхүүжилтийг хослуулан үйл ажиллагаагаа явуулдаг байна.

Хүснэгт 11. Асрамжийн газруудын санхүүжилтийн эх үүсвэр

Шинж чанар	Төрийн санхүүжилттэй асрамжийн газрууд	Хувийн санхүүжилттэй асрамжийн газрууд	Хосолмол санхүүжилттэй асрамжийн газрууд
Санхүүжилтийн эх үүсвэр	100 % төрийн санхүүжилт (улсын болон орон нутгийн төсөв)	100 % хувийн санхүүжилт (хувийн хөрөнгө оруулалт, үйлчлүүлэгчийн төлбөр)	Төрийн болон хувийн санхүүжилт (төрийн санхүүжилт, үйлчилгээний орлого, хандив, бусад санхүүгийн эх үүсвэр)
Санхүүжүүлж буй үйл ажиллагаа	Төрөөс асрамжийн үйлчилгээ, эмнэлгийн тусламж болон бусад нийгмийн үйлчилгээ, ажилтны цалин хөлс, үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлнэ.	Асрамжийн үйлчилгээ, хоол хүнс, байр, эмчилгээ, нэмэлт үйлчилгээ зэрэг бүх үйлчилгээ, ажилтны цалин хөлс, үйл ажиллагааны зардлыг асрамжийн газраас санхүүжүүлнэ.	Төрөөс (нийгмийн халамжийн даатгал) асрамжийн үйлчилгээний 50-80 хувийг санхүүжүүлнэ. Үйлчлүүлэгчээс орон байр, хоол хүнс, нэмэлт эмчилгээ, тусгай үйлчилгээний төлбөрийг авна.

Улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг асрамжийн газрууд нь үйл ажиллагааны зардлыг олон нийтийн санхүүжилт, хандив тусламжаар санхүүжүүлсэн бол Нийгмийн халамжийн даатгалын санд мэдээлэх үүрэгтэй. Мөн шаардлагатай хөрөнгө оруулалт, түрээс, хөрөнгө оруулалт, барилга байгууламжийн засвар зэргийг зээл, буцаан төлөгдөх эх үүсвэрээр санхүүжүүлэх тохиолдолд харьяа нутаг дэвсгэрийн захиргаанаас зөвшөөрөл авах шаардлагатай.

¹⁷ Sozialgesetzbuch (SGB) - Elftes Buch (XI) https://www.gesetze-im-internet.de/sgb_11/

4.2 Их Британи

Их Британи улсад ахмад настны асрамжийн газрын төлбөр тухайн асрамжийн газар хаана байрладаг, үйлчилгээний төрөл зэргээсээ хамааран харилцан адилгүй байна. Сувилахуйн асрамжийн газрын төлбөр нь эрүүл мэндийн тусгай асрамж үйлчилгээнээс хамааран харьцангуй өндөр байна. Асрамжийн газрын 7 хоногийн дундаж төлбөр:

- Энгийн асрамжийн газар ойролцоогоор 600 фунт стерлинг
- Сувилахуйн асрамжийн газар ойролцоогоор 800 фунт стерлинг.

Асрамжийн газрын төлбөрийг үйлчлүүлэгч хувиараа, орон нутгийн захиргааны тусламжтайгаар, Үндэсний эрүүл мэндийн байгууллагын тусламжтайгаар болон хувийн эрүүл мэндийн даатгалаар тус тус төлөх боломжтой. Төлбөрийн ойролцоогоор 40-45%-ийг төрөөс буюу орон нутгаас санхүүжүүлдэг бол үлдсэн хувийг үйлчлүүлэгч өөрөө, тухайлбал, үйлчлүүлэгчийн тэтгэврийн орлогоос төлдөг байна. Ингэхдээ үйлчлүүлэгчид долоо хоногийн Хувийн зардал (Personal Expenses Allowance)-д доод тал нь 30.15 фунт стерлинг үлдээх шаардлагатай. Шаардлагатай тохиолдолд орон нутгийн захиргаанаас хувийн зардлын хэмжээг нэмэгдүүлэх боломжтой.

Орон нутгийн захиргааны тусламжтайгаар төлөх тохиолдолд үйлчлүүлэгч Санхүүгийн үнэлгээ (financial assessment) хийлгэх шаардлагатай. Санхүүгийн үнэлгээний ажилтан дараах мэдээллүүдийг нягталснаар орон нутгийн санхүүжилт авах боломжтой эсэхийг шийдвэрлэнэ:

- Орлого
- Тэтгэвэр
- Тэтгэмж (Тэтгэврийн насанд хүрсэн иргэдэд олгох тэтгэмж (Attendance Allowance) зэрэг)
- Хадгаламж
- Өмч хөрөнгө (гадаад улс дахь өмчийг оруулан тооцно).

Хэрэв үйлчлүүлэгчийн хадгаламж 23.250 фунт стерлингээс илүү бол Хөрөнгийн дээд хязгаар (Upper capital limit) гэж үзэн, мөн тодорхой хэмжээний өмч хөрөнгө эзэмшдэг бол тус тус орон нутгийн санхүүжилт авах боломжгүй байна. Өндөр настан эрүүл мэндийн байдлын улмаас асрамжийн газарт байх шаардлагатай тохиолдолд тодорхой шалгуурын үндсэн дээр Үндэсний эрүүл мэндийн байгууллагаас төлбөрийг бүрэн эсхүл тодорхой хэмжээг төлөх боломжтой.¹⁸

¹⁸ <https://www.ageuk.org.uk/information-advice/health-wellbeing/health-services/nhs-continuing-healthcare/>

4.3 Бүгд Найрамдах Солонгос Улс

Асрамжийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагуудын санхүүжилт нь нийгмийн халамжийн сан буюу улс, орон нутгийн төсөв, хууль ёсны сан болон үйлчлүүлэгчийн хувийн зардал гэсэн гурван төрөлтэй.

Ахмад настны халамжийн тухай хуулийг хэрэгжүүлэх журмын 15-2-т ахмад настны асрамжийн газарт хэвтэх зардлыг дараах байдлаар зохицуулсан. Үүнд:

- Төрийн болон орон нутгийн засаг захиргаа зардлыг 100 хувь хариуцах: Үүнд амжиргааны тэтгэмж авагч, эсхүл эрүүл мэндийн тэтгэмж авагч 65 ба түүнээс дээш насны хүн болон 65-аас дээш насны тэжээн тэтгэх хүнгүй ахмад настан хамаарна.
- Төр болон орон нутгийн засаг захиргаа зардлын тодорхой хувийг хариуцах: Энэ тохиолдолд өргөдөл гаргагч болон түүний гэр бүлийн нэг хүнд ногдох сарын дундаж орлогоос хамаарах бөгөөд 65-аас дээш насны ахмад настан хамаарна.
- Үйлчлүүлэгч бүх зардлаа өөрөө хариуцах: Асрамжийн газар болон ахмадын нийтийн байр нь үйлчлүүлэгчээс бүх зардлыг гаргуулдаг буюу хувийн асрамжийн газар хамаарах бөгөөд 60-аас дээш насны ахмад настан хамаарна.

Өөрөөр хэлбэл, 65-аас дээш насны, үндсэн тэтгэмж авах боломжтой, эсвэл тэжээн тэтгэх хүнгүй ахмад настанд зориулагдсан асрамжийн газар нь төр эсвэл орон нутгийн засаг захиргаа бүх зардал болон зардлын тодорхой хувийг татаасаар олгодог.

4.4 Япон Улс

Ахмад настны тусгай асрамжийн газрын үйл ажиллагааны санхүүжилт нь урт хугацааны асрамжийн даатгалын шимтгэлээр дамжуулан төрийн санхүүжилт (25%), үйлчлүүлэгч болон тэдний гэр бүлээс төлөх хувийн төлбөр (10-30%), орон нутгийн санхүүжилт(45%)-ээс бүрдэнэ. Урт хугацааны асрамжийн даатгалын тогтолцооны үйлчилгээний төлөвлөгөөг 3 жил тутам шинэчлэнэ. Тус төлөвлөгөөний дагуу даатгалын шимтгэл, нөхөн төлбөрийг шинэчилдэг.

Урт хугацааны асрамжийн даатгалын шимтгэл – 40 ба түүнээс дээш насныхан эрүүл мэндийн даатгалаар дамжуулан шимтгэл төлнө. Энэ нь шимтгэл төлөгчийн орлого наснаас хамааран шимтгэлийн хэмжээ өөр өөр байна. 65-аас дээш насны иргэдийн шимтгэлийг тэтгэврээс нь автоматаар хасна.

Хувийн төлбөр – үйлчлүүлэгчийн орлогоос хамааран 10-30 хувийн төлбөрийг авна.

Орон нутгийн санхүүжилт – Асрамжийн газруудын хөгжил, ашиглалт, чанарыг дэмжих зорилгоор гаднын санхүүжилтийг олгодог. Үүнд:

- Барилга байгууламжийг барих, засварлахад татаас өгөх
- Инновацад суурилсан буцалтгүй тусламж
- Олон нийтийн хандив
- Халамж үйлчилгээний буцалтгүй тусламж зэрэг орно.

4.5 Монгол Улс

Монгол Улсын Нийгмийн халамжийн тухай хуульд зааснаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үзүүлэх нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээний зардлыг орон нутгийн төсөв, халамжийн сангаас гэрээний үндсэн дээр хэсэгчлэн буюу бүрэн санхүүжүүлдэг (НХтХ 26.5).

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн А/189 дүгээр тушаалаар батлагдсан “Төрөлжсөн асрамжийн газрын төсвийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам”-д зааснаар Төрөлжсөн асрамжийн газрын орлого дараах эх үүсвэрээс бүрдэнэ. Үүнд:

- тухайн төсвийн жилд асрамжийн газрын үйл ажиллагаанд зарцуулахаар улсын төсвөөс, эсхүл орон нутгийн төсвөөс олгосон хөрөнгө;
- асрамжийн үйлчилгээнд шууд зориулалтаар олон улсын байгууллага, гадаад улс, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага, иргэдээс өгсөн хандив, тусламж;
- төлбөртэй асрамжийн үйлчилгээнд хамрагдсан иргэний төлсөн төлбөр;
- асрамжийн газарт хэрэгжсэн төсөл, хөтөлбөрөөс олгосон санхүүжилт;
- асрамжийн газрын үйл ажиллагааны өөрийн орлого /туслах аж ахуй, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх/;
- Нийгмийн халамжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.8-д заасны дагуу тэтгэвэр авагч ахмад настан, 18 ба түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэврийн 30 хувийг асрамжийн газарт төвлөрүүлсэн хөрөнгө;
- бусад холбогдох хууль, журмын дагуу санхүүжүүлсэн эх үүсвэр.

Асрамжийн газрын үйл ажиллагааны зардалд зарцуулах хөрөнгийг Нийгмийн халамжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.5-д заасан зардлын норматив болон төрөлжсөн асрамжийн үйлчилгээний стандартын шаардлага хангасан дараах үйлчилгээнд зарцуулна. Үүнд:

- эрүүл ахуй, чанарын шаардлага хангасан хоол хүнс, ариун цэврийн хэрэгсэл;
- улирлын онцлогт тохирсон хувцас, зөөлөн эдлэл;
- эмнэлгийн үйлчилгээ /урьдчилан сэргийлэх болон төрөлжсөн мэргэшлийн эмчийн үзлэгт хамруулах, шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл/;
- төрөлжсөн мэргэшлийн эмнэлэгт эмчлүүлэх үйлчлүүлэгчийн замын зардал, эмчилгээ, шинжилгээний төлбөр;
- ариутгал халдваргүйжүүлэлт;
- ариун цэврийн хэрэглэл;
- хатуу, зөөлөн эдлэл;
- үйл ажиллагааны зардал /цалин, цахилгаан, халаалт, цэвэр, бохир ус, бичиг хэрэг, албан томилолт, харилцаа холбоо, ажилтны нормын хувцас, шимтгэл, шатахуун, байгууллагын эд хогшил, тавилга, тоног төхөөрөмж /;
- үйлчлүүлэгчийн хөгжлийн үйлчилгээний зардал / үдэшлэг, уулзалт, урлаг, уран сайхан, спорт, аялал зугаалга, уралдаан тэмцээн зохион байгуулах зэрэг чөлөөт цагийн арга хэмжээ/;

- үйлдвэрлэл,үйлчилгээ эрхлэх /үйлчлүүлэгчийн эрүүл мэнд, чадавхад тохирсон гар урлал, төмс, хүнсний ногоо тариалах, мал маллах, байр, талбайн цэвэрлэгээ, тохижилт хийх/-тэй холбоотой зардал;
- асрамжийн газраас гарч бие даан амьдрах үйлчлүүлэгчид үзүүлэх 1 удаагийн дэмжлэг;
- асрамжийн үйлчилгээг сайжруулахад зориулсан хөрөнгө оруулалт;
- ажилтан, албан хаагчийн мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх,
- чадавхжуулах сургалтын зардал;
- тогтвор суурьшилтай ажилласан ажилтан, албан хаагчийн нийгмийн хамгааллын зардал болон байгууллагын дотоод журамд заасан арга хэмжээний зардал;
- үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдлын зардал;
- үндсэн хөрөнгийн урсгал засвар;
- хөрөнгийн даатгал, татвар, төлбөр;
- үйлчлүүлэгчийн асрамжийн газарт байхдаа төрүүлсэн хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын болон их дээд сургууль, коллежид суралцах хугацааны төлбөр.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн А/190 дугаар тушаалаар батлагдсан “Төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа ахмад настан, 18 ба түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй иргэнд тэтгэвэр олгох журам”-д зааснаар төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа нийгмийн даатгалын болон нийгмийн халамжийн сангийн тэтгэвэр авагч ахмад настны тогтоогдсон тэтгэврийнх нь 70 хувийг үйлчлүүлэгчид, 30 хувийг тухайн асрамжийн үйлчилгээ үзүүлж байгаа асрамжийн газар олгохоор зохицуулсан.

Дээр дурдсан зардлын нормативыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 09 дүгээр сарын 28 -ны өдрийн А/130 дугаар тушаалаар тус тус баталсан байна. "Төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа иргэний хоногт хэрэглэх хоолны норм, илчлэгийн хэмжээ, зардлын норматив"-ыг нэгдүгээр, "Төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа иргэний хувцас, ариун цэврийн болон хичээлийн хэрэглэлийн зардлын норматив, эдэлгээний хугацаа"-г хоёрдугаар, "Төрөлжсөн асрамжийн газарт зайлшгүй байх эмийн жагсаалт"-ыг гуравдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Герман Улс

- Нийгмийн халамжийн тухай хууль
https://www.gesetze-im-internet.de/sgb_11/BJNR101500994.html
- Асрамжийн газрын тухай хууль (Heimgesetz) <https://www.gesetze-im-internet.de/heimg/>
- Асрамжийн газрын барилгын доод стандартын хууль (HeimMindBauV)
<https://n9.cl/gijt9>
- Enhancing Dementia Nursing Homes in South Korea: Lessons from German Building Standards <https://www.mdpi.com/2075-5309/14/5/1427>
- Long-term care in germany <https://n9.cl/c5afoj>
- <https://n9.cl/96sgu6>

Их Британи

- Health and Social Care Act 2008 <https://www.legislation.gov.uk/ukpga/2008/14>
- Care Standards Act 2000 <https://www.legislation.gov.uk/ukpga/2000/14/enacted>
- Care Quality Commission <https://www.england.nhs.uk/ourwork/part-rel/cqc/>
- National Minimum Standards Care homes for Older People
https://www.dignityincare.org.uk/_assets/resources/dignity/csipcomment/csci_national_minimum_standards.pdf
- Care homes <https://www.nhs.uk/conditions/social-care-and-support-guide/care-services-equipment-and-care-homes/care-homes/>
- Paying for residential care <https://www.ageuk.org.uk/information-advice/care/paying-for-care/paying-for-a-care-home/>

БНСУ

- Ахмад настны халамжийн тухай хууль (1997) <https://n9.cl/f3kwt>
- Ахмад настны халамжийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах журам
<https://n9.cl/dpxj7>
- Ахмадын асрамжийн байгууламж болон ажилтнуудын стандарт (Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яамны журам 2024.11.01-д нэмэлт, өөрчлөлт орсон) <https://n9.cl/9r3hgp>
- Department of Architecture and Architecture Engineering, Seoul National University, Seoul 08826, Republic of Korea. (2024) Enhancing Dementia Nursing Homes in South Korea: Lessons from German Building Standards
<https://www.mdpi.com/2075-5309/14/5/1427>

Япон Улс

- Act on Social Welfare for the Elderly
<https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/3930/en>

- Long-Term Care Insurance Act
<https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/3807/en>
- Act on Social Welfare for the Elderly <https://www.japaneselawtranslation.go.jp>
- Standart for the staffing, facilities <https://www.mhlw.go.jp/index.html>
- 特別養護老人ホーム <https://kaigo.homes.co.jp/manual/facilities>
- 特別養護老人ホーム стандартын 24-р зүйл

Монгол Улс

- Нийгмийн халамжийн тухай хууль (2012):
<https://legalinfo.mn/mn/detail?lawId=393>;
- Ахмад настны тухай хууль (2017): <https://legalinfo.mn/mn/detail?lawId=12453>;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль (2016):
<https://legalinfo.mn/mn/detail?lawId=11711>;
- <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16389973496901&showType=1>;
- Төрөлжсөн асрамжийн газарт ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хүлээн авах, шилжүүлэх, гаргах журам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн А/188 дугаар тушаалын хавсралт: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17048033844831>;
- Нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээ үзүүлэх иргэн, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулах журам, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын даргын 2012 оны 164 дүгээр тушаал;
- Асаргаа сувилгааны болон асрамжлах үйлчилгээний ур чадвар эзэмшүүлэх сургалт зохион байгуулах журам: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын даргын 2012 оны 165 дугаар тушаал;
- "Төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа иргэний хоногт хэрэглэх хоолны норм, илчлэгийн хэмжээ, зардлын норматив" Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 09 дүгээр сарын 28 -ны өдрийн А/130 дугаар тушаал;
- "Төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа иргэний хувцас, ариун цэврийн болон хичээлийн хэрэглээний зардлын норматив, эдэлгээний хугацаа" Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 09 дүгээр сарын 28 -ны өдрийн А/130 дугаар тушаал;
- "Төрөлжсөн асрамжийн газарт зайлшгүй байх эмийн жагсаалт" Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 09 дүгээр сарын 28 -ны өдрийн А/130 дугаар тушаал;
- Монгол Улсын нийгмийн хамгааллын тогтолцоон хийсэн дүн шинжилгээ, ОУХБ 2023:
https://www.ilo.org/sites/default/files/wcmsp5/groups/public/@asia/@ro-bangkok/@ilo-beijing/documents/publication/wcms_895739.pdf

ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

АСРАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

Ажлын зорилго:

Асрах үйлчилгээний тухай хуулийн төсөл батлагдсанаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог гаргаж, зардал, үр нөлөөний шинжилгээг хуульд заасан аргачлалын дагуу тодорхойлох.

Улаанбаатар хот
2026 он

АГУУЛГА

Ажлын зорилго:	1
Нэг. Ерөнхий мэдээлэл.....	1
Хоёр. Асрах үйлчилгээтэй холбоотой нийгмийн халамжийн чиглэлийн зардлын өнөөгийн байдал.....	3
Одоогийн хууль, эрх зүйн орчин.....	3
Асрах үйлчилгээтэй холбоотой бусад дүрэм, журам:	3
Санхүүжилтийн эх үүсвэр, зарцуулалт	5
Санхүүжилтийн бүтэц	6
Асрах үйлчилгээний одоогийн төрөл, зохион байгуулалт	7
Үйлчилгээний загварууд ба байгууллагын тогтолцоо	7
А. Төрөлжсөн асрамжийн байр.....	7
Нийгмийн халамжийн сангийн асаргааны тэтгэмжийн төрөл, 2021-2024 оны хооронд хамрагдсан хүний тоо, санхүүжилт	10
Ахмад настны тухай хуулийн хүрээнд үзүүлж буй тусламж, үйлчилгээний төрөл	11
В. Сувилал (Санаториум).....	12
Г. Идэвхтэй Насжилтыг Дэмжих Төв (ИНДТ/ААН) — Туршилтын загвар ...	13
Д. Гэр бүлийн асрагчийн дэмжлэг	14
Гурав. Ирээдүйн бодлогын чиглэл (шинжээчийн санал) хувилбар	17
АСРАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУУЛИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БОЛОН ДААТГАЛ, ТӨСВИЙН ТАТААС, ДЭМЖЛЭГИЙН ТАЛААРХ САНАЛ, ТЭДГЭЭРИЙН ЗАРДЛЫН ТООЦОО	17
3.1 Хувийн хэвшлийг дэмжих “Care infrastructure financing model”	20
Зээлийн хүүгийн татаасын бодлогын 3 хувилбар	22
Төрийн төсвийн нөлөө (жишээ)	23
3.2 АСРАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ДААТГАЛЫН ХУВИЛБАР, ТООЦОО	26
Санал болгох даатгалын 3 хувилбар	27
Бодлогын түвшний санал	28
Дүгнэлт.....	29
Дүгнэлт	31
Монголд хамгийн тохиромжтой загварын санал	32

АСРАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ЗАРДЛЫН ТООЦОО, ТӨСВИЙН НӨЛӨӨЛӨЛ

Дөрөв. Асрах үйлчилгээний тухай анхдагч хуулийн төсөл батлагдсанаар иргэн, аж ахуйн нэгж болон төрийн байгууллагын зардлын нөлөөллийн тооцоолол ..33

4.1.Иргэнд үүсэх зардлын тооцоо:33

“39 дүгээр зүйл. Иргэний төлбөр33

40 дүгээр зүйл.Асрах үйлчилгээний даатгал33

1) Асрах үйлчилгээний төрлийн харьцуулалт Хүснэгт№19.34

2) Асрах үйлчилгээний ангилал (хугацаа)-ын харьцуулалт Хүснэгт №20.

35

Хуулийн төслийн хүрээнд шинээр нэмэгдэх болон бусад үйлчилгээний төлбөрийн тодорхой хэсгийн иргэн хариуцах тохиолдол:.....38

2. Иргэний зардлын нөлөөлөл38

4.3. Асрах үйлчилгээний тухай хуулийг хэрэгжүүлэх төрийн байгууллагын зардлын тооцоолол.....40

А. Тооцоолол-1:.....42

Нэг нүүрний өртгийн үндэслэл.....47

Эрсдэл, нөөц хөрөнгө, зардал бууруулах зөвлөмж.....48

Б.Тооцоолол-2 Хувийн хэвшлийн асрах үйлчилгээ үзүүлэгч байгууллагын дэмжлэг, төрийн татаасны зардлын нөлөө49

В. Тооцоолол- 3.....49

Г. Тооцоолол-4:50

Хэсгийн дүгнэлт:52

Төрийн байгууллагын түвшинд гарах нэгдсэн төсвийн нөлөө (жилийн)52

4. Бодлогын үр нөлөө53

5. Хэсгийн дүгнэлт53

Тав. Санал дүгнэлт57

ЗАРДЛЫН БҮТЭЦ (ДҮГНЭЛТ).....58

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ61

Монгол хэл дээр61

Англи хэл дээр:61

Нэг. Ерөнхий мэдээлэл

Асрах үйлчилгээний тухай анхдагч хуулийн төсөл болон бусад дагалдан гарах хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцооллыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал /цаашид “аргачлал” гэх/-ын дагуу хийж гүйцэтгэлээ.

Асрах үйлчилгээний тухай хуулийн үйлчлэл нь ахуйн өдөр тутмын асаргаа, нөхөн сэргээх асрах үйлчилгээ, асаргааны хувилбарт үйлчилгээ болон хүний эрх, нийгмийн харилцаанд бие дааж оролцоход хүндрэл бэрхшээлтэй, бусдын туслалцаа, дэмжлэг шаардлага бүхий хүнд үзүүлэх асрах үйлчилгээнд хамаарна. Энэ нь зөвхөн ахмад настны асрах үйлчилгээ бус өргөн хүрээнд хүртээмжтэй байдлаар хэрэгцээтэй иргэнд стандартын шаардлага хангасан, мэргэжлийн асрах үйлчилгээг үзүүлэхээр зохицуулсан болно. “Асрах үйлчилгээ бол халамж биш — амьдралын эрсдэлийг даатгах нийгмийн хамгааллын шинэ багана” гэсэн концепцын хүрээнд боловсруулсан хуулийн төсөл болжээ.

Дэлхий даяар эмэгтэй ажиллах хүчний оролцооны 19.3 орчим хувь нь хөлстэй асрахуйн ажиллах хүчинд ногдож байна. Улс оронд нийгэм, эдийн засгийн ач холбогдолтой байгаа боловч асрахуйн ажил хөдөлмөрийн хуваарилалт жендерийнн хувьд ихээхэн тэнцвэргүй байна. Иймд энэхүү асрах үйлчилгээний тухай хууль нь асрахуйн эдийн засгийг дэмжих, улмаар асрахуйн ажил хөдөлмөрийг үнэлэх, эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх нэг гол хүчин зүйл байх боломжтой.

Асрах үйлчилгээний тухай хуулийн хамрах хүрээг тус хуулийн төслийн 3.2-т дараах байдлаар тусгасан. Үүнд:

- 3.2.1. өндөр наслалт, архаг болон даамжирсан өвчлөлөөс шалтгаалан өдөр тутмын амьдралын үйлдлийг өөрөө гүйцэтгэх боломжгүй болсон хүн;
- 3.2.2. хөгжлийн бэрхшээлээс шалтгаалан ахуйн болон нөхөн сэргээх асаргаа, байнгын асаргаа дэмжлэг шаардлагатай хүн;
- 3.2.3. тодорхой хугацааны асаргаа, нөхөн сэргээх дэмжлэг, хүний эрхийн хамгаалал, нийгмийн оролцоог хангах зэрэг хосолсон үйлчилгээ шаардлагатай хүн;
- 3.2.4. жирэмсний болон төрсний дараах үеийн ахуйн асаргаа, нөхөн сэргээх дэмжлэг, сэтгэл зүй, нийгмийн хамгаалал шаардлагатай болсон эх, нярай.

Асрах үйлчилгээний тухай хуулийн төсөл болон бусад дагалдан гарах хуулийн төслүүдийг 2027 оноос хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг дараах төрөл тус бүрээр тооцлоо:

- Асрах үйлчилгээний чиглэлээр нийгмийн халамжийн чиглэлийн зардлын өнөөгийн байдал /2010-2024/;
- Нийгмийн халамжийн сан болон бусад хэлбэрээр үүсэх зардал;

АСРАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ЗАРДЛЫН ТООЦОО, ТӨСВИЙН НӨЛӨӨЛӨЛ

- Төрийн байгууллагад үүсэх зардал;
- Хуулийн этгээдэд үүсэх зардал;
- Иргэнд үүсэх зардал;
- Гадаад орны туршлага, тариф, санхүүжилтийн эх үүсвэр;
- Санхүүжилтийн болон даатгалын хувилбар.

Түүнчлэн зардлыг тооцохдоо 2021-2025 оны нийгмийн халамжийн сангийн батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг суурь болгон авсан бөгөөд хувийн хэвшлийг дэмжих санхүүжилтийн хувилбар, асрах үйлчилгээний даатгалын тогтолцооны хувилбарыг олон улсын жишиг болон Монгол улсын нөхцөлд тохирсон хувилбарыг санал болгож, холбогдох зардлын тооцооллыг хийсэн болно.

Хоёр. Асрах үйлчилгээтэй холбоотой нийгмийн халамжийн чиглэлийн зардлын өнөөгийн байдал

Одоогийн хууль, эрх зүйн орчин

Асрах үйлчилгээтэй холбоотой төрөөс үзүүлж байгаа нийгмийн хамгааллын үйлчилгээний зардал нь Ахмад настны тухай хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Алдар цолтой ахмад настанд төрөөс нэмэгдэл хөнгөлөлт олгох тухай хуулиудын хүрээнд

Асрах үйлчилгээтэй холбоотой бусад дүрэм, журам:

Засгийн газрын тогтоол:

Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын 5 дугаар хавсралт
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНД ТУСЛАМЖ, ХӨНГӨЛӨЛТ ҮЗҮҮЛЭХ ЖУРАМ

Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 236 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт Хүүхэд хамгааллын үйлчилгээний нэг хүүхдэд ногдох дундаж зардлын норматив

Засгийн газрын 2025 оны 26 дугаар тогтоол – Журамд өөрчлөлт оруулах тухай

Засгийн газрын 2025 оны 241 дүгээр тогтоол –Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг шинэчлэн тогтоох

Засгийн газрын 2024 оны 245 дугаар тогтоол Ахмад настны асрамжийн үйлчилгээ шинээр үзүүлэх, барилга байгууламж барих аж ахуйн нэгж, байгууллагад төрөөс нэг удаагийн дэмжлэг үзүүлэх журам

Сайдын тушаал:

Сангийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан 2018 оны А/03/А/03 тоот тушаал “Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалттай асрамжийн газарт санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”

ХНХС-ын сайдын 2023 оны А/180 тушаал – Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ болон ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүнд зарим төрлийн үйлчилгээ үзүүлэх иргэн, ААН, ТББ-ыг магадлан итгэмжлэх журам

[https://pmc.ncbi.nlm.nih.gov/articles/PMC11467513/#:~:text=From%202019%20to%202022%2C%20the,implemented%20from%20March%202026.5\)](https://pmc.ncbi.nlm.nih.gov/articles/PMC11467513/#:~:text=From%202019%20to%202022%2C%20the,implemented%20from%20March%202026.5))

Comparative Analysis of Long-Term Care in OECD Countries: Focusing on Long-Term Care Financing Type

https://pmc.ncbi.nlm.nih.gov/articles/PMC9858923/?utm_source=chatgpt.com

Nearly 20 pct of Mongolians expected to be elderly by 2050-Xinhua

<https://english.news.cn/asiapacific/20241001/16ef52ccbd5f4a169ea81c51ac89f102/c.html>
mlsp.gov.mn

<https://www.mlsp.gov.mn/uploads/files/2127ecb08d24cbce33fb2c4f8bf3511d37c17940.pdf>

ОУХБ, 2024, Geneva, https://www.ilo.org/sites/default/files/2024-07/ILC112-Resolution%20V-%7BRELMEETINGS-240620-001%7D-Web-EN_0.pdf?utm_source=chatgpt.com

Health at a Glance 2025, OECD Indicators, https://www.oecd.org/en/publications/health-at-a-glance-2025_8f9e3f98-en/full-report/health-and-social-care-workforce_63ea8f12.html?utm_source=chatgpt.com



АСРАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Улаанбаатар хот
2026 он

АСРАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Гарчиг

Удиртгал.....	3
Нэг. Шалгуур үзүүлэлтийг сонгосон байдал.....	4
Хоёр. Хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал.....	4
2.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал:.....	5
2.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал:.....	5
2.3. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал:.....	5
2.4. “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал:.....	5
2.5. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал:.....	6
Гурав. Шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэлсэн байдал.....	7
3.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал.....	8
3.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал.....	12
3.3. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал.....	14
3.4. “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал.....	14
3.5. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал.....	17
Дөрөв. Үр дүнг үнэлж, зөвлөмж өгсөн байдал.....	18
4.1. Үнэлэлт, дүгнэлт.....	18

Удиртгал

Хууль тогтоомжийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1-т “Энэ хуулийн зорилго нь хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг санаачлах, боловсруулах ажиллагааны үндэслэл, чанарыг сайжруулах, түүнд олон нийтийн оролцоог хангах, хууль тогтоомжийн төсөлд тавих шаардлагыг тодорхойлох, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр нөлөөг үнэлэх замаар хууль дээдлэх ёсыг бэхжүүлэх” гэж тусгасан.

Тус үнэлгээ нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсэгт (1) хууль тогтоомжийн төсөл, эсхүл түүний зарим зүйл, заалтын зохицуулалтын практикт хэрэгжих боломж, харилцан уялдаа зэргийг тооцож шинжилгээ хийх; (2) хууль тогтоомжийн төслийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах; (3) хууль тогтоомжийн төслийг батлан хэрэгжүүлснээр үүсэж болзошгүй, урьдчилан тооцоогүй үр дагаврыг тодорхойлох; (4) хууль тогтоомжийн төслийн хүний эрхэд нөлөөлөх байдлыг үнэлэх зэрэг асуудлыг судлах замаар хуулийн төслийн үр нөлөөг үнэлж, холбогдох зөвлөмжийг гаргасан болно.

Энэ хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал” (цаашид “аргачлал” гэх)-ын дагуу Асрах үйлчилгээний тухай (анхдагч) хуулийн төсөл (цаашид “хуулийн төсөл” гэх)-д үнэлгээ хийж, хуулийн төслийг боловсронгуй болгох санал боловсруулахад энэхүү ажлын зорилго оршино.

Түүнчлэн хуулийг хэрэглэхэд ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулахад хууль санаачлагчид дэмжлэг үзүүлж, хуулийн төслийн чанарыг сайжруулахад чиглэсэн зөвлөмж боловсруулахыг зорилоо.

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх ажиллагааг аргачлалд заасны дагуу дараах үе шаттайгаар хийлээ. Үүнд:

1. шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох;
3. урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
4. үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх зэрэг хамаарна.

Нэг. Шалгуур үзүүлэлтийг сонгосон байдал

Хуулийн төслийн үр нөлөөний судалгааг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан, аргачлалд дурдсан 6 шалгуураас 5 шалгуур үзүүлэлтийг сонгож төслийн үр нөлөөг үнэллээ. Үүнд:

1. зорилгод хүрэх байдал
2. практикт хэрэгжих байдал
3. ойлгомжтой байдал
4. хүлээн зөвшөөрөгдөх байдал
5. харилцан уялдаа зэрэг болно.

Эдгээр шалгуур үзүүлэлтийг сонгохдоо дараах үндэслэлийг харгалзан үзсэн. Үүнд:

1. Хуулийн төсөл нь арван бүлэг, 30 зүйлтэй бөгөөд *нэгдүгээр бүлэгт* нийтлэг үндэслэл, *хоёрдугаар бүлэгт* асрах үйлчилгээний төрөл, ангилал, хэлбэр, *гуравдугаар бүлэгт* асрах үйлчилгээнд тавигдах шаардлага, *дөрөвдүгээр бүлэгт* асруулагчийн эрх, үүрэг, *тавдугаар бүлэгт* асрах үйлчилгээ үзүүлэгчийн эрх, үүрэг, *зургадугаар бүлэгт* асрах үйлчилгээний төв байгуулах нөхцөл, шаардлага, удирдлага зохион байгуулалт, *долдугаар бүлэгт* асрах үйлчилгээний талаар төрөөс баримтлах бодлого, *наймдугаар бүлэгт* санхүүжилт, төлбөрийн тогтолцоо *есдүгээр бүлэгт* хяналт, хариуцлага маргаан шийдвэрлэх, *аравдугаар бүлэгт* бусад зүйл гэсэн харилцааг агуулгын хувьд зохицуулах зэрэг нь практикт хэрэгжих эсэх;

2. Хуулийн төсөлд тусгагдсан зохицуулалтуудыг хэрэглэх, хэрэгжүүлэх субъектүүдийн хувьд хуулийн төсөлд ойлгомжтой, логик уялдаатай боловсруулагдсан эсэх;

3. Хуулийн төслийн зүйл, заалт нь өөр хоорондоо болон бусад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжтой нийцсэн эсэх, мөн төрийн байгууллагын чиг үүрэгтэй давхардсан, зөрчилдсөн эсэх, зорилгодоо хүрэх, хүлээн зөвшөөрөгдөх байдал зэргийг тус тусад нь шалгана.

Хоёр. Хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал

Энэхүү хэсэгт уг хуулийн төслөөс үр нөлөөг нь үнэлэх хэсгээ тогтоож, шалгуур үзүүлэлтийн хүрээнд холбогдох хэсгийг сонгов. Эдгээр хэсгийг сонгохдоо хууль зүйн хувьд шууд үр дагавар үүсгэж байгаа ач холбогдол бүхий байдлаар нь сонгож авсан. Өөрөөр хэлбэл тус хуулийн төслийн үр нөлөөг

үнэлэхдээ цаг хугацаа, зардал хэмнэх үүднээс хуулийн төслөөс шинэлэг зохицуулалт бий болгож буй, эсхүл голлох ач холбогдол бүхий хэсгийг сонгож, тухайн сонгосон хэсгийн үр нөлөөг судаллаа.

Ингээд сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдлыг шалгуур үзүүлэлт тус бүрийн дагуу авч үзлээ.

2.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал¹:

Зорилгод хүрэх байдал гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн нэгдүгээр бүлгийг нь үнэлэв. /Хуулийн төслийн нэгдүгээр бүлэг, 5 зүйлтэй./

2.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал²:

Практикт хэрэгжих байдал гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн 8, 10 дугаар зүйлийг үнэлэв.

2.3. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал³:

Уг хуулийн төсөлд бүхэлд нь дүн шинжилгээ хийж, үр нөлөөг тооцов. /Хуулийн төсөл 10 бүлэг, 30 зүйлтэй./

2.4. “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал⁴:

Уг хуулийн төсөлд бүхэлд нь дүн шинжилгээ хийж, үр нөлөөг тооцов. /Хуулийн төсөл 10 бүлэг, 30 зүйлтэй./

¹ “Зорилгод хүрэх байдал” нь тухайн хуулийн төслөөр тавьж байгаа зорилгодоо хүрч чадах эсэхийг тооцон судалдаг шалгуур үзүүлэлт юм. Хуулийн төсөлд тусгагдсан зохицуулалт, арга хэмжээнүүд нь хуулийн төслөөр тавьсан зорилгод хүрэх боломжтой эсэхийг үнэлэхэд ашиглана.

² “Практикт хэрэгжих боломж” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн хуулийн төслийн зохицуулалтыг дагаж мөрдөх буюу хэрэгжүүлэх боломжтой эсэхийг, тухайлбал, хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээд байгаа эсэх, тэдгээр этгээдэд тухайн хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж, бололцоо (санхүү, хүний нөөц зэрэг) байгаа эсэхийг шалгаж тооцно.

³ “Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалт түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх субъектүүдийн хувьд ойлгомжтой, логик дараалалтайгаар боловсруулагдсан эсэхийг шалгана.

⁴ “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн хуулийн төслийн зохицуулалт иргэд, байгууллагад хэрхэн нөлөөлөх, түүнийг эдгээр этгээдүүд (хуулийн төсөл шууд нөлөөлөх иргэн, хуулийн этгээд) хүлээн зөвшөөрөх эсэхийг шалгана. Өөрөөр хэлбэл, тухайн зохицуулалтаар иргэдийн эрх чөлөөг хязгаарлаж байгаа эсэх, аж ахуйн нэгжүүдэд шинээр үүрэг хүлээлгэсэн эсэх, эсхүл тухайн хуулийн төслийг хэрэгжүүлэх байгууллагын үйл ажиллагаанд нийцэх эсэхийг шалгана.

2.5. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал⁵:

Уг хуулийн төсөлд бүхэлд нь дүн шинжилгээ хийж, үр нөлөөг тооцов.
/Хуулийн төсөл 10 бүлэг, 30 зүйлтэй./

⁵ “Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн хуулийн төслийн зүйл, заалт өөр хоорондоо болон хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хууль тогтоомжтой нийцсэн эсэх, мөн төрийн байгууллагын чиг үүрэгтэй давхардсан, зөрчилдсөн эсэх, тухайн чиг үүргийг төрийн байгууллага зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай эсэх, уг чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх боломжтой эсэхийг шалгана.

Гурав. Шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэлсэн байдал

Өмнөх үе шатуудад хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоосон тул тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараах байдлаар харуулав:

№	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах хэрэгсэл
1.	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн нэгдүгээр бүлгийг үнэлнэ.	Зорилгод дүн шинжилгээ хийсэн.
	Практикт хэрэгжих боломж	Хуулийн төслийн хуулийн төслийн 8, 10 дугаар зүйлийг үнэлнэ.	Хуулийн төсөлд тусгасан зохицуулалт практикт хэрэгжих боломжтой эсэхийг хууль тогтоомжид заасан эрх зүйн зохицуулалтын хүрээнд үнэлсэн.
3.	Ойлгомжтой байдал	Хуулийн төслийг бүхэлд нь үнэлнэ.	Ойлгомжтой байдлыг судлах, ингэхдээ Хууль тогтоомжийн тухай хууль болон аргачлалд заасан асуулгаар хуулийн төслийг шалгасан.
4.	Хүлээн зөвшөөрөгдөх байдал	Хуулийн төслийг бүхэлд нь үнэлнэ.	Хуулийн төслийн зохицуулалтаар иргэдийн эрх чөлөөг хязгаарлаж байгаа болон аж ахуйн нэгжүүдэд шинээр үүрэг хүлээлгэсэн эсэх гэсэн асуулгаар шалгасан.
5.	Харилцан уялдаа	Хуулийн төслийг бүхэлд нь үнэлнэ.	Хуулийн төслийн уялдаа холбоог Хууль тогтоомжийн тухай хууль болон аргачлалд заасан асуулгуудаар шалгасан.

Дээрх урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирсон шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг дараах байдлаар үнэллээ:

3.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь асрах үйлчилгээний төрөл, хэлбэр, шаардлага, үйлчилгээ үзүүлэгч болон үйлчилгээ авах иргэний эрх, үүрэг, талуудын хамтын ажиллагаа, санхүүжилт, төрөөс үзүүлэх дэмжлэг, зохицуулалт, хяналттай холбогдсон харилцааг зохицуулахад оршино

Олон улсын туршлагаас харахад асрах үйлчилгээний эрх зүйн зохицуулалт нь ихэвчлэн урт хугацааны асаргааны тогтолцоог бий болгох, үйлчилгээний төрөл, стандарт тогтоох, асаргааны хэрэгцээг үнэлэх, санхүүжилтийн тогтолцоо зэргийг тодорхойлох гэсэн үндсэн зорилгыг агуулдаг. Ийм зохицуулалт нь асаргаа шаардлагатай иргэдийн амьдралын чанарыг хамгаалах, гэр бүлийн асаргааны ачааллыг бууруулах, үйлчилгээний чанарыг баталгаажуулахад чиглэдэг байна.⁶

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)-ын судалгаагаар урт хугацааны асаргааны бодлого нь хүн амын насжилт нэмэгдэж буй орнуудад нийгмийн хамгааллын тогтолцооны чухал бүрэлдэхүүн хэсэг болж байгаа бөгөөд ихэнх улс орон асрах үйлчилгээний эрх зүйн зохицуулалтыг тусгай хууль, бодлогын хүрээнд хэрэгжүүлж байна⁷. Тухайлбал ХБНГУ, Япон, Бүгд Найрамдах Солонгос Улс зэрэг орнууд урт хугацааны асаргааны даатгалын тогтолцоог хуульчилж, асаргаа шаардлагатай иргэдэд үзүүлэх үйлчилгээний зохион байгуулалт, санхүүжилт, хяналтын механизмыг нарийвчлан зохицуулсан байдаг.⁸

Европын Холбооны улс орнуудын туршлагаас харахад урт хугацааны асаргаа нь ихэвчлэн нийгмийн хамгааллын тогтолцооны нэг хэсэг бөгөөд асаргаа шаардлагатай иргэдийн өдөр тутмын амьдралын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, тэдний нэр төртэй, бие даасан амьдрах боломжийг хадгалах зорилготой үйлчилгээний цогц хэлбэр гэж үздэг. Ийм тогтолцоонд асрах үйлчилгээний төрөл, үйлчилгээний стандарт, үйлчилгээ үзүүлэгчийн зөвшөөрөл, чанарын хяналт, санхүүжилтийн механизмыг хууль тогтоомжоор тодорхой зохицуулсан байна.⁹

Уг хуулийн төслийн зорилт нь дараах гол асуудлыг зохицуулахад чиглэгдсэн байна. Үүнд:

⁶ Lee, S. H. (2023). *Comparative Analysis of Long-Term Care in OECD Countries*. <https://pmc.ncbi.nlm.nih.gov/articles/PMC9858923/> (сүүлд 2026.03.05-нд хандсан)

⁷ OECD. (2025). *Health at a Glance 2025: OECD Indicators*. OECD Publishing, Paris. https://www.oecd.org/en/publications/health-at-a-glance-2025_8f9e3f98-en/full-report.html (сүүлд 2026.03.06-нд хандсан)

⁸ Ibid

⁹ European Commission. (2024). *Long-term care – Social protection and social inclusion*. European Commission. https://employment-social-affairs.ec.europa.eu/policies-and-activities/social-protection-social-inclusion/social-protection/long-term-care_en (сүүлд 2026.03.06-нд хандсан)

(1) асрах үйлчилгээний төрөл, хэлбэр, шаардлага;

(2) үйлчилгээ үзүүлэгч болон үйлчилгээ авагчийн эрх, үүрэг, хариуцлага;

(3) санхүүжилт, төрөөс үзүүлэх дэмжлэг;

(4) хяналт тавих зэрэг харилцааг зохицуулахаар тусгасан байна. Өөрөөр хэлбэл энэ хууль нь асрах үйлчилгээний тогтолцоог бүхэлд нь зохицуулах суурь хууль байх зорилготой байна.

Хуулийн төслийн зорилт нь ямар харилцааг, ямар ерөнхий зорилгоор, ямар хүрээнд зохицуулахыг илэрхийлдэг.

Хуулийн төслийн зорилтын заалт нь хуулиар зохицуулах асуудлуудыг жагсаасан бөгөөд асрах үйлчилгээний тогтолцоог бүрдүүлэх, асаргаа шаардлагатай иргэний эрх, хэрэгцээг хангах зэрэг бодлогын үндсэн зорилгыг илэрхийлэх чиглэлээр цаашид боловсронгуй болгох шаардлагатай байна. Иймд зорилтыг зохицуулах асуудлын жагсаалт хэлбэрээс татгалзаж, хуулийн нийгмийн зорилго, үр дүнг илэрхийлсэн байдлаар томьёолох нь хууль зүйн техникийн шаардлагад илүү нийцнэ гэж үзэж байна.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Асрах үйлчилгээний тухай хуулийн үйлчлэл нь өдөр тутмын ахуйн асаргаа, сэргээн засах асаргаа, хувилбарт асрах үйлчилгээ болон нийгмийн харилцаанд бие даан оролцоход хүндрэлтэй, бусдын туслалцаа, дэмжлэг шаардлагатай хүнд үзүүлэх асрах үйлчилгээтэй холбогдсон харилцаанд хамаарна.

Хуулийн үйлчлэх хүрээ нь тухайн хууль ямар төрлийн нийгмийн харилцаанд, ямар этгээдэд, ямар нөхцөлд үйлчлэхийг тодорхойлсон зохицуулалт бөгөөд эрх зүйн тодорхой байдлыг хангах, тухайн хуулийн зохицуулах асуудлын хил хязгаарыг тогтоох үндсэн ач холбогдолтой.¹⁰ Иймд хуулийн үйлчлэх хүрээ нь ихэвчлэн зохицуулах харилцаа, хамаарах субъект, үйл ажиллагааны хүрээ гэсэн үндсэн агуулгыг тодорхойлдог.

Асрах үйлчилгээний тухай хуулийн төслийн 3 дугаар зүйлд хуулийн үйлчлэх хүрээг тодорхойлохдоо асрах үйлчилгээтэй холбоотой харилцаанд хамаарах үйл ажиллагааны төрөл болон үйлчилгээ авах боломжтой иргэдийн хүрээг тодорхойлсон байна. *Тухайлбал*, асрах үйлчилгээний хүрээнд өдөр тутмын ахуйн асаргаа, сэргээн засах асаргаа, хувилбарт асрах үйлчилгээ болон нийгмийн харилцаанд бие даан оролцоход хүндрэлтэй, бусдын туслалцаа, дэмжлэг шаардлагатай хүнд үзүүлэх үйлчилгээ зэрэг үйл ажиллагаанд хамаарах зохицуулалтыг тусгасан бөгөөд асрах үйлчилгээнд хамрагдах боломжтой иргэдийн ангиллыг мөн тодорхойлсон байна. Ийм зохицуулалт нь тухайн

¹⁰ Хууль тогтоомжийн тухай хуулийн 14.2.2 дахь заалт.

хуулийн үйлчлэлд хамрагдах үндсэн харилцаа болон үйлчилгээ авах субъектын хүрээг тодорхойлох зорилготой гэж үзэж болно.

Онолын үүднээс авч үзвэл хуулийн үйлчлэх хүрээ нь ихэвчлэн тухайн хууль ямар төрлийн харилцаанд үйлчлэхийг товч тодорхой илэрхийлэх шинжтэй байдаг бөгөөд үйлчилгээний төрөл, хэлбэрийг нарийвчлан жагсаах нь хуулийн бусад зүйлд зохицуулах агуулгатай давхцах боломжтой байдаг. Тиймээс үйлчлэх хүрээний зохицуулалтад харилцааны ерөнхий хүрээг тодорхойлох байдлаар тусгах нь хууль зүйн техникийн хувьд илүү оновчтой гэж үздэг.

Иймд Асрах үйлчилгээний тухай хуулийн төслийн 3 дугаар зүйлд заасан зохицуулалт нь асрах үйлчилгээтэй холбоотой харилцаа болон үйлчилгээ авах боломжтой иргэдийн хүрээг тодорхойлсон талаараа хуулийн үйлчлэх хүрээний үндсэн шаардлагад нийцэж байна. Харин үйлчилгээний төрөл, хэлбэрийг нарийвчлан жагсаасан нь зохицуулалтын логикийг тодорхой хэмжээнд давхцуулсан шинжтэй байна. Иймд үйлчлэх хүрээний зохицуулалтыг илүү ерөнхий байдлаар томъёолох нь хуулийн бүтэц, логик дарааллыг илүү тодорхой болгох ач холбогдолтой юм.

4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

Хууль тогтоомж нь нийгмийн харилцааг зохицуулах үндсэн эрх зүйн баримт бичиг тул түүний хэл зүй, найруулга нь ойлгомжтой, хоёрдмол утгагүй, логик дараалалтай байх шаардлагатай. Хуулийн төслийн найруулга нь эрх зүйн зохицуулалтын агуулгыг тодорхой илэрхийлэх, хууль хэрэглэх явцад маргаан, зөрүүтэй тайлбар гарахаас урьдчилан сэргийлэх чухал ач холбогдолтой. Иймээс хуулийн төслийг боловсруулахдаа хууль зүйн техникийн нийтлэг шаардлага, Монгол хэлний зөв бичих дүрэм, найруулгын хэм хэмжээг баримтлан боловсруулах нь зүйтэй.

Монгол Улсын “Хууль тогтоомжийн тухай хууль”-д хууль тогтоомжийг боловсруулахдаа хэл зүй, найруулгын хувьд тодорхой, ойлгомжтой, товч бөгөөд нэг утгатай байх зарчмыг баримтлахыг шаардсан байдаг. Үүнтэй уялдуулан хуулийн төслийн найруулга нь давхардалгүй, логик дараалалтай, нэг ойлголтыг нэг нэр томъёогоор илэрхийлсэн, хэрэглэхэд хялбар байх шаардлагатай. Мөн хуулийн заалтыг ойлгомжтой, хэрэгжүүлэхэд хүндрэл учруулахгүй байдлаар томъёолох нь эрх зүйн зохицуулалтын үр нөлөөг нэмэгдүүлэх ач холбогдолтой.

Иймд хуулийн төслийн хэл зүй, найруулгын шаардлагыг хангах нь хууль тогтоомжийн чанарыг сайжруулах, хууль хэрэгжих явцад эрх зүйн тодорхой байдлыг хангах, хууль хэрэглэх практикт үүсэх маргаан, зөрүүтэй тайлбарыг бууруулахад чухал ач холбогдолтой юм.

Асрах үйлчилгээний тухай хуулийн төслийг хэл зүй, найруулгын үүднээс шинжилж үзэхэд ноцтой алдаа байхгүй байна.

5 дугаар зүйл. Асрах үйлчилгээнд баримтлах зарчим

5.1. Асрах үйлчилгээнд дараах зарчмыг баримтална:

5.1.1. Асруулагчийн амь нас, аюулгүй байдлыг хангах, нэр, нэр төр, эрх, эрх чөлөөг хүндэтгэх;

5.1.2. Асруулагчийн хувийн мэдээлэл, нууцлалыг хамгаалах, ялгаварлан гадуурхахгүй, тэгш хүртээмжтэй байх;

5.1.3. Асруулагчийн хүсэл, сонголт, оролцоог хүндэтгэх;

5.1.4. Асрах үйлчилгээг шуурхай, хүртээмжтэй, тасралтгүй хүргэх;

5.1.5. Асрах үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангах;

5.1.6. Асрах үйлчилгээний ил тод, хариуцлагатай байдлыг хангах;

5.1.7. Асрах үйлчилгээг алслагдсан болон нийгмийн дэмжлэг шаардлагатай бүсэд шуурхай, хүртээмжтэй хүргэх;

5.1.8. Асрах үйлчилгээний салбарт хувийн хэвшлийн оролцоог дэмжих;

5.1.9. Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлж, түүнээс ангид байх.

Монгол Улсын Үндсэн хуулийн нэгдүгээр зүйлийн 2-т Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн гэж заасан байдаг. Энэхүү тодорхойлсон нь төрийн аливаа эрх мэдэл эдгээр зарчимд тулгуурлана, бас эдгээр зарчмаар хязгаарлагдана гэдгийг тунхаглаж, хүний эрх, эрх чөлөөг төрийн эрх мэдлийн элдэв дур зоргоос хамгаалсан хэрэг гэж ойлгогдоно.¹¹

Үйл ажиллагааны зарчим нь тухайн хууль хэрэгжих, тайлбарлагдах, мөрдөгдөх явцад баримтлах суурь үзэл баримтлал, чиг баримжаа, үнэт зүйлсийг ойлгодог. Өөрөөр хэлбэл, хууль хэрхэн “ажиллах”, төр болон бусад этгээд хэрхэн үйл ажиллагаа явуулах ёстойг тодорхойлдог удирдах зарчим юм. Хууль зүйн техникээр зарчим нь нийтэд мөрдөгдөх суурь чиг баримжаа, хууль хэрэгжүүлэхэд баримтлах ерөнхий шаардлага, бусад заалтыг тайлбарлахад ашиглах хэм хэмжээг ойлгодог.

¹¹ Н.Лүндэндорж. Монгол Улсын Үндсэн хууль шинжлэх ухааны тайлбар. (УБ., 2024), 2 дахь хэвлэл.

Асрах үйлчилгээний тухай хуулийн төслийн 5 дугаар зүйлд асрах үйлчилгээнд баримтлах зарчмыг тодорхойлсон боловч зарим заалт нь зарчмын шинжтэй бус, бодлогын арга хэмжээ болон зохион байгуулалтын зохицуулалт агуулсан байна. *Тухайлбал,*

Хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.1.1, 5.1.2, 5.1.3, 5.1.5, 5.1.6, 5.1.9-д заасан агуулга нь зарчмын шинжийг агуулж байна. Харин 5.1.3-д заасан “хөдөлгөөнт үйлчилгээ болон түр байранд...” гэдэг хэсэг нь зарчим биш хэрэгжилтийн зохицуулалт тул найруулга байдлаар засах.

Хуулийн төслийн 5.1.4 “Асрах үйлчилгээг шуурхай, хүртээмжтэй, тасралтгүй хүргэх;” гэснийг “хүртээмжтэй байх” нь зарчим мөн. Харин шуурхай, тасралтгүй гэсэн нь үйлчилгээний чанарын шалгуур, стандартын шинжтэй. Иймд “Асрах үйлчилгээний хүртээмжийг хангах” гэж товчлох нь зарчмын шинжийг илүү тодорхой болгоно.

Хуулийн төслийн 5.1.7 “Асрах үйлчилгээг алслагдсан болон нийгмийн дэмжлэг шаардлагатай бүсэд шуурхай, хүртээмжтэй хүргэх” гэсэн нь зарчим гэхээсээ илүүтэйгээр бодлогын чиглэл гэж ойлгогдож байна. Иймд төслийн 5.1.7-г хасах саналтай байна.

3.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

Практикт хэрэгжих боломж гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн хуулийн төслийн зохицуулалтыг дагаж мөрдөх буюу хэрэгжүүлэх боломжтой эсэх, хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээд байгаа эсэх, тэдгээр этгээдэд тухайн хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж, бололцоо (санхүү, хүний нөөц зэрэг) байгаа эсэхийг шалгаж тооцлоо. Үүнд:

8 дугаар зүйл. Асрах үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлага

8.1.10. асруулагчийг шаардлагатай тохиолдолд эрүүл мэндийн байгууллагад шуурхай шилжүүлэх зохицуулалттай байх;

Асрах үйлчилгээний байгууллага нь эмнэлгийн байгууллагаас ялгаатай бөгөөд тэдгээрийн үйл ажиллагааны үндсэн чиг үүрэг нь өдөр тутмын асаргаа, дэмжлэг үзүүлэхэд чиглэдэг. Эрүүл мэндийн ноцтой нөхцөл үүссэн тохиолдолд тухайн байгууллага эмнэлгийн байгууллагатай хамтран ажиллах боломжтой боловч өвчтөнийг шууд шилжүүлэх шийдвэр гаргах, тээвэрлэлтийг зохион байгуулах зэрэг асуудал нь зарим тохиолдолд тухайн байгууллагын чадавхаас давсан байж болзошгүй юм.

Учир нь Монгол Улсын нутаг дэвсгэр өргөн уудам, хүн амын нягтрал бага бөгөөд зарим сум, багийн түвшинд эрүүл мэндийн байгууллагын хүртээмж

хязгаарлагдмал байдаг.¹² Орон нутгийн олон суманд зөвхөн сумын эрүүл мэндийн төв ажилладаг бөгөөд нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээ үзүүлэх боломж хязгаарлагдмал байна. Түүнчлэн зарим алслагдсан бүсэд эмнэлгийн байгууллага хүртэл хэдэн арван километрийн зайд байрлах тохиолдол байдаг.

Хуулийн төсөлд “асруулагчийг шаардлагатай тохиолдолд эрүүл мэндийн байгууллагад шуурхай шилжүүлэх зохицуулалттай байх” гэсэн нь хэрэгжилтийн хувьд илүү бодитой бөгөөд хууль зүйн техникийн шаардлагад нийцсэн зохицуулалт болсон байна.

Тухайлбал, нэгт, үйлчилгээ үзүүлэгч байгууллагаас тодорхой үр дүн шаардахын оронд эрүүл мэндийн тусламж шаардлагатай нөхцөл үүссэн үед авах арга хэмжээ, дотоод зохион байгуулалт, хамтын ажиллагааны механизмыг бүрдүүлэх үүргийг онцолсон байна.

Хоёрт, “шуурхай” гэсэн ойлголт нь нөхцөл байдалд нийцүүлэн боломжит богино хугацаанд арга хэмжээ авахыг илэрхийлдэг тул үйлчилгээ үзүүлэгч байгууллагын бодит боломж, орон нутгийн нөхцөл байдалтай нийцэх боломжтой байна. Гуравдугаарт, “зохицуулалттай байх” гэж томъёолсноор үйлчилгээ үзүүлэгч байгууллага нь эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажиллах журам, холбоо барих тогтолцоо, шилжүүлэн хүргэх үйл ажиллагааны дотоод зохицуулалтыг урьдчилан бүрдүүлэх шаардлагатай болох бөгөөд энэ нь асруулагчийн аюулгүй байдлыг хангахад чиглэсэн урьдчилан сэргийлэх ач холбогдолтой юм.

10.2. Асруулагч, түүний хууль ёсны төлөөлөгч нь асрах үйлчилгээ авахдаа дараах үүрэг хүлээнэ:

10.2.1. Эрүүл мэндийн байдал, эмийн хэрэглээ, харшил, өвчний түүх, халдварт шинж тэмдэг, эмчилгээний зааврын талаарх мэдээллийг үнэн зөв, бүрэн мэдүүлэх.

Тус заалтад асруулагч болон түүний төлөөлөгч эрүүл мэндийн байдал, эмийн хэрэглээ, өвчний түүхийн талаар үнэн зөв мэдээлэл өгөх үүрэгтэй гэж заасан байна. Гэвч асрах үйлчилгээний гол хэрэглэгчид болох өндөр настан, танин мэдэхүйн хомсдолтой, сэтгэцийн өвчтэй хүмүүсийн хувьд өөрийн эрүүл мэндийн байдлын талаар үнэн зөв мэдээлэл өгөх боломж хязгаарлагдмал байж болзошгүй юм. Иймд энэ үүргийг асруулагчийн хууль ёсны төлөөлөгч, гэр бүлийн гишүүдэд илүү тодорхой байдлаар хуваарилах нь зүйтэй байна.

¹² Б.Цэцэгсайхан. Эрүүл мэндийн салбарын хөгжил, байршлын судалгаа. (УБ., 2018), 7 дахь тал.

3.3. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

Асрах үйлчилгээний тухай хуулийн төсөлд тусгасан зохицуулалтууд нь түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдүүдэд ойлгомжтой, логик дараалалтай байна гэж үзлээ. Харин зарим заалтад хэт урт өгүүлбэр, ойлголтын давхардал, тодорхой бус нэр томьёо, хэмжих боломжгүй шаардлага зэрэг ойлгомжтой байдлыг бууруулж болзошгүй асуудал ажиглагдаж байна. Доорх агуулгын хүрээнд зохих өөрчлөлтийг хийхийг зөвлөж байна. Үүнд:

1.Хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “...болон бусад шалтгааны улмаас” гэсний “бусад шалтгаан” нь хязгааргүй өргөн хүрээтэй ойлголт. Хуулийн хэрэглээний хүрээ хэт тэлэх эрсдэлтэй байгааг анхаарах.

6.3-т “...амьдралын чанарыг дээшлүүлэх” гэдэг нь үнэлгээний шалгуургүй ерөнхий ойлголт байгааг анхаарах. 8.1.5-д “орчны тохируулгатай байх” нь ямар орчны тохируулгыг хэлж байгаа нь тодорхойгүй байгаа тул үүнийг анхаарах. 9.2.5-д “...идэвхтэй насжилтыг дэмжих хөтөлбөртэй байх” гэсэн бөгөөд ямар хөтөлбөрийг “идэвхтэй насжилт” гэж үзэх нь тодорхойгүй байгааг анхаарах. 11.2.11-т “шударга ёс, хүмүүнлэг зарчимд нийцүүлэн, өрсөлдөөнд суурилсан зах зээлийн бодит үнэд үндэслэн” гэсэн бөгөөд шардрга ёсны үнэ?, хүмүүнлэг үнэ? зах зээлийн бодит үнэ гэж юу вэ? гэдэг нь тодорхойгүй байгааг найруулгын хувьд анхаарах шаардлагатай байна.

3.4. “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

Энэхүү хуулийн төслийн зохицуулалт иргэн, хуулийн этгээдэд хэрхэн нөлөөлөх, тухайн зохицуулалтаар иргэдийн эрх чөлөөг хязгаарлаж байгаа эсэх, хуулийн этгээдэд шинээр үүрэг хүлээлгэсэн эсэх гэсэн шалгуур үзүүлэлтээр шалгах нь зүйтэй гэж үзлээ.

Асрах үйлчилгээний тухай хуулийн төсөл нь өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн, архаг өвчтэй иргэдэд үзүүлэх асрах үйлчилгээний тогтолцоог бүрдүүлэх зорилготой бөгөөд нийгмийн хамгааллын тогтолцоог өргөжүүлэх, асаргаа шаардлагатай иргэдийн амьдралын чанарыг сайжруулах бодлогын ач холбогдолтой зохицуулалт юм. Хуулийн төсөлд асрах үйлчилгээний төрөл, ангилал, үйлчилгээний стандарт, үйлчилгээ үзүүлэгчийн эрх, үүрэг, санхүүжилтийн механизм, төрийн дэмжлэг зэрэг асуудлыг цогцоор нь зохицуулахыг зорьсон байна.

Хуулийн төсөл нь нийгмийн бодлогын хэрэгцээ шаардлагад нийцсэн бөгөөд нийгмийн халамж, эрүүл мэнд, ахмад настны бодлого зэрэг салбарын бодлоготой уялдах боломжтой тул зарчмын хувьд хүлээн зөвшөөрөгдөх боломжтой гэж үзэж байна.

1.Иргэдийн зүгээс хүлээн зөвшөөрөгдөх байдал: Асрах үйлчилгээний тухай хуулийн төсөл нь асаргаа шаардлагатай иргэдэд үзүүлэх үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, асрах үйлчилгээний чанарыг сайжруулах, асруулагчийн эрхийг хамгаалах зэрэг зорилготой тул иргэдийн зүгээс эерэгээр хүлээн авах боломжтой байна. Ялангуяа дараах зохицуулалтууд нь иргэдийн эрх ашигт нийцэж байна. Үүнд:

-асруулагчийн эрхийг тодорхойлсон зохицуулалт;

-асрах үйлчилгээний төрөл, хэлбэрийг нэмэгдүүлэх;

-төрөөс үйлчилгээ худалдан авах боломж;

-төлбөрийн чадваргүй иргэдэд төрөөс дэмжлэг үзүүлэх боломжтой зэрэг эдгээр зохицуулалт нь асрах үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, гэр бүлийн асаргааны ачааллыг бууруулахад эерэг нөлөө үзүүлэх боломжтой.

Мөн асрах үйлчилгээний тогтолцоо хөгжсөнөөр нийгмийн халамж, эрүүл мэндийн үйлчилгээний уялдаа сайжирч, шинэ ажлын байр бий болох, үйлчилгээний шинэ зах зээлд иргэн оролцох боломжийг бүрдүүлэхээр байна.

2.Үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын зүгээс хүлээн зөвшөөрөгдөх байдал: Хуулийн төсөл нь асрах үйлчилгээний салбарт төр, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн оролцоог дэмжих зохицуулалтыг тусгасан байна. Үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын хувьд дараах зохицуулалтууд нь эерэг нөлөөтэй гэж үзэж болно. Үүнд:

-төрөөс үйлчилгээ худалдан авах боломж;

-татвар болон санхүүгийн дэмжлэг;

-дэд бүтэц, хөрөнгө оруулалтын дэмжлэг зэрэг эдгээр зохицуулалт нь асрах үйлчилгээний салбарт хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх боломжтой.

Гэвч үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудад тавигдах зарим шаардлага нь практикт хэрэгжихэд хүндрэлтэй байж болзошгүй байна. Тухайлбал, үйлчилгээний стандартын өндөр шаардлага, мэргэжлийн хүний нөөцийн хүрэлцээ, үйлчилгээний баримтжуулалт, хяналтын шаардлага зэргийг хэрэгжүүлэхэд санхүүгийн болон хүний нөөцийн нэмэлт зардал гарах магадлалтай тул үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын хувьд тодорхой болгоомжлол үүсэж болзошгүй юм.

3.Төрийн байгууллагын зүгээс хүлээн зөвшөөрөгдөх байдал: Хуулийн төсөлд төрийн байгууллагын чиг үүргийг тодорхойлсон бөгөөд бодлого боловсруулах, үйлчилгээний стандарт тогтоох, хяналт тавих, төрөөс үйлчилгээ худалдан авах зэрэг үүргийг төр хэрэгжүүлэхээр тусгасан байна. Энэхүү

зохицуулалт нь асрах үйлчилгээний салбарын бодлого, зохицуулалтыг сайжруулахад эерэг нөлөө үзүүлэх боломжтой.

Гэвч төрийн байгууллагуудын хувьд асрах үйлчилгээний хяналтын тогтолцоог бий болгох, хүний нөөцийн бүртгэл, хяналт хийх, үйлчилгээ худалдан авах санхүүжилтийг бүрдүүлэх зэрэг хүндрэл үүсэх магадлалтай байна. Иймээс хуулийг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагын институцийн чадавх, санхүүжилтийн боломжийг бодитой үнэлэх шаардлагатай.

4.Санхүүгийн хувьд хүлээн зөвшөөрөгдөх байдал: Хуулийн төсөлд асрах үйлчилгээний санхүүжилтийг улсын болон орон нутгийн төсөв, төрөөс үйлчилгээ худалдан авах санхүүжилт, иргэний төлбөр, даатгал, олон улсын байгууллагын санхүүжилт, хуулиар хориглоогүй бусад санхүүжилт зэрэг олон эх үүсвэрээс бүрдүүлэхээр тусгасан байна.

Энэ нь санхүүжилтийн олон эх үүсвэрийг ашиглах боломжийг бүрдүүлж байгаа боловч асрах үйлчилгээний тогтолцоог шинээр бий болгоход их хэмжээний санхүүжилт шаардлагатай байж болзошгүй. Иймээс хуулийн төсөл нь урт хугацаанд хэрэгжих боломжтой боловч эхний шатанд санхүүгийн тодорхой ачаалал үүсгэх магадлалтай байна.

5.Нийгмийн бодлогын хувьд хүлээн зөвшөөрөгдөх байдал: Асрах үйлчилгээний тухай хуулийн төсөл нь Монгол Улсад хүн амын насжилт нэмэгдэж байгаа нөхцөлд нийгмийн хамгааллын тогтолцоог өргөжүүлэх чухал ач холбогдолтой юм. Энэ хуулийн төсөл батлагдсанаар дараах эерэг үр нөлөө гарах боломжтой. Тухайлбал,

-асрах үйлчилгээний тогтолцоо бүрдэх;

-гэр бүлийн асаргааны ачаалал буурах;

-ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдралын чанар сайжрах;

-асрах үйлчилгээний шинэ салбар хөгжих боломж бүрдэхээр байна.

Иймээс нийгмийн бодлогын хувьд уг хуулийн төсөл нь хүлээн зөвшөөрөгдөх боломжтой гэж үзэж байна.

3.5. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

“Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах” гэсэн шалгах хэрэгслээр хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг судлан, хуулийн төслийн дотоод болон бусад хуультай уялдах уялдаа холбоог сайжруулах юм. Түүнчлэн хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалд заасан дараах асуудлыг тодорхойлох байдлаар хуулийн төслийн харилцан уялдаатай байдлыг үнэллээ.

1.	Хуулийн төслийн зохицуулалт нь тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
2.	Хуулийн төслийн нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
3.	Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
4.	Хуулийн төслийн зүйл заалт нь тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардал, хийдэл үүссэн эсэх	Хуулийн төслийн төслийн энэ зохицуулалт тогтоогдоогүй.
5.	Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх	Хуулийн төслөөр хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан байна.
6.	Хуулийн төсөлд байх шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
7.	Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх	Давхардлыг арилгах талаар хуулийн төсөлд зохицуулсан.
8.	Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр хураамж тогтоосон эсэх	Энэ хуулийн төслөөр татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр хураамж тогтоосон зохицуулалт байхгүй.
9.	Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгаж байгаа эсэх	Энэ хуулийн төсөлд шинээр тусгай зөвшөөрөл бий болгох зохицуулалт тусгагдсан.
10.	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх;	Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц болон бусад хууль тогтоомжтой нийцсэн.
11.	Хуулийн төслийн зүйл, заалт нь жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх	Хуулийн төслөөр хүйсийн ялгавартай байдал бий болгосон зүйл заалт байхгүй.

12.	Шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэгдсэн заалт тусгагдсан эсэх	Хуулийн төслөөр шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн, бий болгосон заалт байхгүй.
13.	Авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэгдсэн заалт тусгагдсан эсэх	Хуулийн төслөөр авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэгдсэн заалт тусгагдсан зүйл, заалт тогтоогдоогүй болно.
14.	Хуулийн төсөлд тусгасан хориглосон зохицуулалтыг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх	Хуулийн төслөөр хориглосон зохицуулалтыг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаарх зохицуулалтыг тусгасан.

Дөрөв. Үр дүнг үнэлж, зөвлөмж өгсөн байдал

4.1. Үнэлэлт, дүгнэлт

“Асрах үйлчилгээний тухай” хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээг Монгол Улсын Хууль тогтоомжийн тухай хууль болон Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ын дагуу хийж гүйцэтгэлээ. Үнэлгээг хийхдээ хуулийн төслийн зорилго, зохицуулах хүрээ, хэрэгжих орчин, зохицуулалтын шинж чанарт үндэслэн дараах таван шалгуур үзүүлэлтээр дүн шинжилгээ хийсэн. Үүнд:

1. зорилгод хүрэх байдал;
2. практикт хэрэгжих боломж;
3. ойлгомжтой байдал;
4. хүлээн зөвшөөрөгдөх байдал;
5. харилцан уялдаа.

Эдгээр шалгуур үзүүлэлтээр хийсэн судалгааны дүнгээс харахад уг хуулийн төсөл нь Монгол Улсад асрах үйлчилгээний тогтолцоог эрх зүйн хувьд бүрдүүлэх, асаргаа шаардлагатай иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад чиглэсэн бодлогын ач холбогдолтой хуулийн төсөл байна гэж үзлээ.

Уг хуулийн төсөл батлагдсанаар асрах үйлчилгээний тогтолцоо бүрдэж, төр, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн хамтын оролцоонд суурилсан үйлчилгээний шинэ салбар хөгжих боломж бүрдэхээр байна.

1.Зорилгод хүрэх байдлын үнэлгээ: Хуулийн төслийн зорилт нь асрах үйлчилгээний тогтолцоог бүрдүүлэх, асаргаа шаардлагатай иргэдэд үзүүлэх үйлчилгээний төрөл, стандарт, зохион байгуулалт, санхүүжилтийн асуудлыг зохицуулахад чиглэсэн байна. Судалгааны дүнгээс харахад энэхүү зорилт нь олон улсын туршлагатай нийцэж байгаа бөгөөд урт хугацааны асаргааны тогтолцоог хөгжүүлэх бодлогын чиг хандлагатай уялдаж байна.

2.Практикт хэрэгжих боломжийн үнэлгээ: Асрах үйлчилгээний тухай хуулийн төслийн практикт хэрэгжих боломжийг үнэлэхэд хуулийн төсөл нь асрах үйлчилгээний байгууллага, үйлчилгээ үзүүлэгч, төрийн байгууллагын эрх, үүргийг харьцангуй тодорхой тогтоосон бөгөөд хэрэгжилтийн үндсэн тогтолцоог бүрдүүлэх боломжтой байна.

Монгол Улсад асрах үйлчилгээний салбар хараахан бүрэн хөгжөөгүй, хүний нөөцийн хүрэлцээ хязгаарлагдмал, орон нутгийн үйлчилгээний дэд бүтэц хангалтгүй байгаа нь хуулийн зарим зохицуулалтыг хэрэгжүүлэхэд хүндрэл учруулах магадлалтай байна.

3.Ойлгомжтой байдлын үнэлгээ: Асрах үйлчилгээний тухай хуулийн төслийн ойлгомжтой байдлыг үнэлэхэд хуулийн бүтэц, бүлэглэлт, зүйл заалтын дараалал нь логик уялдаатай бөгөөд асрах үйлчилгээний төрөл, хэлбэр, үйлчилгээ үзүүлэгч, үйлчилгээ авагчийн эрх, үүрэг, төрийн дэмжлэг, санхүүжилт зэрэг үндсэн асуудлыг үе шаттайгаар зохион байгуулсан байна. Энэ нь хуулийг хэрэглэх, хэрэгжүүлэх субъектүүдэд зохицуулалтын ерөнхий агуулгыг ойлгох боломжтой байна.

Мөн хуулийн төсөлд асрах үйлчилгээтэй холбоотой үндсэн нэр томьёог тусгайлан тодорхойлсон нь эрх зүйн тодорхой байдлыг хангах, хууль хэрэглээний явцад үүсэх зөрүүтэй тайлбарыг бууруулах ач холбогдолтой байна. Зарчим, үйлчилгээний төрөл, үйлчилгээ үзүүлэгч болон үйлчилгээ авагчийн эрх, үүргийг тус тусад нь бүлэглэн зохицуулсан нь хуулийн бүтцийн ойлгомжтой байдлыг нэмэгдүүлжээ.

4.Хүлээн зөвшөөрөгдөх байдлын үнэлгээ: Судалгаанаас үзэхэд уг хуулийн төсөл нь нийгмийн бодлогын хувьд хүлээн зөвшөөрөгдөх боломжтой байна. Учир нь:

- асаргаа шаардлагатай иргэдийн эрхийг хамгаалах;
- асрах үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх;
- гэр бүлийн асаргааны ачааллыг бууруулах;
- асрах үйлчилгээний шинэ салбарыг хөгжүүлэх зэрэг нийгмийн ач холбогдолтой зорилгыг агуулж байна.

Гэвч үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын хувьд стандартын шаардлага, хүний нөөцийн шаардлага, санхүүгийн зардал зэрэг асуудал нь тодорхой хэмжээнд болгоомжлол үүсгэж болзошгүй байгааг анхаарах.

5.Харилцан уялдааны үнэлгээ: Хуулийн төслийн зохицуулалтыг судалж үзэхэд:

- хуулийн зорилт болон зохицуулалтын хооронд ноцтой зөрчил илрээгүй;
- нэр томьёоны тодорхойлолт нь бусад хууль тогтоомжтой зөрчилдөөгүй;
- төрийн байгууллагын чиг үүргийн давхардал тогтоогдоогүй;

- Үндсэн хууль болон олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт илрээгүй байна.

Иймээс хуулийн төслийн зохицуулалт нь нийтлэг байдлаар Монгол Улсын хүчин төгөлдөр хууль тогтоомжтой нийцсэн гэж үзэж болно.

---oOo---

АСРАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ИРҮҮЛСЭН САНАЛЫН НЭГТГЭСЭН ТОВЬЁГ

2026.6.8

№	САНАЛ ГАРГАГЧ	ГАРСАН САНАЛ	САНАЛЫГ ТӨСӨЛД ТУСГАСАН, ЭС ТУСГАСАН БАЙДАЛ
----------	----------------------	---------------------	--

1.	Засгийн газар	1.Хуулийн төслийн үзэл баримтлалд асрах үйлчилгээг нийгмийн халамжийн хавсарга, туслах хэлбэрээс ангид, бие даасан, мэргэжлийн, хүний эрхэд суурилсан үйлчилгээ болгож хөгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх гэж, төслийн 36 дугаар зүйлийн 36.2 дахь хэсэгт “Асрах үйлчилгээний санхүүжилт нь нийгмийн халамжийн тэтгэмжтэй адилтгахгүй бөгөөд үйлчилгээний бодит өртөг, чанарт суурилна.” гэж заасан боловч Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт оруулах төсөлд асрах үйлчилгээг нийгмийн халамжийн төрөлд хамруулахаар, халамжийн сангийн хөрөнгөөс санхүүжүүлэхээр заасан нь төслийн үзэл баримтлалд нийцэхгүй байгааг анхаарах.	1.Хуулийн төслийн үзэл баримтлал болон Засгийн газраас ирүүлсэн саналыг харгалзан хуулийн төслийн 36 дугаар зүйлийн 36.2 дахь хэсгийг өөрчилж, наймдугаар бүлэгт заасан санхүүжилт, төлбөрийн тогтолцооны зохицуулалтыг бүхэлд нь шинэчлэн боловсруулсан. Асрах үйлчилгээ нь нийгмийн халамжийн үйлчилгээний уламжлалт ойлголтоос ангид, бие даасан эрх зүйн зохицуулалттай, үйлчилгээний чанар, стандарт, санхүүжилтийн олон эх үүсвэр бүхий тогтолцоо болон хөгжих үзэл баримтлалтай болно. Иймд асрах үйлчилгээтэй холбоотой харилцааг бие даасан Асрах үйлчилгээний тухай хуулиар зохицуулахаар тусгасан. Харин Нийгмийн халамжийн тухай хуульд асрах үйлчилгээг нийгмийн хамгааллын тогтолцооны нэг бүрэлдэхүүн хэсэг, халамжийн үйлчилгээний төрөл болох бодлогын хүрээнд тусгасан бөгөөд энэ нь асрах үйлчилгээг зөвхөн нийгмийн халамжийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх, эсхүл халамжийн үйлчилгээтэй адилтган зохицуулах агуулгыг агуулаагүй болно. Түүнчлэн хуулийн төсөлд асрах үйлчилгээний санхүүжилтийг үйлчилгээ эрхлэгчийн өөрийн хөрөнгө, төрөөс үйлчилгээ худалдан авах санхүүжилт, үйлчилгээ авагчийн төлбөр, даатгалын санхүүжилт, олон улсын байгууллага, төсөл, хөтөлбөрийн дэмжлэг болон хуульд хориглоогүй бусад эх үүсвэрээс бүрдүүлэхээр зохицуулсан. Иймд асрах үйлчилгээний санхүүжилтийг зөвхөн нийгмийн халамжийн сангийн хөрөнгөөр
----	----------------------	---	---

			хэрэгжүүлэхээр төсөлд тусгаагүй болно. Иймээс хуулийн төсөл нь асрах үйлчилгээг бие даасан эрх зүйн зохицуулалттай үйлчилгээ болгон хөгжүүлэх үзэл баримтлалтай нийцэж байгаа бөгөөд саналд дурдсан зөрчил арилсан гэж үзэж саналыг хүлээн авсан болно.
--	--	--	---

	2.Хуулийн төслийн 8, 10 дугаар бүлэгт асрах үйлчилгээнд төрөөс үзүүлэх дэмжлэг, санхүүжилт, төлбөрийн тогтолцооны талаарх зохицуулалт, төслийн 27.1.1, 27.1.2 дахь заалтад заасан татварын хөнгөлөлт, нийгмийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлт, төслийн 38 дугаар зүйлд тусгасан төр асрах үйлчилгээг худалдан авах талаарх зохицуулалтад хамаарах асуудлыг бүрэн тусгаагүй, төрөөс үзүүлэх дэмжлэгийн төрөл, тэдгээрийн хамрах хүрээ, олгох нөхцөл, шалгуур нь тодорхойгүй байна.	2.Саналыг үндэслэн нийгмийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлтийг хасч, татвартай холбоотой бодлогын дэмжлэгийн зохицуулалтыг дагалдан гарах хуульд оруулах нэмэлтээр тусгасан, хуулийн төслийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төр нь асрах үйлчилгээний төвөөс асрах үйлчилгээ болон сэргээн засах асрах үйлчилгээ худалдан авч болно.” гэж, 21 дүгээр зүйлийн 21.2-д “Энэ хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, энэ зүйлийн 21.1.2, 21.1.3-д заасан хөнгөлөлт, дэмжлэг үзүүлэх нөхцөл, журам, хэмжээг Засгийн газар батална.” гэж тусгав. Хуулийн төсөлтэй холбоотойгоор дагалдан гарах Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, Үндэсний баялагийн сангийн тухай хуульд нэмэлт оруулахаар тусгасан.
	3.Татварын ерөнхий хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтад татвар бий болгох, тогтоох, ногдуулах, тайлагнах, төлөх, хяналт шалгалт хийх, хураах, хөнгөлөх, чөлөөлөх үйл ажиллагаанд шударга байх зарчмыг баримтлахаар заасан. Хуулийн төсөлд тусгасан мэргэжил, орлогын эх үүсвэрээс хамааран татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх зохицуулалт нь дээрх хуулийн шударга байх зарчимд нийцэхгүй тул татварын хөнгөлөлт, чөлөөлөлт” хасах, “ус, дулаан, цахилгаан, хог хаягдлын төлбөрийн хөнгөлөлт” гэснийг “дулаан, цахилгааны төлбөрийн хөнгөлөлт” гэж	3.Татварын ерөнхий хуулийн 5.1.3-т заасан шударга байх зарчим нь бүх татвар төлөгчид ижил нөхцөл, ижил хэмжээний татварын ачаалал ногдуулахыг бус, харин ижил нөхцөлд байгаа этгээдэд ижил, ялгаатай нөхцөлд байгаа этгээдэд тухайн нөхцөл байдалд нь нийцүүлэн ялгаатай зохицуулалт хийх боломжийг хүлээн зөвшөөрдөг зарчим юм. Асрах үйлчилгээ нь ашиг олох үндсэн зорилготой ердийн бизнесийн үйл ажиллагаанаас ялгаатай бөгөөд ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, байнгын асаргаа шаардлагатай иргэдийн эрх, нийгмийн хамгааллыг хангахад чиглэсэн нийгмийн ач холбогдол бүхий үйлчилгээ болно. Иймд энэхүү салбарын хөгжлийг дэмжих, үйлчилгээний

	өөрчлөх	хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор татварын бодлогоор дэмжлэг үзүүлэх нь нийгмийн хамгааллын төрийн бодлоготой нийцэж байна. Түүнчлэн Монгол Улсын хууль тогтоомжид боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал зэрэг нийгмийн ач холбогдол бүхий тодорхой үйл ажиллагаанд татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх зохицуулалт түгээмэл хэрэглэгддэг бөгөөд энэ нь татварын шударга байх зарчмыг зөрчсөн гэж үздэггүй. Хуулийн төсөлд тусгасан татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн зорилго нь тодорхой салбарын үйл ажиллагааг давуу байдалд оруулах бус, харин асрах үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, хувийн хэвшил болон төрийн бус байгууллагын оролцоог дэмжих, иргэдэд үзүүлэх үйлчилгээний өртгийг бууруулахад чиглэж байгаа болно. Иймд уг зохицуулалт нь Татварын ерөнхий хуульд заасан шударга байх зарчимд харшлахгүй бөгөөд нийгмийн хамгааллын бодлогын зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн үндэслэл бүхий татварын дэмжлэг гэж үзэж энэхүү саналыг хүлээн аваагүй болно. Тэгш байдлыг хангах нь бүх салбарт ижил татвар ногдуулахыг бус, харин нийгмийн эмзэг бүлгийн хэрэгцээг хангах зорилгоор ялгаатай нөхцөлд ялгаатай зохицуулалт хийхийг зөвшөөрдөг энэ нь Үндсэн хуулийн хүний эрхийг хангах, эрх тэгш байдлын зарчимд суурилсан болно. Төсөлд тусгасан “ус, дулаан, цахилгаан, хог
--	---------	--

		хявгдлын төлбөрийн хөнгөлөлт” гэснийг “дулаан, цахилгааны төлбөрийн хөнгөлөлт” гэж өөрчлөх саналыг хүлээн авч тусгав.
	4.Хуулийн төсөлд асрах үйлчилгээний зардлыг Нийгмийн халамжийн сангаас санхүүжүүлэхээр тусгасан нь Нийгмийн халамжийн сангийн төсөвт хэт их ачаалал үүсгэх эрсдэлттэй байна. Төрөөс асрах үйлчилгээний зардлыг гаргахаас гадна гэр бүлийн гишүүд, хамаатан садан, хүмүүнлэгийн болон буяны байгууллагаас гаргах боломжийг олгох зохицуулалтыг нэмж тусгах	4.Саналыг хүлээн авч, хуулийн төслийн санхүүжилт, төлбөрийн тогтолцоог бүхэлд нь шинэчлэн боловсруулж, асрах үйлчилгээний санхүүжилтийг зөвхөн Нийгмийн халамжийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр хязгаарлаагүй болно. Тухайлбал, хуулийн төслийн 23 дугаар зүйлд асрах үйлчилгээний санхүүжилтэд төр, төрийн бус байгууллага, хувийн хэвшил болон бусад хуульд заасан этгээд бүрэн буюу хэсэгчлэн оролцож болохоор тусгасан. Мөн 24 дүгээр зүйлд асрах үйлчилгээний санхүүжилтийн эх үүсвэрийг үйлчилгээ үзүүлэгчийн өөрийн хөрөнгө, улсын болон орон нутгийн төсөв, төрөөс үйлчилгээ худалдан авах санхүүжилт, үйлчилгээ авагчийн төлбөр, даатгалын санхүүжилт, олон улсын байгууллага, төсөл хөтөлбөр, хандив болон хуульд хориглоогүй бусад эх үүсвэрээс бүрдүүлэхээр зохицуулсан. Түүнчлэн үйлчилгээ авагч нь үйлчилгээний өртөгт тохирсон төлбөр төлөх, төлбөрийн чадваргүй иргэнд төрөөс үйлчилгээ худалдан авах хэлбэрээр дэмжлэг үзүүлэх, иргэн сайн дурын үндсэн дээр асрах үйлчилгээний даатгалд хамрагдах, Үндэсний баялгийн сангийн хуримтлалын сан дахь өөрийн нэрийн дансны хөрөнгийг асрах үйлчилгээний

		төлбөр, зардалд ашиглах боломжийг тус тус бүрдүүлсэн. Иймд хуулийн төсөлд асрах үйлчилгээний санхүүжилтийг олон эх үүсвэрт тулгуурласан, төр, хувийн хэвшил, иргэн, олон улсын байгууллага болон бусад этгээдийн хамтын оролцоонд суурилсан тогтолцоогоор зохицуулсан бөгөөд Нийгмийн халамжийн сангийн төсөвт хэт их ачаалал үүсгэх эрсдэлийг бууруулах зохицуулалтыг тусгасан гэж үзэж саналыг хүлээн авсан болно.
	5.Хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, 7 дугаар зүйлийн 7.8 дахь хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.1.5 дахь заалт, 32 дугаар зүйлийн 32.1 хэсэг, 46 дугаар зүйлийн 46.2 дахь хэсэгт тус тус дүрэм, журам батлах эрх олгосон зохицуулалтыг хуулийн төсөлд тусгах	5.Саналыг хүлээн авч хуулийн төсөлд тусгасан дүрэм, журмыг Засгийн газар болон холбогдох салбарын сайд дангаар болон хамтран батлан гаргахаар хуулийн төсөлд тусгав.
	6.Хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн 9.3.1 дэх заалтад асрах үйлчилгээ эрхлэхэд “үйл ажиллагааны эхний хугацаанд түр зөвшөөрөлтэй байж болох” гэж , 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсэгт “хувилбарт болон шинээр байгуулагдаж буй төвд 24 сарын хугацаатай түр зөвшөөрөл” олгохоор тусгасан нь Зөвшөөрлийн тухай хуульд заасан зөвшөөрлийн ангилал болон	6.Саналыг хүлээн авсан. Хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн 9.3.1 дэх заалт болон 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсэгт тусгасан түр зөвшөөрөл олгохтой холбоотой зохицуулалтыг дахин хянан үзэж, Зөвшөөрлийн тухай хуульд нийцүүлэн өөрчлөн найруулсан. Зөвшөөрлийн тухай хуульд зөвшөөрлийн төрөл, ангилал, олгох журам, хугацаатай холбоотой харилцааг нэгдсэн байдлаар зохицуулсан бөгөөд салбарын хуулиар зөвшөөрлийн шинэ төрөл, ангилал тогтоох нь хууль тогтоомжийн уялдаа, нэгдмэл байдлыг алдагдуулах

		зөвшөөрлийн хугацаанд тавигдах шаардлагад нийцэхгүй байна.	эрсдэлтэй гэж үзэв. Иймд хуулийн төсөлд тусгасан “түр зөвшөөрөл”, “24 сарын хугацаатай түр зөвшөөрөл” гэсэн зохицуулалтыг хасаж, асрах үйлчилгээ эрхлэх зөвшөөрөлтэй холбоотой харилцааг Зөвшөөрлийн тухай хуульд нийцүүлэн зохицуулахаар өөрчилсөн болно.
		7.Стандартын батлах чиг үүргийг Стандарт, хэмжил зүйн газар хэрэгжүүлдэг тул хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэгт “Үйлчилгээний орчин, хөдөлгөөнт үйлчилгээний стандарт шаардлагыг Засгийн газар батлана” гэснийг хасах	7.Тухайн зохицуулалтыг хуулийн төслөөс хассан.
		8.Бусад санал болон хэл зүй, найруулга, томъёоллын шинжтэй санал	8.Бусад санал болон хэл зүй, найруулга, томъёоллын шинжтэй саналыг бүхэлд нь хүлээн авч хуулийн төсөлд тусгав.
2.	Иргэн Алтанхуяг Отгонболд	Асрах үйлчилгээний санхүүжилтийг асаргааны даатгалаар шийдэх тухай	Хуулийн төсөлд асаргааны даатгалын талаар тусгав.
3.	Иргэн Гэрэлчимэг Чулуунбаатар	Дараахь зүйлийг тусгах саналтай: 1.Асргааны даатгал: асрах үйлчилгээний хөлс, санхүүжилтийн гол үүсвэр байж болох асаргааны даатгал, түүнийг асаргаа, халамжийн зэрэглэл тогтоох, эрүүл мэндийн даатгалтай хэрхэн уяж холбогдох талаар тусгаж өгөх, төр, хувийн оролцоо хягаарыг тодруулах.	Саналыг зарчмын хувьд хүлээн авсан.Хуулийн төсөлд асрах үйлчилгээний даатгалын тогтолцоог тусгаж, иргэн сайн дурын үндсэн дээр асрах үйлчилгээний даатгалд хамрагдах боломжийг бүрдүүлсэн. Гэсэн хэдий ч асрах үйлчилгээний даатгал нь Монгол Улсад шинээр хөгжих харилцаа бөгөөд даатгалын хамрах хүрээ, санхүүжилтийн эх үүсвэр, эрсдэлийн үнэлгээ, асрах үйлчилгээний хэрэгцээ, зэрэглэл тогтоох асуудал нь цаашид

	2.Асаргааны мэргэжилтэн: системтэй бэлдэх - асрах үйлчилгээг үзүүлэх мэргэжил, үндэсний мэргэжилтэнг одоогийн боловсролын (МСҮТ, асаргааны мэргэжлийн индекс сувилахуйн сургууль... зэрэг) бүтэц тогтолцоотой уялдуулж цэгцтэй системтэй бэлдэх талаар тодорхой тусгах. 3.Асаргааны мэргэжлийн ослын даатгал: асаргааны үйлчилгээ үзүүлэгч байгууллага, асрагч сувилагчид мэргэжлийн ослын даатгалд заавал хамруулах талаарх зохицуулалт. Энэ нь шинэ салбарт ажиллагчид болон асруулагч талуудыг эрсдлээс хамгаалах, урт хугацаанд тогтвортой хөгжүүлэх ийм хариуцлагын зохицуулалт чухал шаардлагатай байгаа юм. Дөнгөж бий болж ядаж буй эмзэг салбарын хувьд үүсэхээсээ өмнө дампуурч шүүх дээр очихоос сэргийлэх ач холбогдолтой. Эцэст нь хэлэхэд хуулиа аль болох ойлгомжтой, ухагдхуун ойлголтуудыг товч тодорхой байлгаж, асрах үйлчилгээ үзүүлэгчид, оролцогч талуудыг аль болох цөөн зөвшөөрөл, зардал, чирэгдэл багатай ажиллах орчин бүрдүүлбэл асаргааны салбар өөрөө цэгцрээд явчих боломж найдвар бий.	даатгалын болон нийгмийн хамгааллын бодлоготой уялдуулан үе шаттай хөгжүүлэх шаардлагатай гэж үзэв. Иймд асрах үйлчилгээний даатгалын үндсэн эрх зүйн зохицуулалтыг хуулийн төсөлд тусгаж, нарийвчилсан зохицуулалтыг цаашид холбогдох хууль тогтоомжийн хүрээнд боловсронгуй болгохоор тусгав. Хуулийн төсөлд асрах үйлчилгээний хүний нөөц, сургалттай холбоотой зохицуулалтыг тусгаж, асрах үйлчилгээний ажилтны сургалтын агуулга, хөтөлбөр, үнэлгээний шалгуур, гэрчилгээ олгох журмыг боловсролын болон нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батлахаар тусгасан. Мөн асрах үйлчилгээний хүний нөөцийг үйлчилгээний төрөл, эрсдэлийн түвшин, үйлчилгээ авагчийн хэрэгцээнд нийцүүлэн бэлтгэх эрх зүйн үндсийг бүрдүүлсэн бөгөөд цаашид мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага болон дээд боловсролын тогтолцоотой уялдуулан асрах үйлчилгээний мэргэжилтэн бэлтгэх асуудлыг хөгжүүлэх боломжтой гэж үзэв. Хуулийн төслийн 26.3-т асрах үйлчилгээ үзүүлэгч нь үйлчилгээ үзүүлэх явцад бусдад учруулж болзошгүй хохирол, хариуцлагын эрсдэлийг хамгаалах зорилгоор хариуцлагын даатгалд даатгуулсан байх зохицуулалтыг тусгасан. Энэхүү зохицуулалт нь үйлчилгээ авагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, үйлчилгээ үзүүлэгч байгууллага болон ажилтны эрсдэлийг бууруулах,
--	--	---

			асрах үйлчилгээний салбарын тогтвортой хөгжлийг дэмжих ач холбогдолтой гэж үзэв. Хуулийн төслийг боловсруулахдаа зохицуулалтыг аль болох ойлгомжтой, хэрэгжих боломжтой байхаар боловсруулж, үйлчилгээ үзүүлэгч, үйлчилгээ авагч болон оролцогч талуудад шаардлагагүй хүндрэл, давхардсан зөвшөөрөл, захиргааны ачаалал үүсгэхгүй байх зарчмыг баримталсан болно.
4.	Иргэн Алтантүлхүүр, Хүмүүн капитал байгууллага, Хүний нөөцийн ажилтан	Хуулийн төсөлд хүний нөөцийн ёс зүйн шаардлага, оюун санааны асаргаа, Аугимттай (хөгжлийн бэрхшээлтэй) хүүхдийн асаргаа, хүүхдийн асуудлыг сайтар тусгах, Ахмад настны сэтгэл зүйч, тэтгэврийн өмнөх сэтгэл зүйг бэлдэх	Саналыг хэсэгчлэн хүлээн авсан. Хуулийн төслийг боловсруулах явцад асрах үйлчилгээний хүний нөөцийн мэргэжлийн ур чадвар, үйлчилгээний чанар, үйлчилгээ авагчийн нэр төр, эрх, ашиг сонирхлыг хамгаалах асуудлыг онцгойлон анхаарч тусгасан болно. Хуулийн төсөлд асрах үйлчилгээ үзүүлэгч нь хүний эрхийг дээдлэх, ялгаварлан гадуурхахгүй байх, хүний нэр төрийг хүндэтгэх, үйлчилгээ авагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зарчмыг баримтлахаар тусгасан бөгөөд хүний нөөцийн ёс зүй, мэргэжлийн шаардлагатай холбоотой нарийвчилсан зохицуулалтыг үйлчилгээний стандарт, сургалтын хөтөлбөр, холбогдох журмаар тогтоох боломжтой гэж үзэв. Мөн хуулийн төсөлд асрах үйлчилгээг нас, эрүүл мэндийн байдал, хөгжлийн онцлог, хэрэгцээ шаардлагад нь нийцүүлэн үзүүлэхээр тусгасан бөгөөд хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, байнгын асаргаа шаардлагатай иргэдэд үзүүлэх үйлчилгээг хамруулахаар

			зохицуулсан. Иймд аутизмын хүрээний эмгэгтэй хүүхэд болон бусад хөгжлийн онцлогтой хүүхдэд үзүүлэх асрах үйлчилгээ нь хуулийн үйлчлэлийн хүрээнд хамаарч байгаа болно. Түүнчлэн асрах үйлчилгээ нь зөвхөн бие махбодын тусламж үйлчилгээ бус, сэтгэл зүйн болон нийгмийн дэмжлэгийг хамарсан цогц үйлчилгээ байх зарчмыг хуулийн төсөлд тусгасан. Ахмад настны сэтгэл зүйн хэрэгцээ, ганцаардлаас урьдчилан сэргийлэх, тэтгэвэрт гарах үеийн дасан зохицол, сэтгэл зүйн дэмжлэг зэрэг асуудлыг үйлчилгээний төрөл, стандарт, сургалтын хөтөлбөрөөр нарийвчлан зохицуулах боломжтой гэж үзэв. Иймд саналд дурдсан асуудлуудын үзэл санааг хуулийн төсөлд тусгасан бөгөөд тухайн үйлчилгээний онцлогтой холбоотой нарийвчилсан шаардлагыг стандарт, сургалтын хөтөлбөр, холбогдох журмаар зохицуулахаар тусгав.
5.	Хүлэгчимэг, Батсүмбэрийн асрамжийн газрын нийгмийн ажилтан	Асрах үйлчилгээг зөвхөн зорилтот бүлэгт биш, сонирхсон хэн бүхэнд үйлчилдэг зохицуулалттай болгох, Хүний нөөцийн асуудал, ажиллагсдын нийгмийн асуудал, цалин хөлс, хөдөлмөрлөх эрхийг хамгаалах	Саналыг хүлээн авсан. Хуулийн төслийг боловсруулахдаа асрах үйлчилгээг зөвхөн нийгмийн халамжийн зорилтот бүлэгт хязгаарлах бус, нас, хүйс, нийгмийн байдал, хөгжлийн онцлог үл харгалзан бусдын тусламж, дэмжлэг шаардлагатай болсон иргэн бүрт үйлчилгээ үзүүлэх боломжтой байхаар үзэл баримтлалыг тодорхойлсон. Иймд хуулийн төсөлд асрах үйлчилгээний хамрах хүрээг зөвхөн ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй

		иргэнээр хязгаарлахгүйгээр, бие даан өдөр тутмын амьдралын хэрэгцээгээ хангахад хүндрэлтэй болсон, асрах үйлчилгээ шаардлагатай иргэдэд үйлчилгээ үзүүлэхээр зохицуулсан.
		Харин төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэг, үйлчилгээ худалдан авах болон хөнгөлөлттэй нөхцөлөөр үйлчилгээ үзүүлэх асуудлыг нийгмийн хамгаалал зайлшгүй шаардлагатай зорилтот бүлгийн иргэдэд чиглүүлэхээр зохицуулсан болно.
		Ингэснээр асрах үйлчилгээ нь нэг талаас бүх иргэнд нээлттэй үйлчилгээний тогтолцоо болж хөгжих, нөгөө талаас төрийн дэмжлэг нь хэрэгцээ шаардлага өндөртэй зорилтот бүлэгт чиглэх боломж бүрдэх юм. Асрах үйлчилгээ бол халамж биш, хэрэгцээ үүссэн хүн бүр ашиглаж болох үйлчилгээ юм. Иймд саналыг хүлээн авч, асрах үйлчилгээний хамрах хүрээтэй холбоотой зохицуулалтыг хуулийн төслийн үзэл баримтлалтай нийцүүлэн боловсруулсан болно.
6.	“Ачлал ХХК Номун”	Асрах үйлчилгээний салбарыг ойлгох, нийгмийн сэтгэл зүйг бэлтгэх, өөрчлөх шаардлагатай. Үйлчилгээ авагчдын дийлэнх нь төлбөрийн чадваргүй байдаг. Санхүүжилтийн асуудлыг маш олон арга, хэлбэрээр зохицуулах боломжийг хайж тусгаарай. Цаашид ингэж хөгжүүлвэл, Монгол асаргаа брэнд бий болох боломжтой. Саналыг хүлээн авч, цаашид бодлогын түвшинд анхааран хөгжүүлэх шаардлагатай гэж үзэв. Асрах үйлчилгээ нь зөвхөн нийгмийн халамжийн үйлчилгээ бус, хүн амын насжилт, хөгжлийн бэрхшээл, урт хугацааны асаргаа шаардлагатай иргэдийн хэрэгцээтэй холбоотой нийгэм, эдийн засгийн чухал салбар юм. Иймд асрах үйлчилгээний талаарх олон нийтийн ойлголт, хандлагыг өөрчлөх, үйлчилгээний ач холбогдлыг таниулах, асрахын хөдөлмөрийн үнэ цэнийг нийгэмд зөвөөр ойлгуулах бодлогын арга хэмжээг

		Үе шаттай хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна. Мөн асрах үйлчилгээ шаардлагатай иргэдийн дийлэнх нь төлбөрийн чадвар сул, эсхүл урт хугацаанд өндөр зардалтай үйлчилгээ авах санхүүгийн боломжгүй байдаг тул үйлчилгээний санхүүжилтийг зөвхөн улсын төсөвт тулгуурлах бус олон эх үүсвэрт суурилсан тогтолцоогоор хөгжүүлэх шаардлагатай байна. Энэ хүрээнд хуулийн төсөлд төрөөс үйлчилгээ худалдан авах санхүүжилт, үйлчилгээ авагчийн төлбөр, сайн дурын даатгал, олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрийн санхүүжилт, хандив, хуульд хориглоогүй бусад эх үүсвэрийг тусган олон тулгуурт санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэхээр зохицуулсан болно. Цаашид асрах үйлчилгээний даатгалын тогтолцоо, хуримтлалын механизм, төр-хувийн хэвшлийн түншлэл, нийгмийн хөрөнгө оруулалт, буяны болон хүмүүнлэгийн санхүүжилтийн хэлбэрүүдийг хөгжүүлэх боломжийг бодлогын түвшинд үргэлжлүүлэн судалж боловсронгуй болгох шаардлагатай гэж үзэв. Асрах үйлчилгээний салбар тогтвортой хөгжсөнөөр зөвхөн нийгмийн хамгааллын үйлчилгээ сайжрахаас гадна шинэ ажлын байр бий болох, хүний нөөцийн шинэ мэргэжил төлөвших, үйлчилгээний шинэ зах зээл хөгжих, цаашлаад Монгол Улсын онцлогт тохирсон асрах үйлчилгээний тогтолцоо буюу “Монгол асаргаа”
--	--	---

			хөгжих боломж бүрдэх ач холбогдолтой гэж үзэж байна.
7.	Doula Mongolia Association НҮТББ	Doula (Жирэмсний болон төрөлтийн хамтрагч-асрах үйлчилгээ үзүүлэгч)-г 2019 онд Амгалан амаржих газарт туршилт хийхэд маш сайн үр дүн гарсан. Doula асаргааны үр дүнд кесаров төрөлт 45% багасдаг. Эх барих эмч болон төрсөн эхийн сэтгэл зүй, сэтгэл санаанд маш өндөр тус дэм үзүүлдэг. Энэ бол нийгмийн эрүүл мэндийн асуудалд маш сайн үр дүнтэй (амаржих газрын ажилтнууд, жирэмсэн болон төрсөн эхчүүд, хүүхэд), Doula-г албан ёсоор хуулинд тусгах	Саналыг зарчмын хувьд хүлээн авсан. Жирэмсэн эх, төрөлт болон төрсний дараах үед үзүүлэх сэтгэл зүйн, нийгмийн болон ахуйн дэмжлэг нь эх, хүүхдийн эрүүл мэнд, сайн сайхан байдалд чухал ач холбогдолтой бөгөөд олон улсын хэмжээнд төрөлтийн хамтрагч (Doula) үйлчилгээний үр нөлөөг хүлээн зөвшөөрч байна. Саналд дурдсанчлан төрөлтийн хамтрагч үйлчилгээ нь эхийн сэтгэл зүйн тогтвортой байдлыг дэмжих, төрөлтийн айдас, стрессийг бууруулах, эх барих эмч, эмнэлгийн ажилтны ачааллыг хуваалцах, төрөлтийн зэрэг үр дүнг нэмэгдүүлэхэд ач холбогдолтой болохыг олон улсын судалгаанууд харуулдаг. Хуулийн төсөлд асрах үйлчилгээг зөвхөн ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэнд хязгаарлахгүйгээр тухайн хүний хэрэгцээ, нөхцөл байдалд тохирсон ахуйн, сэтгэл зүйн, нийгмийн болон дэмжих үйлчилгээний хүрээнд зохицуулсан болно. Гэсэн хэдий ч төрөлтийн хамтрагч (Doula) зэрэг үйлчилгээний тодорхой хэлбэрийг хуульд нэг бүрчлэн нэрлэн тусгах нь эрх зүйн зохицуулалтын уян хатан байдлыг хязгаарлах эрсдэлтэй гэж үзэв. Иймд жирэмсэн эх, төрөлт болон төрсний дараах үеийн асрах, дэмжих үйлчилгээний эрх зүйн

			ундсийг хуулийн төсөлд хамруулж, төрөлтийн хамтрагч үйлчилгээний стандарт, сургалт, мэргэшлийн асуудлыг холбогдох журам, стандарт болон эрүүл мэндийн салбарын зохицуулалтаар нарийвчлан зохицуулах боломжтой гэж үзэв. Цаашид эх, хүүхдийн эрүүл мэндийг дэмжих хүрээнд төрөлтийн хамтрагч үйлчилгээний сайн туршлагыг хөгжүүлэх, хэрэгжүүлэх асуудлыг холбогдох бодлого, хөтөлбөрийн хүрээнд судлан хэрэгжүүлэх боломжтой гэж үзэж байна.
--	--	--	---

---OO---

ХҮҮЛЬ ОНГОХЧУМ ӨНӨР

УИХ-ын гишүүн
Доржсүрэн ЗИНГУУЯ

БОЛОВЕРУУЛХ БҮЙ

Батлах

Засгийн хэлэлцүүлэг

Ахлахны хэлэлцүүлэг

Хэлэлцэх эсэх

Өргөн баригдсан

МОНГОЛ УЛСЫН ХҮҮЛЬ

АСРАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХҮҮЛЬ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь асрах үйлчилгээний төрөл, ангилал, хэлбэр, түүний хүрээг хязгаарлах, асрах үйлчилгээнд тавигдах шаардлага, үйлчилгээний чанар, стандарт, үйлчилгээ үзүүлэгчийн эрх, үүрэг, хариуцлага, асуултгүй байдлыг төр, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа оролцох болон үйлчилгээнд тавих хяналт, санхүүжилт, өрөөс үзүүлэх дэмжлэгтэй холбоотой хариуцаж зохих дүрлэхэд оршино.

2 дугаар зүйл. Асрах үйлчилгээний хууль тогтоомж

2.1. Асрах үйлчилгээний тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, Нийтийн халамжийн тухай хууль, Үнэ хууль болон тэд зэрэгт үндэслэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын Олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр зэвсгэн бол олсон улсын гэрээний заалтыг дагаж мөрднө.

3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 ДҮГЭЭР ЗҮЙЛ

2 ДУГААР ЗҮЙЛ

3 ДУГААР ЗҮЙЛ

4 ДҮГЭЭР ЗҮЙЛ

5 ДУГААР ЗҮЙЛ

ХӨӨРДҮГААР БҮЛЭГ

АСРАХ

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ

ТӨРӨЛ, АНГИЛАЛ,

ХЭЛБЭР

6 ДУГААР ЗҮЙЛ

7 ДУГААР ЗҮЙЛ

ГУРАВДУГААР БҮЛЭГ

АСРАХ ҮЙЛЧИЛГЭЭНД

ТАВИГДАХ ШААРДЛАГА

8 ДУГААР ЗҮЙЛ

9 ДҮГЭЭР ЗҮЙЛ

Дөрөвдүгээр бүлэг

АСРАХ ҮЙЛЧИЛГЭЭНД

ХАМРАГДАХ ХҮНИЙ

ЭРХ, ҮҮРЭГ

10 ДУГААР ЗҮЙЛ

ТАВДУГААР БҮЛЭГ

ҮЙЛЧИЛГЭЭ

ХЭҮҮЛЭГНИЙД

ТАВИГДАХ

ШААРДЛАГА, ЭРХ

ҮҮРЭГ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 ДҮГЭЭР ЗҮЙЛ

2 ДУГААР ЗҮЙЛ

3 ДУГААР ЗҮЙЛ

4 ДҮГЭЭР ЗҮЙЛ

5 ДУГААР ЗҮЙЛ

ХОЁРДУГААР БҮЛЭГ
АСРАХ
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ТӨРӨЛ, АНГИЛАЛ,
ХЭЛБЭР

6 ДУГААР ЗҮЙЛ

7 ДУГААР ЗҮЙЛ

ГУРАВДУГААР БҮЛЭГ
АСРАХ ҮЙЛЧИЛГЭЭНД
ТАВИГДАХ ШААРДЛАГА

8 ДУГААР ЗҮЙЛ

9 ДҮГЭЭР ЗҮЙЛ

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ
АСРАХ ҮЙЛЧИЛГЭЭНД
ХАМРАГДАХ ХҮНИЙ
ЭРХ, ҮҮРЭГ

10 ДУГААР ЗҮЙЛ

ТАВДУГААР БҮЛЭГ
ҮЙЛЧИЛГЭЭ
ҮЗҮҮЛЭГЧИД
ТАВИГДАХ
ШААРДЛАГА, ЭРХ,
ҮҮРЭГ

11 ДҮГЭЭР ЗҮЙЛ

12 ДУГААР ЗҮЙЛ

ЗУРГААДУГААР БҮЛЭГ
АСРАХ
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ
БАЙГУУЛАХ НӨХЦӨЛ,
ШААРДЛАГА

13 ДУГААР ЗҮЙЛ

14 ДҮГЭЭР ЗҮЙЛ

15 ДУГААР ЗҮЙЛ

ДОЛДУГААР БҮЛЭГ
АСРАХ
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
УДИРДЛАГА, ЗОХИОН
БАЙГУУЛАЛТ

16 ДУГААР ЗҮЙЛ

17 ДУГААР ЗҮЙЛ

18 ДУГААР ЗҮЙЛ

19 ДҮГЭЭР ЗҮЙЛ

20 ДУГААР ЗҮЙЛ

21 ДҮГЭЭР ЗҮЙЛ

22 ДУГААР ЗҮЙЛ

23 ДУГААР ЗҮЙЛ

НАЙМДУГААР БҮЛЭГ
АСРАХ ҮЙЛЧИЛГЭЭНД
ТӨРӨӨС ҮЗҮҮЛЭХ
ДЭМЖЛЭГ,
САНХҮҮЖИЛТ

24 ДҮГЭЭР ЗҮЙЛ

Хууль санагчдын нэр



УИХ-ын гишүүн
Доржзаяагийн ЭНХТУЯА

Тогтоомж буй | Өргөн баригдсан | Хэлэлцэх эсэх | Ажлын хэсэг | Анхны хэлэлцүүлэг | Эцсийн хэлэлцүүлэг | Батлах

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 ОНД ТӨРӨЛӨН ГЭЖИЛГЭ

ХАМРАГДАХ

АСРАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬ



Дарах

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь асрах үйлчилгээний төрөл, ангилал, хэлбэр, түүний хүртээмж, асрах үйлчилгээнд тавигдах шаардлага, үйлчилгээний чанар, стандарт, үйлчилгээ аан буй иргэн, үйлчилгээ үзүүлэгчийн эрх, үүрэг, хариуцлага, аюул үй байдал, төр, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, оролцоо болон үйлчилгээнд тавих хяналт, санхүүжилт, төрөөс үзүүлэх дэмжлэг тэй холбогдох харилцааг зохицуулахад оршинс.

2 дугаар зүйл. Асрах үйлчилгээний хууль тогтоомж

2.1. Асрах үйлчилгээний тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, Нийгмийн халамжийн "ухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад ачгаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

3.1. Асрах үйлчилгээний тухай хуулийн үйлчлэл нь ахуйн өдөр тутмын асаргаа, нөхөн сэргээх асрах үйлчилгээ, асаргааны хувилбарт үйлчилгээ болон хүний эрх, нийгмийн харилцаанд бие дааж оролцоход хүндрэл бэрхшээлтэй, бусдын туслалцаа, дэмжлэг шаардлага бүхий хүнд үзүүлэх асрах үйлчилгээнд хамаарна.

3.2. Асрах үйлчилгээнд дараах хүн хамрагдана.

3.2.1. өндөр насралт, өсхөг болон дээмжирсэн өвчлөлөөс шалтгаалан өдөр тутмын амьдралын үйлдлийг өөрөө гүйцэтгэх боломжгүй болсон хүн,

3.2.2. хөгжлийн бэрхшээлээс шалтгаалан ахуйн болон нөхөн сэргээх асаргаа, байнгын асаргаа дэмжлэг шаардлагатай хүн,

3.2.3. тодорхой хугацааны асаргаа, нөхөн сэргээх дэмжлэг, хүний эрхийн хамгаалал, нийгмийн оролцоог хангах зэрэг хосолсон үйлчилгээ шаардлагатай хүн,

3.2.4. жирэмсний болон төрсний дараах үеийн ахуйн асаргаа, нөхөн сэргээх дэмжлэг, сэтгэл зүй, нийгмийн хамгаалал шаардлагатай болсон эх, нярай,

3.3. Энэ хуулиар зохицуулагдах үйлчилгээг төр, төрийн бус байгууллага, хувийн хэвшил, мэргэжлийн байгууллага болон хүмүүнлэгийн байгууллага дангаар болон хамтран хэрэгжүүлж болно.

4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1. Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгонс:

4.1.1. "Ахмад настан" гэж Ахмад настны тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан хүнийг,

4.1.2. "Хөгжлийн бэрхшээлтэй хүн" гэж Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 4.1.1 д заасан хүнийг,

4.1.3. "Асрах үйлчилгээ" гэж асаргаа шаардлагатай байгаа хүнд үзүүлэх орон байр, хоол хүнс, хувцас, ссел ахуй, сувилах, биемэхбодь, нийгэм, сэтгэл зүй болон тэдний амьдралын хэвийн нөхцлийг бүрдүүлэх зорилготой дэмжлэг, үйлчилгээг,



Асрах үйлчилгээний тухай хуулийн төслийн олон нийтийн хэлэлцүүлгийн тэмдэглэл

2026 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр

Төрийн ордон

Хэлэлцүүлэг өглөөний 09 цагт Төрийн ордны Чингис хаан танхимд эхлэв. Хэлэлцүүлгийг гишүүний зөвлөх Д.Элбэрэл нээж, оролцогчдыг төслийн талаар бүрэн дүүрэн мэдээлэл авч, өөрсдийн саналыг чөлөөтэй илэрхийлэхийг хүсэв.

Хэлэлцүүлэгт УИХ-ын гишүүд, төрийн болон төрийн бус байгууллага, салбарын мэргэжилтнүүд, судлаачид, хувийн хэвшлийн төлөөлөл, иргэдийн төлөөллийг хамарсан 100 гаруй хүн оролцож байна.

Хууль санаачлагч УИХ-ын гишүүн Д.Энхтуяа хуулийн төслийн талаар оролцогчдод танилцуулж, асуултад хариулт өгөв.

Хууль санаачлагчтай гэрээ байгуулан, хуулийн төслийг боловсруулахад мэргэжлийн байгууллагын хувьд хамтран ажилласан хууль зүйн “Эрх зүйн гүүр консалтинг” ХХК-ийн захирал Д.Оросоо хуулийн төслийн талаарх дэлгэрэнгүй танилцуулгыг хийж, оролцогчдын сонирхсон асуултуудад хариулт өглөө.

Оролцогчид дараах саналуудын гаргасан:

БГД-ийн иргэн:

1. Салбарын хүмүүсийн санал, хүсэлтийг сайтар сонсож, тэдний саналыг хуульд түлхүү тусгах;
2. Холбогдох бусад хуультай зохицох зохицуулалтыг сайн анхаараарай.

МУИС-ийн багш, судлаач Амаржаргал:

1. Хүүхдийн асуудлыг хуульд чухалчлан тусгах;
2. Байгууллага бүхэн бага насны хүүхэдтэй ажиллагсадтай тул ажиллагсдын хүүхдийн өрөөтэй байх;
3. Асрах үйлчилгээнд хамрагдахад шат дамжлага, хүнд суртлыг аль болох бага байлгах талаарх зохицуулалт чухал.

Хүмүүн капитал, хүний нөөцийн ажилтан Алтантүлхүүр:

1. Хүний нөөцийн ёс зүйн шаардлагыг тусгах;
2. Оюун санааны асаргаа их чухал;
3. Аутизмтай хүүхдийн асаргааны зохицуулалт оруулах;
4. Хүүхдийн асуудлыг сайтар анхаарч тусгах.

Ахмад настны сэтгэл зүйч:

1. Ахмад настны тэтгэвэрт гарахын өмнөх үеийн сэтгэл зүйг бэлтгэх тухай хуульд тусгамаар байна.

БГД-ийн иргэн Бурмаа:

1. Хувилбарт асрах үйчилгээний талаар нарийн тусгах;
2. Асаргаа, сувилгаанаас гадна хөгжлийн үйлчилгээг нэмж сайн тусгах;
3. Хүүхдүүд асрах газраас насанд хүрээд гардаг, тэдний амьдрах орчин, орон байрны асуудал асар эрсдэлтэй байдаг тул тэдний амьдрах орчны талаарх зохицуулалтыг хуульд тусгах боломжтой юу?.

Хувийн хэвшлийн төлөөлөл:

Монгол улс Их Монгол Улсын үеэс хууль цаазандаа тусгах замаар асаргаа шаардлагатай хүмүүс болон ахмадуудаа асарч ирсэн түүхтэй. Харамсалтай нь энэ уламжлал олон жил тасраад одоо шинээр сэлгээх гэж байна гээд дараах саналуудыг хэлэв:

1. Асаргааны байгууллагуудад ахмадуудыг ажиллуулдаг, ажиллах өдөр цагийг харилцан ярилцаж сонгодог байх;
2. Хувьсах зардлыг төрөөс олгох;
3. Барилга, байгууламжийг ногоон зээлд хамруулах;
4. Цахилгаан дулааныг шийдэхэд төрөөс дэмжлэг үзүүлэх.

Иргэн Цэцэгмаа:

1. Одоо ажиллаж байгаа байгууллага, иргэдийг орхигдуулахгүй, цаашид үргэлжлүүлэх боломжийг нээлттэй байлгах;

2. Даатгалын асуудлыг маш тодорхой тусгах;
3. Орон гэртээ асаргаа хийж байгаа хөдөлмөрийн насны хүнийг сайн анхаармаар (нийгмийн даатгалыг төрөөс даах);
4. Санхүүжилтэнд уул уурхайн компаниудыг нийгмийн хариуцлагын хүрээнд үүрэгжүүлж өгмөөр байна.

БГД-ийн иргэн Гадинжид дэмжиж, амжилт хүсэв.

УИХ-ын гишүүн С.Эрдэнэбат:

Нийгмийн даатгалын шинэчлэлийн асуудал яригдаж байна. Эрүүл мэндийн даатгалын 70 орчим хувь нь ахмадууд, хүүхдүүдийн хэвтэн эмчлүүлэх зардалд зарцуулагддаг тул ЭМД-ын 30-аас багагүй хувийг гэрээр очиж үйлчилгээ үзүүлдэг хэсэгт оногдох ёстой гэж харж байна.

Гэрээр асаргаа үзүүлэгч Нью хоум кэйр төвийн сэргээн засалч эмч:

Асаргаанд хамрагддаг ихэнх хүмүүс төрөл бүрийн чадвар алдалттай байдаг. (Нөхөн сэргээх биш, сэргээн засах гэдэг болсон шүү). Их эмч 6 жил сурч мэргэшдэг бол сэргээн засах эмч дахин 2 жил сурч, мэргэшдэг.

- 1 Ямар хүний зардлыг төрөөс дэмжих, ямар хүн өөрөө даах гэдгийг тодорхой тусгах;
- 2 Хүний нөөц ба санхүүжилтийг сайн холбож авч үзэх;
- 3 Асрах үйлчилгээнд эмчийн тодорхойлолтоор хамрагдах гэж төсөлд байна. Яг ямар эмчийн тодорхойлолт байх юм бэ? Эсвэл комисс байх юм уу?.

УИХ-ын гишүүн С.Одонтуяа:

Нийгэмд маш онцгой, тулгамдсан хэрэгцээ, шаардлагатай чухал хууль юм. Бүх талаар дэмжиж, хамтарч, батлуулахын төлөө ажиллах болно.

Ачлал Номуун ХХК-ын төлөөлөл:

1. Асаргааг ойлгох нийгмийн сэтгэл зүйг чиглүүлэх, өөрчлөх шаардлагатай.
2. Хүний нөөцийн асуудал маш чухал, асаргааны ажилтнуудын нэр хүндийг өргөх хэрэгтэй.

3. Үйлчилгээ авагч нь төлбөрийн чадваргүй байх нь дийлэнх тул төлбөрийн асуудлыг маш олон арга хэлбэрээр, олон эх үүсвэрээс зохицуулах;
4. Цаашид асрах үйлчилгээний салбар хөгжвөл Монгол асаргаа брэнд болох боломжтой.

Асаргаа, үйлчилгээ үзүүлэгч эмч:

1. Асрах үйлчилгээнд хамруулахад сэргээн засах лицензтэй эмчийн тодорхойлолттой байвал зүгээр.
2. Асрах үйлчилгээнд хүний эрхийн ажилтан заавал хэрэгтэй юу?
3. Асрах үйлчилгээнээс шаардлагатай тохиолдолд эмнэлгийн байгууллагад хэрхэн шилжүүлэхийг зохицуулах.

Батсүмбэрийн асрамжийн газар, Хүлэгчимэг:

1. Асрах үйлчилгээг зөвхөн зорилтот бүлэгт биш, сонирхсон бүх хүмүүст үйлчилдэг зохицуулалт хийх;
2. Асрах үйлчилгээнд ажиллаж байгаа ажилтнуудын нийгмийн асуудал, цалин хөлс, хөдөлмөрийн эрхийг хамгаалах талаар тусгах.

Doula Mongolia Association НҮТББ:

1. Жирэмсэн болон төрсөн эхчүүд, нярайн хувьд тусгай асаргаа маш чухал байдаг. Энэ үйлчилгээ хөгжсөн улс орнуудад төрөлтийн хамтрагч гэдэг асаргааны төрөл амьдралд хэрэгжсэн байдаг. Энэ үйлчилгээг авснаар кесаров төрөлт 45%-иар багассан гэдэг судалгаа байдаг. Doula үйлчилгээг авснаар эх баригч эмчийн сэтгэл санаа, ажлын үр дүнд сайнаар нөлөөлдөг гэдэг судалгаа байдаг. Асрах үйлчилгээний үндсэн үүрэг, үр дүн нь амьдралын чанарыг сайжруулдаг. Энэ нь нийгмийн эрүүл мэндийн чухал хэсэг юм. Асарч байгаа хүний эрүүл мэнд, нийгмийн асуудлыг хуульд онцлон тусгамаар байна.

Хэлэлцүүлэг 15.30 цагт өндөрлөв.

Тэмдэглэл хөтөлсөн



Э.Ариунзаяа



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН Д.ЭНХТУЯА ТАНАА

МОНГОЛ УЛС

ЖЕНДЭРИЙН ҮНДЭСНИЙ ХОРОО

Нэгдсэн үндэстний гудамж 20, 6-р хороо,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14200
Утас: (976) 70071113, 70071117
Цахим шуудан: secretariat@ncge.gov.mn,
Цахим хуудас: www.ncge.gov.mn

1026.03.09 № 34
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөлд санал хүргүүлэх тухай

Асрах үйлчилгээний тухай хуулийн төсөлд жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, зарчимд үндэслэн хүүхэд, ахмад настан болон гэр бүлийн гишүүдээ асрах зэрэг гэрийн хөлсгүй хөдөлмөрийг эдийн засагт оруулж буй хувь нэмэр гэж хүлээн зөвшөөрөх, урт хугацаанд гэр бүлийн гишүүнээ асарсан хүнийг ажилгүйд тооцохгүй байх, тэдний нийгмийн даатгал болон эрүүл мэндийн даатгалыг төрөөс, эсхүл халамжийн сангаас нөхөн төлөх, тэтгэвэр тогтоолгох эрхийг нь хамгаалах, гэр бүлд болон асрах үйлчилгээнд эрэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх, асаргаа, үйлчилгээ үзүүлэгч иргэн, байгууллагын хөдөлмөрийг дэмжих, үнэлэх, асруулагчийн жендэрийн онцлогийг харгалзан үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зэрэг асуудлыг тусгуулахаар холбогдох саналаа хүргүүлж байна.

Хавсралт ... хуудастай.

Хүндэтгэсэн,

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА БӨГӨӨД
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА А.АДИЛБИШ



АСРАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬ

/Анхдагч хуулийн төсөл/

№	Хуулийн төслийн холбогдох зүйл заалт	Хуульд нэмэлт өөрчлөлт оруулах саналын томъёолол	Эрх зүйн үндэслэл Хэрэгцээ, шаардлага
1.	3.1. Асрах үйлчилгээний тухай хуулийн үйлчлэл нь ахуйн өдөр тутмын асаргаа, нөхөн сэргээх асрах үйлчилгээ, асаргааны хувилбарт үйлчилгээ болон хүний эрх, нийгмийн харилцаанд бие дааж оролцоход хүндрэл бэрхшээлтэй, бусдын туслалцаа, дэмжлэг шаардлага бүхий хүнд үзүүлэх асрах үйлчилгээнд хамаарна.	Асрах үйлчилгээний тухай хуулийн үйлчлэл нь ахуйн өдөр тутмын асаргаа, нөхөн сэргээх асрах үйлчилгээ, асаргааны хувилбарт үйлчилгээ болон хүний эрх, нийгмийн харилцаанд бие дааж оролцоход хүндрэл бэрхшээлтэй, бусдын туслалцаа, дэмжлэг шаардлага бүхий хүнд тохирсон нас, сэтгэхүй, хүйсийн онцлог, ялгаатай хэрэгцээнд суурилсан асрах үйлчилгээ хамаарна.	
4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт:			
2.	4.1.3. “Асрах үйлчилгээ” гэж асаргаа шаардлагатай байгаа хүнд үзүүлэх орон байр, хоол хүнс, хувцас, соёл, ахуй, сувилах, биемахбодь, нийгэм, сэтгэл зүй болон тэдний амьдралын хэвийн нөхцлийг бүрдүүлэх зорилготой дэмжлэг, үйлчилгээг хэлнэ.	“Асрах үйлчилгээ” гэж асаргаа шаардлагатай байгаа нас, хүйс, эрэгтэй, эмэгтэй хүний онцлог, ялгаатай хэрэгцээнд тохирсон хүнд үзүүлэх орон байр, хоол хүнс, хувцас, соёл, ахуй, сувилах, биемахбодь, нийгэм, сэтгэл зүй болон тэдний амьдралын хэвийн нөхцлийг бүрдүүлэх зорилготой дэмжлэг, үйлчилгээг хэлнэ.	
3.	4.1.11. “Түр асаргаа” гэж асарч буй гэр бүл, асран хамгаалагчид нь амсхийх хугацаа олгох, түр хугацаанд мэргэжлийн орчинд асаргаа үзүүлэх үйлчилгээг;	“Түр асаргаа” гэж асарч буй гэр бүл, асран хамгаалагчид хөдөлмөр эрхлэх, сурч боловсроход дэмжлэг үзүүлэх зорилгоор түр хугацаа олгох, түр хугацаанд мэргэжлийн орчинд асаргаа үзүүлэх үйлчилгээг;	
4.	Хуулийн нэр томъёоны тодорхойлолтод нэмэлт заалт нэмэх	4.1.15. “Албан бус асран хамгаалагч” гэж гэр бүлийн гишүүн, хамаатан садан болон бусад этгээд сайн дурын үндсэн дээр цалин хөлсгүйгээр асаргаа үзүүлж байгаа хүнийг;	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөө /2022-2031/-д заасны хүүхэд асрах үйлчилгээний зардлыг ач эзэгээ асарч буй ахмад настанд олгох зэрэг арга хэмжээ
5.		4.1.16. “Жендэрийн мэдрэмжтэй үйлчилгээ” гэж үйлчилгээний хүртээмж, чанар,	

		аюулгүй байдал, санхүүжилтыг төлөвлөхдөө эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн ялгаатай хэрэгцээ, нөхцөл байдлыг харгалзан үзсэн бодлого, арга хэмжээг;	
5 дугаар зүйл. Хувилбарт асрах үйлчилгээг үзүүлэх зарчим			
6.	нэмэлт заалт нэмэх	5.1.13 асрах үйлчилгээ нь жендэрийн хэвшмэл ойлголтыг дэмжихгүй байх, эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тэгш оролцоог хангах;	
7.	нэмэлт заалт нэмэх	5.1.14 албан бус асран хамгаалагчийн хөдөлмөрийг үнэлэх, нийгмийн хамгааллын тогтолцоотой уялдуулах;	
6 дугаар зүйл. Хувилбарт асрах үйлчилгээний төрөл			
8.	6.4. Хүний эрх ба нийгмийн оролцооны асаргаа дэмжлэгт асруулагч хүний нэр төр, эрх, өмч, санхүүгийн аюулгүй байдлыг хамгаалах, нийгмийн харилцаа, соёл, мэдээллийн хүртээмж, оролцоо, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх болон хохирол арилгах үйлчилгээний цогц арга хэмжээг багтаана.	Хүний эрх ба нийгмийн оролцооны асаргаа дэмжлэгт асруулагч хүний нэр төр, эрх, өмч, санхүүгийн аюулгүй байдлыг хамгаалах, нийгмийн харилцаа, соёл, мэдээллийн хүртээмж, оролцоо, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх болон хохирол арилгах үйлчилгээний цогц арга хэмжээг багтаах бөгөөд асруулагч болон асрах үйлчилгээ үзүүлэгчийн аль алиных нь хүйсийн ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийг хангана.	
7 дугаар зүйл. Хувилбарт асрах үйлчилгээний ангилал:			
9.	7.8. Төрөөс үзүүлэх хувилбарт асрах үйлчилгээ, хувийн хэвшлээс төрийн худалдан авах үйлчилгээний зардал, үзүүлэх хөнгөлөлт, даатгалын сангаас санхүүжүүлэх журмыг Засгийн газар батална.	7.8. Төрөөс үзүүлэх хувилбарт асрах үйлчилгээ, хувийн хэвшлээс төрийн худалдан авах үйлчилгээний зардал, үзүүлэх хөнгөлөлт, даатгалын сангаас санхүүжүүлэх журмыг Засгийн газар батална. Тус журмыг асран хамгаалагчийн хөдөлмөр эрхлэлт тасалдахаас сэргийлэх, нийгмийн даатгалын тасралтгүй байдлыг хангах зохицуулалтыг тусгасан.	
8 дугаар зүйл. Асрах үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлага			
10.	нэмэлт заалт нэмэх	8.1.10. Асрах үйлчилгээ нь үйлчлүүлэгчийн хүйс, насны онцлогт тохирсон байх бөгөөд үйлчилгээ үзүүлэгч нь	

		жендэрийн мэдрэмжтэй харилцааны ур чадвар эзэмшсэн байх;	
9 дүгээр зүйл. Асрах үйлчилгээнд тавигдах тусгай шаардлага			
11.	9.2.2. үйлчлүүлэгчийн хувийн орон зай, нууцлалыг хангах дэд зохион байгуулалттай байх	үйлчлүүлэгчийн хувийн орон зай, нууцлалыг хангах, шаардлагатай тохиолдолд нас, хүйс, онцлог хэрэгцээг харгалзан тусгаарлах, нэр төр, аюулгүй байдлыг хангах	
10 дугаар зүйл. Асрах үйлчилгээнд хамрагдах хүний эрх, үүрэг			
12.	10.1.3. хүчирхийллийн эсрэг хамгаалалтад хамрагдах;	Хүний эрх, жендэрийн эрх тэгш байдлыг хангах, аливаа хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хамгаалалтад хамрагдах	
13.	10.2.3. үйлчилгээний аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдөх;	Нас, хүйсийн онцлогт зориулсан үйлчилгээний аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдөх;	
14.	10.2.8. хүчирхийлэл, үл хайхрал, ялгаварлал, эрсдэлийн бусад нөхцөл илэрсэн тохиолдолд заавал мэдээлэх;	хүчирхийлэл, үл хайхрал, ялгаварлал, дарамт, бэлгийн дарамт зэрэг эрсдэлийн бусад нөхцөл илэрсэн тохиолдолд заавал мэдээлэх;	
11 дүгээр зүйл. Асрах үйлчилгээ үзүүлэгчийн эрх, үүрэг			
15.	11.1.1. үйлчилгээ үзүүлэгч нь өөрийн үйлчилгээний үнийн бодлогыг тодорхойлохдоо шударга ёс, хүмүүнлэг зарчимд нийцүүлэн, зах зээлийн бодит үнэд үндэслэх;	Үйлчилгээ үзүүлэгч нь өөрийн үйлчилгээний үнийн бодлогыг тодорхойлохдоо шударга ёс, хүмүүнлэг зарчимд нийцүүлэн, жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтөд суурилсан үйлчилгээг , зах зээлийн бодит үнэд үндэслэх;	- Жендэрийн мэдрэмжтэй үйлчилгээ” гэж үйлчилгээний хүртээмж, чанар, аюулгүй байдал, санхүүжилтыг төлөвлөхдөө эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн ялгаатай хэрэгцээ түүний гэр бүлийн нөхцөл байдлыг харгалзан үзсэн бодлого, арга хэмжээ - Мөн үйлчилгээ авах гэж буй гэр бүлийн байдал, хөдөлмөрийн насны гишүүдийн тоо, өрх толгойлсон эцэг эх, бага насны хүүхэдтэй өрх зэргийг харгалзан үзэж хөнгөлөлттэй

			үнээр үйлчилгээг үзүүлэх
16.	11.1.3. асруулагчийн хувийн мэдээллийг хуульд заасан хүрээнд хамгаалах, нууцлах;	11.1.3. асруулагчийн болон түүний гэр бүл, хамаарал бүхий хүмүүсийн хувийн мэдээллийг хуульд заасан хүрээнд хамгаалах, нууцлах;	- Гэр бүл болон бусад хамаарал бүхий хүмүүсийн мэдээллийг хамгаалах
Асруулагч болон түүний гэр бүлийн гишүүн, асран хамгаалагч нь дараах эрхтэй:			
17.	Нэмэлт заалт оруулах	10.3.1. асаргааны улмаас хөдөлмөр эрхлэлт тасалдахаас хамгаалах бодлогын дэмжлэг авах;	
18.		10.3.2. түр асаргаа авах;	
19.		10.3.3.сэтгэл зүйн зөвлөгөө, мэдээлэл, сургалтад хамрагдах	
12 дугаар зүйл. Асрах үйлчилгээ үзүүлэгчийн үүрэг			
20.	12.1.2. үйлчилгээ үзүүлэгч нь хууль тогтоомж, үйлчилгээний стандарт, эрүүл мэнд, сэтгэл зүйн мэдлэг, ур чадвар олгох сургалтад хамрагдсан байна. Ажлын тайлангаа холбогдох байгууллагад хүргүүлж, үнэлгээ авна.	үйлчилгээ үзүүлэгч нь хууль тогтоомж, эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хэрэгцээнд тохирсон үйлчилгээний стандарт, жендэрийн эрх тэгш байдал, хүйсийн мэдрэмжтэй харилцааны арга зүйг тусгах, эрүүл мэнд, сэтгэл зүйн мэдлэг, ур чадвар олгох сургалтад хамрагдсан байна. Ажлын тайлангаа холбогдох байгууллагад хүргүүлж, үнэлгээ авна.	
21.	12.1.3. эрүүл мэнд, хоол тэжээл, сэтгэл зүй, хөдөлгөөн, амрах нөхцлийг хангаж, халдвар хамгааллын болзол, шаардлагыг чанд мөрдөх;	эрүүл мэнд, хоол тэжээл, нас, хүйс, сэтгэл зүй, хөдөлгөөн, амрах нөхцлийг хангаж, халдвар хамгааллын болзол, шаардлагыг чанд мөрдөх;	
22.	Нэмэлт заалт оруулах	12.1.9. Үйлчилгээ үзүүлэгч нь хүний нөөцийн бодлогодоо хүйсийн тэнцвэрт байдлыг хангах, эрэгтэйчүүдийг асрах үйлчилгээний салбарт ажиллахыг дэмжих.	
14 дүгээр зүйл. Хувилбарт асрах үйлчилгээний төвийн барилга, орчны шаардлага, стандарт			
23.	14.1. Хувилбарт асрах үйлчилгээний төвийн барилга, модуль, түр байр болон хөдөлгөөнт байгууламж нь дараах шаардлагыг хангасан байна:	Хувилбарт асрах үйлчилгээний төвийн барилга нь эрэгтэй, эмэгтэй хүний онцлог хэрэгцээнд тохирсон жендэрийн мэдрэмжтэй барилга... байх	
24.	14.1.3. асруулагч хүний хувийн орон зайг тусгаарлах хөшиг, тасалгаа, хаалт, нууцлалын	14.1.3. асруулагч хүний хувийн орон зайг тусгаарлах хөшиг, тасалгаа, хаалт, нууцлалын	

	зохион байгуулалт бүхий бүсчлэлтэй байх;	зохион байгуулалт бүхий бүсчлэлтэй байх бөгөөд амрах болон ариун цэврийн үйлчилгээг хүйсэд харгалзан тусгаарласан байх;	
16 дугаар зүйл. Удирдлага, зохион байгуулалтын үндсэн зарчим			
25.	Нэмэлт заалт оруулах	6.4. Хувилбарт асрах үйлчилгээний удирдлага, зохион байгуулалт нь жендэрийн эрх тэгш байдал болон оролцоог хангана.	
17 дугаар зүйл. Төрийн чиг үүрэг			
26.	17.1.1. асрах үйлчилгээний бодлого, стандарт, шаардлага тогтоох;	асрах үйлчилгээний бодлого, стандарт нь хүний эрх, жендэрт суурилсан байх шаардлагыг тогтоох	
27.	17.1.4. үйлчилгээний чанар, хүний эрх, аюулгүй байдлын хяналт хэрэгжүүлэх;	17.1.4. үйлчилгээний чанар, хүний эрх, жендэрийн эрх тэгш байдлыг хангах , аюулгүй байдлын хяналт хэрэгжүүлэх;	
28.	17.1.5. төрийн худалдан авалт, санхүү, даатгалын дэмжлэгийн бодлого хэрэгжүүлэх.	төрийн худалдан авалт, санхүү, жендэрийн мэдрэмжтэй даатгалын дэмжлэгийн бодлого хэрэгжүүлэх.	
29.	Нэмэлт заалт оруулах	17.1.6. Асрах үйлчилгээний салбар дахь хүйсийн ялгаварлан гадуурхалтыг арилгах, асран хамгаалагчдын ажил, амьдралын тэнцвэрийг дэмжих бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэх;	
30.	Нэмэлт заалт оруулах	17.1.7. Асруулагч болон асрах үйлчилгээний хэрэгцээ, хүртээмжийг хүйсээр ангилсан статистик мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх , бодлогын нөлөөллийн шинжилгээ хийх.	ЖЭТБХТХ-ийн 5 дугаар зүйлд заасан жендэрийн мэдэ элэл хүртээмжтэй байх зарчим
18 дугаар зүйл. Асруулах хүний тодорхойлох, ангилах журам			
31.	18.1. Хувилбарт асрах үйлчилгээний төвд хамруулах хүнийг тухайн сум, дүүргийн нийгмийн халамжийн ажилтан тодорхойлно.	18.1. Хувилбарт асрах үйлчилгээний төвд хамруулах хүнийг тухайн тухайн хүний хүйсийн онцлог хэрэгцээ болон түүнийг асарч буй гэр бүлийн гишүүний саналыг үндэслэн , сум, дүүргийн нийгмийн халамжийн ажилтан тодорхойлно.	
20 дугаар зүйл. Дотоод удирдлагын бүтэц			

32.	20.1.2. хүний эрх, нууцлалын хяналтын ажилтан.	хүний эрх, жендэрийн эрх тэгш байдал , нууцлалын хяналтын ажилтан.	
33.	Нэмэлт заалт оруулах	20.2. Удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагын бүрэлдэхүүнд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд заасан хүйсийн төлөөллийн квотыг баримтална.	
24 дүгээр зүйл. Төрөөс дэмжлэг үзүүлэх үндсэн зарчим			
34.	24.2. Төрөөс үзүүлэх дэмжлэг нь үйлчилгээний чанар, хүний эрх, аюулгүй байдлын шалгуурыг хангасан тохиолдолд олгогдоно.	Төрөөс үзүүлэх дэмжлэг нь үйлчилгээний чанар, хүний эрх, жендэрийн эрх тэгш байдлыг хангасан , аюулгүй байдлын шалгуурыг хангасан тохиолдолд олгогдоно.	
35.	Нэмэлт заалт	24.4.Төрөөс үзүүлэх дэмжлэг нь гэр бүлийн хүрээнд хөлсгүй асаргаа үзүүлж буй иргэдийн (ихэвчлэн эмэгтэйчүүд) эдийн засгийн хараат бус байдлыг дэмжих , тэднийг хөдөлмөрийн зах зээлд эргэн орох боломжоор хангахад чиглэнэ.	
25 дугаар зүйл. Дэд бүтэц, хөрөнгө оруулалтын дэмжлэг			
36.	25.2. Төр нь хувилбарт асрах үйлчилгээний төвийн барилга, модуль байгууламж, дэд бүтэц, суурь тоног төхөөрөмжийн бүтээн байгуулалтыг дангаар болон бусад этгээдтэй хамтран санхүүжүүлж, байгуулж, ажиллуулж болно.	Төр нь хувилбарт асрах үйлчилгээний төвийн барилга, модуль байгууламж, дэд бүтэц, суурь тоног төхөөрөмжийн бүтээн байгуулалтыг дангаар болон төрийн болон төрийн өмчит, ААНБ дэргэд болон хувилбарт асрах үйлчилгээний төвүүдтэй гэрээт бусад этгээдтэй хамтран санхүүжүүлж, байгуулж, ажиллуулж болно.	Жендэрийн нэр томъёоны тайлбарт Гэр бүлд ээлтэй ажлын байр, гэр бүлд үйлчлэх төв гэж ажилтнуудын ажилдаа болон ар гэрийн амьдралдаа сэтгэл ханамжтай байхад анхаарч дэмжсэн бодлого. Албан хаагчдын асран хамгаалагчдыг дэмжих бодлого юм. Энэхүү бодлогыг дэмжиж төрөөс татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлэх
Асрах үйлчилгээнд төрөөс үзүүлэх дэмжлэг, санхүүжилт			
37.	24.4. Төр нь албан бус асран хамгаалагчийг дараах байдлаар дэмжинэ:	24.4.1. нийгмийн даатгалын шимтгэлд хөнгөлөлт үзүүлэх; 24.4.2. тэтгэврийн шимтгэлийн тодорхой хувийг төрөөс хариуцах боломжийг судалж хэрэгжүүлэх;	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөөний 2.1.9 хүүхдээ асарч буй эцэг, эхийн нийгмийн

		24.4.3. ур чадвар олгох сургалтад үнэ төлбөргүй хамруулах.	даатгалын хариуцдаг төрөөс
27 дугаар зүйл. Татвар, төлбөр зардлын хөнгөлөлт			
38.	27.1.2. нийгмийн даатгалын шимтгэлтэй холбоотой хөнгөлөлт;	27.1.2. Асран хамгаалагчийн асарсан хугацааг ажилласан жилд тооцох, тэтгэврийн даатгалын шимтгэлийг төрөөс хариуцах.	Гэр бүлийн гишүүний хувьд
30 дугаар зүйл. Хүний нөөцийн зохицуулалтын үндсэн зарчим			
39.	Дараах нэмэлт заалт	30.4. Асрах үйлчилгээний салбарт эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг мэргэжлээр бэлтгэх, ажиллах нөхцөлийг дэмжих бодлого баримтална.	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль
40.		30.5. Асаргааны мэргэжилтнийг бэлтгэх сургалтад жендэрийн мэдрэмж, ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх агуулгыг заавал тусгана.	
32 дугаар зүйл. Ахуйн асрах үйлчилгээний сургалт, зөвшөөрөл			
41.	32.3.1. хүний эрх, нэр төр, ёс зүй болон холбогдох хууль тогтоомж;	32.3.1. хүний эрх, жендэрийн эрх тэгш байдал, нэр төр, ёс зүй болон холбогдох хууль тогтоомж;	
42.	Нэмэлт заалт нэмэх	32.4. Гэр бүлийн хүрээнд асаргаа үзүүлж буй иргэдэд зориулсан "Асрахуйн хөдөлмөрийг мэргэшүүлэх" сургалтын хөтөлбөртэй байх бөгөөд энэ нь тэднийг цаашид хөдөлмөрийн зах зээлд хөрвөхөд дэмжлэг болно.	
42 дугаар зүйл. Санхүүжилт, төлбөрийн хяналт, ил тод байдал			
43.	Нэмэлт заалт	42.4. Асрах үйлчилгээний хүртээмж, санхүүжилт, хүний нөөцийн мэдээллийг жендэрээр ангилан бүртгэж, жил бүр дүн шинжилгээ хийнэ.	
45 дүгээр зүйл. Хуулийг зөрчсөнд хүлээлгэх хариуцлага			
44.	Нэмэлт заалт	45.2.5. Үйлчилгээ үзүүлэх явцад хүйсээр ялгаварлан гадуурхсан, дарамт, бэлгийн дарамт үзүүлсэн, хүйсийн шинжтэй хүчирхийлэл үйлдсэн тохиолдол	ЖЭТБхТХ-ийн 4, 6 дугаар зүйл
48 дугаар зүйл. Асаргаа үзүүлэгчийг хамгаалах зохицуулалт			
45.	Нэмэлт заалт	48.4. Асаргаа үзүүлэгч нь үйлчилгээ үзүүлэх явцад	

		хүйсийн шинжтэй дарамт, хүчирхийлэлд өртөхөөс хамгаалагдах эрхтэй бөгөөд үйлчилгээ үзүүлэгч байгууллага нь ажилтны аюулгүй байдлыг холбогдох хууль, дүрэм журмаар хамгаална. (эрх зүйн зохицуулалт дотоод журамтай байна).	
--	--	---	--

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН,
ХУУЛИЙН АЖЛЫН ХЭСГИЙН АХЛАГЧ Д.ЭНХТУЯА ТАНАА

Санал: Ахмад настны урт хугацааны асаргаа, сувилгааны чиглэлд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжих эрх зүйн бодлогын дэмжлэг

1. Товч үндэслэл

Өндөр настны урт хугацааны асаргаа, сувилгааны үйлчилгээ нь нийгмийн халамж, эрүүл мэндийн түслэмжийн тогтолцооны суурь дэд бүтэц бөгөөд ахмад настны амьдралын чанарыг дээшлүүлэх, гэр бүлийн асаргааны ачааллыг бууруулах, эмнэлгийн хэвтэлтийн хэрэгцээ, давтан хэвтэлтийг бууруулах бодит үр нөлөөтэй. Гэвч уг салбар нь хөрөнгө оруулалт их шаарддаг, хүний нөөцийн хэрэгцээ өндөр, ашигт ажиллагаа харьцангуй бага тул хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт орж ирэхэд төрийн бодлогын дэмжлэг шаардлагатай.

2. Хэрэгцээ, хамрах хүрээний баримжаа

Эхний үе шатанд 65+ бүлгийн 10–15 хувь нь урт хугацааны асаргаа шаардлагатай гэж үзвэл 19 000–29 000 иргэн (цогц үнэлгээгээр баталгаажуулна).

3. Эдийн засгийн баримжаа тооцоо (нэг хүнд жилд / нийт жилд)

Сан бүрдүүлэх жишиг (0.5% шимтгэлийн хувилбар): даатгуулагч 811,600 хүн, сарын дундаж цалин 2 621 900 төгрөг гэж үзвэл жилд ойролцоогоор 127 676 042 400 төгрөг төвлөрөх боломжтой (баримжаа).

Хүснэгт 1. Асаргаа, сувилгааны жилийн зардлын баримжаа (өгөгдсөн хамрагдалтаар)

Хувилбар	Сарын өртөг (₮)	Нэг хүнд жилд (₮)	Нийт 19 000 хүн (₮)	Нийт 21 000 хүн (₮)	Нийт 29 000 хүн (₮)	Тайлбар
Эрхийн бичгийн жишиг (суурь дэмжлэг)	500 000	6 000 000	114 000 000 000	126 000 000 000	174 000 000 000	Эрхийн бичиг/тэтгэмж хэлбэрээр дэмжих доод жишиг
Стандарт асаргаа, сувилгааны төв (дунд түвшин)	2 000 000	24 000 000	456 000 000 000	504 000 000 000	696 000 000 000	Сувилахуйн түслэмж + хоол, байр, өдөр тутмын асаргаа

Хувилбар	Сарын өртөг (₮)	Нэг хүнд жилд (₮)	Нийт 19 000 хүн (₮)	Нийт 21 000 хүн (₮)	Нийт 29 000 хүн (₮)	Тайлбар
Өндөр хэрэгцээтэй (хүнд сувилгаатай)	3 000 000	36 000 000	684 000 000	756 000 000	1 044 000 000 000	Хэвтрийн шат/өндөр асаргаатай тохиолдлын өндөр зардлын жишиг

Жишээлбэл, нэг хүнд сард 500 000 төгрөгийн эрхийн бичиг олгох суурь дэмжлэгийн загвараар жилд 127 676 042 400 төгрөгийн сан бүрдсэн гэж үзвэл 21 279 орчим ахмадыг хамруулах боломжтой (баримжаа).

4. Хөрөнгө оруулалтыг татах эрх зүйн ба санхүүгийн багц санал

4.1. Хөрөнгө оруулалтын зардлыг бууруулах шууд дэмжлэгийн багц

- Зээлийн хүүгийн дэмжлэг: Барилга байгууламж, дэд бүтэц, тоног төхөөрөмжийн урт хугацааны санхүүжилтийн зээлийн хүүг жилийн 6 хувиас доош түвшинд барих дэмжлэг үзүүлэх. ✓
- Зээлийн батлан даалт: Чанар, стандарт, тайлагналын шаардлага хангасан бөгөөд төрийн санхүүжилтийн хэлбэрүүд (эрхийн бичиг, гэрээт худалдан авалт)-д хамрагдсан үйлчилгээ үзүүлэгчид төрөөс зээлийн батлан даалт гаргах эрх зүйн боломж бүрдүүлэх. ✓
- Газрын эрх: Асаргаа, сувилгааны төв байгуулах газрыг урт хугацаагаар хөнгөлөлттэй нөхцөлөөр, шаардлагатай тохиолдолд үнэ төлбөргүй олгох; төр-хувийн хэвшлийн түншлэлийн хэлбэрийг ашиглах боломж бүрдүүлэх. ✓
- Нэмэлт санал (татварын 1%-ийн хөнгөлөлтийг хөрөнгө оруулалт татахад ашиглах): Аж ахуйн нэгжүүд нийгмийн хариуцлагын хүрээнд ахмад настны асаргаа, сувилгааны төвийн барилга байгууламж, тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтыг дэмжих зорилгоор татварын хууль тогтоомжийн хүрээнд харилцан хамааралгүй этгээдэд олгосон хөрөнгө оруулалт, дэмжлэг, хандивыг тухайн татварын жилийн татвар ногдох орлогын 1 хүртэлх хувьтай тэнцэх хэмжээгээр албан татвараас хасаж хөнгөлөх зохицуулалтыг бодитой хэрэгжүүлэх (шаардлага, баримтжуулалт, баталгаажуулалтын журмыг тодорхой болгох). ✓

4.2. Татвар, гаалийн зорилтот хөнгөлөлтийн багц

- Импортын татвар, нэмэгдсэн өртгийн албан татварын хөнгөлөлт: Асаргааны ор, өргөгч төхөөрөмж, аюулгүй байдлын систем, сувилахуйн дуудлагын систем, сэргээн засах тоног төхөөрөмж зэрэг зайлшгүй шаардлагатай тоноглолын нэр төрөл, ангиллыг баталж, гаалийн татвар болон нэмэгдсэн өртгийн албан татвараас хөнгөлөх/чөлөөлөх.
- Үйлчилгээ үзүүлэгч байгууллагын татварын хөнгөлөлт: Чанар, стандарт, тайлагналын шаардлага болон эмзэг бүлгийн хамралтын нөхцөлийг хангасан байгууллагад хөрөнгийн албан татвар, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл-ийг хугацаатайгаар хөнгөлөх/чөлөөлөх зохицуулалт бий болгох.

Там Төхөөрөмж 5-61 - Хөнгөлөгч
Там Төхөөрөмж

4.3. Нийгмийн даатгалын тогтолцоонд “урт хугацааны асаргаа, сувилгааны шимтгэл” шинээр бий болгох

- Нийгмийн даатгалын тухай хуульд ахмад настны урт хугацааны асаргаа, сувилгааны үйлчилгээний шимтгэлийн шинэ төрөл (эсхүл тусгай зориулалтын дэд сан) бий болгох.
- Иргэд 40 наснаас эхлэн тэтгэвэр тогтоолгох хүртэл хугацаанд уг шимтгэлийг төлж хуримтлуулдаг байх. ? хэд %
- Тэтгэвэрт гарсны дараа тухайн иргэн хэрэгцээний үнэлгээнд үндэслэн эрхийн бичиг хэлбэрээр урт хугацааны асаргаа, сувилгааны үйлчилгээ худалдан авах эрхтэй байх (төрийн болон хувийн байгууллагаас сонгон авах боломжтой).
- Төлбөрийн чадваргүй, эмзэг бүлгийн иргэдийн шимтгэлийг төрөөс хэсэгчлэн, эсхүл бүрэн дэмжих зохицуулалттай байх.

5. Хүлээгдэх үр дүн

- Ахмад настны урт хугацааны асаргаа, сувилгааны үйлчилгээний хүртээмж, чанар нэмэгдэнэ.
- Гэр бүлийн асаргааны ачаалал буурч, нийгмийн болон эдийн засгийн сөрөг үр дагавар саарна.
- Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын эрсдэл буурч, шинэ төвүүд бодитоор бий болно.
- Төсөвт нэг удаагийн огцом дарамт үүсгэхгүйгээр тогтвортой санхүүжилтийн эх үүсвэр бүрдэнэ.

6. Шаардлагатай хөрөнгө оруулалт ба нийт барилгын талбай (баримжаа)

Дараах тооцоо нь бодлогын саналын зорилгоор гаргасан баримжаа бөгөөд бодит хэрэгжилтэд үйлчилгээний түвшин (асаргааны хэрэгцээ), стандарт, бүсчлэл, зураг төсөл, инженерийн шугам сүлжээний нөхцөл, хүний нөөцийн олдоц зэрэг хүчин зүйлээс хамааран нарийсгана.

6.1. Орны хэрэгцээний баримжаа

Урт хугацааны асаргаа шаардлагатай бүлгийг 19 000–29 000 хүн гэж баримжаалсан. Энэ бүлгийн бүх иргэн байгууллагад байнга байрлан асаргаанд хамрагдахгүй (гэрээр, өдрөөр, түр асаргаа зэрэг хэлбэрүүд хамт хэрэгжинэ) тул байгууллагад байрлуулах хувийн жинг 20–40 хувийн хүрээнд авч тооцох нь бодитой.

Сценари	Шаардлагатай орны тоо (баримжаа)
20% байгууллагад байрлуулах	3 800 – 5 800
30% байгууллагад байрлуулах	5 700 – 8 700
40% байгууллагад байрлуулах	7 600 – 11 600

6.2. Нийт барилгын талбайн баримжаа

Нэг оронд ногдох нийт барилгын талбайг (нийтийн талбай, үйлчилгээний блок, коридор, агуулах, гал тогоо, сүвилагчийн пост, сэргээн засах хэсэг, тусгаарлалт зэрэг багтсан) 38–45 м²/ор гэж үзэх боломжтой. Энэхүү саналд 40 м²/ор гэж баримжаалав.

Орны тоо	Нийт талбай (40 м ² /ор)
2 000 ор	80 000 м ²
5 000 ор	200 000 м ²
10 000 ор	400 000 м ²

30%-ийн сценарийг (5 700–8 700 ор) суурь баримжаа гэж үзвэл нийт талбай ойролцоогоор 228 000–348 000 м² байна.

6.3. Хөрөнгө оруулалтын (CAPEX) баримжаа

Барилгын 1 м² өртгийг бодлогын түвшинд 4.5–6.5 сая төгрөг/м² хүрээнд баримжаалж, дотор тоноглол, тавилга, сүвилахуйн үндсэн хэрэгсэл, дотор тохижилтын зардлыг 20%-иар нэмэн тооцох жишиг хэрэглэв.

Жишиг хэмжээ	Нийт талбай	Барилгын өртөг (баримжаа)	Нийт CAPEX (+20%)
2 000 ор	80 000 м ²	360–520 тэрбум ₮	432–624 тэрбум ₮
5 000 ор	200 000 м ²	900–1 300 тэрбум ₮	1 080–1 560 тэрбум ₮
10 000 ор	400 000 м ²	1 800–2 600 тэрбум ₮	2 160–3 120 тэрбум ₮

30%-ийн сценарийн хүрээнд (5 700–8 700 ор; 228 000–348 000 м²) нийт хөрөнгө оруулалтын хэрэгцээ ойролцоогоор 1–3 их наяд төгрөгийн хүрээнд байна (баримжаа).

7. Ажиллах хүчний баримжаа тооцоо (хүний нөөц)

Энэхүү тооцоо нь урт хугацааны асаргаа, сувилгааны байгууллагын 24/7 горимоор ажиллах нөхцөлийг харгалзан гаргасан баримжаа бөгөөд бодит хэрэгжилтэд асаргааны хэрэгцээний түвшин (Level), үйлчилгээний стандарт, технологи, өрөөний зохион байгуулалт, аутсорсингийн хувь, хөдөлмөрийн зах зээлийн олдоц зэрэг хүчин зүйлээс хамааран нарийсгана.

Баримжаа аргачлал: 100 оронд ногдох бүтэн цагийн ажилтны (FTE) тоог олон улсын практикт ашиглагддаг хүрээгээр авч, нийт орны тоонд үржүүлэн тооцлоо. FTE нь 24/7 ээлжийн зохион байгуулалттай уялдсан дүн тул 'ээлжийн коэффициент'-ыг тусад нь давхардуулахгүй.

100 оронд ногдох нийт ажиллах хүчний баримжаа: 242–342 FTE/100 ор (өөрөөр хэлбэл нэг оронд 2.42–3.42 FTE/ор).

Албан тушаалын бүлэг	Доод (FTE/100 ор)	Дээд (FTE/100 ор)	Тайлбар
Асрагч, сувилагчийн туслах	140	180	24/7 ээлжийн зохион байгуулалттай
Сувилагч (мэргэжлийн/бакалавр)	35	55	24/7 ээлжийн зохион байгуулалттай
Эмч (ерөнхий + зөвлөх)	6	10	Өдрийн үзлэг + 24/7 дуудлагын зохион байгуулалт
Нийгмийн ажилтан / сэтгэл зүйч	3	5	24/7 ээлжийн зохион байгуулалттай
Сэргээн засах баг (физик/хөдөлгөөн заслын мэргэжилтэн)	6	10	Хэвийн ажлын цаг (шаардлагатай тохиолдолд өргөтгөсөн)
Эмийн зохицуулалт (эм зүйч/эмийн ажилтан)	2	4	24/7 ээлжийн зохион байгуулалттай
Хоол үйлдвэрлэл, гал тогоо	20	30	Хэвийн ажлын цаг (ээлжийн зохион байгуулалттай байж болно)
Ариун цэвэр, угаалга	15	25	Хэвийн ажлын цаг

			(ээлж/аутсорсинг боломжтой)
Инженер, засвар үйлчилгээ	5	8	Өдрийн цаг + дуудлагын жижүүр (объектын хэмжээнээс хамаарна)
Захиргаа, санхүү, хүний нөөц, чанар	10	15	24/7 ээлжийн зохион байгуулалттай

7.1. Нийт ажиллах хүчний хэрэгцээ (жишиг сценаруудаар)

Сценари	Орны тоо	Нийт ажиллах хүч (доод)	Нийт ажиллах хүч (дээд)
2 000 ор	2 000	4 840	6 840
5 000 ор	5 000	12 100	17 100
10 000 ор	10 000	24 200	34 200
30%-ийн сценар (5 700– 8 700 ор)	5 700–8 700	13 794–21 054	19 494–29 754

Тайлбар: Дээрх нь байгууллагын дотоод үндсэн ажиллах хүч (FTE)-ийн баримжаа юм. Хоол үйлдвэрлэл, угаалга, хамгаалалт, цэвэрлэгээ зэрэг зарим үйлчилгээ аутсорсинг хэлбэрээр хэрэгжвэл байгууллагын дотоод ажилтны тоо буурах боломжтой. Харин өндөр хэрэгцээтэй (хүнд сүвилгаатай) тохиолдлын эзлэх хувь өсөхөд сувилагч болон асрагчийн хэрэгцээ нэмэгдэнэ.

Холбогдох хууль тогтоомж	Өөрчлөлтийн санал	Тайлбар
Асрах үйлчилгээний тухай хууль (Төсөл)	4.1.7. "Асаргааны хувилбарт үйлчилгээ" гэж асруулагч хүний эрэлт хэрэгцээ, нөхцөл байдалд үндэслэн төрөлжсөн асрамжийн газарт, <u>хувилбарт асрах үйлчилгээний төвд</u> , гэрт нь, асралт гэр бүлд, өдрөөр, цагаар, түр, урт хугацаагаар, байнга асрах үйлчилгээг төлбөртэй, төлбөрийн хөнгөлөлттэй, төлбөргүй нөхцлөөр үзүүлэх үйл ажиллагааг; 4.1.13. "Хувилбарт асрах үйлчилгээний төв" гэж ахуйн асаргаа, урт хугацааны нөхөн сэргээх дэмжлэг болон хүмүүнлэг оролцооны үйлчилгээг тасралтгүй, түр, өдрөөр болон цагаар, хөдөлгөөнт хэлбэрээр <u>төлбөртэй, төлбөрийн хөнгөлөлттэй, төлбөргүй нөхцлөөр үзүүлэх</u> зорилгоор энэ хуульд заасан нөхцөл, шаардлагыг хангаж байгуулагдсан, тодорхой байгууламж бүхий төвийг;	Хувилбарт асрах үйлчилгээний төв гэсэн хуулийн тодорхойлолт нь байнгын асрах үйлчилгээг үзүүлж буй төвүүд гэж байгаа хэдий ч төлбөрийн нөхцлийг тусгаагүй байгаа нь төрөлжсөн асрамжийн төвтэй мөн адил зарчмаар ажилладаг байгууллагуудыг хамруулж үзэх эрсдэл байна. Иймд, асаргаа сувилгаа болон нийгэмшүүлэх зэрэг олон төрлийн үйлчилгээг төлбөрийн уян хатан нөхцлөөр сонголттойгоор үзүүлэх боломж нь хуулиар нээлттэй байх нь тус хуулийн төслийн үзэл баримтлалтай нийцэх болов уу.
Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль	22.9.2.ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдийн асрамжийн үйлчилгээ, <u>асрах үйлчилгээ, тэдгээрийн эрхийг хангах</u> , хамгаалах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тохируулгат орчин бүрдүүлэх, хүүхдийн тоглоомын талбай, зуслан, цэцэрлэгт хүрээлэн, <u>хувилбарт асрах үйлчилгээний төв барьж байгуулах, ашиглах</u> ;	ААНОАТХ-ийн одоогийн зохицуулалтаар асрамжийн үйлчилгээ гэж тусгасан хэдий ч нарийвчилсан журмаар тус үйл ажиллагааг "төрөлжсөн асрамжийн төв"-р хязгаарласан нь хувийн болон сайн дурын үндсэн дээр хамрагдах асрамжийн үйлчилгээ болон тус үйлчилгээг үзүүлэх төв барьж, байгуулах нь татварын хөнгөлөлтөд хамрагдахгүй байх нөхцлийг бүрдүүлээд байна. Иймд, хуулийн төслийн шинэлэг зохицуулалтын хүрээнд үзүүлэх боломжтой асрах үйлчилгээ болон хувилбарт асрах үйлчилгээний төв барьж, байгуулахыг хамруулахаар өөрчлөлт оруулсны үндсэн дээр татварын хөнгөлөлт эдлэх боломжтой.
Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 12 сарын 12-ны өдрийн А/67 дугаар тушаалын хавсралт	3.1.1.ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдэд зориулсан төрөлжсөн асрамжийн газар болон <u>хувилбарт асрах үйлчилгээний төв</u> шинээр барих, сэргээн засварлах, тохижилт, тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлэх; Хүснэгт 1- Бүтээн байгуулалт, төсөл үйл ажиллагаанд тавигдах бусад шаардлага, стандарт Нэг. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдэд зориулсан төрөлжсөн асрамжийн газар болон <u>хувилбарт асрах үйлчилгээний төв</u>	Тус шаардлага, стандарт баталсан хавсралтад "хувилбарт асрах үйлчилгээний төв"-ийг нэмж тусган, холбогдох шаардлага, стандартуудыг яамны зүгээс тодорхойлж нэмж тусгаснаар хувийн хөрөнгө оруулалттай ахмад настануудад асрах үйлчилгээ үзүүлж буй төв барьж, байгуулах үйл ажиллагаа татварын хөнгөлөлтөд хамрагдах боломж бүрдэнэ.

	шинээр барих, сэргээн засварлах, тохижилт, тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлэх	
--	--	--